


Рынок Вурлодранг

ЭНЕРГИЯ НАУКИ И ТЕХНИКИ



ИТГЭЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

ИТГЭЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

Ричард Вурмбранд

Өмнөх үгийг Христэд итгэгчдийн европын нийгэмлэгийн
ерөнхий захирал В. Стuard Харрис бичив.

Хэвлэлийн газар:

Монголын Библийн Нийгэмлэг

Улаанбаатар

2005

"Tortured for Christ"

Анхны хэвлэл 1967 онд

Орчуулгын чанарыг алдаглуулж зохиогчийн эрхэнд халдахаас хамгаалах үүднээс доорхи зүйлийг сануулж байна.

Энэ номыг, мөн номын зарим хэсгийг орчуулагчийн зөвшөөрөлгүй авч өөр номонд хэрэглэх, иш татаж хэвлэх, хэвлэл мэдээллийн бусад аргаар олон нийтэд түгээхийг хориглоно.

Бернийн конвенцийн дагуу (1886) зохиогчийн эрх нь орчуулагчид хадгалагдана.

© ШХИ, 2005

ISBN 1 84475 007 8

ЗОХИОГЧИЙН ТАЛААР ӨГҮҮЛЭХЭД ...

Энэхүү номын зохиогч Ричард Вурмранд нь Христэд итгэгчийн бүлгийн хүндэт ахлагч бөгөөд арван дөрвөн жил коммунистуудын шоронд хоригдон, өөрийн эх орон Румындаа тамлуулан зовж явсан, Ертөнцийн Эзэний авралын тухай тунхаглагч үнэнч итгэлтэй хүн билээ. Тэр Румыны хамгийн шилдэг, олны танил болсон Христэд итгэгчийн удирдагч, зохиолч, сурган хүмүүжүүлэгчийн нэг юм. Түүний төрөлх нутагт үнэлэгдвэл зохих хэдхэн хүн байдгийн нэг нь тэр билээ.

Коммунистууд 1945 онд Румыныг гартаа оруулсан ба Христэд итгэгчийн байгууллагыг өөрсдийн зорилгодоо ашиглахыг оролдож байв. Тэр үеэс Ричард Вурмбранд оросын цэргүүдэд эзлэгдсэн, адгийн муу ёрын сүнсэнд боолчуулсан ард түмэндээ Ертөнцийн Эзэний авралыг таниулах хүч нөлөөтэй, идэвхтэй нууц ажиллагаагаа явуулж эхэлсэн. 1948 онд түүнийг эхнэр Сабинагийнх нь хамт баривчилжээ. Эхнэр нь гурван жилийн турш нийгмийн тустай хөдөлмөрт зүтгэн хоригдож, харин Ричард Вурмбранд гурван жилийн турш тусгай дэглэмтэй хориход суув. Тэр гурван жилийн турш тусгаарласан өрөөнд сууж, хэнтэй ч уулзахгүй, холбоо барихгүй, зөвхөн коммунистуудад тамлуулан байлаа. Гурван жил ийнхүү хоригдсоны дараа түүнийг нийтийн хориход шилжүүлэн таван жил үргэлжлүүлэн тамлан зовоожээ.

Христэд итгэгчийн удирдагчийнхаа хувьд олон улсын хэмжээнд нэр нөлөө бүхий хүн байсан тул гадаад орнуудын элчин сайдын яамдууд түүний аюулгүй байдлыг хангах талаар асуун шалгааж байв. Түүнийг Румынаас зайлан зугтаж гарсан гэхээс өөр тэдэнд юм хэлдэггүй байлаа. Суллагдсан хоригдлууд хэмээн өөрсдийгөө нэрлэдэг нууц цагдаагийн ажилтнууд эхнэрт нь шоронгийн оршуулах газар оршуулганд нь оролцсоноо хүртэл

хэлж нас барсан хэмээн ойлгуулахыг хичээж байв. Румын дахь түүний гэр бүл, дотоод, гадаадад буй найз нөхдөд нь нэгэнт нас барсан тул түүний тухай дурсахгүй байвал зохино гэж зөвлөсөн байна.

Найман жилийн дараа түүнийг сулласан ба тэрээр шоронгоос гараад шууд л нууц бүлгийн ажилд нэгдэн оров. Хоёр жилийн дараа буюу 1959 онд түүнийг дахин баривчилж хорин таван жил шоронд хорих ял оноосон байна.

Тэрээр 1964 онд олон нийтийн өршөөлөөр суллагдан гараад дахин нууц бүлгийнхээ үйл ажиллагаанд оролцох болжээ. Гурав дахь удаагаа баривчлагдвал амь насанд нь бодитой аюул учирч болзошгүйг олж мэдсэн Норвегийн Христэд итгэгчид коммунист эрх баригчидтай тохиролцон хэлэлцэж түүнийг Румынаас гаргах болжээ. Румыны засгийн газар тэр үед улс төрийн хоригдлуудаа худалдаад эхэлчихсэн байв. Хоригдож буй хүний чөлөөлөгдөх үнэ 800 фунт стерлинг байсан боловч түүнийг тэд 2500 фунт стерлингээр үнэлсэн байлаа.

1966 онд тэрээр Америкийн Нэгдсэн Улсын сенатуудын танхимиын дотоодыг хамгаалах зөвлөлийн өмнө өөрийн түүхийг ярьж бүсэлхийнээсээ дээш нүүргэлэн тамлуулж байсных нь гэрч болон биед нь үлдсэн гүн шарх сорвийг харуулсан юм. Түүний амьдралын түүхийг европ, америк, азиин орнууд сонин хэвлэлүүдэдээ өргөн бичиж байв. 1966 оны есдүгээр сард Румыны засгийн газрын коммунистууд түүнийг хөнөөхөөр шийдсэн тухай мэдээлэл ирэв. Үхлийн аюул бодитоор нүүрлээд байсан тэр үед ч гэсэн тэрээр дуугүй суугаагүй юм. Түүнийг "Нууц бүлгийн дуу хоолой" гэж нэрлэдэг байлаа. Христэд итгэгчдийн ахлагч нар түүнийг "итгэлийнхээ төлөө амиа зориулсан бодит амьд хүн", "Төмөр хөшигний цаана буй Пууль" гэж нэрлэдэг.

ӨМНӨХ ҮГ

Өмнөх үгийг Христэд итгэгчдийн европын нийгэмлэгийн ерөнхий захирал В. Стуарт Харрис бичив.

Би анх 1964 оны арван хоёрдугаар сард Румынд очсон. Европын бүх орооор би явж байсан бөгөөд Албанийг оруулахгүй бол Румын миний очиж үзээгүй ганц улс байлаа, гэтэл одоо хүрээд ирчихсэн байв. Бүр хэдэн сарын өмнөөс л Ертөнцийн Эзэн намайг тэнд очих хэрэгтэй гэж хэлж, зааж өгөөд байгааг би мэдсэн. Тиймээс би Христэд итгэгчдийн бүлгийн хүндэт ахлагч Жон Моселийн хамт Унгараас гарч Румыны хилийг давсан нь энэ.

Удалгүй биднийг цаг ямагт нүд цавчилгүй ажиглан харж байдаг засгийн газрын эрх баригчид бүхий коммунист дэглэмтэй улс оронд байгаагаа ухаарав. Гэсэн ч тэндхийн Христэд итгэгчид биднийг халуун дотно угтан авч уулзсан ба шинэ оны эхний ням гаригийн орой бид Бухарест хот дахь германы баптист байгууллагад очицгоов. Биднийг тэнд очиход хэрхэн Христэд итгэсэн тухай түүхээ хуваалцан, мэндчилгээ дэвшүүлэхийг хүсэв. Хурлын төгсгөлд бидэнтэй чин сэтгэлээсээ ярилцааар хэдэн хүн үлдсэн бөгөөд тэдний дотор өндөр нуруутай, цонхигордуу цайвар царайд нь чин сэтгэлээс үнэнийг эрэн хайж буй шинж тодорсон нэг эрэгтэй байлаа. Тэрээр хэрэв та бүхэн зориг гарган гэрт маань ирвэл би та нартай юу ч болсон хамаагүй ярилцахыг хүсч байна гэдгээ хэлж урив. Тэгээд тэр өдөр оройн 10 цаг өнгөрч гадаа таг харанхуй болсон хойно бид гэрт нь очигоор явлаа. Тэнд Ричард Вурмбранд эхнэр, хүү Михай нарын хамт дээд давхрын жижигхэн умгар өрөөнд амьдарч байв.

Биднийг тийш чимээгүйхэн явж ороход баруунд хaa сайгүй нэр нь дурдагдаж байдаг өнөөх ахлагч маань арван дөрвөн жилийн турш хэрхэн шоронд хоригдож, суллагдаж явсан тухай гайхамшигтай түүхээ бидэнд ярьж өгөв. Эхлээд түүний хүү,

эхнэр Сабина хоёр нь гадагш гарч эргэн тойрныг ажиглаад эргэн ирж байшиг тэр чигт нь цагдаа нар бүсэлсэн байна гэж мэдэгдэв. Байшигийн эсрэг талд цагдаагийн машин хүлээгээд зогсч байгааг ч бас хэллээ. Тэд энэ байшиг хир удаан ажиглах бол? Ричард Вурмбранд өөрийн амьдралын түүхийг ярьж дуусаад бид хамтран Ертөнцийн Эзэнтэй ярьж уулзалтаа өндөрлөв. Тэр бол бидний хувьд мартагдашгүй дурсгалтай мөч байсан бөгөөд бид Ертөнцийн Эзэнээс зарц нарынхаа амь насыг хамгаалахыг гүйж байсан юм. Бид түүний бие дэх тамлуулсны ор мөр болон үлдсэн сорвийг харан урьд өмнө байсан тэр аймшигт цаг мөч одоо ч бодитой байж болохыг ухаарлаа. Шоронгийн тамлал зовлонгийн талаархи харанхуй түүх ч бас Ертөнцийн Эзэнний энэрэл хайр, яруу алдрыг гайхуулан байлаа. Ертөнцийн Эзэн бидний гүйлтиг сонсож, эцэст нь биднийг тэндээс гарахад нөгөө цагдаа нар алга болсон бай!

Ертөнцийн Эзэнний гэр бүлд багтсан, Христийн баатар зоригт гэрчүүд болсон энэ хүмүүстэй бид анх удаагаа уулзаж байсан боловч дахиад хэзээ ч ийнхүү уулзахгүй гэдгээ дотроо мэдэж байв. Тиймээс энэ номыг та бүхэнд толилуулах эхний хэдэн үгийг бичиж байгаагаа би хүндэтгэлтэй хэрэг гэж үзнэ. Энэ номыг уншсан олон хүний сэтгэл зүрхэнд Ертөнцийн Эзэн хүрч зүүн европт буй хүмүүсийг хайлрах хайр өгч, энэ хайрынх нь үр дунд сайхан сэтгэлтэй хүмүүс Христэд итгэснээсээ болж хавчигдан зовж буй ахан дүүстээ туслах болтугай хэмээн Ертөнцийн Эзэнээс би гүйж байна. Ингэснээр Христийн бие мэт болж нэгдсэн түүний хүмүүс сэтгэл зүрхээрээ нэгдэх болно.

Энэхүү номыг намайг 1964 онд шоронгоос суллагдсаныхаа дараахан Румынд барууны Христэд итгэгчдийн анхны элч болон ирж уулзсан Лондон дахь Христэд итгэгчдийн европын нийгэмлэгийн ерөнхий захирагч, Христэд итгэгчдийн бүлгийн хүндэт ахлагч В. Стюарт Харрист зориулав. Урьдчилан сануулсан ч тохиолдож болох аюулыг үл тоон бидний умгар гэрт харанхуй шөнө болсон хойно зочлон ирэхдээ Христийн төлөө амиа үл хайрлан зүтгэж буй хүмүүс бидэнд урам зориг, тайтгарал авчрах хайрын үгийг тэр дамжуулсан юм. Христийн төлөө амиа зориулсан анд нөхдөө хүндэтгэн тэдний өмнөөс талархлаа илэрхийлье.

ТАНИЛЦУУЛГА

НОМ БИЧИХ БОЛСНЫ УЧИР

Төмөр хөшигний цаана баригдалгүй, одоохондоо эрх чөлөөтэй байгаа Христэд итгэгч хүн бүрийн үгийг та бүхэнд хүргэхийг би зорьж байна.

Олон жилийн турш миний ахалж ирсэн нууц бүлгийнхэн маань хоорондоо ярилцаад байж болох бүх л аргыг хэрэглэн баруунд гарах нь миний хувьд хамгийн чухал хэрэг гэж үзсэн юм. Та бүхэнд дамжуулах туйлын чухал хэдэн үг байсан тул ийм шийдвэр гаргасан билээ. Би олон бэрхшээлийг туулсан хэдий ч баруунд гарч эрх чөлөөтэй байгаа минь зөвхөн Ертөнцийн Эзэний бүтээж чадах гайхамшигийн үр дүн. Энэ номдоо би коммунист системийн улс орнуудад хавчигдан зовж буй Христэд итгэгчдийн бүлгийн найдаж даалгасан тэр чухал үгсийг та бүхэнд хүргэхийг зорьж байна.

Тиймээс нууц бүлгийнхний дамжуулж буй эдгээр үгсийг анхааран сонсч чухалчлан үзнэ гэдэгт найдаж байна. Юуны түрүүнд би өөрийн амьдралын түүхээс та бүхэнтэй хуваалцаж, улмаар нууц бүлгийн үйл ажлын талаар толилуулах болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ШАШИНГҮЙ ҮЗЭЛТЭН ХРИСТИЙГ ОЛОВ

Би хар багаасаа л огт шашин шүтлэггүй гэр бүлд өссөн билээ. Хүүхэд байхад минь ч надад ямар нэгэн шашны талаар зааж сургасангүй, бүр огт тийм юм байхгүй байсаар арван дөрөв хүрэхдээ би яагаад ч эргэх аргагүй хатуу үзэл бодолтой, өөртөө бат итгэлтэй шашингүй үзэлтэн болсон байлаа. Бага балчир байхаасаа л элдвийн зовлон үзсэн нь намайг ийм хүн болж өсөхөд хүчтэй нөлөөлсөн юм. Төрөөд удаа ч үгүй би өнчин хоцорсон агаад дэлхийн нэгдүгээр дайны дараахи ядуурлын туйлд хүрсэн цаг үед амьдарч ядуугийн зовлон амссан. Тийнхүү арван дөрөв хүрэхдээ би өнөөгийн коммунистуудын адил яагаад ч өөрчлөх аргагүй бат үзэл бодолтой шашингүй үзэлтэн болсон байв. Би Ертөнцийн Эзэн, Христэд итгэдэггүйдээ биш харин тэднийг хүний оюун ухааныг хордуулагч аймшигтай, аюулт эд гэж үзэн яддаг байснаасаа болж шашингүй үзлийг хөхүүлэн дэмжсэн олон ном уншсан. Тиймээс би шашинд хорсон дотоод сэтгэлдээ асар их хорсол занал агуулсан хүн болж өссөн билээ.

Гэвч хожим нь би ойлгохын аргагүй олон шалтгааны улмаас Ертөнцийн Эзэн намайг хайрлан өөрийн хүнээ болгон авсан нь чухамхүү түүний хязгааргүй аугаа их хайр байсныг ойлгосон. Эдгээр нь миний зан чанараас огтхон ч хамаараагүй юм. Хүн авчихаар сайхан ааш, зан чанар надад үнэндээ ер байсангүй.

Хэдийгээр би шашингүй үзэлтэн байсан боловч тайлахын аргагүй нэгэн шалтгааны улмаас Христэд итгэгчдийн тухай ямагт сонирхдог байв. Христэд итгэгчид хуралдаж буй байшингийн хажуугаар дотогш орохгүй зүгээр өнгөрөөд явна гэхээр надад нэг л байж боломгүй хэрэг шиг санагддаг байв. Гэсэн ч тэнд хүмүүс юу хийдэг, ямар байдалтай байдаг талаар юу ч мэддэггүй байлаа. Би сургаалыг нь сонсох боловч энэ нь хэзээ ч

сэтгэлд минь хүрч нөлөөлж байсангүй. Ертөнцийн Эзэн огт байдаггүй гэдэгт би огтхон ч эргэлзээгүй бат итгэсэн байв. Би өөрөө Ертөнцийн Эзэнийг дуулгавартай дагаж байх хэрэгтэй гэдэг талаар уншахад л үзэн ядах сэтгэл оволзоод ирнэ. Бодол санаанд минь буй Ертөнцийн Эзэний талаархи буруу үзэл бодлыг би үзэн ядаж байлаа. Гэсэн ч энэ орчлонгийн төвд хaa нэгтээ энэрэл хайр дүүрэн ямар нэгэн зүрх сэтгэл оршин байх ёстой агаад түүнийг олж мэдэх юмсан гэж битүүхэндээ хүсдэг байв. Хүүхэд ахуй насны гэгээтэй сайхан дурсамж гэвэл хэдхэн. Миний төлөө үргэлж цохилж байдаг хайр дүүрэн зүрх сэтгэл энэ ертөнцийн хaa нэгтээ байгаасай гэж маш их хүсдэг байлаа. Гэвч Ертөнцийн Эзэнд итгэнэ гэдэг нь шашина шүтлэгтэй ерхолбоогүй хэрэг болохыг огт мэддэггүй байв.

Ертөнцийн Эзэн гэж байхгүйг мэддэг байсан ч энэрэл хайр дүүрэн Ертөнцийн Эзэн байдаггүйд тун их харамсдаг байв. Дотоод сэтгэл, оюун санаандаа тэмцэлдсээр би нэг удаа католик сүм рүү яваад орчихов. Тэнд хүмүүс өвдөг сөгдөн суугаад амандаа ямар нэгэн юм хэлээд байгааг олж хараад дэргэд нь очиж тэдний адил сөгдөөд суувал хэлээд байгааг нь олж сонсож юу магад, тэгээд сонсогдвол юу болохыг нь үзэхийн тулд давтаад хэлье гэж бодов. Тэд хөндөгдөөгүй бүсгүй Марьд хандан гүйж байх ба "Энэрэл хайр дүүрэн гэгээн Марь таныг дуудаж байна" гэх сонсогдов. Би тэдний үгийг давтан ахин дахин хэлж гэгээн Марийн гэрэлт хөшөөг ширтэн харж байсан боловч юу ч болсонгүй. Үүнээс болж би улам бүр харамсах боллоо.

Бат итгэлтэй шашингүй үзэлтэн байсан ч нэг өдөр Ертөнцийн Эзэнтэй ярихаар шийдлээ. Миний ярьсан яриа нэг иймэрхүү л юм байв:

— Ертөнцийн Эзэн, та огт оршин байдаггүй гэдгийг би мэднэ л дээ. Гэвч юмыг яаж мэдэхэв хэрвээ та оршин байдаг юмаа гэхэд би заавал танд итгэх албагүй шүү дээ. Харин өөрийгөө надад илчлэн үзүүлэх нь таны үүрэг биз дээ?

Би шашингүй үзэлтэй хүн байсан боловч үүнээсээ болж амар тайван амьдарч чадахгүй, сэтгэл дотор үргэлж л ямар нэг асуудал байдаг байсныг үгүйсгэхгүй.

Дотоод сэтгэлдээ тэмцэлдэн байх яг энэ үед маань Румыны өндөр уулсын дунд байх нэгэн тосгонд настай мужаан,

— Ертөнцийн Эзэн минь, энэ дэлхий дээр байх үедээ би танд олон жил үнэнч зүтгэлээ. Үүнийхээ үр дунг би мөнхийн улсад үзэх болно гэдгээ мэдэх боловч энэ дэлхий дээр байхдаа бас үзэхийг хүсч байна. Би өөд болохосоо өмнө нэг Иудей хүнийг Христэд итгүүлэн таны өмнө авчрахыг хүсч байна. Есүс Христ Иудей хүн байсан тул би үүнийг өөртөө шагнал болгон хийхийг хүсч байна. Би ядуу, бас дээр нь нас өндөр, өвчинд баригдсан тул ийш тийш Иудей хүн хайгаад яваад байж чадахгүй. Гэтэл миний амьдардаг энэ тосгонд нэг ч тийм хүн байдаггүй. Тиймээс Их Эзэн минь, та манай тосгонд нэг Иудей хүн авчирч өгөөч, би түүнд Христийг танилцуулж, таны өмнө авчрахын тулд чадах бүхнээ хийе хэмээн Ертөнцийн Эзэнээс чин сэтгэлээсээ гүйн ярьж байсныг би хожим олж мэдсэн юм.

Эсэргүүцэхийн аргагүй ямар нэг юм намайг тэр тосгон руу дуудаж байв. Тэнд надад хийх юм үнэндээ юу ч байсангүй. Румынд арван хоёр мянган тосгон байдаг. Гэтэл би тэр олон тосгоны дотроос очиж очиж яг тэр тосгонд явж очлоо. Намайг еврэй хүн болохыг харангутаа нөгөө мужан өвгөн тосон уулзав. Хамгийн царайлаг сайхан эмэгтэйг хөл алдан угтах мэт тэр намайг угтан авлаа. Намайг хараад Ертөнцийн Эзэн гүйлтиг нь сонсон хариу өгснийг харж байсан тул надад Библи бэлэглээд унш гэв. Өмнө нь би Библийг соёл заншилтайгаа холбон үзэх гэж маш олон удаа уншиж байсан. Гэтэл түүний надад өгсөн тэр Библи тун өөр байв. Харин хожим нь тэрээр надад эхнэрийнхээ хамт миний авралын төлөө, мөн эхнэрийн минь авралын төлөө Ертөнцийн Эзэнээс тэвчээртэйгээр их удаан гүйсан гэдгээ хэлсэн юм. Түүний надад өгсөн Библи нь цаасан дээр бичигдсэн үг гэхээсээ илүү түүний Ертөнцийн Эзэнтэй ярьсных нь үр дүн болох энэрэл хайраар дүрэлзсэн гал мэт байсан билээ. Би бараг уншиж чадахгүй шахам байв. Өөрийнхөө өөдгүй муу амьдралыг Есүсийн амьдралтай, бузар булаг байдлаа түүний ариун дархан чанартай, сэтгэл зүрхэндээ тээсээр ирсэн үзэн ядалтаа түүний хайр энэрэлтэй харьцуулан үзээд асгаруулан уйлахаас өөр юу ч хийж чадахгүй байлаа. Ийм арчаагүй намайг тэрээр хүүгээ болгон сонгон авсан гэдгийг мэдээд үнэхээр сэтгэлээ барьж чадахгүй байв.

Намайг Христийн хүн болсноос хойш тун удалгүй эхнэр маань ч бас түүний хүн болов. Тэр маань өөр бусад хүмүүсийг бас Христтэй уулзуулж, тэд нар нь бусдыг араасаа дагуулсаар байв. Ийнхүү Румыны Христэд итгэгчдийн тоо нэмэгдэн бүлэг нь өргөжсөөр байлаа.

Гэтэл нацистуудын цаг мөч эхэллээ. Бид ч их зовлон амссан даа. Румыны засаг захиргаа нацистуудын хатуу чанд дэглэмийн гарч орж тэд протестантуудыг Иудейчууд шиг үзэн хавчин гадуурхдаг болов.

Би энэ бүлгийн анхны гишүүдийн нэг байсан учир хүмүүс намайг албан ёсоор томилогдохоос өмнө аль хэдийн ахлагч гэж үздэг болсон байв. Нэгэнт би үүсгэн эхлүүлсэн хүн нь туд тэдний өмнө хариуцлага хүлээх ёстой. Эхнэр бид хоёр нилээд хэдэн удаа баривчлагдан зодуулж нацист шүүхийн нүүрийг үзэж байсан. Нацистуудын учруулж байсан аюул занал үнэхээр бодитой байсан хэдий ч коммунист дэглэмийн дор түүнийг нь бас эдэлнэ гэдэг хэлэхийн аргагүй хэцүү. Хүүгийнхээ амь насыг хамгаалахын тулд бид хүү Михайдаа еврэй бус нэр өгөхөөс өөр аргагүй болов.

Нацистууд ноёрхож байсан үеийн ганц давуу тал нь бие махбодоороо зовох, тамлуулах гэж чухам юу болох, түүнийг хүн хэрхэн Ертөнцийн Эзэний хүч чадлаар даван туулж, тэсээд гарч чаддагийг бидэнд зааж өгсөн явдал юм. Тэд бидэнд Христийн ажлыг хийх нууц арга замуудыг заан хожим ирэх илүү аймшигтай, хахир цагийг урьдаас мэдэн биднийг бэлдэж байсан мэт санагдана.

ОРОСУУДЫН ДУНД

Ертөнцийн Эзэнийг үгүйсгэсэн тээрслүү үзэлтэн байсандаа би ихэд харамсаж Христэд итгэх болсон анхны өдрөөсөө л оросуудтай ажиллах юмсан гэж хүсдэг болов. Оросууд гэдэг бол хар багаасаа Ертөнцийн Эзэнийг үгүйсгэж, шашин бол хар тамхи гэсэн сургаал заалгаж өссөн улс. Оросуудтай ажиллах юмсан гэсэн хүсэл маань удалгүй биелэлээ олов. Энэ хүсэл маань нацистуудын үеэс биелж эхэлсэн билээ. Дайны үед олзлогдсон

орос хоригдлууд Румынд маш олон байсан ба бидэнд тэдний дунд орж Христийн ажлыг хийх боломж байв.

Энэ бол гайхалтай эрчтэй, амжилттай ажил байлаа. Орос хоригдолтой анх уулзсан тэр мөчийг би хэзээ ч мартдаггүй, мартах ч аргагүй. Тэр надад өөрийгөө инженер гэж танилцуулав. Түүнээс Ертөнцийн Эзэнд итгэдэг үү гэж асуухад тэрээр,

— Үгүй, тэгээд ч энэ талаар нэг их бодоод байдаггүй гэж хариулав. Итгэх үү, итгэхгүй байх уу гэдгээ хүн бүр шийдэх эрхтэй. Гэвч намайг түүнээс Ертөнцийн Эзэнд итгэдэг үү гэж асуухад тэрээр гайхан хөмсгөө өргөн юу ч ойлгохгүй байгаа янзтай,

— Ийм юманд итгэх цэргийн даалгавар би аваагүй. Хэрвээ тийм даалгавар авах юм бол мэдээж итгэлгүй яахав гэж хариулж билээ.

Хацар даган нулимын урслaa. Зүрх сэтгэл минь эмтрэн хэдэн хэсэг тасраад унах мэт болоод явчихав. Миний өмнө нэгэн сайхан эр зогсох аж. Гэвч түүний оюун санаа үхмэл, Ертөнцийн Эзэний өгсөн хувь хүн байх хамгийн аугаа бэлгийг алджээ. Тэр бол юунд итгэж, итгэхгүй байхаа бодохгүй өгсөн тушаалыг сохиор дагахад бэлэн болтлоо коммунистуудын гар тархиа юу ч үгүй болтол угаалгасан хүн байлаа. Тэр өөрөө бодоод дүгнэлт, шийдвэр гаргах чадваргүй болжээ! Коммунист дэглэмийн дор хэдэн жил болоход л бүх оросууд яг ийм байдалтай болсон байв! Хүн төрөлхтнийг коммунизм яаж юу ч үгүй болтол нь өөрчилснийг хараад үнэхээр итгэж чадсангүй. Тэгээд би Ертөнцийн Эзэнд эдгээр хүмүүсийн төлөө бүх амьдралаа зориулан тэдэнд Ертөнцийн Эзэн болон Христэд итгэн өөрийн гэсэн мөн чанараа олж авахад нь тусална гэж шийдсэнээ хэлэв.

Оросуудтай ажиллахын тулд надад оросын нутагт очиж амьдрах хэрэг байсангүй.

1944 оны наймдугаар сарын хорин гуравнаас эхлэн нэг сая орос цэрэг Румыны нутаг дэвсгэрт орж ирсэн ба тун удалгүй манай улсын засгийн эрхэнд коммунистууд гарлаа. Тэгснээр аймшигт хавчлага зовлон эхэлж, түүний дэргэд нацистуудын учруулсан зовлон юу ч биш мэт санагдах болов.

Тэр үед Румыны хүн ам арван найман сая байсан ба коммунист намын гишүүд дөнгөж арван мянга л байв. Гэвч Зөвлөлт

Холбоот Улсын Гадаад орнуудын хэрэг эрхэлсэн нарийн бичгийн дарга Вишинский ард түмний хүндэтгэл хайрыг хүлээсэн их хаан нэгдүгээр Михаилын албан ажлын өрөөнд салхи шуурга татуулах мэт давхин орж ирээд гарaa зангидан ширээг нь шааж, коммунистуудыг заавал засгийн эрхэнд гаргах ёстой хэмээн шаардаж байв. Нэгэнт бидний цэрэг арми, цагдаа нарын зэр зэвсгийг хураан нүцгэлчихсэн байсан тул бараг бүх хүнийг дургүй байсаар байтал тэд хүч хэрэглэн засгийн эрхийг булаан авав. Тэр үед Америк, Их Британийн засгийн газрын тэргүүлэгчид үүнд оролцоогүй гэж бид хэлж болохгүй.

Хүн өөрийн үйлдэж хийсэн гэмийн болон улс үндэстнийхээ гэмийн хариуцлагыг Ертөнцийн Эзэний өмнө хүлээдэг. Баривчлагдан хорионд орсон улс үндэстнүүдийн эмгэнэлт байдлын хариуцлага америк, их британийн Христэд итгэгчдэд оногдох болно. Аллага, хүчирхийлэл, айdas үүрүүлсэн энэ дэглэмийг тогтооход учрыг нь сайн тайлаагүй байж оросын талд тусалсан гэдгээ америкчууд мэддэг байвал зохино. Тиймээс америкчууд баривчлагдсан энэ хүмүүсийг чөлөөлөн Христийн гэрэл гэгээ, эрх чөлөөг олж авахад нь туслах үүрэгтэй.

ХАЙР БА БЯЛДУУЧЛАЛ НЭГ АМНААС

Коммунистууд засгийн эрхийг гартаа аваад шууд л Христийн хүмүүсийн эсрэг ард олныг чиглүүлэх ухуулгаа тун чадварлаг хийж эхлэв. Хайр ба бялдуучлалын үг нэг л амнаас гарах ажээ. Нэг сайхан охиныг эхнэрээ болгохыг хүсч буй эр, мөн тэр охиныг нэг шөнө ашиглан хамт унтаж зугаагаа гаргачихаад хаях гэж буй эр хоёул ялгаа байхгүй "хайртай" гэж хэлдэг. Есүс бидэнд энэрэл хайрын хэлийг бялдуучлан буй хэлээс хэрхэн ялган танихыг, хонины арьс нөмөрсөн чоныг хэрхэн жинхэнэ хониноос нь ялган салгахыг зааж өгсөн.

Коммунистууд засгийн эрхэнд гарахад олон ахлагч нар, Христийн ажлыг хийгч хүмүүс энэ хоёр дуу хоолой хоорондоо хичнээн их ялгаатай болохыг таниагүй билээ.

Манай их хурлын байранд коммунистууд Христийн биеийг бүрдүүлэгч бүх хүмүүсийг зарлан хуралдуулав. Тэнд бүх ургалын бүлэглэлүүдээс дөрвөн мянга орчим ахлагч, сургаал

заагч нар ирсэн байв. Энэ дөрвөн мянган сургаал заагч, ахлагч нар бүгд дуу нэгтгэйгээр энэ бүлгийн тэргүүн нь Жозеф Сталин мөн гэдгийг хүлээн зөвшөөрч хүндэтгэв. Гэтэл тэр үед тэрээр Ертөнцийн Эзэнийг үл ойшоо дэлхий нийтийн хөдөлгөөнийг тэргүүлэгч ба Христэд итгэгчдийг бөөнөөр нь хомроголон устгагч аюултай этгээд байв. Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч, сургаал заагч нар их хурлын танхимд босч зогсоод коммунизм, Христэд итгэх явдал нь уг чанартаа адил учир хамтран оршин тогтнож болно гэж давтан хэлж байв. Христийн ажлыг хийгчид, ахлагч нар удаа дараа коммунизмыг магтан сайшааж Христийн шашинд үнэн итгэлтэй шинэ засгийн газартай болно гэж итгэж байлаа.

Эхнэр бид хоёр тэр уулзалтад бас очив. Эхнэр минь миний дэргэд суугаад надад,

— Ричард, бос! Христийн нүүрнээс энэ ичгүүр сонжуурыг холдуулан хаяач! Тэд түүний нүүр өөд нулимж байна шүү дээ! гэж хэлэв. Би эхнэртээ хандан,

— Би тэгнэ гэдэг чинь чи нөхрөө алдана гэсэн үг шүү дээ гэв. Тэгэхэд,

— Би арчаагүй хулчгар нөхөртэй баймааргүй байна гэлээ.

Тэгээд би босч тэдэнд Христэд итгэгчдийг алж устгадаг алуурчдыг магтсан сайшаалын үгийг бус харин Ертөнцийн Эзэн, түүний хүү Есүс Христийн үнэнийг, итгэл найдвараа бид зөвхөн түүнд өгч, юуны өмнө ганцхан түүнд үнэнч байх ёстой тухай ярьсан юм. Тэр хурлын бүх үйл явцыг орон даяар төлөвлөж тунхаглан буй Христийн үнэнийг ард түмэн тэр аяараа сонсох боломжтой байлаа! Үүний дараа би хийсэн хэргийнхээ төлөө шийтгэл амсах хэрэгтэй болсон боловч харьцуулан үзвэл үр дүн нь хавьгүй илүү агуу байв.

Үнэн алдартны болон протестант байгууллагуудын ахлагч нар хоорондоо коммунизмыг тууштай дэмжин дуулгавартай байх гэж тэмцэлдэж байв. Үнэн алдартны шашны нэг байгууллагын тэргүүн лам ёслолын хувцасныхаа энгэрт алх хадуур хадаад бусад сургаал заагч нартаа үүнээс хойш намайг "гэгээн ламтан" бус харин "нөхөр ламтан" гэж дуудаж бай гэж хэлсэн байв. Би Ресита хотод байдаг нэгэн баптист байгууллагын хуралд

оролцсон ба тэр сүмийн барилгын оройд улаан туг хатган, хүн бүр босч зогсоод Зөвлөлт Холбоот Улсын сүлд дуулалыг хүндэтгэлтэйэ дуулж байв. Баптист байгууллагуудын тэргүүн баходалтайгаар Сталин бол Ертөнцийн Эзэний тушаалыг биелүүлэхээс өөр юу ч хийгээгүй гэж тунхаглана. Тэр Сталиныг хамгийн сайн Библи заадаг багш хэмээн магтаж байлаа! Патраскои, Розианю нар тэднийг бодвол хамаагүй илүү шуурхайлан нууц цагдаагийн ажилтнууд болжээ. Румыны лютеран байгууллагын тэргүүн ламын орлогч Рапп Библийн ерөнхий онолын сургалт семинаруудад Ертөнцийн Эзэн гурван замаар өөрийгөө илчилсэн гэж зааж эхлэв. Ингэхдээ тэрээр нэгдүгээрт Мүшэхээр, дараа нь Есүсээр, сүүлд нь Сталинаар дамжуулан өөрийгөө илчилсэн гэж хэлж байлаа. Сталин өмнөх хүмүүсээсээ хавьгүй илүү агуу ажлыг хийлээ гэж ярьж байв.

Ертөнцийн Эзэнд чин сэтгэлээс итгэсэн, итгэлдээ үхтлээ үнэнч байж, бусдын хийж хэлж байгааг огт хүлээн зөвшөөрөөгүй, миний хайртай тэр цөөхөн хүмүүс хамгийн ихээр зовж байсан гэдгийг та бүхэн ойлгох хэрэгтэй. Ямар ч байсан коммунистууд өөрсдийн удирдагчдыг сонгон тавьсан бөгөөд хөөрхий үнэнч итгэлтэй энэ хүмүүст ямар ч сонголт байсангүй, зөвхөн хүлээн зөвшөөрөх л үлдэв. Энэ байдал өнөөдөр ч гэсэн шашны тэргүүн "удирдагчдын хувьд" энэ хэвээр байгаа гэдэгтэй хэн ч маргахгүй.

Христийн оронд коммунизмыг дэмжин дагах болсон нөгөө хүмүүс өөрсөдтэй нь нэгдэн нийлээгүй ахан дүүсээ хавчин гадуурхаж, түлхэн хаях болов.

Орос оронд хувьсгал ялж коммунистууд засгийн эрхэнд гарсны дараа Христэд итгэгч оросууд нууц бүлэг үүсгэн ажиллаж байсны адил Христэд итгэгчдийн бүлгийн олон ахлагч нар итгэлээсээ урван, коммунизм газар авч байгаа энэ үед бид тэдний адил нууц бүлэг бий болгохоос өөр аргагүй боллоо. Энэ нууц бүлэг нь Христийн авралын тухай үнэн мэдээг тунхаглах, Ертөнцийн Эзэний сургаалыг гажуудуулахгүй заах, хүүхдүүдэд Христийг таниулж ойлгуулах зорилготой байлаа. Коммунистууд энэ бүгдийг хориглоход албан ёсны зөвшөөрөл бүхий байгууллагууд үүнийг хүлээн зөвшөөрч энэ бүхэн хаягдсан асуудал болсон байв.

Бусад хэдэн нөхдийнхөө хамт би Христэд итгэгчдийн нууц бүлгийн ажилд идэвхтэй оролцож эхлэлээ. Би нууц бүлгийн ажилтай ямар ч холбоогүй, би нилээд нөлөө бүхий томхон алба хашиж байсан тул надад сайхан халхавч болж байв. Дэлхий нийтийн Зөвлөлд би Румыны бүлгүүдийг төлөөлсөн төлөөлөгчөөр ажиллахын хажуугаар норвегийн лютеран байгууллагын ахлагчийн үүргийг гүйцэтгэж байв. (Тэр үед энэ байгууллага зөвхөн хүмүүнлэгийн тусlamжийн ажил гүйцэтгэдэг байсан учир энэ байгууллага коммунистуудтай хамтран ажиллана гэж бодож байсан хүн Румынд огт байгаагүй юм.) Энэ хоёр албан тушаал намайг засгийн газрын эрх бүхий хүмүүсийн өмнө нилээд нөлөөтэй болгосон тул тэдний хэн нь ч намайг нууц бүлгийн ажилд идэвхтэй оролцдог гэж мэдэхгүй байв.

Энэ нь хоёр салбартай байлаа.

Эхнийх нь нэг сая орос цэргүүдийн дунд хийж байсан нууц даалгаварт ажил.

Хоёр дахь нь адгийн муу ёрын сүнсэнд боолчлогдон коммунизмд хүлүүлсэн Румыны ард түмний дунд хийж буй ажил байсан юм.

ОРОСУУД — СЭТГЭЛ ЗҮРХ НЬ АНГАЖ ЦАНГАСАН АРД ТҮМЭН

Миний хувьд оросуудад Ертөнцийн Эзэний авралын тухай тунхаглан, зааж сургах нь энэ дэлхий дээрх ер бусын мөнхийн улс мэт байв. Би дэлхийн олон улс үндэстний хүмүүст Есүс Христийн тухай зааж байсан боловч орос хүмүүс шиг сэтгэл зүрхнийхээ цангaaг нэгмөсөн тайлахыг тэмүүлэх мэт асар их хүсэл тэмүүлэлтэй хүлээн авч сэтгэлдээ оруулж байгаа ард түмнийг огт үзээгүй. Тэдний сэтгэл зүрх үнэхээр их ангаж цангаж байсан юм.

Үнэн алдартны шашны байгууллагад сургаал заагч нэг найз маань над руу утасдаад нэг орос офицер итгэснээ хүлээн зөвшөөрч уулзсан тухай хэлэв. Найз маань орос хэл огт мэддэггүй тул ямар ч байсан намайг оросоор ярьдаг гэдгийг мэдэж аваад миний хаягийг түүнд өгөөд явуулжээ. Дараагийн өдөр нь тэр орос манайд ирлээ. Тэр Ертөнцийн Эзэнд үнэхээр хайртай, бас

түүнийг юу юунаас илүү эрхэмлэн хүсдэг хүн байсан боловч хэзээ ч Библи уншиж байгаагүй, тэр бүү хэл барааг нь ч хараагүй ажээ. Тэр Христэд итгэгчдийн хуралд ч очиж үзээгүй хүн байв. (Оросод тэرتээ тэргүй ийм хурал бараг болдоггүй юм.) Библийг албан ёсоор энд тэндхийн сургуульд сураад байсан юмгүй, Ертөнцийн Эзэний талаар өчүүхэн жаахан мэддэг боловч түүнийг бүхнээс илүүд үзэн маш их хайлдаг хүн байв.

Би түүнд Есүсийн уулан дээр заасан сургаал болон түүний ярьсан сургаалт үлгэрүүдээс уншиж өглөө. Түүнийг сонссоныхоо дараа тэр ихэд догдолон их дээр үсрэн өрөөн дотор бүжиглэн чанга цоглог дуугаар хөөр баяр болон,

— Юутай сайхан, юутай гайхамшигтай! Христийг таньж мэдэхгүйгээр би яаж амьд явах билээ! Тэр бол миний амь амьдрал! гэж хашгирч байлаа. Би Христтэй нэгдсэндээ учиргүй их баярлан түүнтэй адил хөөрөн догдолж буй хүнийг урьд өмнө нь огт үзээгүй билээ.

Гэтэл дараа нь би том алдаа хийлээ. Би түүнд ямар ч бэлтгэл болох оршил тавилгүйгээр Христ хэрхэн зовж, эцэст нь цовдлогдон алагдсан тухай уншиж өгөв. Тэр ийм юм болно гэж огт бодоогүй, бүр төсөөлөө ч үгүй байжээ. Тэгээд Христ хэрхэн тамлуулан зовсныг, мөн хэрхэн цовдлогдон нас барсныг сонсоод түшлэгтэй сандал руу гүн шигдэн эхэр татан гүнээ харуусан уйллаа. Тэрээр үнэхээр гайхамшигтай Аврагчид итгэж найдаж байтал тэр нь ийнхүү нас барсан байв!

Би түүнийг хараад өөрөө өөрөөсөө хачин их ичив. Ийм арчаагүй байж би өөрийгөө Христэд итгэгч, бас бусдад Ертөнцийн Эзэний сургаалыг заан дамжуулах чадвартай ахлагч хүн гээд байгаа шүү. Энэ орос офицерийн адил Христийн эдэлж туулсан тэр их зовлонг би мэдэрч байсангүй. Бүр хэзээ ч ингэж мэдэрч байгаагүй гээч. Түүнийг харахад надад Магдал хотын Марь гэгч бүсгүй загалмайн дор гашуудан уйлж байсан нь, мөн түүний булшны дэргэд Есүсийг оршуулсны дараа харуусан уйлж байсныг илчлэх мэт дүр зураг тодхон буув.

Тэгээд дараа нь би түүнд Христийн үхлээс амилсан тухай түүхийг уншиж өглөө. Түүний аврагч Их Эзэн нь үхлээс дахин амилсан гэдгийг тэр мэддэггүй байжээ. Энэ гайхамшигтай сайхан мэдээг сонсоод тэр өвдгөө цохилон миний бодлоор тун

муухай боловч түүний хувьд хамгийн ариунд тооцогдох байдлаар андгай тангараг тавилаа. Тэр угаасаа л иймэрхүү бүдүүлэг үг яриатай хүн байсан юм. Тэгээд тэр дахин учиргүй их баярлаж гарав. Тэрээр,

— Тэр амьд! Тэр амьд! гэж чанга хашгиран хэмжээлшгүй их хөөр баяраар сэтгэл нь дүүрэн өрөөн дотуур тойрон эргэлдэж аз жаргалтайгаа илэрхийлэн бүжиглэн байв!

Би түүнд,

— Одоо хоёулаа Ертөнцийн Эзэнтэй ярья гэж хэлэв. Гэтэл тэр бас Ертөнцийн Эзэнтэй ярина гэж юу болохыг огт мэддэггүй аж. Тэр бидний байнга хэлж заншсан ариун үг хэллэггүүдийг огт мэдэхгүй тул надтай хамт өвдөг сөгдөн суугаад ийнхүү ярилаа. "Аяа, Ертөнцийн Их Эзэн минь! Та яасан дажгүй, сайн залуу вэ! Хэрэв би та байгаад, та би байсан бол би хэзээ ч таны хийсэн гэмийг чинь учлахгүй байсан шүү. Гэвч та үнэхээр сайн залуу байна. Надад хэлэх үг ч олдохгүй нь! Би танд чин зүрхнээсээ маш их хайртай."

Ер бусын элч нар бүгд хийж буй ажлаа орхиод энэ орос офицерийн итгэл төгс яриаг сонсохоор чих тавин байсан болов уу. Энэ хүн Христийг аврагчаа болгон хэдийн түүний хүн болсон байлаа!

Дэлгүүрт би нэг орос ахмад, эмэгтэй офицерийн хамт явж байгаатай тааралдав. Тэд маш олон янзын юм худалдан авч байсан ба худалдагч нь орос хэл мэдэхгүй тул ойлголцох гэж зүдэрч байв. Би тэдэнд тус болж орчуулж өгснөөр танилцлаа. Тэднийг би өдрийн хоолонд урин гэртээ авчрав. Хоолоо идэж эхлэхийн өмнө би тэдэнд,

— Та нар Христэд итгэгчдийн гэрт байна. Бид хооллохын өмнө үргэлж Ертөнцийн Эзэнтэй ярьж талархдаг заншилтай юм аа гэж хэлээд оросоор ярив. Тэд хутга, сэрээгээ доош тавьж хоол идэхээс татгалзав. Тэдний хувьд хоол тэгтлээ сонирхолтой биш байлаа. Тэд Ертөнцийн Эзэн, Христ болон Библийн тухай янз бүрийн юм асууж эхлэв. Тэд үнэхээр юу ч мэддэггүй байжээ.

Тэдэнд энэ бүгдийг тайлбарлан ярина гэдэг амаргүй хэрэг байлаа. Тэдэнд би зуун хоньтой хоньчин нэг хонь нь төөрөн алга болоход хайхаар явдаг хүний тухай сургаалт үлгэрийг ярьж өгөв. Гэтэл тэд ойлгосонгүй,

— Тэр хүн яж зуун хоньтой болсон хэрэг вэ? Коммунистууд ирээд түүнийг нь хураагаад аваад явчихаагүй юм уу? гэж асуув. Тэгэхээр нь би Есүс бол хаан гэж хэлтэл тэд,

— Бүх хаад хүн ардыг дарлан мөлжигч харгис этгээдүүд байдаг. Тиймээс Есүс ч бас тэдний адил дарлан мөлжигч харгис этгээд байх нь гэв. Тэгээд би тэдэнд усан үзмийн талбайд ажиллаж байсан хүмүүсийн тухай сургаалт үлгэрийг ярилаа. Гэтэл тэд,

— За, за. Энэ хүмүүс ч усан үзмийн талбайн ээний эсрэг босч тэмцэн нь сайн хэрэг болж. Усан үзмийн талбай ч бас хамтралын өмч байх ёстой гэдэг юм байна. Тэдний хувьд бүх юм цоо шинэ байлаа. Тэдэнд би Есүсийн төрсөн тухай түүхийг хэлж өгөхөд тэд барууны ямар ч хүн сонссон хараан доромжилж байна гэж хэлэхээр асуултыг,

— Марь чинь тэгээд Ертөнцийн Эзэний эхнэр байсан юм уу? гээд асуучихав. Тэдэнтэй болон өөр бусад олон орос хүмүүстэй ярилцаж үзсэний эцэст би коммунизмын үзэл суртлын дор олон арван жил болсон энэ хүмүүст Христийн авралын тухай тайлбарлахдаа тэс өөр үг хэллэг хэрэглэх хэрэгтэй болохыг ойлгосон билээ.

Төв Африкт очиж Ертөнцийн Эзэний ажлыг хийж буй хүмүүст «Яашяах» номд гардаг «Хэрэв та нарын гэм цус шиг улаан байсан бол тэр үүнийг чинь цаснаас ч цагаан болтол угаан цагаатгаж өгнө» гэсэн үгийг орчуулахдаа хүнд асуудалтай тулгардаг. Цас үзсэн хүн Төв Африкт нэг ч үгүй. Тэдэнд цас гэдэг үг ч байсангүй. Тиймээс тэд энэ үгийг орчуулахдаа «Та нарын гэмийг наргил модны самрын сүү шиг цагаан болтол цагаатгаж өгнө» гэж бичжээ.

Тиймээс бид Христийн тухай үнэн мэдээг марксизмын уг хэллэг рүү хөрвүүлэн тэдэнд ойлгомжтой болгох шаардлагатай болов. Мэдээж бид үүнийг өөрсдийн хүч чадлаар хийж чадахгүй. Гэвч Ариун Сүнс бидэнд туслан ажлаа гайхалтай сайн хийсэн юм.

Ахмад, нөгөө эмэгтэй офицерийн хамт нэг өдөр Христэд итгэн амьдралаа даатгав. Дараа нь тэд бидэнд маш их тус болж оро суудын дунд хийж байсан нууц бүлгийн ажилд ихээхэн нэмэр болсон билээ.

Христийн амьдралын бодит түүхийг өөр бусад Библийн холбогдолтой номнуудын хамт бид орос хэл рүү орчуулан нууцаар хэвлүүлж оросуудын дунд тараадаг байв. Христэд итгэсэн орос цэргүүдийн тусламж дэмжлэгтэйгээр бид Библи болон Библийн номуудыг хэсэгчлэн хэвлэж олноор нь нууцаар хил давуулан орос руу оруулдаг байлаа.

Ертөнцийн Эзэний үгийг оросуудын гарг хүргэхийн тулд бид бас нэг өөр арга хэрэглэдэг байв. Орос цэргүүд олон жил байлдан орон гэрээсээ хол явж байсан тул ихэнх нь ар гэртээ авгай хүүхэдтэй, тэдэнтэйгээ олон жил огт уулзаагүй байдаг байлаа. (Орос хүмүүс ер нь хүүхдэд их хайртай хүмүүс.) Миний хүү Михай болон арваас доош насны нилээд олон хүүхдүүд гудамж талбай, цэцэрлэг гээд олны хөлийн газар халаасандаа Библи, Библийн номууд, эсвэл Библийн холбогдолтой ном, товхимол зэргийг хийн орос цэргүүдтэй уулзахаар очдог байв. Орос цэргүүд тэдний толгойг илж, эелдэгээр ярилцан тоглож олон жилийн турш барааг нь хараагүй өөрсдийн хүүхдүүдтэйгээ адилтган үзэж харьцана. Орос цэргүүд чихэр, шоколад өгөхөд хүүхдүүд хариуд нь халааснаасаа Библи болон бусад номнуудыг гарган өгөхөд тэд тун дуртай хүлээн авдаг байв. Бид өөрсдөө ингэвэл хэтэрхий аюултай байсан боловч харин хүүхдүүд ийм маягаар хийхэд бүрэн аюулгүй байлаа. Тэд бол оросуудын дунд Ертөнцийн Эзэний ажлыг хийгч бяцхан баатрууд байв. Тэдний энэ ажлын үр дүн ч гэж жигтэйхэн. Ийм аргаар маш олон орос цэргүүд Ертөнцийн Эзэний сургаалыг олж мэдэн амьдралаа түүнд даатган өгсөн бөгөөд үүнээс өөр ямар ч аргаар тэд олж мэдэх боломжгүй байсан юм.

ОРОСЫН ЦЭРГИЙН ХУАРАНД

Бид оросуудтай ажиллахдаа зөвхөн ганцаарчлан тулж ажиллах маягаар ажиллаад байсангүй, олон жижиг гэрийн бүлгүүд бас ажиллуулж байв.

Оросууд цагийг маш их сонирхон үздэг улс байв. Тэд хүн болгоноос цагийг нь хулгайлна. Хүмүүсийг гудамжинд саатуулж зогсооход хүмүүс тэдэнд цагаа тайлан өгдөг байв. Оросууд хоёр гартаа хэд хэдэн цаг зэрэгцүүлсэн байгаа нь тун

инээдэмтэй харагддагсан. Орос цэргийн эмэгтэй офицерүүдийн хүзүүнд сэруүлэгтэй цаг байнга дүүжлээстэй харагддаг байлаа. Тэд урьд өмнө нь хэзээ ч цаг хэрэглэж үзээгүй агаад бас хэзээ ч хангалттай цагтай болж чадахгүй улс шиг байв. Цагтай болохыг хүссэн румын хүн байвал орос цэргийн хуаранд очиж хулгайлдсан цагаас худалдан авдаг байлаа. Ихэнхдээ л өөрийнхөө цагийг буцаагаад худалдаад авна. Тиймээс румын иргэд орос цэргийн хуаран руу байнга чөлөөтэй нэвтрэн ордог байв. Нууц бүлгийн бидэнд ч гэсэн цаг худалдан авах гэдэг сайхан далим байдаг байсан тул байсхийгээд л орос цэргийн хуаран руу зүглэнэ.

Гэгээн Павель болон гэгээн Петрийн өдөр болох үнэн алдартны шашны нэгэн их баярын үеэр би орос цэргийн хуаранд орж анх удаа Христийн сургаалыг орос хэлээр заах ородлого хийв. Цэргийн хуаранд би цаг худалдаж авах гэж буй дүр эсгэн орлоо. Үзүүлсэн эхний цаг нь дэндүү үнэтэй байна гэхэд бас өөрийг үзүүлэв. Тэгэхэд нь дэндүү жижигхэн юм, эсвэл дэндүү том юм гэсээр байлаа. Нилээд хэдэн цэрэг намайг тойрч бүчин шавж аль болох өөрсдийн юмыг зарах гэж хичээж байв. Овоо хүн цуглаад ирэхээр нь би тоглоом хийх маягаар,

— Та нарын дотор Павель юмуу Петр нэртэй хүн байна уу? гэж асуув. Зарим нь ч үнэхээр тийм нэртэй байлаа. Тэгээд би цааш нь,

— Өнөөдөр танай үнэн алдартны шашныхны хувьд гэгээн Павель болон гэгээн Петрийн өдөр гэдэг баярын өдөр болохыг та нар мэдэж байна уу? гэж асуув. Хэн ч мэдэхгүй байв. Тэгэхээр нь би тэдэндPuуль, Петр нарын тухай ярьж эхлэв. Нилээд нас тогтсон орос цэрэг намайг түр саатуулан,

— Чи ч цаг худалдаж авахаар ирээгүй бололтой. Харин итгэл үнэмшлийн тухай л ярих гээд байнаа даа. Тиймээс энд бидэнтэй хамт суугаад тухтай, тайван гэгч нь яриадах! Гэхдээ болгоомжтой байгаарай! Бид ч хэнээс болгоомжлохoo сайн мэднэ шүү. Миний эргэн тойронд байгаа энэ эрчүүд бүгд сайн залуус. Хэрэв би гарaa өвдгөн дээр чинь тавибал чи зөвхөн цагны тухай ярих ёстой шүү. Харин намайг гарaa авахад цааш нь Үргэлжлүүлэн итгэлийн тухай ярьж өгөөрэй гэж хэлэв. Миний эргэн тойронд олон эрс суусан байв. Би тэдэнд Puуль, Петр нарын

тухай, бас тэд Христийн төлөө амиа зориулсан тухай ярьж өглөө. Үе үе тэдний итгэдэггүй найдлага муутай залуус дөхөж ирэх ба нөгөө настай эр миний өвдгөн дээр гараа тавингуут би шууд л цагны тухай ярьж эхэлдэг байв. Тэр хүн биднээс холдон одоход би цааш нь гол яриагаа үргэлжлүүлнэ. Христэд итгэдэг орос цэргүүдийн дэмжлэгээр иймэрхүү байдлаар бид олон удаа Христийн сургаалаас заадаг байв. Тэдний хамтран зүтгэгч олон нөхөд нь мөн Христэд итгэн амьдралаа түүнд өгсөн билээ. Христийн сургаалын товхимлыг мянга мянган хүнд нууцаар тараан өгч чадсан юм.

Ингэснийхээ төлөө манай нууц бүлгийн олон гишүүд эр эмгүй баривчлагдан аймшигтай зодуулан тамлуулж байсан боловч тэд хэзээ ч урван биднийг илчлэн барьж өгөөгүй билээ.

Энэ ажлыг хийж байхдаа бид оросын нууц бүлгийн ахан дүүстэйгээ уулзан тэдний туршлагыг сонсон сурх их завшаан тохиолдож байв. Юуны өмнө тэднийг хараад бид анхны итгэгчдийн агуу их зориг хатуужлыг олж харсан юм. Тэд маш олон жилийн турш коммунист суртлаар хүмүүжсэн ч итгэлээ чанд хадгалжээ! Тэдний олонхи нь коммунист үзэл суртлын үүр уурхай болсон их дээд сургуулиудыг дүүргэсэн боловч энэ хугацаанд давсархаг усны загас адил зөвлөн амтлаг чанараа алдалгүй хадгалж ирсэн аж. Хэдийгээр тэд коммунизмыг илт дагагч сургуулиудад сурч боловсрол эзэмшиж байсан боловч амин сүнсээ цэвэр ариун авч явж, Христтэй нэгдсэн энэ харьцаандаа сэв огт суулгаагүй бат найдвартай дагасаар иржээ.

Христэд итгэгч энэ оросууд үнэхээр сайхан сэтгэлтэй, гайхамшигтай хүмүүс байлаа! Тэд,

— Бидний малгайны орой дээр хадаастай байгаа энэ алх хадуур бүхий тэмдэг бол Христийг эсэргүүцэгчийн тэмдэг гэдгийг бид сайн мэднэ гэж хэлэхдээ гүн санаа алдана. Сэтгэл нь ихэд зовж байдгийн илэрхийлэл гэмээр ихэд харуусан энэ тухай өгүүлнэ. Орос цэргүүдийн дунд Христийн сургаалыг дэлгэрүүлэхэд тэд бидэнд маш их тус болсон билээ.

Тэдэнд Христэд итгэгчдэд байвал зохих бүх л чанарууд, сайн давуу талууд байсан боловч ганцхан баяр баясгалан л дутагдаж байдаг гэж хэлж болох. Анх Христийг амьдралдаа оруулан Христийн хүн болохдоо л тэд баяр баясгаланг олж амталж

мэдэрдэг байв. Тэгээд үдалгүй энэ нь замхран алга болно. Энэ талаар би маш их гайхан боддог байлаа. Нэг удаа тэсэлгүй,

— Та нар яагаад баяр баясгалан гэж юу болохыг огт мэддэггүй юм бэ? гээд асуучихав. Тэр надад,

— Би чин сэтгэлээсээ Христэд итгэн, бат дагах хүсэлтэй агаад цаг үргэлж Ертөнцийн Эзэнтэй ярьж, бусдыг Христийн өмнө авчрахыг хичээж явдаг гэдгээ ахлагчдаа хүртэл хэлж чадахгүй нуудаг хүн. Тийм байж яаж баяр жаргалтай байх юм бэ? Манай ахлагч чинь нууц цагдаагийнханд мэдээ дамжуулагч суваг нь юм шүү дээ. Бид чинь бие биенээ тагнаж тандсан байдалтай, дээрээс нь ахлагч нар нь хонин сүргээсээ уrvан няцдаг хүмүүс байдаг юм. Бидний сэтгэл зүрхний гүнд, бүр далд газар авралын баяр баясгалан гэдэг чинь байдаг. Та нартай адил ил тодор илэрхийлэх боломж бидэнд байхгүй гэж хариулсан билээ.

Цааш нь,

— Христэд итгэнэ гэдэг бол бидний хувьд эмгэнэлт хэргийг дагуулдаг хэрэг болсон. Та нар эрх чөлөөтэй байхдаа хэн нэгнийг Христийн өмнө авчирлаа гэхэд нөхөд чинь баярлан тэр аяараа хөөр баяр болно. Харин бид хэн нэг хүнийг Христийн өмнө авчирлаа гэвэл үүнээсээ болоод тэр хүн широнд орж, үр хүүхэд нь өнчин өрөөсөн амьтад болж хоцрох аюул байгааг мэдэж байдаг юм шүү дээ. Энэ бол бодитой аюул учир байхгүй гээд үгүйсгээд байж болдоггүй юм даа. Хэн нэг хүн Христэд итгэлээ гэхэд бид хөөр баяр болохын хажуугаар тэр бас төлөөс төлөх хэрэгтэй болно гэдгийг мэдэх тул гунигтай сэтгэгдэл давхар төрдөг юм гэж байв.

Христэд итгэгчдийн цоо шинэ нэг эрин үетэй бид золгочих шиг боллоо. Энэ бол нууц бүлгийн эрин үе байв.

Бидэнд маш олон гэнэтийн хэрэг явдлууд тохиолдоно.

Бидний олонхи нь өөрсдийгөө Христэд итгэгчид л гэж бодож байдаг боловч үнэн чанартaa тийм биш, жинхэнэ итгэлтэй хүн тун цөөн байдагтай адил өөрсдийгөө шашингүй үзэлтэй гэж итгэсэн хүмүүсийн ихэнх нь үнэн чанартaa тийм биш байдгийг бид олж мэдсэн.

Миний өмнө нэг орос гэр бүл сууж байлаа. Тэд хоёул уран барималчид ажээ. Намайг тэдэнд Ертөнцийн Эзэний тухай ярьж өгөхөд тэд,

— Үгүй дээ, үгүй. Ертөнцийн Эзэн гэж байдаггүй юм. Бид чинь "безбожники"-Ертөнцийн Эзэнгүй улс. Гэхдээ бид танд өөрсдөө тохиолдсон сонирхолтой явдлын тухай ярьж өгье гэв.

Нэг удаа бид Сталины хөшөөн дээр ажиллаж байлаа. Ажлаа хийгээд байж байтал эхнэр маань надаас,

— Нөхөөр, эрхий хуруу гэж сонин юм шүү, тийм ээ? Хэрвээ эрхий хуруу бусад хуруунуудынхаа адил байрлалтай, эсвэл хөлийн хуруунуудтай адил байсан бол бид алх, лантуу гээд ямар ч багаж барьж чадахгүй, тэр байтугай талх, ном гээд ер нь юу ч барьж чадахааргүй байх байсан биш үү? Энэ жижигхэн хуруугүй бол хүний амьдралыг төсөөлөх ч юм биш. Амьдрах боломжгүй байхсан. Харин хэн энэ эрхий хурууг хийсэн юм бол? Бид хоёр хоёулаа марксизмын онолыг сургуульд байхдаа судалсан даг. Мөнхийн зовлон, мөнхийн улс гэдэг чинь өөрсдөө бол байдаг. Гэхдээ Ертөнцийн Эзэн тэднийг бүтээгээгүй. Ингэж л заалгасан юм чинь үүнд л итгэхээс өөр яахав. Гэтэл хэрвээ Ертөнцийн Эзэн тэднийг өөрөө бүтээгээгүй юм бол, хэрвээ тэр зөвхөн эрхий хурууг л бүтээсэн юм бол ийм өчүүхэн юмыг тун мэргэн бүтээснийхээ төлөө сайшаан магтуулах ёстай биз дээ? гэж асуув.

— Цахилгаан гэрэл, чийдэн, утас, төмөр зам гээд л янз бүрийн нээлт хийсэн Эдисон, Белл, Стефенсон нарын эрдэмтдийг бид магтан сайшаадаг шүү дээ. Гэтэл яагаад энэ эрхий хурууг бүтээсэн тэр хүнийг бид магтан сайшааж болохгүй гэж? Хэрвээ Эдисонд эрхий хуруу байгаагүй бол тэр лав ямар ч нээлт хийж чадахгүй байхсан. Тийм болохоор эрхий хурууг бүтээсэн Ертөнцийн Эзэнийг магтан хүндлэх нь цорын ганц сайшаалтай, зөв хэрэг болох юм байна гэв.

Тэгтэл нөхөр нь учиргүй их уурлажээ. Ер нь эхнэрүүд ухаалаг мэргэн зүйл хэлэхэд ихэнх нөхрүүд ийнхүү дэлбэртлээ уурладаг.

— Битгий тэнэг юм яриад бай! Ямар ч Ертөнцийн Эзэн байдаггүйг чи өөрөө сурч мэдээ биз дээ? Энэ байшинд чагнах төхөөрөмж тавьчихаад хэн нэг нь чагнаж байгаа ч юм билүү,

чи яаж мэдэж байгаа юм? Зүгээр байж байгаад хэрэг төвөгт унамааргүй байна шүү. Ертөнцийн Эзэн гэж огт байдаггүйг наад тархи толгойдоо сайтар шингээж ав. Тэгээд энэ тэнэг бодлоо бүрмөсөн март. Мөнхийн улсад чинь хэн ч байдаггүй юм гэж хариу барив.

Тэгтэл тэр хариуд нь,

— Үүнээс ч илүү гайхах юм бас байнаа. Хэрвээ мөнхийн улсад бидний эцэг өвгөдийн тэнэглэн итгэж байсан тэр Ертөнцийн Эзэн, бүхнээс эрхэм дээд Их Эзэн үнэхээр байдал бол бид эрхий хуруутай төрөх нь гарцаагүй хэрэг биш үү? Бүхнээс агуу Ертөнцийн Эзэн юм чинь бүгдийг хийж чадна биз дээ? Түүний хувьд хийж чадахгүй юм гэж байдаггүй биз. Тийм болохоор тэр эрхий хурууг лав хийж чадна. Гэтэл харин мөнхийн улсад хэн ч байдаггүй юм бол би дотоод сэтгэлээсээ эрхий хурууг бүтээсэн тэрхүү "Хэн ч бишийг" чинь дээдлэн хүндлэхээр шийдэж байна гэлээ.

Тэгээд тэд "Хэн ч бишийг" бишрэн дээдлэгчид болжээ! Энэхүү "Хэн ч биш"-д итгэх тэдний итгэл цаг улирах тусам батжин ганц эрхий хуруугаар зогсохгүй од гариг, цэцэг ургамал, хүүхдүүд гээд амьдралд байдал аливаа сайхан бүхнийг тэр бүтээсэн гэдэгт итгэх болжээ.

Тэд эрт дээр цагийн Афин хотынхны адил санагдаж байлаа. Пууль тэр хотод байхдаа "Үл мэдэгдэх бурханд" гэсэн бичиг олж үзсэн.

Тэдний итгэсэн энэхүү "Хэн ч биш" нь мөнхийн улсад үнэхээр бодитой оршин байдал Ариун Сүнс болох Ертөнцийн Эзэн бөгөөд тэр хайр, мэргэн ухаан, хүний амьдралын цорын ганц үнэн болоод хүч чадлаар дүүрэн Их Эзэн, тэднийг үнэхээр их хайрласан учир өөрийн цорын ганц хайртай хүүг илгээн өөрөө тэдний төлөө загалмайд цовдлогдон аврах болсон тухай ярьж тэдний ийнхүү итгэсэн нь туйлын зөв хэрэг болсон гэдгийг ярихыг сонсоод тэд маш их баярлаж байв.

Тэд Ертөнцийн Эзэнд итгэж байна гэдгээ өөрсдөө мэдэхгүй л байснаас биш түүнд итгэсэн хүмүүс байлаа. Харин би тэднийг нэг алхам урагшлахад нь туслан гэмээ ухааран хаяж, Ертөнцийн Эзэний өмнө ирэн Христийн хүн болохыг нь харах аз тохиосон хүн болов.

Нэг удаа би нэг орос офицер эмэгтэйтэй гудамжинд тааралдаад ойртон очиж,

— Танихгүй эмэгтэй хүнтэй гудамжинд ийнхүү хоргоон ярилцах нь туйлын зохисгүй бүдүүлэг хэрэг гэдгийг би мэдэж байна. Гэвч би Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч хүн, тантай ярихыг чин сэтгэлээсээ хүсч байна. Би танд Христийн тухай хэлж өгмөөр байна гээд хэлж амжив.

Тэр надаас,

— Та Христэд үнэхээр хайртай юу? гэж асуухад нь би,

— Тиймээ! Чин зүрхнээсээ үнэхээр их хайртай! гэв. Тэгтэл тэр намайг тэвэрч аваад үнсч гарлаа. Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч хүний хувьд энэ нь туйлын ичгэвтэр харагдах хэрэг байсан тул би түүнийг эргэн үnsэв. Хүмүүс биднийг хамаатан садан улс байна гэж бодоосой л гэж найдаж байлаа. Тэр надад,

— Би ч бас Христэд үнэхээр их хайртай! гээд дуу алдан баярлаж байгаа нь илт байв. Би түүнийг гэртээ урьж авчирлаа. Тэгээд түүнтэй ярилцаад тэр энэ нэрнээс өөр Христийн талаар огт юу ч мэдэхгүй болохыг нь олж мэдээд тун их гайхав. Нэрнээс нь өөр юу ч мэдэхгүй боловч тэр түүнд үнэхээр их хайртай ажээ. Тэр бол Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагч гэдгийг, мөн аврал гэж юу болохыг, тэр хэрхэн энэ дэлхийд амьдарч байгаад, хэрхэн нас барсан тухай нь бас юу ч мэдэхгүй. Тэр түүний зааж байсан сургаал, туулж өнгөрүүлсэн амьдрал, хийж байсан ажлынх нь талаар хумсын толионы төдий ч мэдлэггүй байв. Тэр миний хувьд сэтгэл санааны талаас нь авч үзвэл их хачирхалтай хүн шиг санагдаж байлаа. Үнэндээ нэрнээс өөр юу ч мэдэхгүй хүнээ яж хайрлаж болдог байна?

Тэгээд түүнээс лавлан тодруулах санаатай асуутал тэрээр,

— Намайг бүр жаахан хүүхэд байхад зураг харуулж уншуулж сургасан юм. А үсэг байвал алим. Б үсэг байвал бамбааруш. В үсэг байвал ваар гэх мэтээр уншина. Харин намайг ахлах сургуульд орсны дараа тэд надад коммунист эх орноо хамгаалан зүтгэх нь иргэн бүрийн биелүүлэх ёстой ариун үүрэг гэж сургасан. Коммунист ёс суртахууны талаар би олон юм сурсан. Гэвч би коммунист ёс суртахуун, "ариун үүрэг" гэдэг нь чухам юу болохыг огт мэдэхгүй, хараа ч үгүй байсан юм. Надад энэ бүхнийг дүрслэн үзүүлэх бодит зураглал хэрэгтэй байлаа. Тэр

Үед миний өвөг дээдэс амьдралын баяр жаргалтай, сайн сайхан, шудрага үнэн, магтан сайшаагууштай бүхнийг зураглан дүрсэлдэг байсныг би сайн мэднэ. Эмэг эх маань үргэлж нэг зургийн өмнө бишрэн хүндэлдэг байсан агаад надад үүнийг "Христ" гэдэг юм гэж хэлдэг байв. Тэгээд л би энэ нэрийг учиргүй их хайрладаг болсон юм. Энэ нэр миний хувьд туйлын бодитой байдаг юм шүү! Зөвхөн энэ нэр ямар ч хүнд ер бусын сайхан баяр баясгалан өгч чадна гээч! хэмээн тайлбарлав.

Түүний яриаг сонсон суухдаа би «Филиппий хотынхонд бичсэн захидал» номд "хүн бүр түүнийг нэрийг сонсоод өвдөг сөгдөн хүндэтгэх болно" гэж бичсэн байдгийг саналаа. Христийг эсэргүүцэгч цаг хугацаа улиран одоход хэзээ нэгэн цагт хүн төрөлхтний ой ухаанаас Ертөнцийн Эзэний тухай мэдлэгийг бүрмөсөн арчаад хаяж болох л юм. Гэвч Христ хэмээх энэ энгийн нэг нэр асар их хүч чадалтай агаад ямар ч хүнд гэрэл гэгээ өгч, ухааран ойлгох чадвар хайрладаг юм.

Зөвхөн нэрийг нь сонсоод л хайрладаг байсан тэр Их Эзэн одоо сэтгэлд зүрхэнд нь, амьдралд нь бодитой оршин байгааг, мөн ганц нэрнээс гадна өөр олон зүйлийг мэдэх болсондоо тэр маш их баяртай байлаа.

Оросуудтай учирч байсан цаг мөч, тэдэнтэй хамт өнгөрүүлсэн он жилүүд маань надад асар гүн гүнзгий агуулга бүхий шүлэг найрагтай зүйрлүүлбэл оргил үе минь байлаа.

Төмөр замд ажилладаг итгэл нэгт нэг өмэгтэй Христийг сонирхож байгаа нэг офицерт миний гэрийн хаягийг өгөөд явуулсан байв.

Нэг орой тэр манайд ороод ирлээ. Өндөр нуруутай, царайлаг орос хурандаа байв.

Би түүнээс "Танд яаж туслах уу?" гэж асуув.

Тэрээр, "Би гэрэл гэгээ хүсч ирлээ" гэж хариулав.

Би түүнд Христийн сургаалын хамгийн чухал хэсгүүдээс уншиж өглөө. Тэр гараа миний гар дээр тавиад "Би чин сэтгэлээсээ танаас ганц л юм гүйя. Намайг буруу зам руу бүү хөтлөөрэй. Би тас харанхуйд боолчлогдож буй ард түмний хүү. Надад хэлээч, энэ үнэхээр Ертөнцийн Эзэний үг мөн үү?" гэж асуулаа. Би түүнд энэ бол үнэхээр Ертөнцийн Эзэний үг мөн болохыг батлан хэлэв. Тэр надтай олон цаг илэн далангүй ярилцан

сонссоны эцэст Христэд зүрх сэтгэлээ нээн өгч, түүнийг амьдралдаа орууллаа.

Итгэл бишрэлийн асуудалд оросууд мухар сүсгийн үүдиээс эсвэл хөнгөн хуумгай ханддаг улс огтоос биш билээ. Хэрэв тэд итгэл бишрэлийг эсэргүүцэн тулалдаж байсан бол, хэрэв тэд итгэлийнхээ төлөө, Христийг танъж мэдэхийн төлөө тэмцэлдэж байсан бол үүнийхээ төлөө бүхнээ зориулдаг, амин сүнсээ ч тавиад туучихдаг эрс шулуухан зантай хүмүүс. Тийм учраас орост Христэд итгэсэн хүн бүр өөрийгөө бусдыг Христийн өмнө авчрах үүрэгтэй гэж ямагт үзнэ. Тийм учраас орос орноос өөр Христэд итгэхэд үнэхээр бэлэн болсон, хүмүүс нь Христийг, амьдралын цорын ганц үнэнийг чин сэтгэлээс эрэн хайж байгаа улс орон байхгүй. Оросууд цаанаасаа л Ертөнцийн Эзэнд итгэх ёстой төрсөн улс шиг санагдана. Угаасаа итгэлийн асуудалд хөнгөн хуумгай хандан, хоёр нүүр гаргана гэж барагтай бол үгүй. Хэрэв бид бүхий л хүч чадлаараа Христийн тухай үнэн мэдээг бүх хүн төрөлхтөнд тунхаглаж чадвал энэ дэлхий тун хурдан гайхамшигтай өөрчлөгдхөксөн.

Орос орон, оросын ард түмэн Ертөнцийн Эзэний угийг хүсэн тэмүүлэн ангаж цанган байгаа боловч тэр чигт нь тэднээс үүнийг нь ор мөргүй болтол нь арчаад хаясан мэт Христийн мэдээг хүргэхгүй байгаа нь хачин эмгэнэлтэй хэрэг шиг санагдана.

Галт тэргэнд явж байтал нэг орос офицер миний урд ирээд суув. Би түүнтэй Христийн талаар ярилцаад хэдхэн хором болж байтал тэр гэнэт шашингүй үзлээ илт хамгаалан гарaa даллан маргалдаж эхлэв. Маркс, Сталин, Волтер, Дарвин гээд өч төчнөөн хүний хэлсэн үгсээс иш татан Библийг үгүйсгэх гэж байдгаараа хичээн байв. Эдгээр үгс нь түүний аманаас ус урсах мэт зогсолтгүй гарна. Надад түүнийг эсэргүүцэн үг хэлэх ч боломж олгосонгүй. Ертөнцийн Эзэн гэж огт байдаггүй хэмээн батлах санаатай бараг бүтэн цаг ярилаа. Түүнийг яриагаа дуусахад би түүнээс “Хэрвээ Ертөнцийн Эзэн байдаггүй юм бол та нар яагаад зовлон зүдгүүрт орохоороо түүнээс тусlamж гуйдаг юм бэ?” гэж асуув. Хулгай хийж байгаад баригдсан хулгайч гайхахын адил “Намайг Ертөнцийн Эзэнтэй ярьдаг гэж чи яаж мэдэж байгаа юм?” гэлээ. Би ч түүнд зугтах боломж өгөхгүйг хичээн “Би эхлээд танаас асуусан шүү. Яагаад та тусlamж гуйдаг

юм бэ? Хариулаач!“ гэв. Тэр толгой гудайн “Фронтын шугам дээр германчуудад бүслэгдсэн байх үедээ бид Ертөнцийн Эзэнээс тусламж гүйсан! Бид яаж ярихаа мэдэхгүй байсан болохоор“Ертөнцийн Эзэн, ер бусын бүх сүнснүүдийн эх минь,“ гээд гүйж гарсан юм“ хэмээн аргагүй хүлээн зөвшөөрөв. Ямар ч байсан энэ нь зүрх сэтгэлийг тольdon харж сонсч байдаг түүний чихэнд чимэгтэй байж таалагдсан байх.

Оросуудын дунд хийж байсан бидний ажил их үр дүнтэй болж байлаа.

Би Петрийг маш сайн санаж байна. Оросын аль широнд тэр нас барсныг мэдэх хүн нэг ч үгүй. Тэр залуу, тун залуу хүн байсан юм! Магадгүй дөнгөж л хорь хурч байсан байх. Тэр орос цэргүүдийн хамт Румынд ирээд байлаа. Нууц бүлгийнхний хурлын үеэр тэр Ертөнцийн Эзэний замаар баттай явах шийдвэр гарган итгэснээ харуулан надаар угаалган батлуулсан билээ.

Усаар угаан баталсныхаа дараа би түүнээс Библийн аль уг түүнд онцгой ихээр нөлөөлөн ийнхүү Христэд амьдралаа зориулах шийдвэр гаргахад хүргэснийг асуулаа.

Тэгтэл тэр нууц хурлуудын нэгэн дээр «Луух» номын 24-р бүлгээс хоёр дагалдагч нь Еммай тосгон руу явж байхад нь Есүс тэдэнтэй уулзсан тухай уншихыг маш анхааралтай сонссон ажээ. Тэднийг тосгонд ойртон очиход тэрээр тэднээс салан цааш явах гэж байв. Петр, “Яагаад Есүс ингэж хэлсэн юм бол гэж би гайхаж байна. Тэр мэдээж дагалдагч нартайгаа хамт байхыг хүсч байсан нь лав. Гэтэл яагаад цааш явахыг хүсч байна гэж хэлсэн юм бол? Харин би үүнийг тайлбарлахдаа Есүс үнэхээр эелдэг дөлгөөн хүн байсан гэж бодсон юм. Тиймээс түүнийг тэд хамт байгаасай гэж хүсч байна уу үгүй юу гэдгийг баттай мэдэхийг хүссэн. Тэд түүнийг маш их хүсч урьж байгааг хараад тэр баяртайяа хамт байшинд орсон. Харин коммунистууд бол эелдэг зөвлөн сэтгэл гэж огт байхгүй, их түрэмгийн улс. Тэд бидний сэтгэл зүрх, оюун ухаанд хүчирхийлэн орж ирдэг. Өглөө Үүр цайхаас эхлээд үдшийн бүрийн болтол өөрсдийн суртал ухуулгыг бидэнд хүчээр байнга сонсгож байдал. Тэд сургуулиуд, радио, сонин сэтгүүл, зурагт хуудас, кинонууд, шашингүй үзлийг хөхүүлэн дэмжих хурал зөвлөгөөн гэх мэтээр байгаа болгоныг ашигладаг. Хүссэн ч, хүсээгүй ч, дуртай ч бай, дур-

гүй ч бай хүн бүр тэдний Ертөнцийн Эзэнийг үгүйсгэн басамжилсан суртал ухуулгыг өдөржин шөнөжин сонсох болдог. Харин Есүс бол бидний эрх чөлөөг хүндэтгэн үздэг. Тэр үүдний дэргэд зогсоод хаалгыг аяархан тогшдог. Есүсийн зөвлөн эелдэг зан чанар намайг бүрэн эзэмдэн дийлсэн юм“ гэж хэллээ. Коммунизм болон Есүс Христийн хооронд орших энэ үл ялих ялгаа түүнийг бүрэн итгүүлж чадсан билээ.

Есүсийн энэ зан чанарыг ойлгон сэтгэл нь Христэд татагдах болсон орос хүн бол ганц Петр биш. Өөр олон орос хүн түүний энэ чанарыг олж харсан байдаг. (Харин би ахлагч байж хэзээ ч тэдний адил үүнийг олж хараагүй.)

Христэд итгэх болсноосоо хойш Петр олон удаа Румынаас орос руу хил давуулан Библи, Библийн холбогдолтой номуудыг оруулах нууц бүлгийн ажилд туслан амь нас, амьдралаа аюулд учруулан явж байсан юм. Эцэст нь тэр баригдсан ба 1959 онд широнд байгаа сураг сонсогдох байв. Одоо тэр ясан бол? Аль хэдийн нас бараад одоо мөнхийн улсад Их Эзэнтэй хамт байгаа болов уу? Эсвэл энэ дэлхий дээр эсэн мэнд Их Эзэний төлөө үнэнч зүтгэсээр байгаа болов уу? Би үнэхээр мэдэхгүй. Тэр өнөөдөр хаана байгааг зөвхөн Ертөнцийн Эзэн л мэднэ.

Христэд итгэгч болсныхоо дараа олон хүн түүний адил зүгээр суугаагүй юм. Бид бусдад Христийн үнэнийг тунхаглан амьдралд нь гэрэл өгөгч Ертөнцийн Эзэн рүү эргүүлэн авчрахаа хэзээ ч зогсоохгүй хийсээр байх үүрэгтэй. Ийнхүү Христийн өмнө авчирч итгүүлснээр та ажлынхаа зөвхөн талыг нь хийж байгаа хэрэг. Энэ үүргээ бүрэн дүүрэн биелүүлэхийн тулд та түүнийг бусдад үнэнийг тунхаглагч болгох хэрэгтэй. Оросууд Христэд итгэн амьдралаа өгөөд зогсоохгүй манай нууц бүлгийн идэвхитэй гишүүд болсон билээ. Тэд Христийн төлөө зогсоо чөлөөгүй зүтгэж, түүний төлөө амь өрссөн аюулын өөдөөс ч шантрахгүй зүтгэсээр байсан бөгөөд өөрсдийг нь аврахын тулд амиа өгсөн Христийн хийсэн бүхэнтэй харьцуулахад тэдний хийж буй бүхэн өчүүхэн жаахан хэрэг гэж хэлдэг улс байв.

БООЛЧЛОГДСОН АРД ТҮМНИЙ ДУНД

Бидний нууц бүлгийн ажлын хоёр дахь хэсэг нь боолчлогдож буй Румыны ард түмний дунд хийгдэж байв.

Тун удалгүй коммунистууд багаа тайлан үнэн дүр төрхөө харуулж эхэллээ. Эхлээд тэд Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч, ажилтнуудыг талдаа татахын тулд уран аргаар уяраан мэхэлж байсан бол харин одоо аюул заналхийлэл өрнөн тэднийг мянга мянгаар нь баривчилж байв. Хэн нэгэнд Христийн тухай тунхаглан итгүүлэх нь бидний хувьд оросуудынхтай адил эмгэ-нэлтэй хэрэг болж хувирлаа.

Нэг их удалгүй би шоронд орсон бөгөөд тэнд Христэд итгэхэд нь миний тусалж байсан нөхөд маань хамт хоригдож байв. Тэдний нэг болох зургаан хүүхэдтэй эхнэрээ орхиод Христэд итгэснийхээ төлөө шоронд хоригдож буй эр надтай хамт нэг өрөөнд байлаа. Түүний эхнэр хүүхдүүд нь өлсгөлөнгийн байдалтай амьдарч байв. Тэр тэднийгээ дахиад хэзээ ч олж харахгүй, тэдэнтэйгээ уулзахгүй ч байж магад. Би түүнээс“Би танд Христийн тухай ярьж энэ замаар дагуулсан учир надад гомдох сэтгэл төрж байна уу? Ингээгүй байсан бол гэр бүл чинь ийм аймшигтай байдалд орохгүй байх байсан шүү дээ!” гэж асуухад тэр,“Аугаа гайхамшигтай Аврагчтай минь намайг танилцуулж өгсөн танд би хэрхэн яаж талархаахаа огт мэдэхгүй байна. Хэрвээ та надад хэлж өгөөгүй бол би хэзээ ч олж мэдэхгүй өнгөрөх байсан юм шүү!” гэж хариу өчив.

Шинэ нөхцөл байдалд дасан зохицон сургаалаа заан түгээсээр байна гэдэг амаргүй хэрэг байлаа. Ямар ч байсан коммунистуудын хатуу харгис шалгуураар шалгуулж байж нилээд хэдэн товхимол хэвлүүлж чадав. Бид нэг товхимолынхоо хавтасны зурагт коммунизмыг үндэслэгч Карль Марксын зургийг тавиад коммунистуудад шалгуулахаар өгөв. Гарчигаа өгөхдөө бид“Шашин бол хүмүүсийг мунхруулагч хар тамхи“ гэх мэт бүрхэг утгатай үгсийг хэрэглэсэн байв. Тэр тэднийг хараад коммунист үзэл суртал бүхий ном байна гэж ойлгосон тул тамгаа даран баталгаажуулж зөвшөөрөл олгов. Эдгээр товхимлын эхний хэдэн хуудаснуудад бид мэдээж шалгагч нарт таалаг-

дах Маркс, Ленин, Сталин нарын хэлсэн үгсээс иш татан тавьж дараагаар нь Христийн сургаалыг бичиж байв.

Нууц бүлэг маань бүрэн нууцлагдмал байдалтай биш байлаа. Мөсөн уулын адил хийдэг ажлынх нь өчүүхэн хэсэг л олны нүднээ ил үзэгдэхээр байна. Коммунистуудын жагсаал цуглаан хийж буй газар бид очиж өнөөх “коммунист” ухуулгын товхимлуудаа тараадаг байв. Марксын зургийг харсан коммунистууд нөгөө товхимлыг худалдан авах гэж бие биесээсээ өрсөн зүтгэнэ. Тэгээд эхнээс нь уншсаар аравдугаар хуудаснаас эхлээд тэд Ертөнцийн Эзэн болон Есусийн тухай унших тэр мөчид бид аль хэдийн холдож сураггүй болж амждаг байв.

Ийм шинэ нөхцөл байдалд сургаал заана гэдэг тун хэцүү. Манай ард түмэн асар ихээр дарамтлуулж байв. Коммунистууд хүн болгоноос бүх юмыг хураан авч хоосолж байлаа. Фирмчний тариан талбай, мал сүргийг нь бэлчээрийнх нь хамт, үсчин, оёдолчин гэх мэт хүмүүсийн ажлын бяцхан байрыг хүртэл юу ч үлдээлгүй хураан авсан байв. Зөвхөн капиталист баячуудын хөрөнгийг албадан хураасангүй, өмссөн хувцаснаасаа өөр юмгүй ядуус хүртэл үүнд нь өртөн зовж байлаа. Айл бүрээс бараг дор хаяж нэг хүн широнд сууж байсан төдийгүй ядуурал дээд цэгтээ хүрэв. Хүмүүс хaa сайгүй л “Энэрэл хайр дүүрэн Ертөнцийн Эзэн яаж ийм адгийн бузар хэрэгт ялалт байгуулах зөвшөөрөл олгодог байна?” хэмээн асуун гайхацаана.

Есус Христ загалмайд цовдлогдоод байхдаа “Ертөнцийн Эзэн минь, Ертөнцийн Эзэн минь! Та намайг юунд орхив?” хэмээн чанга хашгираад нас барсан тэр нэгэн баасан гаригт ч гэсэн анхны төлөөлөгчид Христийн үнэнийг тунхаглаж чадахгүй болтлоо хэцүү байдалд орж байсан билээ.

Гэвч Ертөнцийн Эзэний хийх ёстой байсан ажил дууссан хэмээх ганц үнэн баримт нь хийсэн бүхэн маань бидний хийсэн ажил биш, харин Ертөнцийн Эзэний хийсэн ажил болохыг баталж буй хэрэг билээ. Тийм учраас иймэрхүү асуултуудад Христэд итгэгчид хялбархан хариу өгч чадах ажээ.

Бидний одоогийнхтой адил байдалтай байсан хөөрхий ядуу Лаазар дарамтад орон өлсөж, цанган, шархaa нохдод долоолгон үхэж байсан боловч эцэст нь ер бусын элч нар ирж түүнийг аваад Авраахам өвгийнх нь өвөр дээр суулгасан билээ.

БАГА Ч АТУГАЙ ИЛ ТОД АЖИЛЛАСАН ТУРШЛАГААС

Христэд итгэгчдийн бүлгийнхэн нэг нэгнийхээ гэрт, ой монднд, байшигийн хонгилд гэх мэтээр нууцаар уулзаж болох газар хаа байна тийш очиж хуралддаг байв. Тийнхүү нууцаар цугласан байх үедээ бид “ил тод” хийх ажлаа төлөвлөн бэлтгэдэг байлаа. Коммунистуудын хяналт хатуу ч гудамжинд ил тод сургаал заах арга боловсруулж аваад энэ аргаа ашиглан олон хүнд Ертөнцийн Эзэний үнэнийг хүргэж амжсан ба яваандаа энэ нь дэндүү амь өрссөн хэрэг болж хувирав. Тэдний дотор өөр ямар ч аргаар энэхүү гайхамшигт мэдээг сонсож чадахгүй хүн олон байсан. Эхнэр минь ийм ажилд их идэвхтэй оролцно. Христэд итгэгч хэсэг хүмүүс гудамжны хаа нэгтээ буланд очоод тойрон зогсч магтан дуулж эхлэхэд хүмүүс уянгалаг таатай тэр сайхан дууг сонирхон цуглахад эхнэр минь Христийн тухай ярьж эхэлнэ. Эргүүлийн цагдаа нар хүрч ирэхээс өмнө бид тэндээс амжин зайлан оддог байв.

Нэг өдөр намайг хaa нэгтэй завгүй гүйж байх зуур эхнэр минь Бухарест хотод байх Румыны хамгийн том үйлдвэрийн газар болох МАЛАКСА-ийн үүдэнд зогсоод мянга мянган ажилчдад Христийн тухай тунхаглав. Үйлдвэрийн ажилчдад тэр Ертөнцийн Эзэн болон түүний авралын тухай дэлгэрэнгүй ярив. Гэтэл дараагийн өдөр нь коммунизмын шудрага бус байдлыг эсэргүүцэн тэмцсэнийхээ төлөө энэ үйлдвэрийн олон ажилчид буудуулан нас барцгаалаа. Тэд яг цагаа олж Христийн үнэнийг сонсож чадсан билээ.

Бид хэдийгээр нууцаар үйл ажиллагаа явуулдаг байсан боловч усаар угаан батлагч Жоганы адил олон түмэнд болон засгийн эрх баригчдад ил тод үгээ хэлдэг байв.

Нэг өдөр Христэд итгэгч хоёр залуу засгийн газрын ордны шатны ойролцоо явж байгаад олны дундуур зүтгэсээр байж ерөнхий сайд Георгию Дейтэй уулзаж амжив. Цаг хугацаа тун богино байсан боловч тэр хэдхэн хормыг ашиглаад түүнд Христийн тухай ярьж, өөрийн хийсэн гэмээ ухааран хаяж, Ертөнцийн Эзэний хүмүүсийг хавчихаа болихыг анхааруулж амжлаа. Аймшиггүй зоригтойгоор Христийн тухай ярьсных нь улмаас тэр

тэднийг баривчлуулан шоронд хийв. Бүр хэдэн жилийн хойно нөгөө ерөнхий сайд Георгио Дей хүндээр өвчилж, тэртээ хэдэн жил зориг гарган Ертөнцийн Эзэний үр мэт үгийг сэтгэлд нь суулгасныхаа төлөө шоронд суун олон жилийн турш зовсон тэдний ажил талаар болсонгүй үр дүн гарлаа. Яах ч аргагүй зовлонд унаад байхдаа ерөнхий сайд тэртээ хэдэн жилийн өмнө өөдөөс нь эгцлэн хараад зоригтой хэлсэн тэдний үгсийг санаж эхлэв. Тэр үгс яг л Библид дүрслэн хэлсэн байdag шигээ“хоёр талдаа иртэй ямар ч хурц сэлмээс илүү хурдан агаад хүч чадалтайгаар“ сэтгэл зүрхэнд нь нэвтрэн орж байлаа. Тэр үгс түүний хатуурсан харгис зүрх сэтгэлийг нэвт зүсэн орж, эцсийн эцэст тэр Христийн өмнө буuj өгөн амьдралаа түүнд тушаасан юм. Тэр гэмээ хүлээн зөвшөөрч, ухааран хаяад түүнийг өөрийн Аврагч Их Эзэнээ болгон амьдралдаа оруулаад өвчин шаналалдаа баригдан зовж байсан ч түүний төлөө өөрийгөө зориулан зүтгэсээр байсан билээ. Тэр удалгүй нас барсан боловч төлөөсийг нь төлөхөд бэлэн байсан зоригт хоёр эрийн ажлын үр дүнд одоо өөрийн Аврагч Их Эзэнтэйгээ хамт байхаар болжээ. Өнөөдөр ч гэсэн коммунист дэглэм ноёрхсон улс оронд буй Христэд чин сэтгэлээсээ итгэсэн хүмүүсийн байдал ямар байгааг энэ хоёр залуу үзүүлсэн юм.

Ийнхүү нууц бүлгийнхэн маань үйл ажиллагаагаа зөвхөн нууц далд байдлаар хийгээд явсангүй харин зоригтой шийдэмгий байдлаар коммунистуудын нүдэн дээр гудамжинд, коммунизмыг дэмжигч удирдагчдад Христийн үнэн мэдээг ил тод тунхаглан мэдуулсээр байсан билээ. Үүнийг хийснийхээ төлөө шийтгэл амсах нь зайлшгүй байсан ч бид тэр шийтгэлийг эдлэхэд бэлэн байв. Эдүгээ нууц бүлгийн гишүүд бид ямар ч шийтгэлийг амсахад бэлэн хэвээр.

Өөрсдийг нь хамгийн хүчтэй эсэргүүцэх хүч нууц бүлэгт агуулагдаж буйг нууц цагдаагийнхан нэгэнт мэдсэн тул биднийг улам бүр хавчих болов. Энэ эсэргүүцэл нь улс төрийн эсэргүүцэл байсангүй харин оюун санааны, ер бусын хүч чадлын тухай асуудал байсан учир тэд арга хэмжээ авахгүй бол ухуулж буй шашингүй үзэл суртлын хүч нь сулран унах байлаа. Зөвхөн адгийн муу ёрын сүнсний ялган танъж чадах энэ байдлыг тэд мэдэж байсан тул аюулыг нь ч бас мэдэж байв. Тэд хэрэв хүн

Христэд итгэх юм бол өөрийн толгойгүй, ухаангүй тэнэг байхaa болж, тэднийг үг үсэггүй дуулгавартай дагахаа болино гэдгийг мэдэж байв. Тэд хүмүүсийг шоронд хоривч Ертөнцийн Эзэнд итгэх хувь хүний итгэлийг яагаад ч таслан зогсоож, хорж чадахгүй гэдгээ ч мэдэж байлаа. Тиймээс тэд үүний эсрэг маш хүчтэй тэмцэлдэж байв.

Гэвч засгийн газар болон нууц цагдаагийн байгууллагад чухал албан тушаал эрхэлдэг боловч бидний талд байдаг хүмүүс нилээд байв.

Христэд итгэгчдэд бид нууц цагдаагийн байгууллагад элсэн орж эх оронд маань хамгийн ихээр ад үзэгдэх болсон олиггүй амьтны углах дүрэмт хувцсыг өмссөхийг зөвлөнө. Ингэснээр тэд нууц цагдаагийнхны авах гэж буй арга хэмжээний талаар, тэдэнд байгаа мэдээллийг нууц бүлгийнхэндээ дамжуулах боломжтой болох байв. Нууц бүлгийн нилээд хэдэн залуус өөрсдийн итгэлийн талаар нууцлан ийм байдлаар ажилладаг байлаа. Коммунистуудын дүрэмт хувцсыг өмссөнийхөө төлөө эцэг эх, гэр бүл, анд найзуудадаа ад үзэгдэн, үнэн хэрэгтээ ямар үүрэгтэй тэнд байгаагаа хэлж чадахгүй урт удаан хугацааг барна гэдэг туйлын хэцүү хэрэг. Гэвч тэд үүнийг ч гэсэн тэсээд л гарсан. Тэд Христийг үнэхээр их хайлрадаг байсан учраас энэ бүхнийг тэвчин давж тулсан юм.

Намайг гудамжинд явж байхад минь хулгайлан баривчилж хамгийн чанга дэглэмтэй хориход олон жил хорих хугацаанд ямар байдалтай байгааг минь мэдэхийн тулд Христэд итгэдэг гайхалтай сайн эмч хүртэл нууц цагдаагийн ажилтан болсон билээ! Нууц цагдаагийн албаны эмчийн хувьд түүнд хоригдлуудын өрөөгөөр чөлөөтэй нэвтрэн үзлэг хийх эрх байсан тул тэр намайг хаана байгааг хайж олно гэж найдаж байжээ. Түүний бүх найз нөхөд нь коммунист боллоо гэж үзээд түүнээс нүүр буруулан харьцаагаа бүрмөсөн тасалсан байв. Өөрсдийг нь тамлан дарлагчийн хувцсыг өмсөн алхаж явах нь Христийн төлөө хийж чадах хамгийн агуу үйлдэл юм. Түүний дэргэд шоронгийн хоригдлын хувцас өмсөх нь юу ч биш, харин шагнал мэт санагдана.

Намайг газрын гүнд, харанхуй өрөөнд хоригдож байхад нөгөө эмч олоод амьд мэнд байгааг минь дамжуулав. Шоронд орсноос

хойш найман жил хагасын хугацаа өнгөрч байхад намайг хайсаар байж олж ирсэн эхний найз маань энэ эмч байсан юм! Түүнээс болж Христэд итгэгч нөхөд маань намайг амьд мэнд байгааг мэдэж, 1956 оны Айзенхаур—Крушев“өршөөл“ үзүүлэн хоригдлуудыг суллах болоход намайг суллуулахаар хүсэлт гаргасан тул би түр зуур ч болов суллагдав.

Зөвхөн намайг олох зорилгоор нууц цагдаагийн ажилтан болсон Христэд итгэгч энэ эмч байгаагүй бол би хэзээ ч суллагдахгүй байх байлаа. Өнөөдөр ч би шоронд л сууж байх байсан. Бүр аль хэдийн авсанд орчихсон ч байж болох шүү дээ.

Нууц бүлгийн гишүүд маань тэдний ажилтан болсноороо албан тушаалаа ашиглан мэдээлэл олж авснаар олон удаа бидэнд тусалж учирч болох аюулаас аварч байсан билээ. Тохиолдох гэж буй аюулын талаар сануулж, мэдээлэн нууц бүлгийн ахан дүүсээ хамгаалж байдаг нууц цагдаагийн ажилтнууд болсон олон Христэд итгэгч өдүгээ ч гэсэн байж л байна. Христэд итгэснээ чандлан нууцалж, коммунист эрх баригчдын дунд өндөр албан тушаал хашдаг хүмүүс тэдний дунд нилээд байдаг ба бидэнд үргэлж тусалж байдаг. Энэ дэлхийд байхдаа хайрлан зүтгэж буй Их Эзэнийхээ өмнө зогсон хожмын нэг өдөр тэд итгэлээ ил тод зарлан мэдэгдэх болно.

Гэсэн хэдий ч нууц бүлгийн олон гишүүд баригдан шоронд орцгоосон. Учир нь бидний дунд ч бас“Юудаас“ шиг нөхөд байсан тул бидний тухай мэдээлэн илчилдэг байлаа. Зодох, айлган сүрдүүлэх, хүнд хүчир ажлаар нухлах, заналхийлэх маягаар тэд ахлагч, итгэгчдийг дарамтлан итгэгч ахан дүүсээ илчлэхийг шаардаж байв.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Би 1948 оны хоёрдугаар сарын 29-нийг хүртэл албан ёсоор ил тод, бас нууц байдалтайгаар ажиллаж байв. Ням гариг байсан юм даг. Үнэхээр сайхан өдөр байв. Яг тэр ням гаригийн өдөр би Христэд итгэгчдийн хуралд очихоор сүм рүү явж байтал замд минь нууц цагдаагийнхан тааралдан намайг хулгайллан баривчилав.

“Хүн хулгайлах” гэсэн үг Библид олон гарахыг олж уншаад би тэр үг чухам ямар утгатай болохыг гайхан учрыг нь олдоггүй байв. Гэтэл коммунизм бидэнд үүний утга учрыг ойлгуулж өглөө.

Тэр үед олон хүн ийм байдлаар хулгайлагдсан юм. Намайг явж байтал урд минь гэнэт жижиг автобус ирж зогсоод хаалга нээгдэн дөрвөн цагдаа үсрэн бууж ирээд намайг шууд л барин машин руу түлхэн оруулав. Тэгээд би олон жил хоригдон сураггүй болов. Найман жилийн турш миний үхсэн, амьд аль нь болохыг мэдэх хүн нэг ч байсангүй. Шоронгоос суллагдсан хоригдлын дүр эсгэсэн нууц цагдаагийн ажилтнууд гэрт маань очиж эхнэртэй минь уулзаад миний оршуулгад оролцсон тухайгаа ярьжээ. Тэд бол анд нөхрийн дүр эсгэсэн хуурамч амьтад байв. Эхнэр маань энэ мэдээг сонсоод асар их гашуудан уйлжээ.

Тэр үед Христийн гэгдэх янз бүрийн урсгалын бараг бүлэг болгоноос олон мянган хүн баривчлагдан хоригдож байв. Христэд итгэгчдийн байгууллагын ажилтнууд төдийгүй энгийн номхон ард, хөвгүүд охидууд Христийн үгийг тунхагласныхаа төлөө баривчлагдаж байлаа. Ганц Румынд ч биш ер нь бүх коммунист оронд широнгууд хоригдлуудаар дүүрсэн байсан агаад широнд хоригдоно гэдэг нь тамлуулан зовох гэсэн утгатай байлаа.

Тамлан зовоох арга нь заримдаа бүр аймшигтай болно. Өөрийн тэсч гарсан тэр аймшигт аргуудын талаар нэг их дэлгэрэнгүй ярих хүсэл надад алга. Би тэр тухай бодох бүрдээ шөнө ч

унтаж чадахгүй болтлоо шаналдаг. Дурсан санаад ч дэндүү их шаналам аймшигтай их зовлон байв.

“Ертөнцийн Эзэнтэй хамт газрын гүнд“ номноо би Ертөнцийн Эзэний хамт шоронд үзсэн олон зүйлсийнхээ талаар дэлгэрэнгүй өгүүлсэн.

ҮГЭЭР ИЛЭРХИЙЛЭХИЙН АРГАГУЙ ИХ ЗОВЛОН

Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч Флореску гэдэг залууг тэд час улаан болтол нь улайсгасан төмөр хадаас, хутгаар тамлан туйлын аймшигтай нүд хальтрам байдалтай болгосныхоо дараа өрөөнд нь том хоолойгоор дамжуулан олон өлсгөлөн үхэр хулгана оруулав. Тэр огт унтаж чадахгүй боллоо. Хэрвээ жаахан ч гэсэн амран хэвтэж дуг хийвэл нөгөө үхэр хулганууд түүн рүү дайрна.

Тэр бүтэн хоёр долоо хоногийн турш өдөр шөнөгүй үүнийг тэвчин тэмцэлдсээр байв. Коммунистууд түүнийг ах дүү нараасаа урван илчилнэ гэж найдаж байсан боловч тэр нэг ч үг хэлэлгүй тэвчсээр. Аргаа барсан тэд эцэст нь арван дөрвөн настай хүүг нь авчирч харуулж байгаад сураар ороолгож эхлэв. Хүсч байгаа тэр хэдэн үгийг хэлэх л юм бол хүүг чинь зодохoo болино гэж тэд хэлж байлаа. Хөөрхий эрийн ухаан балартан орон гаран болов. Чадах чинээгээрээ тэр үүнийг тэссэн боловч цаашид тэвчиж чадахаа болиод ирэхдээ тэр хүүдээ хандан уйлан байж, “Александр, хүү минь! Надад тэдний хүсч буйг хэлэхээс өөр арга алга! Чамайг ингэж зодуулахыг чинь харж тэсэхгүй нь!” гэхэд хүү нь, “Аав аа! Та тийм харгис юм бүү хий. Урвагч эцэгтэй гэсэн шившигтэй нэрийг надад зүүлгэх гэж буу оролд. Тэвч! Тэд намайг алсан ч хамаагүй, би тэртээ тэр-гүй “Есүс Их Эзэн болон эх орондоо үнэнч байсаар үхнэ!” гэж хариулав. Коммунистуудын уур дээд цэгтээ хүртэл бадран хүүг нэвширтэл ороолгосоор, эцэст хөөрхий хүүгийн биеэс цус садарч ийш тийш үсрэн өрөөний ханануудыг будаад нас барав. Хүү Ертөнцийн Эзэнийг магтан хүндэлсээр нас эцэслэсэн билээ. Бидний хайрт нөхөр Флореску тэр өдөр энэ явдлыг харснаасаа хойш тэс өөр хүн болсон юм. Хэзээ ч урьдын адил байхаа болив.

Хурц үзүүртэй хадаас үзүүрээр нь дотогш харуулан зоосон гав бидний бугуйнд зүүнэ. Хэрвээ огт хөдөлгөөнгүй байвал хатгуулж, зүсүүлэхгүй байж болно. Гэвч жигтэйхэн хүйтэн широнгийн өрөөнд даарсандaa болоод чичирч байгаа улс яаж хөдлөхгүй байх билээ, чичрэх бүр бидний гар зүсэгдэж сийчигдэнэ.

Христэд итгэгчдийг толгойг нь доош нь харуулж олсноос дүүжлээд аймшигтай тамлан зоддог байсан тул тэдний бие нь хүчтэй салхи үлээхэд нааш цааш хийсэх мэт ганхана. Тэднийг бас “хөргөгч өрөө” хэмээх мөсөн хонгилд оруулна. Тэр нь дотроо цан хүүрэг, мөсөөр бүрхэгдсэн айхтар хүйтэн өрөө байдаг байв. Намайг ийм өрөөнүүдийн нэгэнд нь бараг хувцас гэхээр юмгүй орууллаа. Широнгийн эмч нар жижиг нүх шиг цонхоор үе үе шалган харах ба хөлдөж үхэж байгаа шинж тэмдэг илэрч эхлэхэд харуулуудад дохио өгөх ба тэд гүйн орж ирээд биднийг тэндээс гарган дулаацуулах арга хэмжээ авна. Тэгээд арайхийж дулаацаад авахад тэд тэр даруй буцаагаад мөсөн хонгилд хөлдөөхөөр хийнэ. Энэ байдал дахин дахин давтагдана! Хөлдөж үхэхээс нэг хоёрхон хормын өмнөхөн мөсөн хонгилоос гарган дулаацуулаад дахиад л мөсөн хонгилд хийнэ, энэ мэтээр эцэс төгсгөлгүй үргэлжилнэ. Би одоо ч гэсэн хөргөгчөө онгойлгоходоо энэ тухай санан чичирч байдаг.

Бидний биеийн хэмжээтэй бараг адил шахуу модон хайрцагт биднийг хийнэ. Тэр дотор хөдлөх ямар ч боломж байхгүй. Хайрцагныхаа гаднаас мянга мянган маш хурц үзүүртэй хутга, хадаас зоосон байх тул бид огт хөдөлгөөнгүй тэр хайрцаг дотор нь зогсох шаардлагатай болдог байв. Огтхон ч хөдлөхгүй зогсоод байхад яах ч үгүй байгаад л байна. Ийм хайрцагт биднийг хэдэн цаг өдрөөр хийдэг байсан тул ядарч туйлдан цаашид бараг зогсох боломжгүй байдалд ороход бие маань өнөөх хадаас хутгуудад сийчигдэн зүсэгдэнэ. Бие эжаахан хөдөлгөх, булчингаа чангалах төдийд нөгөө аймшигт хадаас, хутгууд зүсэхэд бэлэн ангайгаад л байж байна.

Христэд итгэгчдийг коммунистууд хэрхэн тамладаг байсан тухай өгүүлэхэд хүний ухаанд багтамгүй аймшигтай дүр зураг буух тул хэн ч төсөөлөн ойлгох аргагүй.

Христэд итгэгчдийг тамлан тарчлааж байгаа коммунистуудыг би олонтаа харж байсан. Тэдний царайд хүний зовлонг хараад хязгааргүй их баярлах шинж тодрон харагдана. Христэд итгэгчдийг тарчлаан тамлаж байхдаа тэд баярлалдан“Бид бол муу ёрын сүнснүүд” хэмээн хашгиралдаг байв.

Бид хүн төрөлхтний эсрэг тэмцэлдээгүй, харин энэ дэлхийг гартаа атган хүн төрөлхтнийг захирч байдаг адгийн муу ёрын сүнсний эсрэг тэмцэж байна. Бид коммунизм бол хүн төрөлхтнөөс өөрсдөөс нь бий болж гараагүй, харин адгийн муу ёрын сүнс үүнийг бий болгосон гэдгийг тодорхой ойлгож байв. Энэ бол адгийн муу ёрын сүнснээс ирсэн далдын хүч учир үүнийг түүнээс хавьгүй илүү аугаа Ертөнцийн Эзэний Ариун Сүнсний хүч чадлаар л эсэргүүцэн дийлж чадна.

Намайг тамлан зовоогчдоос би“Та нарт өрөвдөх сэтгэл огтхон ч байдаггүй юм уу?” гэж байнга асуудаг байв. Тэд ихэвчлэн надад Лениний хэлсэн үгээс иш татан,“Хэрэв өндгийг хагалахгүй бол яаж өндөгний ороомог хийх вэ, үүний адил эмтэлж хэмхлэхгүйгээр яаж мод хагалж болох билээ?” гэж хариулдаг байв. Тэгэхээр нь би тэдэнд“Лениний хэлсэн энэ үгийг би ч бас сайн мэднэ шүү. Гэвч үүнд чинь том ялгаа байна. Та нар мод хагалахад мод чинь юу ч мэдрэхгүй биз дээ? Гэтэл та нар хүнтэй, амьд хүнтэй харьцаж байгаа биш үү? Та нар зodoх тоолонд өвчин шаналал бий болж хаа нэгтээ эхчүүд хүүхдүүдийнхээ төлөө нулиms урсган шаналан байна“ гэдэг байв. Тэгээд ямар ч нэмэр болдоггүй байлаа. Тэд бол материалист үзэлтнүүд байсан юм. Тэдний хувьд материас өөр юу ч байхгүй бөгөөд хүн гэдэг бол мод, өндөгний хальс төдий ажээ. Ийм үзэлд итгэн сохиор дагаснаараа тэд эцсийн үр дүнд ийнхүү аймшигтай зэрлэг тамлан зовоогч яргачид болон хувирсан аж.

Итгэхэд хамгийн хэцүү зүйл бол шашингүй үзлийн харгис хэрцгий чанарын асуудал юм. Сайн үйлийн төлөө хүртээх шагнал, саар муу үйлийн төлөө оноох шийтгэл гэж байхгүй хэмээн итгэх нь хүн байх учир утга, шалтгаанаа алдаж байгаа хэрэг юм. Хүний сэтгэлд гүн шингэсэн байдаг төрөлхийн зуршил нь бузар булаг илчлэн харуулж зугтан зайлах хүслийг төрүүлдэг бол шашингүй үзэлтнүүдийн хувьд энэ хүчин зүйл үгүй болно. Тарчлаан зовоогч коммунистууд“Ертөнцийн Эзэн гэж огт байх-

гүй, үхсэний дараа ч амьдрал байхгүй, муу үйлийн төлөө оноох шийтгэл ч гэж байхгүй. Бид хүссэнээ хийж болно“ гэж хэлэх нь олон. Тэдгээр тамлан зовоогчдын нэг нь“Би өөрийн байхгүй гэж итгэдэг тэр Ертөнцийн Эзэнд талархаж байна. Энэ өдрийг хуртэл намайг амьд байлгаж миний сэтгэл зүрхний гүнд байсан бузар булагай гэмт чанарыг минь илчлэн ил гаргасан тул би бүгдийг нь ил тод илэрхийлэх боломжтой болсон“ гэж байхыг би сонссон. Шоронд хоригдож буй хөөрхий хүний аймшигтай, бүр тэсэхийн аргагүй их зовлонг хараад тэр харгис хэрцгий байдлаа сайшаан ийнхүү өгүүлж байсан юм.

Хэрвээ матар хүн залгичихсан байвал надад үнэхээр харамсалтай санагдах боловч би түүнийг шийтгэн, засаж чадахгүй. Гэтэл тэр бол ёстай жинхэнэ матар байлаа. Тэр бол хүний мөс сайтай хүн огтоос биш. Тиймээс коммунистуудыг засаж залруулах арга огт байхгүй. Коммунистууд бол өөрсдөө амьдралын зарчим, ёс суртахуун гэгдэх аливаа ойлголтыг оргүй болтол нь устган зайлуулж, улмаар юуг ч энэрэн хайрлаж, өрөвдөггүй хүмүүс болж үүгээрээ маш их бахархан баярладаг улс.

Би тэднээс нэг юм сурч авсан. Тэд сэтгэл зүрхэндээ Есүсийг оруулах өчүүхэн ч гэсэн зайлгэхгүй байгаа бол би ч бас адгийн муу ёрын сүнсэнд нэвтрэн орох боломж огтхон ч олгохгүй.

Би Америкийн Нэгдсэн Улсын сенатуудын танхимын дотоодыг хамгаалах зөвлөлийн өмнө зогсон энэ бүгдийг гэрчлэн өгүүлэхдээ коммунистууд Христэд итгэгчдийг загалмайд хүлж уяд дөрвөн өдөр, дөрвөн шөнө хэрхэн тамладаг байсан тухай ярьсан билээ. Загалмайнуудыг шалан дээр эгнүүлэн тавих ба хэдэн зуун хоригдлууд хүлүүлэн хэвтээ тэдний нүүр, биен дээгүүр бие засна. Дараа нь тэд загалмайг дахин өргөн босгох ба коммунистууд тэднийг хараад тохуурхан“Өөрийн Христийг хар! Тэр яасан үзэсгэлэнтэй юм бэ! Юутай таатай үнэрийг тэр мөнхийн улсаасаа илгээгээ вэ!” гэж инээлдэн хаширалдана. Тамлал зовлонгоос болж шархны халуун болон галзуурлын байдалд орсон байсан үнэн алдартны байгууллагын тэргүүн ламыг тэд албадан хүний ялгадас өтгөнийг шээстэй хольж үүнийгээ Христэд итгэгчдэд өгөн хайрын зоог бариулж байсан юм. Энэ явдал Румыны Питести хотын шоронд болсон. Дараа нь би түүнээс та энэ гутамшигт доромжлолд оролцохын оронд үхсэн

бол дээр байсан биш үү гэхэд тэрээр, “Намайг бүү шүү, гуйя! Би Христээс илүү зовж байна!” гэж хариулав. Түүний хувьд мөнхийн зовлонг дүрслэн өгүүлсэн Библийн үгс болон Данте-гийн зурсан “Гал дунд” хэмээх зурагт дүрсэлсэн байдаг нь коммунистуудын шорон дахь тамлалтай харьцуулахад юу ч биш ажээ.

Энэ бол Питестигийн шоронд ням гариг бүр олон аймшигтай хэргүүд болдгийн өчүүхэн ганц жишээ нь юм. Үүнээс бусдыг нь үнэхээр хэлж чадахгүй нь! Хэлэхэд ч үнэхээр хэцүү санагдана. Тийм зүйлсийн талаар дахин дахин яриад байвал миний элэг зүрх эмтэрч үхэх байх. Тэр хэргүүд дэндүү аймшигтай, бичихэд хүртэл гар эвлэхийн аргагүй. Христэд амьдралаа өгсөн итгэл нэгт ахан дүү нар чинь ийм их зовлон туулж, одоо ч зовсоор байна!

Итгэлдээ үнэнч байсан хамгийн алдартай баатруудын нэг нь Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч Милан Хаймовыки байлаа.

Шоронгууд хориглуудаар пиг дүүрсэн байв. Харгалзагч нар бидний нэрсийг огт мэдэхгүй. Тэд хорин тав ташуурдуулах ялтан этгээд гэх мэтээр дуудна. Шоронгийн дүрмийг зөрчсөнийхөө төлөө ингэж ташуурдуулна. Тоймгүй олон удаа ахлагч Милан Хаймовыки бусдын өмнөөс ташуурдуулсан билээ. Ингэснээрээ тэр бусад хоригдлуудын хүндэтгэлийг хүлээгээд зогсохгүй тэдэнд Христийг хүндлэх сэтгэлийг бий болгон өгч байв. Үнэндээ Христийг төлөөлөн тэнд байсан тул түүнийг хүндлүүлэх бол цорын ганц хүсэл нь байв.

Хэрэв би коммунистуудын тамлан зовоох аргууд, хийсэн хэргүүд, мөн түүнчлэн Христэд итгэгчдийн амиа золиослон тэмцэж байсан тухай яриад байвал хэзээ ч дуусахгүй урт түүх болох нь гарцаагүй. Тамлан зовоож байгаа нь аймшигтай байсан ч тэднийг тэсэн гарч баатарлаг гавьяа байгуулсан тухай түүхүүд ч бас олон бий. Шоронд буй ах дүүсийнх нь баатарлаг үйлс эрх чөлөөтэй байгаа нөхдөдөө урам зориг өгдөг байв.

Нууц бүлэгт маань нэг охин ажилладаг байлаа. Нууц цагдаагийнхан түүнийг Христийн үгийг тунхаглан, хүүхдүүдэд Библи заадаг болохыг нь илрүүлчихэв. Тэд түүнийг баривчлахаар шийджээ. Баривчлах ажиллагааг илүү тamtай хэцүү болгохын тулд тэд хуrimынх нь өдрийг хүртэл хэдэн долоо хоног хүлээ-

хээр шийдсэн аж. Хуримынх нь өдөр байсан тул тэрээр сүйт бүсгүйн цав цагаан даашины өмсөж, энэ өдөр түүний хувьд амьдралынх нь хамгийн сайхан, мартагдашгүй, жаргалтай мөч байв! Гэтэл ... гэнэт хаалга нээгдэн нууц цагдаагийнхан хар гүйхээрээ дайран орж ирлээ.

Бэр болох бүсгүй нууц цагдаагийнхныг хараад гавлуулахаар гараа сунган өгөв. Тэд түүний гаргавыг зэрлэг хүний адил угзчин зүүлээ. Тэр хайртай залуу өөдөө хараад гаран дахь гаваа үнсэн“Хуримын минь өдөр ийм үзэсгэлэнтэй эрдэнийг бэлэг болгон өгсөн ер бусын ханхүү хайртдаа би маш их баярлаж байна. Би ямар ч байсан түүний төлөө зовлон эдлэх хувьтай байгаадаа баярлан талархаж байна“ гэв. Түүнийг тэд чирч нударсаар аваад гарахад ард нь Христэд итгэгч олон үнэнч нөхөд нь уйлсаар хоцорсон билээ. Коммунист харгалзагч нарын гаргарт орсон хөөрхий охинд юу тохиолдохыг тэд сайн мэдэж байлаа. Таван жилийн дараа түүнийг суллахад тэр гучин насаар хөгширсөн харагдаж байв. Түүнийг тэд юу ч үгүй болтол нь устгах гэж оролджээ. Түүнийг суллагдан гарч иртэл хайртай залуу нь хүлээжээ. Тэр хэлэхдээ,“Христийн төлөө би ядаж ийм зүйлийг хийх эрхтэй“ гэж байв. Ийм л гайхамшигтай зоригт хүмүүс нууц бүлэгт маань байдаг юм.

ТАРХИ УГААХ АЖИЛЛАГАА

Барууны орны хүмүүс Солонгосын хойгийн дайн болон одоо ид өрнөж буй Вьетнамын дайнаас болж тархи угаах ажиллагаа гэх мэт үгсийг лав олон сонссон болов уу. Гэтэл би өөрөө ийм байдалтай тулгаран давж гарлаа. Энэ бол хамгийн аймшигтай тамлал мөн.

Олон жил бид өдөр бүр арван долоон цагийн турш нэг л юмыг сонсдог байв.

Коммунизм бол сайн!
Коммунизм бол сайн!
Коммунизм бол сайн!
Коммунизм бол сайн!
Коммунизм бол сайн!

Коммунизм бол сайн!
Коммунизм бол сайн!
Бууж өг!
Бууж өг!
Бууж өг!
Бууж өг!

Бүтэн арван долоон жилийн турш нэг ч өдөр алгасахгүй энэ үгийг л сонслоо.

Тархи угаах ажиллагааг та нар хэрхэн эсэргүүцдэг байв гэж Христэд итгэгч нилээд олон хүн надаас асуусан. Тархиа угаалгахаас хамгаалах ганц л найдвартай арга байдаг. Энэ бол зүрх сэтгэлээ угаах арга. Хэрэв хүний зүрх сэтгэл Есүс Христийн хайраар угаагдсан бол, тэр хүн Христийг сэтгэл зүрхнийхээ угаас хайлладаг бол ямар ч зовлон тамлалыг эсэргүүцэн даван гарч чадна. Хайртай хархуүгийнхээ төлөө юу ч хийхгүй суух сүйт бүсгүй байдаг гэж үү? Үр хүүхдэдээ хайртай эх хүн хүртэл хүүхдийнхээ төлөө бүхнийг хийхгүй гэж үү? Хэрэв та Христийг энгэртээ бяцхан хүү байхад нь өхөөрдөн тэвэрч хайлласан Мариин адил хайлладаг бол, хэрвээ та Есүсийг сүйт хархуүгээ хайллах бүсгүйн адил хайлладаг бол ямар ч зовлон тамлалыг эсэргүүцэн гал усан дундуур ч хамаагүй туулан гарах болно.

Ертөнцийн Эзэн биднийг хичнээн зовлон тэсч гарч байна гэдгээр нь харж хайлладаггүй, харин бид түүнд хичнээн их хайртай байна гэдгийг л хардаг. Христэд итгэгчид коммунистуудын шоронд хэрхэн зовж буйг харсны хувьд би тэд Христэд үнэхээр хайртай, чин сэтгэлээсээ хайлладаг гэдгийг нь батлах гэрч болно. Тэд Ертөнцийн Эзэнийг ч, хүмүүсийг ч хайлаж чаддаг юм.

Тамлал зовлон, хэрцгий балмад харгис хэрэг явдлуудад саад болж зогсоох юм юу ч байхгүй үргэлжилсээр. Намайг ухаан алдаад эсвэл хэлүүлэх гэснийг хэлэх аргагүй болтлоо гайхан алмайрах байдалтай болоод ирэхээр тэд өрөө рүү маань буцаадаг байв. Тэнд би хагас үхдлийн байдалтай хэвтэн амарч жаахан хүч олж авахад тэд дахиад л тамлаж эхэлнэ. Олон хүн ийм байдалд ороод нас эцэслэдэг байсан боловч би ямар ч байсан хүчээ сэлбэн авч дөнгөдөг байлаа. Дараагийн хэдэн жил нь

намайг нилээд хэдэн шоронгуудаар нүүлгэн хорьсон ба тэд миний нурууны дөрвөн үе болон өөр олон ясыг минь хугалсан. Тэд биен дээр минь тоолохын аргагүй олон удаа сийлж, бас арван найман удаа цоолон нүхэлж, галаар тулсэн билээ.

Осло хотын эмч нар миний биен дэх энэ олон шарх сорви, сурьеэтэй байсны улмаас үлдсэн уушгин дахь сорвиудыг хараад эдүгээ миний амьд байгааг гайхамшиг гэж санал нэгтэй хүлээн зөвшөөрч байв. Тэдний анагаахын онолоор бол би аль хэдийн нилээд олон жилийн өмнө талийгаач болсон байх ёстой ажээ. Ертөнцийн Эзэн бол үнэхээр гайхамшгийг бүтээгч Их Эзэн мөн!

Төмөр хөшигний цаана буй нууц бүлгийн ахан дүүсийн минь сэтгэл зүрхний гүнээс гарах шаналал эмгэнэлийн үгийг энэ өдөр та бүхэнд хүргүүлэхийн тулд Ертөнцийн Эзэн гайхамшгийг бүтээсэн гэдэгт би итгэлтэй байна. Тэрээр тэдний дундаас нэгийг нь амьд гарган авч тэнд тамлуулан зовж, шаналж буй итгэл нэгт ахан дүүсийн тань сэтгэлийн гүнээс гарах шаналал зовлонг илтгэх дууг та нарт сонсгохоор шийдсэн ажээ.

ЗУУРДЫН ЭРХ ЧӨЛӨӨ

1956 он гарлаа. Би шоронд ороод нийтдээ найман жил хагас болж байв. Би эцэтгээ турж, биеэрээ нэг шарх сорвитой болсон байлаа. Намайг аймшигтай зодон, өшгичиж, доог тохууны бай болгож, үхтэл минь өлсгөж, дарамтлан, жигшил зэвүүцлийн дуугаар эрүүдэн байцааж байв. Айлган сүрдүүлэлт, заналхий-лэл, үл тоомсорлох гээд надад үзэж туулаагүй юм байхгүй болжээ. Энэ бүх аргын эцсийн үр дүнд аль нь ч намайг итгэлээсээ урван яргачдын хүслийг биелүүлэх байдалд оруулсангүй. Тэгээд урам нь хугарсан тэд намайг суллан тавилаа. Түүнээс гадна намайг баривчилан хорьсныхоо төлөө нилээд эсэргүүцэлтэй тулгараад байсан учир тэдэнд өөр арга байгаагүй биз.

Тэд намайг хуучин ажилдаа буцаж орохыг зөвшөөрсөн боловч энэ нь ганцхан долоо хоногийн хугацаатай байв. Би ердөө л хоёрхон удаа сургаал заалаа. Тэгтэл тэд намайг дуудан ирүүлээд цаашид сургаал зааж, шашны аливаа үйл ажиллагаанд оролцож болохгүй хэмээн хориглов. Би болохгүй юм юу хэлсэн юм бэ? Би хуралд ирсэн хүмүүст “зөвхөн” тэвчээртэй бай, улам илүү

тэвчээртэй байж тэсвэрлэж сурх хэрэгтэй“ гэхээс өөр юм хэлээгүй шүү дээ.“Энэ чинь чи тэдэнд юу ч болдог байсан тэвчээртэй бай, америкууд ирэхдээ л ирнэ, тэгээд та нарыг чөлөөлнө гэсэн үг“ хэмээн цагдаа гуай ууртай хашгирав. Би тэдэнд цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй юм. Тиймээс юм өөр болох цаг ирнэ гэж хэлэх нь ч хэлсэн.“Чи тэдэнд коммунистууд засгийн эрхийг байнга гартаа атгахгүй гээ биз дээ! Энэ бол засгийн газрыг эсэргүүцэж буй хэрэг мөн!“ гэж дахин хашгичив. Тэгээд л миний олны дунд ил тод хийж байсан ажил маань төгсгөл боллоо.

Эрх баригчид намайг өөрсдийг нь үл тоомсорлох болон нууцаар Христийн сургаалыг дэлгэрүүлэхээс айх байх гэж найдаж байсан байх л даа. Гэвч тэд алджээ. Нууцаар би урьд хийж байсан ажлаа үргэлжлүүлэн хийсэн бөгөөд гэр бүлийнхэн маань намайг дэмжин халхалж байлаа. Итгэл хүлээсэн нөхдийнхөө гэрээр ээлжлэн сүнс, хий үзэгдэл аятай ирж очиж итгэлтэй хуралдсаар байсан нөхдөдөө би широнгийн байдлын талаар гэрчлэн ярьж байв. Энэ удаад би өөрийн хэлж байгаа үгээ биен дэх сорвио үзүүлэн улам баттай болгож одоо хир нь холбирч гулбирч буй нөхдөдөө Ертөнцийн Эзэнд л найдаж, зоригтой байх хэрэгтэй хэмээн захиж байв. Ертөнцийн Эзэн бүгдийг ханганд өгдөг чанараа харуулан коммунистуудын нүдийг халхалж өгдөг байсан тул бид боломжийг нь ашиглан Христийн сургаалыг тунхагласаар байв. Ийнхүү бие биедээ туслан нууцаар Христийн үгийг тунхаглагчдын сүлжээг би ахлан удирддаг байлаа. Ямар ч байсан хэрэв хүн Ертөнцийн Эзэний хийж буй ажлыг ялган танихгүй болтлоо сохорсон юм бол Христийн авралын мэдээг тунхаглагчийг ч бас таньж чадахгүй болтлоо таг сохор болсон байдаг биз.

Эцсийн эцэст миний хаана юу хийж явааг сонирхон нүд салгалгүй мөрдөж байсан цагдаагийнхан амжилт олон би дахин илчлэгдэн баривчлагдав. Зарим нэг шалтгааны улмаас тэд энэ удаад манай гэр бүлийнхнийг баривчилсангүй. Олон нийтэд нилээд нэр хүндтэй байсан болохоор тэгэхээс болгоомжилсон байж ч болох юм. Би анх широнд ороод найман жил хагас болоод гарснаасаа хойш бараг гурав хүрэхгүй жил л эрх чөлөө-

тэй явсан билээ. Гэтэл одоо би дахиад таван жил хагас хоригдох боллоо.

Хоёр дахь удаагийн баривчилгааны үр дүн анх шоронд байсан үеэз бодвол олон талаар долоон дор байв. Би юу намайг угтаж байгааг сайн, сайн гэхэд бүр дэндүү сайн мэдэж байлаа. Миний эрүүл мэндийн байдал бараг тэр дороо л тун доройтож орхив. Гэвч бид нууц бүлгийнхээ ажлыг коммунистуудын шоронд үргэлжлүүлсээр байв.

БИД Ч ЗААНА, ТЭД Ч ЗОДНО

Бусад хоригдлуудад Христийн тухай ярих хатуу хориотой. Ийм ажил хийж байгаад баригдсан хэнийг ч болов харгис хэрцгийгээр тамлан зодох ёстой гэдгийг бид бүгд ойлгож байв. Нэгэнт олдож байгаа боломжийг ашиглаад сургаал заан юу ч болсон тэсээд гарахаар бидний нилээд хэдэн нөхөд шийдлээ. Бид ч дуртайяа санаа нийлэн ажилдаа шамдан оров. Энэ бол наймаа байлаа. Бид сургаалаа заана, харин тэд биднийг зодно. Бид сургаалаа баяр жаргалтай заадаг байлаа. Харин тэд биднийг зодож таашаал авах тул үүнд баярладаг байв. Тиймээс хүн бүр л дор бүрнээ баяртай байлаа.

Дараахи хэрэг миний санаж байгаагаас хавьгүй олон удаа тохиолдсон билээ. Нэг нөхөр маань бусад хоригдлуудад сургаалаа заагаад сууж байтал, бүр ганц өгүүлбэрээ бүрэн дуусгаж амжаагүй байхад нь харгалзагч нар гэнэт дайран орж ирэв. Тэд “ташуурын өрөө” рүү түүнийг чирч гулдчisaар хонгилоор авч явлаа. Зогсоо чөлөөгүй хэдэн цаг ташуурдан зодсоны эцэст түүнийг нус нөхтэйгээ хутгалдсан, хөхөрч бяцарсан аймшигтай байдалтай болсон хойно нь шоронгийн өрөөний хатуу чулуун шалан дээр шидэж орхив. Аажмаар тэр бяцарч бутарсан биеэ цуглуулах мэт хамаг хүчээ хуримтлуулан босч, хувцсаа засаж янзлахад өвчин зовиуртай байгаа нь илэрхий мэдэгдэж байсан ч “Ах дүү нар минь, би түрүүн хаана зогслоо?” гэж хэлээд цааш үргэлжлүүлэн Христийн үнэн үгийг ярьсаар байсан юм!

Би гайхамшигтай сайхан хэргүүд олныг үзсэн!

Заримдаа Христийн сургаалыг тэр бүр заагаад байдаггүй “энгийн” хүмүүс хүртэл гайхалтай хүч чадалтай сургаал заадаг

байв. Тэдэнд Ариун Сүнс үргэлж туслах тул гайхалтай хүч чадалтайгаар Христийн тухай ярина. Тэдний хэлж буй үг бүр сэтгэл зүрхнээс нь урсан гарч байсан ба аймшиг, зовлон дагуулсан ийм нөхцөлд сургаал заах нь тэдний хувьд юутай ч зүйрлэшгүй жаргалтай үе байв. Тэгээд харгалзагч нар орж ирж сургаал зааж буй хэнийг ч болов барьж аваад хагас үхдлийн байдалтай болтол нь зодчихоод буцааж авчирна.

Герла дахь шоронд Греку гэдэг залуу Христийн тухай ярсынхаа төлөө үхтлээ зодуулан шийтгүүлсэн юм. Түүнийг зодсоор байж амийг нь таслах энэ ажиллагаа хэдэн долоо хоног үргэлжлэв. Түүнийг алгуурхан зодон алж байлаа. Түүний хөлийг резинэн шаахайгаар сайтар нэг ороолгочиход орхино, тэгснээ хэдэн минутын дараа эргэн ирж дахиад цохино. Энэ маягаар үргэлжилсээр. Түүний төмсөг болон бэлэг эрхтний хэсгийг нь онцлон өөр маягаар зодно. Тэгээд эмч түүнд тариа хийнэ. Түүнийг сэргээн сайн тэжээллэг хоол унд өгч хүчийг нь сэлбэж байгаад дахиад л өнөөх ташуурдалтаа эхэлнэ. Энэ маягаар тун удаан зовиуртай байдлаар түүнийг зодсоор эцэст нь тэр амьсгал хураав. Үүнийг тэргүүлэн биечлэн гүйцэтгэж байсан хүнийг Рик гэдэг байв. Тэр коммунист намын төв хорооны гишүүн байсан юм.

Рик байсгээд л Христэд итгэгчдэд хандан коммунистуудын хэлдэг өнөөх л үгийг тоть шиг гуншина.“Та нар мэдэж байна уу? Би бол Ертөнцийн Эзэн. Та нарын амь амьдрал, үхэл миний гар байна. Би та нарын амьдрах, үхэхийг шийднэ. Мөнхийн улсад байгаа тэр чинь та нарыг амьд байлгах үгүйг шийдэж чадахгүй. Бүх юм зөвхөн надаас л шалтгаална. Хэрэв би хүсвэл та нар амьд байна. Хэрэв би хүсвэл та нарыг одоо ч гэсэн цааш нь харуулж орхино. Би бол Ертөнцийн Эзэн.“ Энэ маягаар тэр Христийг болон түүнд итгэгчдийг доромжлон тохуурхана.

Аймшигтайгаар тамлуулан байх үедээ Греку маш сонирхолтой хариуг Рикт өгснийг хожим нь би Рикийн амнаас сонссон юм. Тэр түүнд:“Ямар гүн гүнзгий утгатай үгийг чи хэлснээ ойлгохгүй л байна даа. Чи бол үнэхээр Ертөнцийн Эзэний нэг хэсэг мөн. Эрвээхэйн авгалдай бүр зөв зохистойгоор хөгжих юм бол үнэн чанартаяа эрвээхэй байдаг шүү дээ. Хэн ч чамайг хүн алдаг яргачин болгох гэж бүтээгээгүй. Харин чамайг Ертөнцийн Эзэн

өөртэйгээ адил төстэйгээр бүтээж, өөрийн адил чанартай байлгахыг хүсдэг. Тухайн үед Есүс Иудейчуудад хандан “Та нар бол Ертөнцийн Эзэнээс хараат улс” гэж хэлж байсан юм. Ертөнцийн Эзэн амьдралыг чинь хүссэн ч, хүсээгүй ч удирдаж байдаг учраас сэтгэл зүрхний чинь гүнд түүнийг эрэн хайх хүсэл оршин байдаг юм. Чамтай адил хавчин гадуурхаж байсан Пууль мэтийн олон хүмүүс амьдралдаа хэзээ нэгэн цагт харгис хэрцгий байх нь гутамшигтай, ичгүүртэй хэрэг агаад үүнээс хавьгүй илүү сайн үр дүнтэй хэргийг хийж болохоо ухаарсан. Тэгээд тэд Ертөнцийн Эзэний ер бусын чанарыг өөртөө авч түүний хамт байх хувьтай хүмүүс болохоор шийдэггээсэн. Надад итгэ, ноён Рик. Таны чин хүсэл бол, таны амьдралд байвал зохих ганц зорилго бол Ертөнцийн Эзэнтэй холбоотой болж, түүний адил зан чанартай болох явдал юм шүү дээ.“ хэмээсэн байв.

Тарс хотын Суулийн дэргэд чулуудуулж амиа алдсан Стефани гэрчлэн ярж байсныг Сууль анхааран сонсоогүйн адил Рик тамлан зовоож буй хүнийхээ үгийг тухайн үед тийм ч их анхааран тоогоогүй аж. Гэвч хожим нь Рик энэ бол түүний амьдралын цорын ганц дуудлага, амьд байхын утга учир болохыг ойлгожээ.

Бид коммунистуудын ташуур, тамлал, яргачлал зэргээс нэг том сургамж авлаа. Энэ нь сүнс гэдэг бол биеийн эзэн байдгийг ойлгосон явдал байв. Тэд биднийг тамлан зодож байхад бид өвчин зовиурыг аймшигтай их мэдрэх боловч энэ нь биднээс алс хол орших мэт санагддаг байлаа. Бидний сүнс, оюун санаа Христийн яруу алдрыг баходан түүнтэй хамт байгаадаа хязгааргүй их баярлан урсан хайлж нэгдсэн байдаг тул ямар ч тамлал өвчин зовиур мэдэгдлээ ч алс хол байх шиг санагддаг байв.

Бидэнд долоо хоногт нэг удаа ганц зүсэм талх, заваан гэгчийн шөл өдөр бүр өгнө. Тэр үед ч гэсэн бид Ертөнцийн Эзэнд өргөх ёстойгоо өргөхөөр шийдэв. Арав дахь долоо хоног дээр бид талх авахаараа Ертөнцийн Эзэнд талархлаа илэрхийлж ядarch туйлдан биднээс илүү дорой байдалтай байгаа ах дүү нартаа нэмэгдэл болгон өгдөг байв.

Христэд итгэгч нэг хүнд цаазаар авах ял оноосон байлаа. Ялыг гүйцэтгэхийн өмнөхөн түүнд эхнэртэйгээ уулзах зөвшөөрөл олгожээ. Эхнэртээ хэлсэн түүний сүүлчийн үгс нь

энэ:“Намайг алж байгаа тэр хүмүүсийг би хайрласаар амьсгал хураах болно гэдгийг чи минь мэдэх хэрэгтэй. Тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна. Тиймээс би чамаас тэднийг хайрлаач гэж гүйя. Энэ миний эцсийн гүйтл шүү. Хайртай нөхрийг чинь алсан гээд сэтгэлдээ хорсол хураах хэрэггүй. Бид ямар ч байсан Ертөнцийн Эзэний мөнхийн улсад дахин уулзана.“ Тэр хоёрын яриаг сонссон нууц цагдаагийн ажилтан харгалзгчийн сэтгэлд энэ үг хүчтэй нөлөөлж, улмаар тэр өөрөө Христэд итгэгч болон шоронд орсон байв. Шоронд би түүнтэй танилцан энэ тухай сонссон билээ.

Тиргу— Оснагийн шоронд Мачевыки хэмээх нэг залуу хоригдож байв. Арван наймтай байхад нь түүнийг баривчлан шоронд суулгажээ. Яргалан тамлаж байснаас болоод уушигны сурьеэ нь айхтар хүндэрсэн байв. Түүний үхлүүт байдалтай байгааг гэрийнхэн нь олж мэдээд савандаа зуун ширхэгтэй стрептомицин явуулсан байв. Түүний амьд үлдэх үү, үхэх үү гэдгийг шийдэхэд энэ эм үнэхээр тус болох байлаа. Шоронгийн улс төрийн офицер түүнийг дуддан авчирч илгээмжийг үзүүлээд, “ Амь насыг чинь аварч чадах эм энд байна. Гэвч чи гэрийнхнээсээ илгээмж хүлээн авах эрхгүй. Чи нас залуу, цус шингэн байна. Хувь хүнийхээ хувьд би чамд туслахыг хүсч байна. Гэвч чи надад туслахгүй бол би бас тусалж чадахгүй болоод байна! Хамт хоригдож буй нөхдийнхөө эсрэг мэдуулэг өгчих, тэгэх юм бол би дарга нартаа чамд илгээмжийг чинь өгснийхөө төлөө хэлэх үgtэй болно. Тэгэхгүй бол надад өөрийн үйлдлийг зөвтгөх шалтаг, шалтгаан олдохгүй баларна шүү дээ!“ гэж хэлэв. Мачевыки тэр даруй,“Надад амьд байх хүсэл алга. Амьд байж толинд нүүрээ харах тоолондоо урвагч этгээдийн өөдгүй царайг өөрөөсөө олж харан амьдрах хэрэг алга. Хэзээ ч хүлээн зөвшөөрч, тийм байдалтай дасан зохицож чадахгүй. Үхсэн нь надад хамаагүй дээр!“ гэж хариулав. Нууц цагдаагийн офицер толгой сэгсрэн хэлсэн нь:“Чамд баяр хүргээ. Энэнээс өөр үг хэлнэ гэж би үнэндээ бодоогүй л дээ. Гэвч яахав, би чамд бас нэг өөр зүйл санал болгоё. Хоригдлуудын зарим нь бидний мэдээлэгч туршуулууд болсон. Тэд коммунистууд болсноо зарлан та нараас нүүр буруулан та нарыг хөсөр хаяж байна. Тэд хоёр талд амжилттай ажиллаж байна. Гэвч бид тэдэнд итгэж чадахгүй

байгаа юм. Тиймээс тэд хир зэрэг чин сэтгэлээсээ хандаж байгааг нь тогтоох хүсэлтэй. Тэд бол та нараас урvasан улс. Тэд та нарын хийж буй хэргүүд болон хэлж ярьж байгаа болгоны талаар бидэнд мэдээлэн маш их гай зовлон та нарт учруулж байна. Чамайг нөхдөөсөө урвах хүсэлгүй байгааг би ойлгож байна. Mash сайн ойлгож байна. Гэвч та нарт гай тариад байгаа хүмүүсийн талаар бидэнд мэдээлэн өөрийн амь насыг авраач!“ гэж хэлэв. Тэгтэл Мачевыки өмнөхийн адил тэр даруй“Би бол Христийн дагалдагч бөгөөд тэр бидэнд дайснаа хүртэл хайрлах хэрэгтэй гэж сургасан. Хэрхэн дайснаа хайрлахыг бас зааж өгсөн. Урvasан этгээдүүд бидэнд маш их гай зовлон тарьж байгаа нь үнэн боловч би бузар мууг бузар муугаар хариулж чадахгүй. Тиймээс тэдний эсрэг мэдүүлэг өгч бас чадахгүй. Би тэднийг маш их өрөвддөг учир тэдний төлөө Ертөнцийн Эзэнтэйгээ ярьж байдаг. Би коммунистуудтай ямар ч байдлаар холбогдох хүсэлгүй.“ гэж хариуллаа. Мачевыки улс төрийн офицертой ярилцаж дууссаныхаа дараа өрөөндөө эргэн ирж, миний байсан яг тэр өрөөнд тун удалгүй нас барав. Тэр нүдэн дээр минь Ертөнцийн Эзэнийг магтан хүндэлсээр насан өөд боллоо. Ертөнцийн Эзэний туйлын аугаа их хайр амьд явах их хүслийг хүртэл ялан дийлж чаддаг ажээ.

Хэрэв ядуу эр дуу хөгжимд ухаангүй дуртай бол эцсийн ганц зоосоо хүртэл шавхаад концерт үзэх байсан нь лав. Тэгээд мөнгөгүй боллоо гэхэд тэр мэдээж харамсахгүй. Тэр хүсэн тэмүүлж байсан гайхамшигтай сайхан эгшиг аялгуугаа сонссон тул ийнхүү сэтгэл хангалаун тайван байж чадна.

Би шоронд амьдралынхаа арван хэдэн жилийг өнгөрүүлсэндээ огтхон ч харамсдаггүй. Би ер бусын гайхамшигтай олон юм үзсэн. Би өөрөө шоронд байхдаа юу ч чадахгүй, онц чухал ач холбогдолгүй энгийн нэг сул дорой өчүүхэн хүн байсан боловч надад анхны Христэд итгэгчид, төлөөлөгчдийн адил итгэлээ бат хамгаалсан баатарлаг, Христийн үнэнч дагалдагч нарын хамт хоригдон тэднийг харж тэднээс суралцах завшаан тохиосон. Энэ бол хэлэхийн аргагүй аз завшаан. Тэд Христийн төлөө баяр хөөртэйгөөр, бүр дуртай нь аргагүй үхлийн өөдөөс алхсан. Итгэлээ бат хамгаалан тэмцсэн тэдний оюун санаа, зан чанарын

Үзэсгэлэнт сайхан байдлыг үгээр дүрслэхийн аргагүй. Үүнийг хэн ч, хэзээ ч үгээр илэрхийлэн гаргаж чадахгүй нь лав.

Миний энд хэлсэн, ярьсан бүхэн үнэхээр үнэн бодитой болсон хэрэг явдлууд бөгөөд үүнд давсалж хачирласан юм огт байхгүй. Ер бусын юмс Христэд итгэгчдийн нууц бүлгийнхний хувьд ердийн үзэгдэл шиг л санагддаг байсан юм.

Нууц бүлгийнхэн гэдэг маань Христэд өгсөн анхны хайраа эргэн санаж олж авсан тийм л хүмүүсээс бүрдэж байв.

Шоронд орохосоо өмнө би Христэд маш их хайртай байв. Одоо харин Христийн бэр мэт хүмүүс гэж хэн болохыг, түүнтэй хамт байх гэдэг нь чухам ямар утгатай болохыг шоронд байхдаа олж хараад Христийг хичнээн их хайлгадгийнхaa адил нууц бүлгийн хүмүүстээ хайртай болсон билээ. Би түүний гоо үзэсгэлэн, амь нас, байгаа бүхнээ золиослоход бэлэн дуулгавартай байдлыг нүдээр үзэж биеэр мэдэрсэн.

ЭХНЭР ХҮҮХДЭД МИНЬ ЮУ ТОХИОЛДОВ?

Намайг эхнэрээс минь салгасны дараа түүнд юу тохиолдсонаyg би огт мэдэхгүй байв. Бүр хэдэн жил өнгөрсөн хойно түүнийг бас шоронд хорьсныг олж мэдлээ. Шоронд орсон эмэгтэйчүүд эрчүүдээс илүү аймшигтай зовлон үзнэ. Охидыг хэрцгий балмад харгалзагч нар хүчиндэнэ. Доог тохуу хийх, доромжлох нь туйлын аймшигтай, бүр дэндуу аймаар. Суваг ухах гэх мэт биеийн хүчний хүнд хүчир ажлыг эмэгтэйчүүдээр хийлгэх ба тэдний өдөрт гүйцэтгэх ажлын норм нь эрчүүдийнхээс ялгарагч. Хөхөө өвлүйн хүйтэнд ч хүрз бариад газар ухна. Янхан хүүхнүүд тэдний харгалзагчаар ажиллаж, үнэнч итгэлтэй хөөрхий бүсгүйчүүдийг тамлан зовоохын тулд хоорондоо өрсөлдөн зүтгэнэ. Эхнэр маань амьд үлдэхийн тулд өвс хүртэл идэж явлаа. Энэ сувгийн ажлыг хийж байсан өлсгөлөн хоригдлууд үхэр хулгана, могой гээд тааралдсан амьтнаа барьж иднэ. Харгалзагч нарын хамгийн их хөгжилддөг өдөр нь ням гариг байв. Тэд ням гаригаар эмэгтэйчүүдийг Данубе мөрөн рүү шидэж, загас барих мэт шүүрдэн гаргаад дооглон шоолж, шалба норсон нүцгэн биеийг нь харж тохуу хийн инээлдэж байгаад буцаагаад ус руу шиднэ, тэгээд загасчлан гаргана, дахиад шиднэ,

дахиад гаргаж ирээд тохуурна. Эхнэр минь ч бас олон удаа ийнхүү мөрний ус руу шидэгдэж байсан билээ.

Эцэг эх хоёр нь хоёул баривчлагдан явсны дараа миний хүү гудамжинд гарлаа. Михай бүр бага байхын итгэл бишрэлийн асуудлыг их сонирхон судлах дуртай хүүхэд байв. Гэвч есөн нас хүрсэн хойно нь эцэг эх хоёр нь хоёул баривчлагдан өөрийг нь орхин явахад түүний Христэд итгэлд асар их эргэлзээ учирч хямралд оржээ. Тэрээр дотроо хорсол тээн итгэлийнхээ талаар олон зүйлд эргэлзэн асуух болов. Тэр ийм жаахан байхдаа л ихэнх хүүхдүүдийн бодоод байдаггүйг бодох хэрэгтэй болсон байв. Тэр амь зуулгаа ажил хийн өөрөө олж авах шаардлагатай болсон тул бодохоос өөр арга түүнд байсангүй.

Христэд итгэснийхээ төлөө ийнхүү зовж, эсвэл нас барсан хүмүүсийн гэр бүлийнхэнд туслах нь гэмт хэрэгт тооцогдоно. Хүүд минь тусалсан хоёр авгайг тэд баривчлан аймшигтай зодон тахир дутуу болгожээ. Эдүгээ бүр арван таван жил өнгөрсөн хойно ч гэсэн тэд тахир дутуу хэвээр. Амь насаа золин байж хүүг минь гэртээ авчран асарч сувилсан эмэгтэйд шоронгийн хоригдлын ар гэрийнхэнд тусалсан гэдэг ял тулган найман жилийн хорих ялаар шийтгэв. Түүний бүх шүдийг нь хуга цохиж яснуудыг нь хугалан түүнийг дахиад хэзээ ч ажил хийх чадваргүй болтол нь хүнд гэмтээсэн байв. Үүнээс хойш тэр эмэгтэй насан турш тахир дутуу болж хоцорсон юм.

«МИХАЙ, ЕСҮСТ Л ИТГЭ!»

Арван нэгэн нас хүрээд Михай ажилчин болж амин зуулгаа өөрөө олж идэх чадвартай боллоо. Амссан зовлон нь түүний итгэлд нөлөөлөн ганхуулах болсон байв. Гэвч эхнэрийг минь шоронд орсноос хойш хоёр жил өнгөрөхөд тэд түүнд эхтэйгээ уулзах зөвшөөрөл олгожээ. Коммунистуудын шоронгийн төмөр торны цаана суугаа ээжтэйгээ тэр уулзаад халтартсан царайтай, турж эцсэн, эвэршин хатаж ширүүссэн гартай болчихсон ээжийгээ хоригдлын хэлхгэр муухай хувцастай байгааг харав. Эхийгээ арай л гэж танилаа. Түүний амнаас гарсан хамгийн эхний үг “Михай! Хүү минь! Есүст л итгэ!” хэмээх үгс байлаа. Галзууртлаа уурласан харгалзагч нар түүнийг татан зулгаасаар

холдуулан авч гарлаа. Ээжийг нь чирэн цааш явахыг хараад Михай дуугүйхэн мэгшин уйлж зогслоо. Энэ бол түүний баттай шийдвэр гарган Христэд амь алдравал үүрд зориулах аяны эхлэл байв. Хэрэв ийм аймшигтай нөхцөлд ч гэсэн хүн Христийг хайлаж чаддаг юм бол тэр гарцаагүй цорын ганц үнэнч найдвартай Аврагч байж таарна гэдгийг тэр сайн мэдэж байлаа. Дараа нь тэр “Христийн сургаалд намайг итгүүлэх өөр ямар ч баримт байхгүй байсан ч ээжийнхээ ийнхүү итгэж байгааг харах нь надад хангалттай, үүнээс өөр баримт баталгаа надад огт хэрэггүй.” гэж хэлэв. Тэр яг энэ өдөр Христийг аврагчаа болгон амьдралаа түүнд бүрэн даатган өгсөн билээ.

Сургуульд суралтад гэж тэр байнга тэмцэлддэг байв. Маш сайн суралтад байсан тул түүнийг Залуу Коммунист Пионерүүдийн гишүүний бэлгэ тэмдэг болсон улаан бүчээр шагнав. Тэгтэл хүү минь, “Эцэг, эхийг минь широнд хорьсон хүмүүсийн улаан бүчийг хэзээ ч зүүхгүй” гэж хэлснийхээ төлөө сургуулиасаа хөөгдлөө. Тэгээд нэг жил алдсаны дараа дахин сургуульдаа орсон ба энэ удаад тэр Христэд итгэгч хоригдлын хүү болохоо бусдаас тас нуухыг хичээж байв.

Гэтэл хожим нь түүнд Библийг үгүйсгэсэн сэдэвтэй бүтээл бичих даалгавар өгчээ. Энэ бүтээлдээ тэрээр, “Библийг үгүйсгэн тавьж буй шалтгаанууд нь дэндүү хүч муутайн зэрэгцээ Библийг үгүйсгэхийн тулд иш татан хэлж байгаа үгс нь хүртэл худал байна. Профессор өөрөө Библийг огт уншиж үзээгүй нь илэрхий. Библи бол шинжлэх ухаанд харшилдаггүй, харин гайхалтай сайн нийцэж байдаг юм” гэж бичсэн байв. Тэгээд дахиад л сургуулиасаа хөөгдөн хоёр жил сургууль завсардлаа.

Эцэст нь түүнд семинарт суралцах зөвшөөрөл өгчээ. Энд түүнд “Марксизмын онол”-ыг зааж байв. Юм бүхнийг Карль Марксын үзлээр тайлбарлана. Михай үүнийг ангидaa олон нийтийн өмнө ил тодоор эсэргүүцэхэд бусад оюутнууд ч түүнтэй нэгдэн үр дунд нь бас дахиад сургуулиасаа хөөгдөн цаашид суралцах боломжгүй болов.

Сургууль дээр нь нэг удаа профессор шашингүй үзэл нэвт шингэсэн агуулгатай яриа хийж байхад нь миний хүү босч зогсоод ийм олон залуу хүнийг буруу замаар удирдан дагуулж буй түүний үүрэг хариуцлагын талаар сануулан хатуухан хэлжээ.

Ангийнхан нь тэр чигтээ түүний талд зогсож байв. Тэдний дотроос хэн нэг нь зориглон ам нээх шаардлагатай байсан нь мэдээжийн хэрэг. Тэгснээр бусад бүх оюутнууд түүний талд орон санал бодлоо илэрхийлж байв. Боловсрол олж авахын тулд Христэд итгэгч хоригдол Вурмбрандын хүү болохоо нуух хэрэг түүнд ямагт гарна. Гэвч дараавч дардайна, булавч бултайна гэгчээр илэрчихдэг байв. Тэгээд өнөөх л улиг болсон захирлын өрөөнд дуудагдан хөөгдөх шийдвэрээ сонсох хэрэг давтагдана.

Михай ч бас өлсгөлөнгөөс болж нилээд их зовсон. Коммунист дэглэмтэй орнуудад широнд хоригдож буй Христэд итгэгчдийн гэр бүлийнхэн ихэвчлэн өлсгөлөнгийн туйлд хүрч үхэхээс наагуур юм болно. Тэдэнд туслах нь аймшигт гэмт хэрэгт тооцогдоно.

Би та нарт өөрийн хамгийн сайн мэдэх нэг гэр бүлд тохиолдсон өмгэнэлт хэргийн талаар цулас өгүүлье. Нууц бүлгийн ажилд зүтгэсэн гэдэг шалтгаанаар залууг баривчлан широнд хорив. Түүний ард зургаан хүүхэдтэй эхнэр нь үлджээ. Түүний том охидууд нь арван долоо, арван естэй сайхан охидууд байсан боловч огт ажил олдохгүй байв. Коммунист оронд ажил олгогч ганц хүчин нь засгийн газар байх ба тэд Христэд итгэгч хэрэгтнүүдийн үр хүүхэд ар гэрийнхэнд ажил олгодоггүй байлаа. Энэ түүхийг ёс суртахууны хэм хэмжээний үүднээс нь авч үзэн шүүх гэж яарсны хэрэггүй! Үнэн бодит баримтыг л хүлээн ав! Христэд итгэгч, итгэлдээ үнэнч байсаар амиараа дэнчин тавьсан баатрын хоёр том охин нь хэдийгээр өөрсдөө Христэд итгэгч байсан боловч өнчин жаахан дүү нар, хүнд өвчтэй эхээ асран тэжээхийн тулд биеэ худалдаж эхлэв. Үүнийг харсан тэдний арван дөрөвтэй эрэгтэй дүү нь галзуурч сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтэх боллоо. Олон жилийн дараа хоригдол эцэг нь суллагдан гарч ирсэн боловч түүний Ертөнцийн Эзэнээс гүйдаг байсан ганц гүйлт нь:“Эцэг минь, та намайг буцаагаад широнд хийгээч. Би үүнийг хараад байж үнэхээр тэсэхгүй нь!” гэдэг ганц үг байв. Түүний энэ хүсэлт биелсэн ба тэр одоо ч широнд сууж байна. Тэрээр хүүхдүүдэд Христийн тухай ярж зааж өгснийхөө төлөө дахин баривчлагдсан юм. Түүний охидууд цаашид биеэ худалдахаа бүрмесөн больсон. Тэд нууц цагдаагийнхны шахалтыг зөвшөөрч даган биелүүлснээр ажилтай болж, тэдний мэдээ-

лэл дамжуулагч туршуулууд болов. Нэгэнт эцэг нь итгэлтэй сайн хүн байсан тул тэднийг Христэд итгэгч ямар ч айл дуртайяа гэртээ оруулан ярилцдаг байлаа. Тэд анхааралтай сонсож байгаад сонссон болгоноо нууц цагдаагийнханд мэдээлдэг байв. Ёстой заваан, ёс суртахуунгүй бузар хэрэг байна гэж бүү хэл, мэдээж энэ үнэн л дээ, гэвч та өөрөөсөө асуу. Ийм эмгэнэлт байдалд орсон Христэд итгэгчдийн ар гэрийнхэнд эрх чөлөөтэй, жаргалтай байгаа та нөхөд туслахгүй бол тэр хоёр охины хийсэнтэй л адил гэм болох бус уу?

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нийтдээ би арван дөрвөн жилийг шоронд өнгөрүүлэв. Энэ хугацаанд би нэг ч Библи болон Библийн холбогдолтой ном хэвлэлүүд олж харсангүй, бүр яаж бичдэгийг ч бараг мартсан байв. Өлсөх, цангах, дээр нь цаг наргүй зодуулан тамлуулсаар байгаад би Библийн үгийг ч санаахаа болих хүртлээ мартсан байлаа. Гэтэл арван дөрвөн жил өнгөрсний дараа мартсан оюун ухаанд минь нэг үг орж ирэв.“Яахоов Рахийлийг авахын тулд арван дөрвөн жил ажиллах хэрэгтэй байсан боловч тэр түүнд маш их хайртай байсан тул энэ нь түүнд туйлын богино хугацаа шиг санагдаж байв.“ Зөвхөн энэ үгийг л би санаж байлаа.

Үүнээс хойш нэг их удалгүй манай оронд болж байсан бүх нийтийн өршөөлийн жилээр би суллагдах боллоо. Өршөөлийн жил гэж зарлан суллах ажиллагааг явуулахад америкийн олон нийтийн санал бодол чухал түлхэц болон нөлөөлсөн билээ.

Би эхнэртэйгээ дахин уулзав. Тэр намайг арван дөрвөн жилийн турш үнэнчээр хүлээжээ.

Нэгэнт хүнийг баривчилсаныхаа дараа тэд бүх эд хөрөнгийг нь хураан авдаг байсан тул бидэнд юу ч байсангүй. Бид асар ядуу байсан ч амьдралаа хамтдаа дахиад шинээр эхлэх болсондоо баяртай байв.

Христэд итгэгчдийн бүлгийн суллагдсан ахлагч, бусад байгууллагын тэргүүн лам нарт ахалж ажиллах жижиг байгууллага олддог байв. Орсова хот дахь нэг байгууллагыг ахлах ажлыг надад өгөв. Шашны асуудал эрхэлсэн хэлтсийн коммунист зүтгэлтэн надад энэ байгууллага гучин таван гишүүнтэй, хэзээ ч гучин зургаа болж болохгүйг, мөн би бас тэдний туршуул болж гишүүдийнхээ хаана юу хийж байгаа талаар байнга мэдээлж, залуусыг ойртуулахгүй хол байлгах үүрэгтэйг хатуу анхааруулав. Коммунистууд Христэд итгэгчдийг захирахын тулд энэ мэт байгууллагыг“захиргаадах“ аргадаа ашигладаг байлаа.

Хэрэв намайг сургаал заавал олон хүн сонсох гэж ирнэ гэдгийг би мэдэж байв. Тийм учраас би албан ёсоор ямар нэг байгууллагад ажиллахыг нэг их хичээсэнгүй, харин дахиад л нууц бүлэгт нэгдэн ажиллаж эхлэв. Би тэдэнд энэ ажлын аюул болоод гайхамшигтай сайхныг хэлж өгдөг байв.

Намайг шоронд сууж байх хэдэн жилийн турш Ертөнцийн Эзэн тун гайхамшигтайгаар ажлаа хийсээр байлаа. Нууц бүлэг маань мартагдсан, хүнгүй хаягдсан байдалтай байхаа хэдийн болжээ. Америк болон бусад орнуудын Христэд итгэгчид бидэнд туслан, бидний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярих болсон байлаа.

Нэг өдөр үд өнгөрч байхад би ойролцоо хотод байх итгэл нэгт нөхрийнхөө гэрт амраад хэвтэж байв. Тэр намайг гэнэт сээрэж, “Хилийн чанадаас ах дүү нар маань ирлээ!” гэв. Баруунд биднийг мартаагүй, хаяагүй ахан дүүс маань байсаар байжээ.

Христэд итгэгч, хохирогчдын ар гэрийнхэнд туслах болон Христийн сургаалтай холбоотой ном зохиолууд нууцаар хил давуулан оруулах ажлыг хийхээр нилээд хэдэн байгууллага, бүлгүүд хамтран ажиллаж байгаа нь энэ байв.

Нөгөө өрөөнд нь ороод энэ ажлыг хийхээр ирсэн зургаан эр сууж буйг мэдэв. Тэд надтай удаан ярилцлаа. Нилээд удаан ярилцсаны эцэст тэд бидэнд энэ хаягаар яваад очвол шоронд арван дөрвөн жил болоод гарсан итгэгч эрийг олох болно гэсэн болохоор түүнтэй уулзах гэж бид ирсэн гэж хэлэв. Тэгээд би тэдэнд хайж яваа хүн чинь би байна гэлээ. Тэд, “Бид меланхолик байдалтай хүнтэй уулзах байх гэж бодож байсан шүү. Та тэр хүн байж явч таарахгүй, та чинь оргилсон их баяр хөөр дүүрэн хүн байна!” гэж хариу хэлэв. Би тэдэнд хайгаад байгаа хүн нь би мөн бөгөөд миний ийнхүү хөөрөн баярлаж байгаагийн шалтгаан нь тэдний ирсэн явдал гэдгийг батлан хэлэв. Үнэндээ биднийг мартаагүй, санаа тавих хүмүүс байсаар байна гэдгийг мэдэх нь хязгааргүй их баяр хөөрийг өгч байлаа. Нууц бүлэгт тасралтгүй, тогтмол туслах ажил ийнхүү эхлэв. Олон нууц арга зам, сувгуудаар бид Библи болон Библийн холбогдолтой ном зохиолууд оруулж, хоригдож буй итгэгч нөхдийнхөө ар гэрийнхэнд тус дэмжлэг үзүүлсээр байв. Одоо нэгэнт бид тэдний

тусlamжийг олж авч урам зориг орсон тул нууц бүлгийн маань ажил тун эрчимтэй урагшилж байлаа.

Тэд бидэнд Ертөнцийн Эзэний үгийг авчирч өгч хангаад зогсохгүй, гол нь бидэнд хайртай гэдгээ илэрхийлж байсан юм. Тэд бидэнд сэтгэл тайвшруулан урам зориг өгөх үгийг дамжуулдаг байв.

Бидний тархийг угаах гэж оролдож байсан тэр өдрүүдэд цаг үргэлж “Хэн ч та нарыг хайлрахгүй. Та нар хэнд ч хайлруулах улс биш. Хэн ч та нарт хайргүй” гэх үгсийг өдөржин шөнөжин сонсож байв. Гэтэл одоо бид өөрсдийн амь насыг дээсэн дөрөөн дээр тавьж бидэнд хайртайгаа харуулахаар ирсэн америк, английн итгэгч ахан дүүсээ харж байна. Биднээс зөвлөгөө аван тэд өөрсдийн нууц ажлын арга барилаа улам бүр боловсронгуй болгон хөгжүүлсээр. Нууц цагдаагийнхны бүслэн отсон байшинд хүртэл тэд элгээрээ мөлхсөөр ямар ч хүнд мэдэгдэхгүй ороод ирж чаддаг боллоо. Цагдаа нар тэднийг тийш орсныг огт мэдэж чаддаггүй байв.

Библийг ийнхүү нууцаар хил давуулан оруулах нь хичнээн чухал, үнэ цэнэтэй болохыг Библиэр хахаж цацан умбаж байдаг америк, английн итгэгчид яаж ч ойлгох билээ.

Хилийн чанад дахь Христэд итгэгчдийн чин сэтгэлийн гуйлт болон материаллаг тусlamж байгаагүй бол манай гэр бүлийнхэн лав амьд гарахгүй байх байлаа. Коммунист орнуудын шоронд хоригдож байгаа итгэгчид болон олон нууц бүлгийн ахлагч нарын хувьд байдал минийхээс ялгараад байх юмгүй. Би өөрийн амьдралын туршлагаас үүдэн Их Британи дахь Христэд итгэгчдийн Европын Нийгэмлэгийнхний өгч байсан эд зүйлс үнэхээр тус болсон төдийгүй тэдний өгч байсан оюун санааны дэмжлэг нь хэлэхийн аргагүй их тус болсон гэдгийг баттай хэлж чадна. Бидний хувьд тэдний илгээсэн хүмүүс бол Ертөнцийн Эзэний илгээсэн ер бусын элч нар шиг санагдаж байв!

Нууц бүлгийн ажил нь шинэчлэгдэн сэргэж эхэлсэнтэй холбогдон миний хувьд дахин баривчлагдах аюул улам илүү бодитоор нүүрлэлээ. Тэр үед Иудейчуудын дунд ажиллах Норвегийн Нийгэмлэг болон Христэд итгэгч Еврэйчуудийн Эвсэл хэмээх Христэд итгэгчдийн хоёр байгууллага хамтран миний төлөөс

болгон 2500 фунт стерлингийг засгийн газарт төлснөөр би Румыныг орхин явах шаардлагатай болов.

КОММУНИСТ РУМЫНЫГ ЯАГААД ОРХИВ?

Хэрвээ нууц бүлгийн ахлагчид маань намайг энэ боломжийг ашиглаад заавал явж “чөлөөт ертөнц” дэх бидний “дуу хоолой” бол гэж ятган тушаагаагүйсэн бол би ямар ч аюул ослыг үл тоон Румындаа үлдэх байлаа. Тэд намайг өөрсдийнх нь өмнөөс хавчлага зовлон болоод хэрэгтэй байгаа бүхнийхээ тухай та бүхэнд ярьж ойлгуулаасай гэж хүсч байв. Би хэдийгээр баруунд гарсан боловч сэтгэл зүрх минь тэдэнтэйгээ хамт эх нутагтаа үлдсэн. Нууц бүлгийнхний ажил үйлс болон хавчлага зовлонгийн тухай та бүхэнд дуулгах нь асар их ач холбогдолтой болохыг мэдээгүй байсан бол би хэзээ ч Румынаас явахгүй байсан. Гэвч энэ бол миний хийх ёстой ажил байв.

Румынаас явахаас минь өмнө нууц цагдаагийнхан намайг хоёр ч удаа дуудан уулзав. Миний өмнөөс төлсөн тэр мөнгийг тэд хүлээн авснаа мэдэгдлээ. (Коммунизмын уршгаар манай оронд учраад байсан эдийн засгийн хүндрэлээс гараахын тулд румын улс иргэдээ гадаадынханд худалддаг байв.) Тэд хэлэхдээ, “Баруунд гараад Христийн тухай хүссэнээрээ тунхагла, гэхдээ биднийг зүгээр орхи! Биднийг бүү муулж яры! Хэрэв юу болсон тухай ярьдаг л юм бол бид чамд ямар гай учруулахаа аль хэдийн төлөвлөсөн гэдгээ хэлье. Юуны өмнө 500 фунт стерлингээр алуурчин хөлслөж аваад чамайг үгүй хийнэ, эсвэл хулгайлаад энд авчирна.” гэв. (Намайг шоронд байхад Австралид байхдаа хулгайлалгдан Румынд эргэж ирсэн үнэн алдартны шашны байгууллагын тэргүүн лам Вазил Луиль гэдэг хүн надтай хамт нэг өрөөнд байсан юм. Түүний гарын бүх хурууны хумсыг хуулан авсан байв. Берлинээс хулгайлалгдан ирсэн өөр олон хүмүүстэй би таарч байсан. Саяхнаас Итали, Парисаас хулгайлан авчрах болсон билээ.) Тэгээд цааш үргэлжлүүлэн, “Ёс суртахууны хувьд ч бид чамайг сүйрүүлж чадна. Чамайг залуухан охинтой амрагийн холбоотой байсан тухай үлгэр зохиогоод залуу зандан насны чинь шившиг гээд дэлгэж өгөхөд чи аймшигтай гэмтэй этгээд болж хувирна. Тэр цагт хэн чиний үгийг тоож сонсох

билээ? Барууныхан тэр дундаа американчууд их итгэмтгий амархан хууртдаг улс“ гэж хэллээ.

Намайг ийнхүү сүрдүүлж аваад дараа нь баруунд гарах зөвшөөрөл олгов. Надад учруулсан зовлонгоос болж тэд өөрсдийн тархи угаах арга нь сайтар хэрэгжсэн хэмээн сэтгэж, үүндээ бүр дэндүү итгэлтэй байгаа бололтой байв. Миний адил зовж явсныхаа эцэст баруунд гарсан хүн олон байдаг боловч бүгд л амаа хамхин дуугүй сууцгаадаг. Тэдний зарим нь коммунистуудын гарг хэрхэн тамлуулж байснаа бүр маргчихаад одоо бүр коммунизмыг шагшин магтах болжээ. Тиймээс коммунистууд намайг тэдний адил таг дуугүй сууна хэмээн бат итгэж байжээ.

Тийнхүү 1965 оны арван хоёрдугаар сард би гэр бүлийн хамт Румыныг орхин явлаа.

Явахаасаа өмнө би намайг баривчлан, тамлан зовоох тушаал өгч байсан хурандаагийн булш руу очив. Энэ бол миний румынд хийх сүүлчийн ажил байлаа. Би түүний булшин дээр цэцэг тавьж, сэтгэл зүрх нь хоосрон таг харанхуй болсон коммунистуудад баяр жаргал өгөх Христийн сайхан мэдээг тунхаглахад өөрийгөө зориулах болно хэмээн бат шийдсэнээ илэрхийлсэн билээ.

Коммунист дэглэмийг би үзэн яддаг боловч хүмүүст хайртай. Би гэмийг үнэнхүү үзэн яддаг боловч гэмт хүмүүсийг хайрлан энэрдэг. Коммунистуудыг би маш их хайлладаг. Коммунистууд Христэд итгэгчдийг алж болох боловч тэдний амийг нь хөнөөж байгааг мэдсэн ч хайрласаар байдаг агуу их хайрыг нь устгаж чадахгүй. Коммунистууд болоод намайг тамлан тарчлааж байсан тэр хүмүүст би гомдон үзэн яддаггүй, очуухэн төдий ч тийм сэтгэл байхгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Иудейчуудын дунд ам дамжин яригддаг нэгэн домог бий. Тэдний өвөг дээдэс египитүүдийн гараас аврагдан, харин египитүүд Улаан Тэнгист живж үхэж байхад ер бусын элч нар баярлалдан Израйльчуудтай нэгдэн ялалтын дуу дуулж байсан гэдэг. Тэгтэл Ертөнцийн Эзэн ер бусын элч нарт хандан, “Иудейчууд хүмүүс учраас амьд мэнд зугтан гарсандаа баярлан дуулах нь аргагүй. Гэтэл та нар тэднээс илүүг ойлгон ухаарч байх ёстой биш билүү? Египитүүд ч бас миний бүтээсэн бүтээл биш гэж үү? Би тэднийг ч бас хайлрадаггүй гэх нь үү? Тэдний эмгэнэлт хувь заяаны төлөө би хэрхэн харуусан шаналж байгааг та нар огт ойлгохгүй байна уу?” гэжээ.

Эрийхүү хотын дэргэд Ишуугаа ирээд нүдээ өргөн дээш хартал нэг аварга биетэй хүн гартаа сэлмээ атгачихсан түүний талд, түүний эсрэг зогсч байгааг олж харав. Ишуугаа түүн рүү гүйн очоод хэлсэн нь,

— Та бидний талд байна уу, эсвэл бидний дайсны талд байна уу? гэв.

«Ишуугаа Эрийхүү хотын ойролцоо сууж байх үедээ нэгэн удаа өмнө нь сэлмээ хийнаас нь сугалаад барьчихсан нэг эр зогсож байхыг харжээ. Ингээд Ишуугаа түүн дээр очоод: “За, та чинь манай хүн үү, дайсны хүн үү?” гэхэд нөгөө хүн ... » (Ишуугаа 5.13)

Хэрэв Ишуугаагийн уулзсан тэр хүн зөвхөн хүн байсан бол түүний хэлэх үг нь ердөө л “Би танай талд байна”, “Би танай дайсны талд байна” эсвэл бүр ч эсрэгээр “Би аль аль талд нь байна” гэж хэлэх байсан биз. Гэвч Ишуугаагийн уулзсан тэр аварга хүн өөр хүрээнийх байсан тул түүнээс Израйльчуудын талд, эсвэл тэдний эсрэг байгааг нь асуухад тэр огт төсөөлөөгүйгээр барахгүй ойлгохын аргагүй хэцүү хариу өгөв. Тэ-

рээр “Үгүй ээ!” гэж хэлэв. Энэ “Үгүй ээ!” гэдэг нь чухам юу гэсэн үг юм бол?

Тэр бол бие биенийхээ талд орж, эсвэл эсэргүүцэн зогсч тэмцэж байдаг ертөнцийнх биш, харин бүгд бие биенээ халуун дотно энэрэн хайлаж, энэ хайр нь гал мэт улам бүр бадран байдаг ертөнцийнх байлаа.

Ямар ч байсан хүн байгаа цагт хүний нийгэм байж л таарна. Тиймээс хүн чанарын үүднээс коммунизмыг эсэргүүцэн тэмцэх нь зөв хэрэг. Хүн чанарын үүднээс л бид коммунизмыг эсэргүүцэн түүний харгис хэрцгийн хэрэг үйлдлүүдийг дэмжин сайшаагчдыг буруушаан тэмцэх хэрэгтэй.

Гэтэл Христэд итгэгчид гэдэг чинь жирийн хүнээс ч илүү. Тэд бол Ертөнцийн Эзэний хүүхдүүд, түүний ер бусын ариун дархан чанараас олж аван эзэмшигчид билээ.

Тиймээс коммунистуудын ямар ч тамлал, шоронгийн зовлонт амьдрал намайг коммунистуудыг үзэн ядахад хүргээгүй. Тэд ч гэсэн Ертөнцийн Эзэний бүтээлүүд. Тийм байхад би яаж тэднийг үзэн ядах билээ? Мөн хэрхэн найз нөхөр нь байж болох билээ?! Найзлан нөхөрлөх гэдэг чинь сүнсээрээ нэгдэн нөхөрлөхийг хэлдэг биш үү? Би коммунистуудтай сүнсээрээ нэгдэн нэг мэт салшгүй холбоотой байж явч чадахгүй. Тэд Ертөнцийн Эзэнтэй холбоотой юм бурийг үзэн яддаг, гэтэл би түүнийг маш ихээр хайлладаг.

Хэрэв надаас “Та коммунистуудын талд байна уу, эсвэл тэдний эсрэг байна уу?” гэж асуувал миний өгөх хариуг ойлгоход туйлын ярвигтай байх болно. Коммунизм бол хүн төрөлхтөнд учирсан хамгийн агуу аюул заналхийлэл мөн. Би үүнийг байдгаараа эсэргүүцэн үүнийг нуран унатаал нь эцсийн хүчээ шавхан тэмцэх болно. Гэвч энэ бүхний хажуугаар би Есүсийн хамт ер бусын мөнхийн улсад сууж байгаа билээ. Би “Үгүй ээ!” гэх тэр л ертөнцөд харьяалагдах тул тэдний үйлдэж буй бүх гэмт хэргийг буруушаан зэмлэх боловч коммунистуудыг ойлгон хайлана. Миний энэ ертөнцөд ер бусын амьд биетүүд оршин байх ба тэд хүн төрөлхтөнд амьдралын зорилгоо олж авч, Христийн адил зан чанартай болоход нь тусладаг. Тиймээс миний зорилго бол коммунистуудад Христийн авралын мэдээг тунхаглан тэдэнд

мөнхийн амьдралын тухай гайхамшигтай мэдээг таниулах явдал болой.

Миний Их Эзэн Христ ч гэсэн коммунистуудыг хайлладаг. Тэр өөрөө хүн бүрт хайртай гэдгээ хэлсэн. Хязгааргүй ихээр хайлладаг учраас хэнийг ч буруу замаар явуулахгүйн тулд, хэнийг ч мөнхийн зовлонд оруулахгүйн тулд зөв замаар яваа ерэн есөн хонь мэт хүмүүсээ орхиод тэнэж төөрсөн хөөрхий ганц хүнийг аврахын тулд хойноос нь явах болно гэдгээ хэлсэн билээ. Түүний төлөөлөгчид болон Христийн сургаалыг тунхаглан заагч аугаа их хүмүүс ч гэсэн түүний нэрээр бүгдэд хүргээлтэй энэхүү аугаа их хайрын тухай зааж сургаж байсан. Гэгэн Макари хэлэхдээ, “Хэрэв хүн бүх хүнийг чин сэтгэлээсээ энэрэн хайлж чадаг боловч нэг л хүнийг хайлж чадахгүй байна гэж хэлж байгаа л бол Христэд итгэгч биш гэсэн үг, учир нь тэрээр бүх хүнийг хүлээн авч хайлрах чадваргүйд байгаа юм“ гэжээ. Гэгэн Августин хэлэхдээ, “Хэрэв хүн төрөлхтөн тэр аяараа зөв шудрага байгаад зөвхөн ганц хүн л гэмтэй байсан бол Христ бүх хүний төлөө эдэлсэн тэрхүү зовлонг ч бас тэр ганц хүний төлөө туулан гарах болно. Учир нь тэр хүн бүрт хайртай билээ“ гэсэн байдаг. Христэд итгэгчдийн сургаал туйлын энгийн агаад тодорхой, далд нууц утгагүй. Коммунистууд бол хүмүүс тиймээс Христ тэдэнд хайртай. Иймд Христийн адил бодол санаатай хүн бүр тэднийг мөн хайлрана. Хэдийгээр бид гэмийг үзэн яддаг боловч гэмт хүмүүсийг хайлладаг.

Бид өөрсдөө тэднийг хэрхэн хайлж байгаагаа хараад коммунистуудыг хайлладаг Христийн хайрыг тодорхой мэдэх болно.

Христэд итгэгчдийг коммунистууд широнд хорихдоо 50-ийн жинтэй гинж хөлд нь зүүж, улайтал нь халаасан төмөр хадаасаар цоолон түлж, дараагаар нь хоолой руу нь халбага дүүрэн давс цутган ямар ч ус өгөхгүй цангааж, өлсгөж, ташуурдан, хөлдөөгчид хийн хөлдөөж гэсгээн янз бүрээр тамлах боловч тэд коммунистуудын төлөө Ертөнцийн Эзэнтэйгээ тэвчээртэй ярин шантралгүй гүйсаар байлаа. Хүний ухаанаар үүнийг тайлбарлах арга үнэндээ үгүй! Энэ бол бидний зүрх сэтгэлд гүн бат орших Христийн аугаа их хайр юм.

Дараахан нь биднийг тамлан зовоож байсан нөгөө коммунистууд өөрсдөө бас широнд оров. Коммунист дэглэмтэй улс ор-

нуудын хувьд коммунистууд, түүн дотроо удирдагч нар нь дайс-нуудынхаа адил шоронд орох нь олонтаа, бараг ямар ч ялгаагүй байдаг. Тэгээд одоо тамлан зовоогч, тарчлан зовж байсан хоёр нэг өрөөнд хоригдож сууна. Христэд итгэдэггүй хоригдлууд Өөрсдийг нь тамлан тарчлаагч байсан тэднийг үзэн ядаж зодож занчиж байхад итгэдэг нөхөд маань амь өрсөн байж тэднийг өмөөрөн хамгаалж, тэдний өмнөөс зодуулах нь энүүхэнд. Тэгээд зогсохгүй хамгаалан өмгөөлснийхөө төлөө коммунистуудтай нэгдлээ гэж ад үзэгдэн давхар яллагдана. Өөрсдийнх нь амийг аварч болох сүүлчийн эм тариа, талхaa урьд өөрийг нь тамлаж байсан боловч одоо нэг шоронгийн хоригдол нөхөр болсон коммунистад өгч байгаа Христэд итгэгчдийг би олонтаа харсан. (Тэр үед бидэнд долоо хоногт ганц л удаа нэг зүсэм талх өгдөг байсан юм.)

Шоронд нас барсан Румыны ерөнхий сайд агсан, Христэд итгэгч Иулио Маниюгийн сүүлчийн угс: “Хэрэв манай улс коммунист дэглэмийг түлхэн унагааж, коммунистуудыг гудамжнаа хөөн гаргавал тэдний дарангуйллыг тэсэн зовж байсан ард түмний шудрага уур хилэнгээс тэднийг аврахаар өөрийн амь биеийг үл хайлран тэмцэх нь Христэд итгэгчдийн ариун журамт үүрэг юм” гэсэн угс байлаа.

Христиин хүн болсон анхны хэдэн өдрөө надад цаашид амьдарч чадахгүй юм шиг санагддаг байв. Гудамжинд алхан явж байхдаа би хажуугаар минь өнгөрөх эрэгтэй, эмэгтэй хүн бүрийн эдлэх зовлон шаналалыг биеэрээ мэдрэх шиг болно. Энэ нь зүрхэнд минь хутга зоогчихоод байх шиг санагдах агаад энэ хүн аврагдсан болов уу, үгүй болов уу гэдэг асуулт сэтгэлд минь шатах мэт дүрэлзэнэ. Хэрэв бүлгийн хэн нэг хүн гэм хийснийг мэдвэл хэдэн цагаар харусан уйлна. Хүн бүр аврагдсан байхыг харах их хүсэл сэтгэл зүрхэнд минь гал адил улам бүр дүрэлзэн ассаар байсан ба коммунистуудыг ч тэдний эгнээнээс гарган хаялгүй санаа тавьсаар байсан юм.

Ганцаар хорих өрөөнд бид урьдын адил Ертөнцийн Эзэнтэй олон цаг тухтай яриад байж чадахаа болив. Бид төсөөлөхийн аргагүй ихээр өлсөнө. Ухаан мэдрэлээ алдтал маань хоол өгөхгүй өлслгөн байлгадаг байлаа. Бид бараг араг яс болтлоо эцэж турж, ядарч байв. Их Эзэний Ертөнцийн Эзэнтэй ярьсан яриа ч

бидний хувьд дэндүү урт санагдах боллоо. Үүнийг хэлж дуусгах хүртлээ ухаан санаагаа төвлөрүүлж чадахгүй болсон байв. Ертөнцийн Эзэнтэй ярихдаа би дахин дахин “Есүс өэ, би танд хайртай!” гэсэн хэдхэн үгийг хэлдэг байлаа.

Тэгтэл, нэгэн гайхамшигтай сайхан өдөр би Есүсийн хэлэхийг сонсов. Тэр надад, “Чи надад хайртай гэл үү? Харин одоо би чамайг хэрхэн хайрладагаа харуульяа” гэж хэлсэн юм. Тэгээд сэтгэл зүрхний минь гүнээс гал дүрэлзэн шатах мэт халуу оргин яг л дүрэлзэн асах их гал мэт болов. Еммай тосгоноос гараад явахдаа дагалдагч нар Есүсийг тэдэнтэй ярьж байх үед тэдний сэтгэлд гал бадран байсан тухай хэлсэн байдаг. Яг л ийм хэрэг надад тохиолдсон юм. Бид бүгдийн төлөө загалмай дээр амиа өгсөн Их Эзэнийхээ хайрыг би сайн мэдэж байв. Тийм аугаа их хайр коммунистуудыг гадуурхаж орхихгүй. Хэдийгээр тэдний гэм дэндүү их ч үүнийг нь үл тоон хайрласаар байх аугаа их хайр бол зөвхөн миний Их Эзэний хайр билээ.

Коммунистууд аймшигт гэмт хэргийг үйлдсэн ба одоо ч үйлдсээр байгаа боловч тэд «аугаа их тэр хайрыг ширгээж чадахгүй, мөн үерийн усанд живүүлэх мэт устгах хүч тэдэнд байхгүй. Хайр гэдэг бол үхлийн адил асар их хүч чадалтай. Хар санаа, хардалт гэдэг нь булш адил харгис хэрцгий» билээ. Гүн харанхуй булш баян, ядуу, хөгшин залуу гэж ялгахгүй үндэстэн бүрийн эрэгтэй, эмэгтэй, үндэсний баатар, улс төрийн зүтгэлтэн, ариун санваартан, гэмт хэрэгтэн ер огт хамаагүй хүн бүрийг, бүр бүгдийг зөвхөн өөрийн болгох гэж шунан тэмцдэгийн адил их хайр ч бас бүгдийг хүлээн авч энэрэн хайрладаг. Аугаа их хайрын биелэл болсон Христ Их Эзэн коммунистуудыг өөрийн болгож авахаас нааш хэзээ ч тэднийг хайрлахаа болихгүй, хайрласаар л байх болно.

Миний өрөөнд Христэд итгэгчдийн нэг бүлгийн ахлагчийг оруулж хаяв. Тэр бараг үхлүүт байлаа. Нүүр толгой, бүх биеэс нь цус урсаж байв. Түүнийг байж болшгүй аймшигтайгаар тамлан зодож занчжээ. Бид түүнийг угааж, шархыг нь цэвэрлэв. Зарим хоригдлууд коммунистуудыг хараан занаж зүхнэ. Гэтэл арайхийж ам ангайн санаа алдан тэрээр, “Тэднийг битгий харааж зүх, гүйя! Дуугүй болж үз! Би тэдний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярихыг хүсч байна.” гэж хэлэв.

ШОРОНД ХҮРТЭЛ АЗ ЖАРГАЛТАЙ БАЙДГИЙН МИНЬ ШАЛТГААН

Шоронд өнгөрөөсөн тэргээх арван дөрвөн жилийг эргэн санан дурсахуйд надад асар их зовлон зүдгүүрийн хажуугаар гайхалтай баяр жаргалтай мөч олон байсан нь тов тодхон санагдана. Хамгийн аймшигтай, яргачид буй нөхцөлд байгаа хир нь Христэд итгэгчид хэрхэн ийм их баяр жаргалтай байж чаддагийг бусад хоригдлууд төдийгүй зарим шоронгийн хуяг, харгалзагч нар гайхан алмайрдаг байв. Хэдийгээр биднийг Их Эзэнээ магтан дуулсан гэж зодж шийтгэдэг байсан ч зогсоох арга тэдэнд байсангүй. Алтан гургалдай дуулж дууссаныхаа дараа үүнийхээ төлөө алуулна гэдгээ мэдэж байсан бол амь биеэ үл тоон дуулах л байсан мэт төсөөлнө. Шоронд хоригдож байсан итгэгчид баярласандаа болж заримдаа бүжиглэдэг байв. Ийм эмгэ нэлтэй байдалтай байгаа мөртлөө тэд яж ийм их баяр баясгалан, аз жаргалтай байж чадна вэ?

Шоронд байхдаа би Есүсийн дагалдагч нартаа хандан хэлсэн “Мөнхийн Эзэний харж буйг олоод харах чадвартай хүмүүс үнэхээр ерөөлтэй” хэмээх хэдэн үгийн талаар маш их боддог байв. Дагалдагч нар нь Палестинд болсон аймшигт явдлыг нүдээр үзээд ирсний дараахан энэ явдал болжээ. Палестин бол эзлэгдсэн, хүн ард нь дарлуулан зовж буй улс байв. Тэр нутгийн хaa сайгүй харгис хэрцгийгээр дарлуулан зовж буй хүмүүс дүүрэн байсан ба тэдний зовлон аймшигтай их байлаа. Дагалдагч нар ч бас өвчин эмгэг, тахал, гай гамшиг, өлсгөлөн, уй гашуутай тулгарчээ. Тэдний орсон айл бүрийн эрэгтэй хүнийг эсэргүү хэмээн баривчлан шоронд хийж, ард нь хөөрхий эцэг эх, эхнэр хүүхдүүд нь уйлан хайллан хоцорсон байдаг байв. Энэ бол хараад байхаар сайхан амьдралын дүр зураг огтхон ч биш байлаа.

Тэгтэл Есүс “Мөнхийн Эзэний харж буйг олоод харах чадвартай хүмүүс үнэхээр ерөөлтэй” гэсэн байна. Энэ бол тэд зөвхөн зовлон гамшгийг биш түүнээс өөр илүү олон юмыг олж харж байсанд оршино. Тэд бүх хүнийг мөнхийн зовлонгоос аврах Аврагчийг, хамгийн эцэст бүхнийг сайн сайхан үр дүнд хүргэх аугаа их амжилт авчрагчийг, хүн төрөлхтний олж авах хүний амьдралын туйлын утга учир, зорилгыг олж харж байсан юм.

Энэ нь эхэндээ навч хэрэн мөлхөх өөдгүй муухай өт мэт авгалдай байдалтай амьдралынхаа эхэн үеийг тарчлан зовж өнгөрөөх боловч эцэст нь энэ үе дуусахад өгүүлэхийн аргагүй үзэсгэлэнтэй, олон өнгөөр солонгорон гайхуулах далавч бүхий эрвээхэй болон хувирч цэцгэнээс цэцгэд дамжин нисэх болно гэдгээ эрвээхэйн авгалдай гэнэт ойлгохтой адил хэрэг юм. Бидний баяр баясгалан ийм л байв.

Миний эргэн тойронд Иовтой адил хүн олон байсан, зарим нь бүр түүнээс ч илүү их зовлонг тэсвэрлэн туулж байлаа. Гэвч би Иовын амьдралын түүх хэрхэн дууссаныг сайн мэднэ. Тэр урьд өмнө нь өөрт байснаасаа бүр хоёр дахин илүү ихийг Мөнхийн Эзэнээс хүлээн авсан билээ. Миний эргэн тойронд хөөрхий ядуу Лаазарын адил өлсөж цанган, яр шарханд битүү идэгдсэн боловч асран эмчлэх хүнгүй зовсон улс олон байлаа. Гэвч Ертөнцийн Эзэний ер бусын элч нар ирж тэднийг бүгдийг нь Аврахаамын өвөр дээр суулган эрхлүүлэн шагнах болно гэдгийг мэдэж байв. Би тэднийг хараадаа одоогийн зовж байгаа төрхөөс нь гадна ирээдүйд ямар байдалтай байхыг нь олж хардаг байлаа. Өнөөдөр миний дэргэд шархандаа дийлдэн дэмийрэх шахсан, зовж тарчлан, сульдан ядарсан өрөвдөлтэй эрс харагдаж байгаа боловч түүний хажуугаар маргаашийн өдөр болоход Их Эзэний сонгосон хүмүүсийн хамт ер бусын шагналыг хүлээн авсан баатар эрсийн дүр тодрон үзэгдэнэ.

Иймэрхүү хүмүүсийн одоогийн байгаа байдлыг нь бус, харин ирээдүйд ямар байхыг олж харж байгаагийнхаа адил биднийг тамлан, хавчин зовоож буй хүмүүсийн одоо ба ирээдүйг ч Тарс хотын Сууль хэрхэн төлөөлөгч Пууль болсонтой адилтган тодхон харж байлаа. Тэдний зарим нь аль хэдийн Пууль шиг болсон байв. Биднийг тагнан туршиж байсан нууц цагдаагийн ажилтнуудад Христийн тухай тунхаглахад тэд итгэн өөрсдөө Христийг Аврагчаа болгон хүлээн аваад Христийн хүн болсныхоо төлөө хожим нь зовлон тамлалтыг туулахдаа баяртай байдаг байв. Шоронд биднийг ташуурдан ороолгодог байсан харгалзагч нарын зарим нь Филипой хотод төлөөлөгч Пуулийг эхлээд ташуурдаж байсан харгалзагч эцэст нь Христийн хүн болсны адил үнэнийг олж мэдэх боломжтой хүмүүс болохыг нь бид олж харж байв. Тэд тун удалгүй биднээс “Аврагдахын тулд бид юу

хийвэл зохих вэ?" хэмээн асуун ирнэ гэж мөрөөддөг байлаа. Христэд итгэгчдийг загалмайд хүлж хүний өтгөн шингэн ялгадсаар будан дээш өлгөөд тойрон зогсч доог тохуу хийж буй улсыг хараадаа бид Голготод цугласан олны дур төрхийг олж харах ба удалгүй тэдний адил цээжээ дэлсэн аймшигтай гэм хийснээ ухааран ойлгох болно гэдгийг мэддэг байв.

Шоронд байхдаа бид коммунистууд ч гэсэн аврагдах боломжтой болохыг ойлгож, итгэл найдвар сэтгэл зүрхэнд минь оргилон бадарсан билээ. Тэр мөчөөс хойш бид тэдний төлөх хариуцлагатай болохоо ухаарч эхэлсэн ба тэд биднийг тамлаж байхад бид тэднийг хайрлах ёстой болохоо зүрх сэтгэлдээ гүн бат ухааран ойлгосон юм.

Миний гэр булийн дийлэнх нь алагдан амиа алдацаасан. Гэтэл миний гэрт тэднийг алсан алуурчин Христэд амьдралаа өглөө. Энэ бол түүний хувьд Христийн өмнө ирэх хамгийн тохиromжтой газар нь байв. Тэгээд л коммунистуудын шоронд сууж байхдаа тэдэнд үнэнийг тунхаглан хүргэх хэрэгтэй юм байна гэсэн санаа төрөн хэрэгжих болсон билээ.

Бид шоргоолжны харж буйг олж харахгүйн адил Ертөнцийн Эзэн аливаа хэргийг бидний харж байгаагаас тэс өөрөөр хардаг. Хүний үүднээс аваад үзвэл, загалмайд хүлүүлчихээд хэвтэж байхад чинь хүмүүс өтгөн ялгадсаараа булна гэдэг бол төсөөлөхийн аргагүй аймшигтай хэрэг. Гэтэл үүний эсрэгээр Библид Ертөнцийн Эзэний хүмүүсийн даван туулж буй зовлон өчүүхэн бага гэж хэлсэн байдаг. Бидний хувьд арван дөрвөн жилийг шоронд өнгөрөөнө гэдэг бол дэндүү урт хугацаа шиг санагдаж байв. Библид харин үүнийг "бидэнд яруу алдрыг харуулах ганц хором" гэж нэрлэжээ. Ийм учраас коммунистуудын үйлдсэн училшгүй мэт гэмт хэрэг нь хүн чанарын үүднээс зайлшгүй эсэргүүцэн зайлцуулах шаардлагатай хэрэг мөн боловч Ертөнцийн Эзэн үүнийг бидний харж байгаагаас тэс өөрөөр харах ба түүний хувьд энэ бол өчүүхэн жаахан хэрэг юм. Энэ бол бидний хирээс хэтэрсэн, дааж давшгүй хэцүү хэрэг биш ажээ. Тавин жилийн турш үргэлжилж буй тэдний харгис хэрцгий дарангуй-лал нь Ертөнцийн Эзэний хувьд ганц хормын хугацаа ч байж болох юм. Учир нь Ертөнцийн Эзэн цаг хугацаанд захирагддаггүй агаад түүний хувьд мянган жил нэг өдөр, нэг өдөр мянган

жил мэт байж болно. Ямар ч байсан тэд ч бас хүн учраас аврагдах зайлшгүй шаардлагатай гэдэг нь цорын ганц маргаангүй асуудал юм.

Ер бусын шинэ Иерусалим бол яг эх хүний адил бөгөөд эхийн хайраар хүүхдүүдээ хайлладаг.

Ер бусын мөнхийн улсын үүд коммунистуудыг ч гэсэн хүлээн авахад үргэлж бэлэн нээлттэй байна. Тэдний төлөө бадамлан асаж буй хайрын гал ч бас бөхөж унтраагүй, хурц бадран ассаар байна. Тэд хүн болгоны адил гэмээ ухааран хаяж, Христ рүү ирэх боломжтой. Тэгээд ч бидний үүрэг бол тэдэнд үүнийг хэлж ойлгуулах явдал юм.

Зөвхөн хайрын хүчээр л коммунистууд өөрчлөгднө. Энэ хайр нь коммунистуудад зусардан бялдуучлахыг заагаагүй харин хайрыг байгаа байдлаараа бодитоор харуулахыг бидэнд заадаг. Гэтэл Христэд итгэгчдийн бүлгийн зарим ахлагч нар зусардан сایмширснаар үүнийг хийж дөнгөнө гэж андуурах нь элбэг. Үзэн ядалт гэдэг бол ямар ч ухаант хүний нүдийг таг сохлох мэт мулгуу болгох чадалтай. Гитлер коммунизмыг эсэргүүцэгч, тэр бүгүү хэл үзэн яддаг хүн байв. Тиймээс тэднийг нэгмөсөн эзлэн авахыг санаархан дайтахдаа тэдэнд дэлхийн гуравны нэгийг эзлэн авах боломжийг олгосон.

Харин хайрын улмаас бид шоронд байхдаа коммунистуудын дунд хийх ажлаа төлөвлөн хэрэгжүүлж эхэллээ.

Тиймээс ч бид юуны түрүүнд коммунист удирдагч нарыг хамгийн түрүүнд эрэгцүүлэн үзэв.

Ертөнцийн Эзэний ажлыг хийхэд бусдыг удирдан дагуулдаг зарим хүмүүс Христэд итгэгчдийн түүхээс бага ч болов судалсан байжээ. Норвегийн ард түмнийг хэрхэн Христийн араас дагуулсан юм бол? Эзэн хаан Олафыг итгүүлснээр бүх ард түмэнд нь нөлөөлжээ. Оросын эзэн хаан Владимир анх Христийн хүн болсноор орос оронд Ертөнцийн Эзэний сургаалыг хүмүүс мэдэх болсон. Эзэн хаан гэгээн Стефаныг итгүүлснээр Унгарын ард түмэн Христийг таних болсон. Польшийн хувьд ч гэсэн байдал адил. Африкийн олон оронд овгийн ахлагч нар нь Христэд итгэхэд тэр овог тэр аяараа дагаж байв. Бид хүмүүсийг үнэхээр сайн бат итгэлтэй болж нийгэмд болон бусад хүмүүст

хэрхэн нөлөөлж чадах хүрээллийнх нь дагуу зэрэг үүсгэн жагсаан бичлээ.

Бид ямар ч байсан улс орны удирдагчдад үнэнийг хүргэн Христийн өмнө авчрах хэрэгтэй. Улс төрийн, эдийн засгийн, шинжлэх ухааны, урлаг уран сайхны гээд аль ч салбарын тэргүүлэгчдийг ялгалгүй Христийн өмнө авчрах нь чухал. Тэд бол хүний амин сүнсийг авралд хүргэхийн тулд ажиллаж чадах инженерүүд л гэсэн үг. Тэд бол хүний оюун санааг төлөвшүүлж байдаг улс байв. Тэднийг Христэд итгүүлснээр тэднийг даган удирдуулж, нөлөөн дор амьдарч байдаг бусад хүмүүсийг итгүүлж чадах байлаа.

Ертөнцийн Эзэний ажлыг хийгч хүнийхээ хувьд би коммунизмыг нийгмийн халамжийн талаараа бусад нийгмийн хэлбэрүүдээс олон талаар давуу байгааг олж харав. Энэ нь түүний хэт төвлөрсөн байдалд тулгуурлаж байлаа.

Хэрэв АНУ-ын ерөнхийлөгч мормоны шашинд (Ecyc Христийн хожмын үеийн гэгээнтнүүд гэж тэд өөрсдийгөө нэрлэдэг) итгэлээ гэвэл бүх америкийн түүнийг дагаад мормоны шашинд итгэхгүй нь лав. Гэвч Мао Зидунг эсвэл Брежнев, аль эсвэл Цүшеский Христэд итгэлээ гэвэл бүхэл улс орон тэр аяараа тэдний итгэлийн улмаас Христийн сургаалыг сонсох үүд нээгдэж болох юм. Улс орны тэргүүний нөлөө гэдэг чинь ийм л хүчтэй зүйл шүү дээ.

Гэвч коммунист удирдагч Христийн хүн болж чадах болов уу? Мэдээж, чадалгүй яахав. Тэд чинь хохирогчийнхоо адил аюулгүй байдалдаа үргэлж санаа зовж, аз жаргалгүй явдаг улс юм хойно аз жаргал, баяр баясгаланг өгөх хүнийг хайж л таарна. Оросын бараг бүх коммунист удирдагч нар эцэст нь широнд орж, эсвэл нэгэн цагт хамтран зүтгэгч байсан нөхдөдөө буудуулан нас эцэслэсэн. Хятадад ч гэсэн ийм л байна. Бүх эрх мэдлийг гартаа атгасан мэт санаж явсан Ягода, Езов, Берия нарын дотоодыг хамгаалах яамны сайд нар бүгд эцэст нь хувьсгалын эцсийн буун дууг дуугарах бэлгэ тэмдэг мэт хүзүүндээ ганц буудуулаад л нас барьгаасан. Саяхан ЗХУ-ын дотоодыг аюулаас хамгаалах яамны сайд Шелепин болон Югославын дотоодыг хамгаалах яамны сайд Ранковик нар ч бас хэнд ч хэрэггүй бохир таар шуудай мэт хаягдсан.

ОЮУН САНААНЫ ЗҮГЭЭС КОММУНИЗМ РУУ ДАЙРААД ...

Коммунист дэглэм нь хэнд ч аз жаргал, хүссэн сайн сайхныг нь өгөөгүй бөгөөд үүний үр ашгийг хүртэн суугаа хүмүүст ч гэсэн аз жаргал авчраагүй. Намын бодлого чиглэл өөрчлөгдсөний улмаас нууц цагдаагийнхан хэзээ л бол хэзээ гэрт нь давхиж ирээд баривчлан ачаад явж магадгүй гэсэн байнгын адис хүн бүрт байдаг байв.

Би олон коммунист удирдагчдыг танина. Тэд бол үнэхээр хүнд дарамт үүрэн зовлонд унасан улс. Гэтэл зөвхөн Есүс л тэдэнд амар тайвныг өгч, хүнд ачааг нь зайлцуулан чөлөөлж чадах аж.

Коммунист удирдагчийг Христийн хүн болгон авчирна гэдэг нь бүх дэлхий ертөнцийг цөмийн дайны аюулаас, хүн төрөлхтнийг өлслгөлөнгөөс аварч байгаатай адил хэрэг юм. Ялангуяа, өндөр үнэтэй зэвсэг үйлдвэрлэх шаардлагатайн улмаас улсын хөрөнгийг хайр найргүй зөвхөн зэвсгийн үйлдвэрлэлд зарцуулж буй одоо цагт энэ нь бүр ч бодитой асуудал болоод байна. Коммунист удирдагчид Христийн хүн болно гэдэг нь магадгүй олон улсын улс төрийн таагүй байдлыг арилгах үндэс байж ч болох. Коммунист удирдагчдыг Христийн өмнө авчрахад Есүс Христ болон ер бусын элч нар баярлалдан дуулах нь гарцаагүй. Учир нь энэ бол түүний хүмүүсийн ялалт юм. Хэрэв коммунист удирдагч нар Христийн хүн болбол ард түмэн нь даган, Христийн ажилд том түлхэц болох тул Шинэ Гвиней, Мадагасгар зэрэг олон улс оронд, ер нь хaa сайгүй Ертөнцийн Эзэний төлөө зүтгэж буй хүмүүсийн шаргуу ажлын үр дүнд ч сайнаар нөлөөлөх нь дамжиггүй.

Христийн хүн болон үндсээрээ өөрчлөгдсөн олон коммунистуудыг би мэднэ. Би хүртэл zaluu байхдаа юунд ч хазайхааргүй бат итгэлтэй шашингүй үзэлтэн байсан билээ. Тэд асар их гэм хийсэн учраас шашингүй үзэлтэн эсвэл коммунист байгаад Христэд итгэн өөрчлөгдсөн хүмүүс Христийг үнэн сэтгэлээс маш их хайлрадаг.

Ертөнцийн Эзэний ажлыг хийхэд стратегийн ямар нэгэн бодлоготой байх нь чухал. Ертөнцийн Эзэний авралын тухайд бол

энэ нь хүн бүрт эрх тэгш олгогдсон бэлэг боловч Христийн ажлыг хийх стратегийн хувьд бол эн тэнцүү бишээ. Ширэнгэн ойд ганцаар амьдрах ганц зэрлэг хүнд авралын тухай тунхаглан ярьж байснаас итгэснийхээ дараа мянга мянган хүнд нөлөөлж чадах нөлөө бүхий хүнд эхлэн ярих нь илүү чухал хэрэг юм. Тиймээс ч Есүс амьдралынхаа сүүлчийн хормыг бүглүү нэг жижигхэн тосгонд нууцхан өнгөрүүлье гэсэнгүй, харин Иерусалим хотод, дэлхийн хүн төрөлхтний оюун санааны төв болсон энэ хотод дуусгасан билээ. Ганц энэ шалтгааны улмаас Пууль Ромд очихын тулд хамаг тэнхээгээрээ тэмүүлэн зүтгэж байсан.

Библид хэлэхдээ, “Эмэгтэйн үр мөгийн өсгийг гэмтээх болно“ гэсэн байдаг. Бид мөгийн гэдсэнд аяархан хүрч түүнийг гижигдэн инээлгэдэг, гэтэл түүний толгой нь хаа нэгтээ Москва эсвэл Бээжинд байж байх юм. Түүний толгойг Тунис, Мадагасгарт байна гэж бүү андуур. Христийн хүмүүсийг ахалж буй, мөн Христийн ажлыг удирдан хүмүүст заавар өгч чиглүүлж буй хүмүүс болон ер нь санаа тавьдаг итгэгч хүн бүрийн гол анхаарал тавих цэг бол коммунист ертөнцийн зүрх болсон газрууд зайлшгүй мөн.

Бид дасал болсон ажлаа, зуршилаа хаях хэрэгтэй.“Их Эзэний ажлыг зальт аргаар хагас хугас хийгч хүмүүс үнэхээр ичгүүртэй ажээ“ гэж бичсэн нь бий. Коммунизмыг улаан нүүрэн дундуур нь тас татах зоригтой, дорвитой, оюун санааны цохилтыг Христийн хүмүүс бид хийх шаардлагатай байна.

Дайн тулаанд ҳэн хамгийн их дайралт хийж байгаа нь хожиж, хамгаалалт хийх аргаар тулалдаж байгаа нь үргэлж ялагдал хүлээж байдаг. Коммунизмын талаар Христийн бие мэт хүмүүс өнөөг хүртэл өөрийгөө хамгаалах байдлаар хандаж ирсэн, ингэснээр бид нэг улсын дараа нөгөөг нь алдан коммунизмын гартаажим атгуулсаар.

Христийн бие болон нэгдсэн нэгдмэл нэг цогцынхoo хувьд бид энэ байдлыг үндсээр нь өөрчлөх хэрэгтэй. Ертөнцийн Эзэн аливааг салган тусгаарласан төмөр торыг хүртэл тас цохин хаяна гэж «Дуулал» номд өгүүлсэн байдаг. Түүний хувьд Төмөр Хөшиг бол өчүүхэн жаахан зүйл тул хоромхон зуурт тас цохин устгаж дөнгөнө.

Христэд итгэсэн эхний хүмүүс бүгд л нууцаар, хууль зөрчин ажлаа хийсээр байсан боловч амжилтад хүрсэн. Бид тэдний адил ажиллаж сурх хэрэгтэй болжээ.

Коммунистууд засгийн эрхэнд гарахаас өмнө би «Шинэ Гэрээнд» гарч буй хүмүүс яагаад ихэвчлэн нууц нэртэй байдгийг огт ойлгодоггүй байв. Жишээлхэд, Сөмүүнийг Нигэр, Иоганыг Маарх гэх мэтээр нэрлэсэн байдаг. Гэтэл одоо бид ажлаа үргэлжлүүлэн хийхийн тулд өөрсдөдөө нууц нэр өгдөг болов.

Урьд өмнө би Есүс баярын зоог барих газар бэлдүүлэхдээ яагаад “Хот руу яв. Тэнд устай сав барьсан хүн хайж олоорой” гэж хэлснийг огт ойлгодоггүй байлаа. Харин одоо бол би ойлгодог болсон. Нууц бүлгийн ажлаа явуулахын тулд бид ч гэсэн иймэрхүү битүүлэг дохио тэмдэг ашигладаг боллоо.

Ийм маягаар анхны итгэгчдийн хэрэглэж байсан аргыг хэрэглэхээр бид санаа нийлэн хөдөлж чадвал Христийн төлөө коммунист системийн олон улс оронд үр нөлөөтэй ажиллаж чадахсан.

Гэтэл баруунд ирснээсээ хойш би коммунист улс орнуудад олон жил ажлаа явуулж байсан ахлагч нартай уулзахад тэдний зарим нь тэднийг хайрлан өрөвдөхийн оронд коммунистуудын нэгэн адил санаа бодол, бодлоготой байдгийг олж мэдэв. Карль Марксын араас сохроор даган яваа хөөрхий төөрөлдсөн тэр хүмүүсийг энэрэн хайрлах Христийн хайрыг, сайн нөхрийн хайрыг би тэднээс олж харсангүй.

Хүн хичнээн чадварлагаар итгэлийн тунхгийг цээжлэн иш татаж чадах боловч үүндээ итгэн амьдралаараа батлан харуулахгүй юм бол итгэдэг байж чадахгүй. Итгэдэг байхын тулд үүнийхээ төлөө амиа өгөхөд бэлэн байх ёстой.

Нууц бүлгийн ахан дүүс маань итгэж буй зүйлийнхээ төлөө амь биеэ үл хайлдаг бат найдвартай хүмүүс болохоо үнэхээр батлан харуулж чадсан. Миний хувьд Төмөр Хөшигний цаана Христийн ажлыг нууцаар хийж, бусдыг удирдаж байсныхаа төлөө коммунистуудын широнд дахин хоригдож, тамлуулж, тэр бүү хэл амь насаа алдаж болох аюул нүүрлэн байгааг мэдэж байсан ч юуг ч эс хайхран Христийн ажлыг хийсээр байна. Энэ бүхнийг би өөрийн биеэр тутулсан учир үнэн бодитой гэдгийг нь хэнээс ч илүү баттай хэлж чадна.

Надад мөн, “Коммунистуудтай нөхөрлөн мөр зэрэгцэн яваа Америк дахь Христэд итгэгчдийн ахлагч нар энэхүү итгэлийнхээ төлөө амь биеэ зориулахад бэлэн гэж үү? Тэгвэл баруунд олж авсан өндөр байр сууриа орхиод зүүнд гарч халуун цэг дээр нь очоод коммунистуудтай нэгдэн албан ёсоор ахлагч хийж хамтран ажиллахад нь юу саад болж, хэн саатуулаад байгаа юм бэ?” хэмээн асуух эрх бий. Үүнийг батлах иймэрхүү алхам хийх гэж барууны ахлагч нарын хэн нь ч хичээгээгүй. Ийм итгэлтэй байгаагаа ч батлан харуулах чадваргүй байгаа шүү дээ.

Хүний хэл яриа хамтын амьдралын шаардлагаар хөгжиж ирсэн. Эхлээд тэд ан хийх, загасчлах зэрэг ажлыг гүйцэтгэхдээ хоорондоо ойлголцох шаардлагатай байсан бол сүүлд нь улам бүр нарийсан хөгжсөөр хүн өөрийн сэтгэл санаа, бодол зорилго, эрмэлзлэлийг бие биедээ илэрхийлдэг болжээ. Харин Ертөнцийн Эзэний ер бусын далд нууц бүхэн, оюун санааны амьдралын өндөрлөгт юу байдгийг илэрхийлэхэд хүний үг яриа хангалтгүй. Ямар ч байдлаар үүнийг илэрхийлэх аргагүй аж.

Үүний адилаар адгийн муу ёрын сүнсний ажил болон бузар булагай, харгис хэрцгий хэргүүдийг дүрслэн хэлэх үгс хүн төрөлхтний үгсийн санд байдаггүй аж. Нацистуудын гарт орж амьдаараа асар хүчтэй дүрэлзэн шатаж буй гал руу шидүүлэх гэж байгаа хүний сэтгэлд юу болж, тэр юу мэдэрч байгааг та үгээр дүрслэн илэрхийлж чадах уу? Эсвэл үр хүүхдийг нь нүдэн дээр чинь гал руу амьдаар нь шидэн шатааж алахыг харж байгаа эцэг хүний сэтгэлд юу бодогдож, тэд юу мэдэрч байдгийг та үгээр илэрхийлж чадах юм уу?

Тиймээс коммунистуудын гарт орсон Христийн хүмүүс хэрхэн зовж тарчилж байсан ба одоо ч тийм байгаа талаар дүрслэн хэлэхийг хичээх нь ямар ч ашиггүй хэрэг болно.

Румынд коммунизмыг бий болгон засгийн эрхэнд гаргахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн Люкретию Патраскану гэгч эртэй би нэг шоронд хамт хоригдож байлаа. Нөхөд нь түүний гавьяя зүтгэлийг үнэлэн шоронд хийжээ. Түүний ухаан санаа цоо эрүүл байсан боловч тэд хүчээр түүнийг галзуучуудын хамт сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтүүлэн улмаар тэр ч бас солио өвчтэй болсон юм. Төрийн нарийн бичгийн дарга агсан Анна Паукерийг ч бас ингэж шагнасан. Христэд итгэгчдийг ч ийнхүү эмчлэх

гэж оролдох нь цөөнгүй. Тэднийг цахилгаанд цохиулна, мөн шулуун хүүдийд хийнэ.

Хятадын гудамжнаа болж буй уйл явдлыг хараад бүх дэлхий тэр аяараа цочирдсон. Харсаар байхад улаан цэргүүд эрх мэдлээ бататган харуулж аймшигийг авчирсан. Тэгвэл хэн ч нэвтрэн орж харж чадахгүй хятадын широнд хоригдож буй Христэд итгэгчдийг тэд яадаг гэж та бодно вэ!

Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр бол Христэд итгэгч хятадын зохиолч нар болон бусад энгийн хүмүүс итгэлээсээ ухрахаас эрс шийдэмгий татгалзсан учир тэдний чих, хэл, хөлийг нь тайрч хаясан байв.

Гэвч коммунистуудын хийдэг хамгийн аймшигтай хэрэг нь хүний бие махбодыг тамлан зовоож, алаад зогсохгүй хүний бодол санааг ямар ч найдлагагүй болтол нь мунхруулан, залуу хойч үеийнхний оюун санааг хордуулж байдагт оршино. Тэд өөрсдийн гар хөл бологсдыг ахлагчаар томилон тавиад удирдаж байгаа нэрийдлээр Ертөнцийн Эзэний хүмүүсийг устгахыг хичээж байдал. Тэд залууст Ертөнцийн Эзэн болон Христэд итгэж болохгүй гэхээс гадна тэдний нэрийг сонсоод л үзэн ядах сэтгэл цээжинд чинь оволзож байх ёстой гэж сургана.

Итгэлээ хамгаалан широнд олон жил хоригдсоны эцэст сүллэгдан гэртээ ирэхэд нь доог тохуу хийн зэвүүцэж угтах хүүхдүүд нь тэр хооронд хаашаа ч хазайхгүй бат шийдвэртэй шашигүй үзэлтэн болсныг мэдэх нь үнэхээр эмгэнэлтэй хэрэг биш гэж үү?

Энэ номыг би үзэг бэхээр эвлүүлэн бичсэнгүй, харин шаналан буй хүмүүсийн сэтгэлийн гүнээс урсан гарах цусаар бичиж байна.

Данийлийн хамт галд шатаагдаж байсан залуусыг Ертөнцийн Эзэн хамгаалан аварч чөлөөлөхөд тэднээс хиншүү хярvas огт үнэртэхгүй байсны адил коммунистуудын широнд зовж буй итгэгчдийн сэтгэлээс тэднийг үзэн ядаж хорсох хатуу сэтгэл өчүүхэн төдий ч гардаггүй билээ.

Хэрвээ цэцгэн дээр хөлөөрөө гишгэвэл няцарч хариуд нь анхилуун сайхан үнэрээ гарган шагнадаг. Үүний адил Христэд итгэгчид коммунистуудын гаргат тамлуулан зовох боловч зовох тусмаа тэднийг улам их хайрлан шагнадаг юм. Шоронгийн

харгалзагч, хуягуудаас бид олноор нь Христийн араас дагуулсан. Тэгээд ч биднийг нэг л хүсэл асар ихээр эзэмдэн байв. Энэ бол биднийг тамлан зовоож буй коммунистуудад өөрсдөдөө байгаа хамгийн сайн зүйлийг өгөх явдал байлаа. Тэр хамгийн сайн зүйл нь бидний Их Эзэн Есүс Христийн өгсөн аврал билээ.

Олон ах дүүсийнхээ адил итгэлээ хамгаалан тэмцээр шоронд нас эцэслэхийг би хичнэн их хүсдэг байсан ч надад тийм завшаан тохиосонгүй. Би суллагдаад зогсохгүй, баруун руу дүрвэн гарч амьдрах боломжтой болов.

Төмөр буюу Хулсан Хөшигний цаана буй нууц бүлгүүдэд давамгай зонхилж байдаг уян зөвлөн сэтгэл барууны ахлагч нарын олонхид нь огт байхгүй, бүр ч эсрэгээр их хатуу сэтгэлтэй хүмүүс байдгийг би харсан. Барууны олон орны Христэд итгэгчдэд коммунистуудыг хайрлах сэтгэл огт байхгүй аж. Үүний нэг баталгаа нь тэд коммунист улс орнуудын хүн ардын авралын төлөө юу ч хийлгүй зүгээр суугаад байгаагаар нь илрэн харагдана. Тэд Иудейчууд, лалын шашинтууд болон буддын шашинтуудын дунд ажиллах гэж хичээнэ. Тэдний хийдэг бас нэг ажил нь аль хэдийн Христийнх болсон хүнийг нэг бүлгээс гарган нөгөө рүү шилжихийг ятгах явдал. Гэсэн ч тэдэнд коммунистуудыг гэх сэтгэл, тэдний төлөө хийж байгаа юм огт алга! Тэднийг хайрланга гэж санадаг ч үгүй ажээ. Тийм бишсэн бол тэд аль хэдийн сэтгэл зүрхээ чангалаан тэдний дунд орж ажлаа хийх л байсан. Тэд Керэй энэтхэгүүдийн дунд, Хадсон Тэйлор хятадуудыг хайрлан Ертөнцийн Эзэнийг таниулах гэж зорин ажлаа шийдэмгий эхлэн хийж байсан шиг л ажиллаж үр дүн гаргаж болох л байсан.

Гэтэл тэдний хувьд коммунистуудыг хайрлахгүй, бас тэгээд тэднийг Христийн хүн болгохын тулд юу ч хийхгүй зүгээр суух нь хангалтгүй ажээ. Өөрсдийн бардам зан, үл тоомсорлох байдал, ихэмсэг зангаараа, заримдаа бүр тэдний хань хамсаатан болж аливаа хэргийг өдөөн коммунистуудын бузар булаг, харгис; бялдууч байдлыг дэвэргэн өөгшүүлж байдаг ахлагч нар баруунд элбэг байна. Тэд коммунистуудад Христэд итгэгч барууны хүмүүсийн хүрээнд түрэмгийлэн орж тэр хүрээнд болоод олон улсын хэмжээнд өндөр байр суурь олж авахад нь тусалдаг.

Тэдний гайгаар Христэд итгэгчид коммунизмын хор уршгийг ухаарах чадваргүй болдог.

Коммунистуудыг хайллан энэрч, Христийн хүн болгохын төлөө юу ч хийдэггүй хирнээ тэд бас өөрсдийн хариуцаж буй бүлгийн хүмүүсээ ч тоодоггүй, хайлладаггүй байна. (Тэд анхны итгэгчид Христийн авралын мэдээг тунхаглахын тулд Нерогоос зөвшөөрөл гүйх хэрэгтэй байсан гэж боддог аятай ямар нэгэн зөвшөөрөл хүсэн албан баримт баталгаа шаардах мэт суух нь үнэхээр зүйд нийцэхгүй.) Хэрэв бид коммунистуудыг Христийн араас дагуулахын тулд юу ч хийхгүй суугаад байвал тэд бүх дэлхийг эзлэн, тэр дундаа барууны улс орнуудыг эзлэн авах үед Христийн хүмүүс та нар ч бас бидний адил зовлонт байдалтай болох болно.

ТҮҮХЭН СУРГАМЖИЙГ ТООХОО БОЛЬЖЭЭ

Анх нэгдүгээр зууны үед Африкт Христийн сургаал дэлгэрэн хүмүүс олноор итгэн дагах болов. Тэдний дундаас гэгээн Августин, Сиприан, Атанасиус болон Тертуллиан нар төрөн гарсан. Гэтэл хойд африкийн Христэд итгэгчид нэг үүргийг умартан тоолгүй өнгөрсөн аж. Тэд Мухамедын дагалдагчдыг Христийн өмнө авчрахыг бодсонгүй. Гэтэл Мухамедийн дагалдагч нар хойд африкийг байлдан эзэлсэн ба үүний үр дүнд Христийн сургаалын оронд лалын шашны сургаал олон зууны турш ноёрхох болжээ. Одоо ч гэсэн хойд африк лалын шашны гол цөм болсон газар хэвээр бөгөөд Христэд итгэгчид энэ газар нутгийг “төөрөлдөн хүмүүсийн орших хавтгай“ гэж нэрлэдэг билээ.

Тиймээс туулж өнгөрүүлсэн түүхээсээ үргэлж нэгийг сурч явья!

Реформацийн үед Хасс, Лютер, Калвин нарын итгэл бишрэлийн чанартай сонирхол нь тухай үеийн европын ард түмний папын дэглэмийн улс төр, эдийн засгийн дарамтаас чөлөөлөгдөх хүсэл сонирхолтой нь яв цав нийцэж байв. Үүний адил өнөөдөр нууц бүлгүүдийн ийнхүү шаргуу хөдөлмөрлөн коммунистуудыг Христийн араас дагуулах зорилго нь дэлхийн эрх чөлөөт улс орнуудын хүн амын эрх чөлөөний баталгаа, аюулгүй байдлаа хангах эрхэм зорилго эрмэлзэлтэй нь нийцэж байгаа юм.

Коммунизмыг түлхэн унагаах улс төрийн нам хүчин өнөөдөр алга. Коммунистуудын гарг цөмийн зэвсэг байгаа учир тэднийг цэрэг зэвсгийн хүчээр унагах гэж оролдох нь сая сая хүний амь насыг хороох дэлхийн бас нэг шинэ дайныг өдөөж буй хэрэг болно. Түүнээс гадна барууны олон орны төрийн тэргүүнүүдийн тархи нь эргэж коммунизмыг түлхэн унагаах шаардлага байхгүй гэж үзэх тул юу ч хийхийг хүсэхгүй, харин ч дэмжих хандлагатай байна. Тэд маш олон удаа үүнийгээ илэрхийлсэн. Мансууруулах бодист донтох, хөлсөөр хүн алдаг танхайн бүлэглэлүүд, хорт хавдар, сүрьеэ зэргийг ул мөргүй арилаасай гэж хүсдэг боловч хор уршиг нь хамаагүй илүү аюултай коммунизмын талаар ингэж боддоггүй.

ЗХУ-ын зохиолч Илья Эринбург хэрэв Сталин бүх амьдралынхаа турш өөрийн хохироосон хүмүүсийн нэrsийг жагсаан бичихээс өөр ямар ч ажил хийдэггүй байсан бол энэ ажлаа дуусгахад нь түүний нас хүрэлцэхгүй байх байсан бизээ гэж хэлсэн байдаг. ЗХУ-ын Коммунист намын хорьдугаар их хурал дээр Хрушев хэлэхдээ, “Сталин мянга мянган гэм зэмгүй, шудрага коммунистуудыг хэлмэгдүүлэн устгасан ... долдугаар их хурлаас Төв Комисст гишүүдээр сонгогдсон зуун гучин есөн хүний далан хувь нь болох ерэн найман хүнийг тэр жилээ баривчлан буудаж хороосон“ гэж байв.

Тэгвэл Христэд итгэгчдийг тэр ясныг та одоо бодоод үз дээ!

Хрушев хэдийгээр Сталиныг буруутган яллаж байсан боловч өөрөө түүний хийж байсныг хэвээр үргэлжлүүлсэн. Зөвлөлт Орос улсад 1959 оноос хойш нээлттэй байсан Христэд итгэгчдийн олон бүлгүүдийн тэн хагас нь хаагдас.

Хятадад Сталины үетэй харьцуулшгүй харгис балмад хэргийн шинэ хөдөлгөөн өрнөөд байна. Христэд итгэгчдийн ямар ч бүлэг нээлттэй байдлаар үйл ажиллагаа явуулж болохгүй болсон ба ийм тийм байгууллага гэхээр юмгүй шахуу болов. Орос болон Румынд шинэ баривчилгaa явагдаж эхэллээ. (Бидэнд дөнгөж сая Орост Христэд итгэгчдийг олноор нь хомроголон баривчилсан тухай мэдээ ирсэн.)

Олон улс орны нэг тэрбум хол давсан хүн ард мэхлүүлэн хууртаж, айдаст автсанаас болж залуу үе нь тэрчигээрээ баруу-

ны юм бүхнийг үзэн ядах, тэр дундаа Христэд итгэхтэй холбоотой болгоныг жигшин зэвүүцэх сэтгэлтэй болон өсч байна.

Орост сүмийн гадаа орон нутгийн эргүүлийн цагдаа хянан зогсч хүүхдүүд тийшээ ирж байгаа эсэхийг тандан байгаа харагдах нь бараг хэвийн үзэгдэл. Тийш орохыг завдсан хүүхдийн нүүрэн дундуур тэд тас алгадан хөөгөөд явуулна. Баруунд буй Христэд итгэгчдийн хойч үеийг үндсээр нь устгахыг санаарахаа ирээдүй үеийг тэд ийнхүү хянуур болгоомжтойгоор системчлэн бэлтгэн боловсруулж байна!

Коммунизмыг бүрмөсөн устгах цорын ганц хүч бий. Энэ бол балар харанхуй Ромын эзэнт улсыг нурааж Христэд итгэгчдэд эрх чөлөө олгох нийгмийг бий болгосон тэр хүч мөн. Энэ хүч Христийн хүмүүсийг Тютонс, Викингс нарын харгис хэрцгий дарангуйлааас чөлөөлж, цуст аллагыг бүрмөсөн устгасан. Энэ бол Есүс Христийн тухай гайхамшигт үнэний хүч юм. Чухамхүү энэ үнэний коммунист орнуудад буй нууц бүлгийнхэн ард түмэндээ хүргэх гэж хичээж байна.

Энэ нууц бүлгийнхэнд туслан дэмжих нь итгэл нэгт ахан дүүсийнхээ зовлонг хуваалцах төдий хэрэг бишээ. Румыны ерөнхий сайд Георгио Дей гэмт байдлаа ухааран хаяж, амьдралаа өөрчлүүлснийхээ дараа нас нөгчсөн. Коммунист улс орнуудад коммунист боловч Христэд итгэдэг агаад үүнийгээ нууцалж байдаг олон хүн төр засгийн чухал албыг хашиж байна. Ийм байдлаар үүнийг улам бүр дэлгэрүүлж болно. Ингэж байж л бид коммунист засаглалын бодлогод жинхэнэ өөрчлөлт гарна гэдэгт найдаж болно. Харин Тито, Гомулка нарын адил харгис хэрцгий, шашингүй үзлийг дэмжсэн нэг улс төрийн намыг нөгөөгөөр солихын тулд биш харин Христийн сургаалыг хүлээн авдаг, эрх чөлөөт амьдралыг дэмжих жинхэнэ өөрчлөлтийг авчрахын төлөө тэмцэн ажиллах ёстой.

Үүнийг хийх янз бурийн боломж бий. Хэрэв хийе гээд хичээвэл боломж үргэлж нээлттэй байдаг.

Христэд итгэгчид өөрсдийн итгэлд хэрхэн үнэнч, чин сэтгэлийн угаас ханддагтай адил өөрсдийн үзэл бодолд үнэнч гэгдэх олон коммунистууд өнөөдөр асар их хямралтай тулгарaad байна.

Улс үндэстнүүдийн хооронд эв санааны нэгдлийг коммунизм бий болгоно гэж тэд үнэхээр итгэж байлаа. Гэтэл одоо тэд

коммунист улс орнууд өөр хоорондоо яс булаалдах ноход адил уралцан хэрэлдэхийг олж харна.

Тэд коммунизм ер бусын мөнхийн жаргалтай улс гэдэг хиймэл, хол хөндий мөрөөдөл мэт санагдах тэр ертөнцийг энэ дэлхий дээр байгуулна гэж итгэдэг байв. Гэтэл одоо тэдний ах дүү болсон ард түмэн нь өлөн зэлмэн байдалтай, үр тариагаа хүртэл өнөө капиталист гэдэг орнуудаасаа импортлон авдаг болжээ.

Коммунистууд удирдагч нартаа их итгэл хүлээлгэн найддаг байв. Гэтэл одоо тэд өөрсдийн өдөр тутмын сонин хэвлэлээсээ Сталин бол олныг хомроголон устгагч алуурчин, Хрущев бол худалч алиалагч болохыг мэдэж авна. Ракоси, Геро, Анна Паукер, Ранковики зэрэг үндэсний баатрууд нь ч мөн адил худалч луйварчид болохыг ойлгоно. Коммунистууд цаашид удирдагч нарынхаа төгс алдаагүй хүмүүс гэсэн худал үгэнд итгэхээ больжээ. Тэдний байдал папгүй католик шүтлэгтнүүдийнхтэй адил юм.

Коммунистуудын зүрх сэтгэл эзгүйрэн хоосорчээ. Энэ хоосон зайлж зөвхөн Христ л дүүргэн өгч чадна. Хүний сэтгэл зүрх угаасаа л Ертөнцийн Эзэнийг эрэн хайж байдаг. Зөвхөн Христийг олж авч нэгдсэнээр л хүн амин сүнснийхээ эрэн хайж шаардан буйг олж, шаналан байгаа сэтгэлийнхээ хоосон зайлж дүүргэж чадна. Өөр ямар ч боломж, арга байхгүй. Коммунистууд ч бас хүн учраас тэдний байдал бас ийм байгааг ойлго. Христийн тухай гайхамшигт үнэнд аугаа их хайрын хүч агуулагдаж байдаг тул тэднийг ч бас аврах хүчтэй. Энэ үнэхээр бодитой болохыг би өөрийн нүдээр үзсэн. Тиймээс энэ бүхэн үнэн бөгөөд зайлшгүй биелнэ гэдгийг ч би мэднэ.

Коммунистуудын элэг доог болон тамлуулан буй Христийн хүмүүс тэдэнд болон тэдний гэр бүлийнхэнд учруулсан бүхнийг мартан училсан. Тиймээс тэд коммунистуудад энэ их хямралаас гарахад нь, мөн Христийн өмнө ирэх замаа олоход нь туслахын тулд чадах бүхнээ хийн зүтгэж байна. Энэ ажилд бид зайлшгүй тэднийг дэмжин туслах хэрэгтэй.

Зөвхөн үүнд ч биш. Христэд итгэгчдийн олж авсан хайр гэдэг бол түгээмэл, бүгдийг хүлээн авах чанартай тул Христэд итгэгчдийн хувьд ялгаварлан үзэх үзэл огтхон ч байх ёсгүй юм.

Есүс хэлэхдээ Ертөнцийн Эзэний бүтээсэн нар ариун гэгээнтэн болоод адгийн муу ёрын гэмт хүмүүсийн дээр адилхан гэрэлтэн илчээ өгч байдаг гэсэн. Христийн хайр ч гэсэн мөн л ийм чанартай.

Коммунистуудтай нөхөрлөн хань хамсаатан нь болон ажилладаг барууны ахлагч нар үүнийгээ зөвтгөхийн тулд Есүсийн дайснаа хүртэл энэрэн хайрлах хэрэгтэй гэж сургасныг иш татан түрий барих гэдэг. Гэтэл үнэн хэрэгтээ, Есүс бидэнд дайснаа хайрлах хэрэгтэй гэж хэлэхдээ, зөвхөн дайснаа хайрлаад итгэл нэгт ахан дүүсээ март гэж хэлээгүй шүү.

Христэд итгэгчдийн цусаар гараа угаасан тэдэнд Христийн тухай гайхамшигт үнэнийг тунхаглахгүй хир нь хамт хооллон, дарс хуваан ууснаар хайраа харуулна гэж үгүй. Гэтэл тэд коммунистуудын дарангуйлал, хүчирхийллийн дор зовж буй хүмүүсийг огт тоохгүй, хайрлахгүй байна шүү дээ.

Өнгөрсөн долоон жилийн турш Баруун Германы Христэд итгэгчдийн бүлгийнхэн өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст 125 сая долларын тусlamж өгсөн байна. Америкчууд үүнээс ч илүү ихийг тусlamж болгон өгчээ.

Өлсгөлөнд нэрвэгдсэн хүн олон байгаа нь мэдээж боловч чөлөөт ертөнцийн итгэгчдээс тусlamж хүртэх ёстой юмуу эсвэл амь насаараа дэнчин тавин итгэлээ хамгаалж буй Христийн хүмүүсээс илүү их өлсөж буй хүн байхгүй нь тодорхой. Хэрэв герман, их британи, америк, скандинавийн орнуудын Христэд итгэгчид тусlamжийн ажилд зориулан тийм их мөнгө хөрөнгийг босгож чадаг юм бол зовж буй хүн бүрт адил тэгш хүртээх хэрэгтэй. Юуны түрүүнд итгэлийнхээ төлөө амь биеэ хайрлахгүй зүтгэж байгаа хүмүүс болон тэдний гэр бүлийнхэнд туслах ёстой юм.

Тэгвэл одоо хир нь ийнхүү тусалж байгаа билүү?

Намайг худалдан авсан явдал Христэд итгэгчдийг мөнгөөр худалдан авч чөлөөлж болдгийн баталгаа болж байна. Гэвч Христэд итгэгчдийн тусlamжтайгаар эх орноосоо худалдагдсан цорын ганц тохиолдол нь миний хэрэг байсан юм. Тиймээс миний суллагдсан байдал нь Христэд итгэгч барууны хүмүүс бусад тохиолдуудыг ашиглан чөлөөлөх ажил хийхгүй зүгээр суусан явдлыг буруутгах хангалттай шалтгаан болно.

Анхны Христэд итгэгчид зөвхөн Иудейчууд л Ертөнцийн Эзэний хүмүүс юмуу эсвэл харь үндэстнүүд ч гэсэн бас түүний хүмүүс байж болох эсэх талаар өөрсдөөсөө асуун ярилцаж байв. Асуултдаа тэд үнэхээр зөв хариулт олсон юм. Гэтэл хорьдуугаар зууны Христийн хүмүүст энэ асуудал бас өөр хэлбэрээр бодитой тулгарсан. Христэд итгэх нь зөвхөн барууны хүмүүст хамаатай хэрэг бишээ. Есүс Христ зөвхөн америкчуудад, их британчуудад эсвэл ардчилал хөгжсөн улс орнуудад хамаатай бус. Тэрээр загалмайд цовдлогдохдоо нэг гарaa баруун тийш, нөгөөгөө зүүн тийш нь сунган тэлсэн. Тэр зөвхөн Иудейчуудын төдийгүй Иудей бус бүх улс үндэстний тэргүүн, дээдийн дээд хаан нь байх хүсэлтэй. Барууны чөлөөт өртөнц төдийгүй коммунист системийн өртөнцийг ч гэсэн тэрээр ноёрхон захирах хүсэлтэй. Есүс хэлэхдээ, “Та нар бүх улс үндэстнийг надад итгуулж, миний хойноос дагуул.” гэсэн.

Тэр бүх хүний төлөө цусаа урсгасан бөгөөд хүн бүр Ертөнцийн Эзэний авралын тухай сонсож итгэн дагах хэрэгтэй юм.

Коммунист системийн улс орнуудад Христийн үнэн мэдээг тунхаглахад биднийг урамшуулж, зоригжуулж байдаг нэг зүйл нь коммунистууд Христийн хүн болохдоо энэрэл хайр, урам зориг бадарсан чигч шулуун хүмүүс болдог явдал байв. Христэд итгэгч оросуудын дундаас би өөх ч биш, булчирхай ч биш байдалтай өрөвдөлтэй гэмээр хүн нэгийг ч олж уулзаагүй. Урьд нь коммунизмын улаан хэнээтэн байсан залуус эргэж буцахыг үл мэдэх Христийн араас бат дагагчид болдог билээ.

Христ коммунистуудыг хайлладаг бөгөөд коммунизмын хүлээнээс тэднийг чөлөөлж эрх чөлөө олгохыг хүсч байдаг. Энэ нь түүний гэмтэй хүн болгоныг хайлаж, гэмээс нь чөлөөлөхийг хүсч байдаг чанараас нь гардаг. Тэд ийм хандлагатай байх ёстой атал барууны зарим ахлагч нар коммунизмын талаар бардам маадгар зантай байдаг байна. Тэд гэмийг таалан коммунизмыг улам бүр газар авахуулж, коммунистуудад аврал олох боломж өгөхөд аль болох саад болж хохироох хүсэлтэй байдаг.

СУЛЛАГДСАНЫХАА ДАРАА ОЛЖ МЭДСЭН ЗҮЙЛ

Шоронгоос суллагдсаныхаа дараа би эхнэртэйгээ дахин уулзаж хамт байх боллоо. Гэтэл эхнэр минь надаас ирээдүйнхээ талаар ямар төлөвлөгөөтэй байгааг минь асуухад, “миний туйлын хүслэн бол оюун санааны хувьд цэвэр ариун амьдрах явдал” гэж хариулав. Эхнэр минь ч бас тийм бодолтой байв.

Би залуудаа тун ч идэвхитэй, дайчин хүн байж билээ. Гэвч шоронд байхдаа, ялангуяа ганцаарчлан хорих өрөөнд олон жил суусны дараа өөрийн эрхгүй аливааг эрэгцүүлэн тунгаадаг бодлогоширонгуй хүн болж хувирав. Сэтгэл зүрхэнд минь бужигнан байсан шуурга намдаад коммунизмыг нэг их тоохоо байж, бүр анзаарахаа ч больжээ. Ер бусын мөнхийн улсад угтан суугаа хайрт хархүүгээ бодох бүсгүй мэт байдалтай байв. Намайг тарчлаан зовоож байсан тэдний төлөө би Ертөнцийн Эзэнтэй ярьж, чин сэтгэлээсээ хайлрадаг болсон байлаа.

Хэзээ ч суллагдах юм бүү мэд, суллагдана гэсэн итгэл найдвар ч бараг үгүй болов. Гэвч үе үе хэрвээ би суллагдвал яах вэ гэж гайхан бодохдоо ихэвчлэн тэтгэвэрт гарч хaa нэг газар гав ганцаар Их Эзэнтэйгээ хамт жаргалтай сайхан амьдарна даа гэж боддог байв.

Ертөнцийн Эзэн бол “хүний амьдралын цорын ганц үнэн” мөн. Библи бол “энэхүү үнэний тухай илчлэн үзүүлсэн үнэн түүх”. Суурь мэдлэг гэдэг нь эдгээр үнэнүүдийн тухай үнэн зөв ойлголт, мэдлэгтэй байхыг хэлнэ. Тэгээд Христэд итгэгчид энэ үнэнийг даган амьдардаг тул тэдэнд өөр үнэн байдаггүй. Өлсөж цангасан, зодуулж тамлуулсан, орчлонгоос тусгаарлагдан мартагдсан бидэнд Библийн тухай үнэн зөв мэдлэг гэгч нь огт хэрэггүй эд болж хувирав. Бид энэ бүх үнэн зөв мэдлэг гэгчийг мартаад оронд нь цорын ганц үнэн болсон түүнтэй бодитоор нэгдэн нөхөрлөж байв. “Ертөнцийн Эзэний илгээсэн хүн та нарын бодоо ч үгүй цагт ирэх ба та нар түүний хэзээ ирэхийг хэлж мэдэхгүй” гэж бичсэн байдаг. Бидэнд цаашид юм бодоод байх тэнхээ байсангүй. Бидний тамлуулан зовж байсан хамгийн харанхуй тэр цагт л Ертөнцийн Эзэний илгээсэн хүн хүрч ирж шоронгийн төмөр ханыг үнэт эрдэнийн шигтгээ адил гэрэлтүүлэн харанхуй хар өрөөнд гэрлээ тусгаж байсан юм. Бидний тээр

доор хaa нэгтээ тамлан зовоогчид маань биет хүний ертөнцөд оршино. Харин бид сүнсээрээ Их Эзэнтэйгээ бат нэгдэн баяр жаргалтай байлаа. Бид энэхүү баяр жаргалаа эзэн хаадын хэдэн ч ордноор, эрх мэдлээр солихгүй.

Ямар нэг юм эсвэл хэн нэгний эсрэг дайтан тэмцэнэ гэнэ үү? Үүнээс өөр бодох зүйл сэтгэлд минь байсангүй. Ямар нэг дайн тулаан хийх нь бүү хэл хэн нэгэнтэй тэмцэлдэх ч хүсэл надад байсангүй. Үүний оронд Христийн оршин байх сүм мэт хүмүүсийг түүний араас бат дагуулах нь хамгийн чухал хэрэг байв. Шоронгоос гарахдаа би өмнөө олон жилийг Их Эзэнтэйгээ нөхөрлөн, үгийг нь бодож тунгаан чимээгүйхэн өнгөрүүлэх болдтой болчихоод ирсэн билээ.

Гэвч шоронгоос суллагдан гараад л эхний өдрөө өнөөх шоронгийн тамлагч нараас ялгарах юмгүй коммунизмын муу муухай талуудыг олж харж эхлэв. Олон сайн сургаал заагч, ахлагч нар болон ажилтуутдтай уулзахад удаа дараалан тэд өөрсдийн хариуцан буй хүмүүсийн хийж буй бүхнийг нууц цагдаагийнханд мэдээлэх үүрэг бүхий мэдээлэл дамжуулагч болсноо тун гашуудангуй аястай хүлээн зөвшөөрцгөөв. Би тэднээс амь насаа алдах, шоронд орох аюул өмнө чинь байсан ч хамаагүй нууц цагдаагийн мэдээлэл дамжуулагч байхаас татгалзаж чадах уу гэтэл тэд бүгдээрээ “үгүй” гэсэн ба шалтгаан нь айдас биш байлаа. Харин нууц цагдаагийн мэдээлэл дамжуулагч болохгүй л юм бол тэднийг тараах аюул нүүрлээд байсан тул тэд арга мухардан ийм хэрэг хийснээ тайлбарлав. Энэ бол намайг шоронд орохоос өмнө байгаагүй нэгэн шинэ хэрэг байсан ба одоо ихээр газар аван хөгжиж байгаа ажээ.

Засгийн газрын шашны асуудал эрхэлсэн албаны хүн хот бүрт байх ба тэд бол коммунист нууц цагдаагийн мэдээлэгч нар байв. Түүнд хүссэн цагтаа, ахлагч, сургаал заагч нарын хэн нэг рүү утасдан хэн хэн хуралд оролцсон, ямар хүмүүс хайрын зоог тогтмол барьдаг, итгэл бишрэлийн асуудалд хэн хамгийн идэвх зорилготой хандаж байгаа, хэн бусдад Христийн тухай ярьж араас нь дагуулж байгаа, хэн хэн шинээр элсэн Христийн хүн болсон гэх мэтээр асууж шалгаах бүрэн эрхтэй гэнэ. Хэрэв ямар нэг хариу өгөхгүй бол тэр дор нь халж, оронд нь өөр ажилтан томилон тавих ба тэр хүн өөрөөс нь илүү ихийг мэдээлнэ. Хэрэв

засгийн газрыг төлөөлсөн мэргэжилтэнд мэдээлэгч байхгүй бол шууд л хүмүүсийг нь тарааж орхидог байв. (Гэхдээ байхгүй байна гэж бараг үгүй дээ, хаанаас ч юм олоод ирдэг байв.)

Ихэнх ахлагч нар нууц цагдаагийнханд мэдээлэл өгч байсан ба зарим нь эргэлзэнгүй аястай ганц нэг зүйл нуух гэж оролдоно, зарим нь бүр зуршил болж сэтгэл зүрх нь хатууран, дотоод сэтгэл нь унтсан мэт таг болсон байв. Гэтэл зарим нь тэднээс хайр халамж горилон асууснаас илүү ихийг мэдээлэн хэлэх нь ч бас байна.

Сайхан сэтгэл гарган хүлээн авсан гэр бүлийнхнийхээ тухай нууц цагдаагийнханд мэдээлэл дамжуулж байх үүрэг авсан хүүхдүүд байдаг тухай ч би сонссон юм. Тэдний эцэг эх нь итгэлийнхээ төлөө амиа алдахад тэд гудамжинд гарсан боловч сайхан сэтгэлт хүмүүс тэднийг өөрсдөө авч байхад тэд харин өөрсдийнх нь талаар бүгдийг мэдээлэх аж. Хэрэв мэдээлэхгүй бол сургуульд сурч боловсрох боломжгүй болгоно гэж сурдүүлнэ.

Улаан туг дээрээ хатгасан нэг батпист урсгалын сүмд очлоо. Энд коммунистууд хуралдан “ахлагч удирдагчдыг сонгож” байсан билээ.

Одоо итгэгчдийн байгууллага болгоны ахлагч удирдагч нар нь коммунист намын нэр дэвшүүлэн сонгосон хүмүүс байгаа гэдгийг би хэлүүлэлтгүй сайн мэдэж байв. Дөнгөж тэгэхэд л би Есүсийн хамгийн ариун газар гутамшигтайгаар эзгүйрэн хоосрох болно гэсэн үгийн утгыг ухаарав.

Цаг ямагт л сайны хажуугаар саар гэгчээр сайн, муу сургаал заагч, ахлагч нар байж л байсан. Харин одоо Христэд итгэгчдийн түүхэнд анх удаа тангараг өргөсөн шашигчий үзэлтнүүдийн намын төв комисс аливаа шашныг устгах зорилго өвөрлөн тунхагласаар ахлагч, удирдагчдыг томилох болжээ. Ямар зорилгоор удирдах болж байна? Ямар ч байсан Христэд итгэгчдийг устгах зорилгоо хэрэгжүүлэхэд нь туслах явдал байж таарна.

Ленин бичихдээ, “Шашны тухай аливаа бодол, Ертөнцийн Эзэний тухай аливаа санаа, тэр бүү хэл Ертөнцийн Эзэний тухай алив бодол санааг хөхүүлэн тоглох нь хамгийн аймшигтай балмад явдал, хамгийн бузар булаг халдварт өвчин. Сая сая гэмт

хэрэг, бузар булаг үйлс, хүчирхийлэл, халдварт өвчин эмгэг хүртэл бүгд нийлээд Ертөнцийн Эзэний тухай оюун санааны залтын үзэл санаатай адил аюултай биш“ гэсэн байдаг.

Зөвлөлтийн холбооны бүх улс орнуудын коммунист намууд бүгд ленинч зарчимтай. Тэдний хувьд аливаа шашин бол хорт хавдар, сурьеэ эсвэл тэмбүүнээс илүү аюултай аж. Гэтэл тэд хэн шашны удирдагч байх вэ гэдгийг шийдэж байдаг. Тэдэнтэй хамтран албан ёсны байгууллагууд ажиллах ба их бага ямар нэг хэмжээгээр үргэлж тэдний талд байна.

Шашингүй үзлээр хүүхэд залуусыг хэрхэн хордуулж байгааг нь би харсан. Энэ асуудалд албан ёсны байгууллагууд өчүүхэн ч хориг саад тавьдаггүй, тийм ч боломж байдаггүй. Манай улсын нийслэл хот Бухарестийн аль ч байгууллагаас та өсвөр үеийнхний хурал болон хүүхдүүдэд зориулсан тогтмол үйл ажиллагаа явуулж буй газрыг хайгаад олохгүй. Христэд итгэгчдийн хүүхдүүд хүртэл үзэн ядалт, хорсол дүүрэн ширтэх харцтай өдөр бүр тулан аймшиг болсон сургуульд сурч хүмүүжнэ.

Энэ бүхнийг хараад би тамлуулж байх үеэ бодвол бүр илүү ихээр коммунизмыг үзэн ядаж жигших болов.

Миний амьдралыг хэрхэн харлуулсныг нь бодож би үзэн ядсангүй, харин Ертөнцийн Эзэний яруу алдар, Христийн нэр төр болон өөрийнх нь атганд буй сая сая хүмүүсийн амин сүнсийг хохироож байгаагийнх нь улмаас жигшинэ.

Улс орны маань өнцөг булан бүрээс ядууран хоосорсон хүмүүс ирж надтай уулзан нэгдэлжих хөдөлгөөн юу хийснийг тодорхой хэлж өгөв. Одоо тэд урьд өмнө өөрсдөө эзэмшдэг байсан атар газар, жимсний талбайнхаа өлөн зэлмэн боол нь болж, хөлс хүчээ урсгаад ч идэх талхгүй болжээ. Үр хүүхдүүдэд нь уух сүү, идэх жимс олдохгүй болсон байв. Эртний Хинаан орны элбэг хангалуун байдалтай эн зэрэгцэхүйц байгалийн баялаг ихтэй улс орны дүр төрх ийм болжээ.

Ах дүүс маань ирж уулзаад коммунизмын уршгаар бүгдээрээ худалч, хулгайч нар болж хувирснаа санаа алдан хүлээн зөвшөөрнө. Өлсөхийн эрхэнд урьд нь өөрийн байсан боловч одоо нэгдлийнх болсон газраасаа хулгай хийх болжээ. Тэгээд хулгайн энэ үйлдлээ нуун далдлахын тулд худал хэлэх болсон байв.

Үйлдвэрийн ажилчидтай уулзахад үйлдвэрт гардаг аймшигтai хэргүүдийн талаар ярьж капитализмын үед зөвхөн мөрөөдэж л болох тийм байдлаар хүний ажиллах хүчийг хэрхэн мөлжиж байгаа тухай өгүүлцгээж байв. Ажилчдад ажил хаялт ч зарлах эрхгүй.

Сэхээтнүүд хүртэл Ертөнцийн Эзэн байхгүй гэж оюун ухаандаа хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа хирнээ бусдад зааж сургах хэрэгтэй болжээ.

Дэлхийн хүн амын гуравны нэгийнх нь оюун санаа, амьдрал тэр чигтээ устгагдан, бурууджээ.

Залуу охидууд хүртэл гомдол мэдүүлж байв. Христэд итгэгч залуу эрийг үнссэнийхээ төлөө тэд коммунист залуучуудын байгууллагад дуудагдан очиж зэмлэл хүлээх ба тэдэнд хэнийг үнсч болохыг нь заан өгч нэrsийн жагсаалт хүртэл гардуулдаг байна. Хэнийг үnsэхээ хүртэл тэднээр цагдуулна!

Юм бүхэн аймшигтай худал хуурмаг агаад бузар муухай байлаа.

Дараагаар нь би олон жилийн өмнө мөр зэрэгцэн тэмцэж явсан нууц бүлгийн дайчин нөхөдтэйгөө уулзав. Тэдний зарим нь огт баригдаагүй байсан ба баривчлагдаад суллагдсан хэд нь эргээд л сайн тэмцлээ үргэлжлүүлэн байлаа. Тэд намайг дуудан тэдэнтэй хамтран цааш зүтгэхийг уриалж байв. Тэдний нууц хуралд оролцдог боллоо. Хурал дээрээ тэд гараар хуулан бичсэн дууны номноос харж хэдэн хуучны дуу дуулна.

Их Антони гэгээнийг би тод санаж байв. Тэрээр гучин жилийг цөлд ганцаар өнгөрөөж, хорвоо дэлхийг тэр чигт нь хаяж орхиод бүх амьдралаа хоол идэлгүйгээр Ертөнцийн Эзэнтэй ярьж өнгөрөөсөн юм. Гэвч тэрээр Ертөнцийн Эзэний бүхний дээд чанарын талаар маргаан дэгдэн гэгээн Атанасиустай Ариус тэмцэлдэж эхэлснийг сонсоод даяанчлах мэт амьдралаа түр орхин Александр хотноо ирж бодит үнэнийг ялуулахын төлөө зүтгэсэн билээ.

Би Христэд итгэгч хүн бүрийн хийх ёстой тэр үүргийг бие-лүүлэхээр шийдлээ. Энэ бол тэтгэвэртээ гарах бодлоо бүрмөсөн хаяад Их Эзэн Есүс Христийн, Пууль болон бусад төлөөлөгчдийн үлгэр жишээг даган сайн сайхны төлөөх тэмцлээ үргэлжлүүлэх явдал байв.

Энэ тэмцэл нь чухам ямар тэмцэл байх вэ?

Шоронд хоригдож буй Христийн хүмүүс үргэлж Ертөнцийн Эзэнээс дайснуудынхаа төлөө гүйж тэдэнд гайхалтай нөлөөлдөг байв. Бид сэтгэл зүрхнийхээ гүнд тэдэнд аврал хэрэгтэйг мэдрэн аврагдах тутам нь баярлан хөөрдөг.

Гэвч би бузар булаг коммунист системийг үзэн ядаж нууц бүлгээ хүчирхэгжүүлэх хүсэлтэй байлаа. Энэ аймшигт дарангуйллыг нурааж чадах цорын ганц хүч бол Христийн авралын тухай үнэн мэдээний хүч чадал юм.

Би зөвхөн Румыны тухай бодсонгүй харин бүх коммунист улс орнуудын тухай бодож байлаа.

Гэтэл баруунд очоод би хүмүүс энэ талаар огт санаа тавьдаггүйг олж мэдэв.

Синавский, Данийл нарын коммунист зохиолчдыг нөхөд нь баривчлан цаазаар авах ял оноход дэлхийн олон орны зохиолчид эсэргүүцсэн. Гэтэл итгэл нэгт нөхөд нь итгэлийнхээ төлөө шоронд тамлуулж байхад энэ байдлыг эсэргүүцэх сөхөөтэй итгэгчдийн бүлэг нэг ч алга аж.

Торрейн бичсэн Христэд итгэгчдийн “хорт“ ухуулга болох ном товхимол, Библийн зарим номнуудыг хэсэгчлэн товхимол болгоод тарааж яваад баривчлагдан цаазаар авах ял авсан анд нөхөр Кюзикийн төлөө хэн санаа тавих болж байна? Ертөнцийн Эзэнийг хүндэтгэх хурал дээр заасан сургаалаа хуулан бичиж хүмүүст тараан өгснийхөө төлөө шийтгүүлсэн итгэл нэгт ах Прокиевийн талаар хэн юу мэдэх вэ? Орост ийм ажил хийж яваад баригдсан Христэд итгэгч Иудей үндэстэн Грунвальдын талаар мэдэх хүн байна уу? Түүний бяцхан хүүгийн амийг үүнээс болж хөнөөснийг бас мэдэх хүн байгаа гэж үү?

Намайг баривчлан бяцхан хүү Михайгаас минь салгахад надад ямар байсныг би сайн санаж байна. Тиймээс би Грунвальд, Иванко, Гранни Чевчук, Тайсия Ткаченко, Екатрина Веказина, Георгий Веказин болон латви нисгэгчийн гэр бүл гээд дурдаад байвал барагдахгүй олон хорьдугаар зууны баатрууд болсон үнэнч итгэлтэй анд нөхдийнхөө зовлонг ойлгоно! Анхны итгэгчид анд нөхдийг нь зэрлэг адгууст хаяж өгөхийн өмнөхөн хүндэтгэн мэхийн үнсдэг байсны адил би тэдний хөл, гартаа угласан гинжийг хүндэтгэлтэй мэхийн үнсэнэ.

Барууны зарим ахлагч нар тэднийг огт тоон үзэхгүй, санаа ч тавихгүй байх юм. Итгэлийнхээ төлөө амь биеэ золин тэмцэж буй тэдний нэр дэвтэрт нь хүртэл тэмдэглэгдээгүй байна. Тэд тамлуулан тарчилж, алах ял заагдаж байхад Оросын баптист болон үнэн алдартны шашины байгууллагын итгэлээсээ урван тэrsэлсэн албан ёсны удирдагчид нь Шинэ Дели, Женев зэрэг хотуудад их, бага хурлуудад оролцон өндөр дээд хүндэтгэл хүлээн зугаалан орос оронд хүн бүрт шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө бүрэн бий хэмээн батлан харуулахыг оролдоно.

Христэд итгэгчдийн дэлхийн зөвлөлийн нэг удирдагч энэ баталгааг үзүүлсэн оросын большевик тэргүүн хамба Никодимд хүндэтгэл үзүүлэн үнсч байгаа харагдав. Тэгээд тэд найрлан энэ зөвлөлийнхөө нэрийг мандуулан сайшаан суух зуур хөөрхий Христэд итгэгчид шоронд сууж угааж цэвэрлээгүй гэдэс дотор байцаатай холин идэж байх ч гэж! Би өөрөө ч үүнийг Их Эзэндээ олж өгсөнд нь талархаад идэж суусан юм шүү.

Цаг цагаараа, цахилдаг хөхөөрөө байдаггүй гэдэг шиг байдал ийм хэвээр байгаад байсангүй. Нууц бүлгийнхэн маань боломж л олдох юм бол юун түрүүн эх нутгаа орхин гарч Христэд итгэгчдийн амьдралд юу тохиолдож байгааг та бүхэнд мэдээлэхийг надад тушаасан.

Хэдийгээр би “коммунистуудад” хайртай боловч коммунизмыг бүрэн эсэргүүцэн хөсөр хаяхаар шийдэв. Коммунизмыг бүх талаар эсэргүүцэхгүйгээр Христийн авралын тухай тунхаглах нь зөв хэрэг гэж бодохгүй байна.

Зарим хүн надад “Христийн сургаалыг үнэнээр нь завхруулалгүй заа!” гэж хэлдэг. Энэ нь надад коммунист нууц цагдаа нар Христийн тухай зааж болно, гэхдээ коммунизмын тухай дурсах ч хэрэггүй гэж хэлснийг л сануулна. Тэгвэл “Христийн сургаалыг үнэнээр завхруулалгүй заа!” гэж хэлдэг тэр хүмүүс коммунист нууц бүлгийнхэнтэй адил нэг сүнсэнд захируулж байгаа хэрэг үү? Үнэхээр байдал ийм гэж үү?

Тэдний нэрлэж буй завхруулаагүй сургаал нь чухам юу болохыг би огт мэдэхгүй. Тэгвэл усаар угаан батлагч Жоганы зааж байсан сургаал цэвэр байсан уу? Тэр зүгээр л “Гэмт амьдралаа хаягтун! Ертөнцийн Эзэний ер бусын улс ирэх ойртож байгаа тул Их Эзэний ирэх замыг бэлдэцгээ!” гэж хэлээгүй. “

Та, Хэрөд хаан, их гэм хийж байна!“ гэж тэр ил тод шуудхан хэлсэн. Тэрээр хийсвэр байдлаар сургаал заагаад байлгүй бодит байдлыг илчлэн хэлснийхээ төлөө толгойгоо авахуулсан. Есүс олива модтой уулнаа гарч сургаалаа заахдаа цэвэр сургаал гээд заагаад байсангүй. Тийм ч учраас зарим ахлагч нар энэ сургаалыг нь тун сөрөг утгатай айхтар хүнд сургаал гэж нэрлэдэг.“Паараши бүлгийнхэн, сургаал номлогчид та нар хорт могойн удам ажээ. Хоёр нүүртэй та нар үнэхээр өрөвдөлтэй ажээ.“ Ийм л цэвэр бус завхарсан сургаал заасан учраас түүнийг тэд цовдлон алсан. Тийм бишсэн бол Паараши бүлгийнхэн түүний уулан дээр зааж байсан сургаалыг тэгж их хорсон сонсохгүй байсан.

Гэмийг нэрээр нь нэрлэх хэрэгтэй. Өнөөдөр коммунизм бол дэлхий ертөнцөд учраад байгаа хамгийн аюултай гэм болоод байна. Үүнийг л эсэргүүцэн илчлэхгүй юм бол Христийн тухай хичнээн сайхан яриад ялгаа байхгүй, завхарсан сургаалд тооцогдох болно. Нууц бүлгийнхэн үүнийг эрс эсэргүүцнэ. Үүнийхээ төлөө амь нас, эрх чөлөөгөө хүртэл гаргуунд нь гаргана. Тэгвэл баруунд бид үүнээс ч илүү дуу шуугиан тарих хэрэгтэй.

“Коммунизмыг эсэргүүцэгчдийн“ адил байдлаар биш ч гэсэн би үүнийг бүрэн эсэргүүцэхээр нэгэнт шийдсэн. Гитлер өөрөө коммунизмыг эсэргүүцэгч байсан боловч бас л дарангуйлагч байв. Харин бид гэмийг үзэн ядаж, гэмт хүмүүсийг хайрлаж байдаг.

БАРУУНД ИРЭЭД ЗОВЖ БҮЙН ШАЛТГААН

Баруунд ирснээсээ хойш би коммунист улс оронд зовж байсаннаасаа илүү ихээр зовох боллоо.

Миний зовлон юуны өмнө үгээр хэлэхийн аргагүй үзэсгэлэнт нууц бүлгийнхэн ахан дүүсээ хүсэн тэмүүлэх сэтгэлээс үүдэн гарна. Тэд эртний латин хэллэг болох Нудис нудум Цхристи сефуи (гар хоосон ч бай хамаагүй, зөвхөн Христийг л даган амьдар) гэсэн үгийн жинхэнэ биелэл болсон хүмүүс байв.

Коммунист дэглэмтэй улс орнуудад Ертөнцийн Эзэнийх болсон хүмүүст толгой тавин унтах орон гэр гэж байхгүй. Христэд итгэгчид өөрсдөдөө зориулан байр байшин барина гэж үгүй.

Ямар сайн юм үүнээс гарна гэж тэгэх вэ? Тэднийг баривчлагдахад тэртээ тэргүй улсад хураагдахаас цааш. Зүгээр л шинэ байшин барьж орвол баривчлах сайхан шалтгийг өөрөө бэлдэж өгч байгаа хэрэг болно, учир нь коммунистууд түүнийг чинь өөрийн болгох гэж санаархана. Тэнд Христийг дагахын тулд эхлээд эцгээ нутаглуулах, эсвэл гэр бүлдээ баяртай хэмээн салах ёс хийх хэрэг байхгүй. Хэн таны эцэг эх, эгч, ах дүүс вэ? Энэ талаараа бол таны байдал Есүсийнхтэй төстэй. Ертөнцийн Эзэний хүслийг даган биелүүлэн амьдарч буй хэн бүхэн таны эцэг, эх адил болно. Сүйт бүсгүй хархуугээ, үр хүүхэд нь эцэг эхээ, эхнэр нь нөхрөө үргэлж эсргүүцэн урвах тохиолдолд салшгүй холбоо тэдний хооронд өнө удаан тэсээд байх юм гэж үү? Зөвхөн ер бусын гайхамшигтай холбоогоор бат нэгдсэн хүмүүс л холбоотой үлднэ.

Тэд бол ядарч туйлдсан, зовсон хүмүүс, гэвч тэдний дунд өөх ч биш, булчирхай ч биш хүн нэг ч байхгүй.

Нууц бүлгийн хурал маань тэртээ арван есөн зууны өмнө анхны итгэгчид ямар байсан түүнтэй адил байдалтай. Сургаал зааж буй хүн уран цэцэн сургаал гэж юу ч мэдэхгүй. Сургаал заах арга барил, уран яруу илтгэх авьяас чадвар бас үгүй. Яг л Пэтрийн адил баттай мэдэж байгаагаа л зоригтой заана. Пэнтэхөөст баярын өдөр Пэтрийн заасан сургаалыг сонссон Библийг судалсан эрдэмтэн мэргэд түүнд лав хамгийн муу үнэлгээг өгөх байсан нь гарцаагүй. Коммунист улс оронд Библи тун ховор олдох тул үг болгоныг нь шахуу цээжээр мэдэх хүн олон. Түүнээс гадна сургаал зааж байгаа хүмүүс нь ихэвчлэн олон жил Библийн бараа харалгүй широнд суусан хүмүүс байв.

Тэд Ертөнцийн Эзэнд хэрхэн итгэлтэй байгаагаа тунхаглахад үүнд үнэхээр чухал нэг зүйл илт агуулагдана. Тэдний хэлж буй үгсийн цаана жинхэнэ бодит амьдралаар туулсан туршлага байнга дагалдана. Тэд широнд байхдаа өдөр бүр ер бусын энэ эцгээсээ талх өгөхийг гүйж байсан ба өдөр бүр талхны оронд цэвэрлээгүй гэдэс доторгой байцаа авдаг байв. Гэсэн хэдий ч тэд ер бусын эцэг нь хайр энэрлийн Их Эзэн гэдэгт бат итгэсээр байлаа. Амь насыг нь хороох байлаа ч хамаагүй, юу ч болж байсан Ертөнийн Эзэнд итгэсээр байх болно гэж нэгэнтээ хэлж байсан Иовын байдалтай тэдний байдал тун төстэй. Загалмай дээр гав ганцаар

хаягдсан мэт санагдах тэр цагт ч гэсэн“Ертөнцийн Эзэн эцэг минь!” хэмээн дуудаж байсан Есүсийн байдалтай адил юм шиг санагдана.

Нууц бүлгийнхний ер бусын тэр гоо үзэсгэлэнг олж харсан хэн боловч барууны итгэгчдийн хөндий хоосон, амьгүй байдлыг хараад сэтгэл амар сууж даанч түвдэхгүй.

Одоо би өөрийн нүдээр барууны иргэншсэн нийгэм сүйрч байгааг харсан учир коммунистуудын шоронд хоригдож байсанасаа илүү их зовлонтой байх боллоо.

Освальд Спинглер“Барууны нийгмийн доройтол“ номдоо, «Та нар үхэж байна. Та нараас би үхэж муудаж байгаагийн бүхий л шинж тэмдгийг олж харж байна. Та нарын агуу их баялаг болон агуу их хоосролыг, капитализм ба социализмыг, та нарын дайн тулаан, хувьсгалт тэмцэл, ёс суртахуунгүй бузар байдал, салж сарнисан гэр бүлүүд, төрөх үхэхийг хянана гэж өөрийгөө дороосоо хөнөөж буй байдал чинь толгойноосоо эхлээд сүйрүүлж байгаагаар чинь батлагдаж байна. Эртний Александр, Грек болон Ромын эзэнт гүрнүүд уруудан мөхөхөд мөн л ийм шинж тэмдгүүд илэрч байсан. Энэ бүхэн хангалттай баталгаа болно» гэсэн байв.

Үүнийг 1926 онд бичжээ. Түүнээс хойш ардчилал, соёл иргэншил гэдэг зүйл европын тэн хагасынх нь хувьд үгүй болжээ. Тэр бүү хэл Кубад хүртэл энэ байдал бий болсон байна. Харин барууны үлдсэн хэсэг нь унтсаар.

Гэтэл унтаж өгдөггүй нэг хүч байсаар, энэ бол коммунизмын хүч болсон коммунистууд юм. Зүүний коммунистууд урам нь хугарч мөрөөдөл болсон хоосон санаагаа хаяж эхлээд байхад баруунд коммунизм хор хөнөөлтэй хэвээр байна. Барууны коммунистууд коммунист улс орнуудын дотоодод олж байдаг аймшигтай харгис хэрэг, хүнд хэцүү зовлонт байдлын тухай мэдээ болон хавчлагын тухай үгэнд огт итгэдэггүй. Хaa сайгүй ядрахыг үл мэдрэн үзэл суртлаа дэлгэрүүлэх гэж зүтгэнэ. Дээд ангийнхны тансаг ширээний ард, оюун ухаантнуудын цугласан клубууд, сургуулиуд, ядуусын хорооллууд болон итгэгчдийн байгууллагуудад хүртэл очсон байгаа харагдана. Гэтэл, Христэд итгэгчид бид аливаа хэрэгт ямагт хоёрдмол сэтгэл гарган чигч

шулуун хандаж чаддаггүй аж. Гэтэл тэд худал хуурмагийн талд чигч шулуун хандан тэр чигтээ эргэж ч харалгүй зүтгэж байна.

Тэгтэл баруунд Библийн ерөнхий сургаалыг судлаачид ялих шалихгүй өчүүхэн юмаар маргалдан сууна.

Энэ нь надад нэгэн түүхийг сануулна. Константинополь хотыг ИИ Мухамедийн цэргүүд 1493 онд бүслэн авсанаас хойш Балканчууд Христийнхний эзэмшил хэвээр байх уу эсвэл Мухамедуудынх болох ёстой юу хэмээх зууны турш хэлэлцсэн асуудлыг шийдэх хэрэг гараад байсан тэр үед бүслэгдсэн хотын итгэгчдийн зөвлөл хуралдаад дараахи асуудлыг хэлэлцсэн байна. Хөндөгдөөгүй бүсгүйн нүд ямар өнгөтэй байсан бэ? Ер бусын элч нарын хүйс юу вэ? Ариун ёслолын усанд нисэж явсан ялаа унаж орвол яах вэ? Тэгвэл ялааг ариуссанд тооцох уу эсвэл усыг бузартсанд тооцох уу? Тэр цаг үеийн амин чухал асуудлыг бодвол эд бол зөвхөн домог төдий хэрэг. Гэвч та өнөөгийн итгэгчдийн байдлыг нэхэн хөөгөөд судлаад үз, тэгвэл ийм аар саар зүйлээр хөөцөлдөн маргаж суугаа улс олныг олж харах болно. Коммунизмын харгис хэрцгий дарангуйдал болон нууц бүлгийнхний зовж тарчилж буй талаар дурсах нь бараг ховор.

Библийн ерөнхий сургаалын талаар, ёслолуудыг хэрхэн үйлдэх болон хийж болох, болохгүй, хэрэгтэй хэрэггүй олон зүйлийн талаар одоо хир нь маргасаар, ярьсаар, төгсгөлгүй мэт үргэлжилсээр.

Том танхимд баяр болж байлаа. Нэг хүн, “Хэрэв чамайг усан онгоцоор далайд явж байхад чинь онгоц живж чамд эзгүй арал дээр гарч гав ганцаар амьд үлдэх боломж олдож, олдохдоо онгоцны номын сангаас ганц л ном авч явах боломжтой байх тохиолдолд ямар номыг сонгох вэ?” гэж асуув. Нэг нь хариулахдаа, “Библи“ гэхэд, нөгөөх нь “Шекспьер“ гэв. Гэтэл зохиогч хамгийн зөв хариуг хэлжээ. “Надад хэрхэн завь хийгээд залуурдан жолоодсоор эх газар ирэхийг зааж өгч чадах тийм л номыг би сонгоно. Тэгээд эх газарт гараад би юу хүссэнээ унших болно“ гэжээ.

Аливаа байгууллага болон үндсэн сургаалыг адил тэгш эрх чөлөөтэй байлгах гэхдээ бид хаана нь хэзээ яаж алдсанаа үл мэднэ. Харин коммунист үзэл суртал, тэдний хавчлагын улмаас бид ганц л зүйлийг ягштал баритлах нь зөв болохыг ойлгосон.

“Тэрхүү үнэн та нарыг үнэн замаар дагуулах болно“ хэмээн Есүс хэлсэн. Гэвч үүний адил“зөвхөн эрх чөлөө л үнэнийг ойлгуулах болно“ гэж хэлэх нь аргагүй. Тэгээд хэрэггүй зүйлсийн талаар маргалдан дэмий цаг үрж байхын оронд бид коммунизмын дарангуйллын эсрэг тэмцэлд хүч нийлүүлэн нэгдвэл зохино.

Төмөр хөшигний цаадах Христэд итгэгчдийн туулж буй өдөр өнгөрөх бүр нэмэгдэх тэр их зовлонг мэдрэх тусам би улам бүр шаналан зовно. Нэгэнт өөрөө би тамлуулж байсан учир тэр бүхнийг нүдэндээ дурслэн бодитоор харж чаддаг байв.

ЗХУ-ын“Известия“,“Деревенская жизнь“ сэтгүүлүүдэд оросын баптистуудыг гэмээ цагаатгуулахын тулд үр хүүхдээ алж өргөх ёстой гэж заасан хэмээн буруутган бичсэн нь 1966 оны зургадугаар сарын дугаарт гарсан байлаа. Энэ бол ёс заншилтай холбоотой эртний асуудал агаад ийм хэрэг эртний Иудейчуудад мөн тохиолдож байсан.

Гэвч энэ нь юу гэсэн үг болохыг би сайн мэдэж байв. Румыны Клуж хэмээх широнд байхад минь Христэд итгэгчдийн бүлгийн нэг ахлагч Лазаровикийг жаахан охин алсан хэргээр хорьж байсан билээ. Тэр дөнгөж гучтай байсан боловч яргалуулан тамлуулснаас болж ганцхан шөнийн дотор цал буурал болтлоо үс нь цайв. Нас дээр гарсан хүн шиг харагдаж байлаа. Түүний гарын хуруунуудынх нь хумснуудыг авч хаясан байв. Хийгээгүй хэргийг нь хийсэн болгон хүлээлгэхийн тулд аймшигтай тасдан хэрчих мэт түүнийг тамлажээ. Бүтэн жил ийнхүү тамлан зовоосны буруугүй болох нь нотлогдож широнгоос суллагдсан ч түүний хувьд эрх чөлөө утга учираа хэдийн алджээ. Түүнийг насан турш зовоох гүн шарх сэтгэлд нь үлдсэн байв.

Зарим хүмүүс үүнийг уншаад ЗХУ-ын сэтгүүлүүд ямар хөгийн шалтгаанаар баптистуудыг буруутгаж байгааг хараад утгагүй юм гэж шоолон инээх байх. Гэвч буруутан болсон хүний хувьд энэ юу гэсэн үг болохыг би дэндүү сайн мэдэж байна.

Баруунд амьдрах хирнээ цаг ямагт ийм дүр зургийг олж харан сэтгэлдээ шаналах үнэхээр хэцүү.

Калугагийн Ермоген (ЗХУ) хэмээх үнэн алдартны шашны байгууллагын тэргүүн хамба одоо хаана байна вэ? Алексей, Никодим гэх мэт урвагч этгүүдүүд коммунизмын гар хөл болж

эхлэхэд эрс шаргуу эсэргүүцэж байсан бусад долоон хамба одоо яасныг мэдэх хүн байна уу? Румынд коммунистуудыг эсэргүүцснийхээ төлөө амиа алдсан тэр хамбатай би широнд байхдаа уулзаагүйсэн бол Ертөнцийн Эзэнд чин сэтгэлээс үнэнхүү итгэсэн эдгээр хүмүүсийн талаар нэг их тоохгүй өнгөрөх байсан бизэ.

Николай Эшлиман, Глеб Якунын нарыг тэргүүн хамба дагалдуулж байсан ба тэд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүсч байв. Энэ талаар барууныхан бүгд л их барагүй мэднэ. Гэтэл намайг широнд байхад миний дэргэд Румыны Владимириштын эцэг Иоан байсан ба түүнд ч гэсэн тэдэнтэй адил зүйл тохиолдсон. Гадна өнгөндөө тэд зөвхөн гүн ухааны чиглэлээр сурган дагалдуулах боловч үнэн хэрэгтээ коммунист орны бүх итгэгчдийн байгууллагын ахлагч, удирдагч нар нууц цагдаагийнхантай гар нийлэн зэрэгцэн ажиллана. Дагалдаж буй хүмүүс нь дороо бас өөрөөсөө илүү аймшигтай тамлан зовоогчийг бий болгохоор дагалдуулах ба эцэст нь тэд широнгийн харгис хуяг, тамлагч болон ирнэ.

Коммунистуудын хорих лагерът хоригдож буй тэдний зовлонг мэдрэхдээ би аймшигтай дагжин чичирдэг. Би тэднийг тамлан зовоож буй хүмүүсийн мөнхийн хувь заняны тухай бодохдоо өөрийн эрхгүй айн дагждаг. Хавчигдан зовж буй ахан дүүстээ тусалдаггүй барууны итгэгчдийг бодохдоо би аймшигтай хэцүү байдлтай болдог.

Зүрх сэтгэлийнхээ гүнд би өөрийн цэцэрлэгийг тордон ургуулж, түүнийхээ гоо үзэсгэлэнг магтан биширч ийм аймшигтай тэмцэлд оролцохгүй явах нь илүү дээр гэж үзмээр. Хaa нэгтээ чимээгүй нам гүм газар амрах нь надад дээр баймаар. Гэтэл энэ нь боломжгүй хэрэг ажээ. Учир нь босго давангут коммунизм өөдөөс угтана. Коммунистууд төвдийг эзлээд юуны түрүүнд оюун санааны аливаа асуудлыг сонирхож байсан хүмүүсийн хүсэл зоригийг мохож эхэлсэн. Манай улс харин өөрсдийгөө бодит байдлаас салгасан хэн хүний хүсэл зоригийг үгүй хийсэн. Сүм хийдүүдийг хааж зөвхөн гадаадынханд л үзүүлэн болгох гэж цөөнхнийг үлдээлээ. Гэтэл ийнхүү чимээгүй нам гүм байдлыг эрхэмлэн амрах нь бодит байдлаас өөрий-

гөө тусгаарлаж буй хэрэг болох бөгөөд энэ нь надад ч гэсэн аюул учруулах хэрэг юм.

Хувь хүний амьдралын тухайд, энэ нь үнэхээр аминд халтай хэрэг боловч энэ тэмцэлд оролцохоос өөр аргагүй. Хэрэв би гэв гэнэт алга болбол коммунистууд намайг хулгайлжээ гэж та нар ойлгох хэрэгтэй. 1948 оны нэг сайхан өдөр гудманд явж байхад минь тэд намайг хулгайлсан худал нэр өгөн шоронд суулгасан. Тэр үед төрийн нарийн бичиг байсан Анна Паукер Швед улсаас манай улсад сууж байсан онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Сер Патрик вон Ройтерсвердэд, “Өө, Вурмбранд одоо ч гэсэн Копингагене гудмаар тайван алхаж яваа л даа” гэж хэлж байжээ. Гэтэл Шведийн элчин сайдын халаасанд шоронгоос нууцаар арайхийж гарган хүргүүлүүлсэн захидал минь байсан ба энэ захидал түүний худал ярьж байгааг илчилж байв. Хэрвээ би аллагдвал алуурчин нь коммунистуудын томилсон хүн байх болно. Түүнээс биш өөр хэнд ч намайг алах шалтаг, шаардлага байхгүй. Ёс суртахуунгүй байдал гаргаж, хулгайн хэрэгт орооцолдож, завхайрч, бусармаг явдал үйлдэж, улс төрийн хэрэгт найдваргүй хандаж, худлаа хэлсэн гэх мэт миний тухай ямар нэг цуу яриа сонсогдвол нууц цагдаагийнхан “Ёс суртахууны хувьд чамайг сүйрүүлэх болно” гэсэн сүрдүүлгээ хэрэгжүүлэхээр оролдож байгаа нь тэр.

АНУ-ын сенатын гишүүдийн өмнө өөрийн түүхийг ярьсны минь дараа найдвартай эх сурвалжаас Румыны коммунистууд намайг алахаар төлөвлөж байгаа тухай мэдээлэл ирэв. Тэд намайг биеэр минь устгана, эсвэл нэр төрийг минь унаган сүйрүүлэх болно. Түүнээс гадна Румынд буй найз нөхдийг минь сүрдүүлэн хар захидал ирүүлэхийг хичээнэ. Тэдэнд олон хүчирхэг зэвсэг, аргууд бий.

Гэсэн ч би дуугүй суугаад байж чадахгүй. Харин таны үүрэг бол миний хэлж байгааг дуугүй сонсоод тунгаан эрэгцүүлэх явдал юм. Миний туулж өнгөрөөсөн бүхнийг сонссоныхоо дараа ч гэсэн танд энэ зовлон дэндүү төвөгтэй санагдаж байгаа бол коммунизмын хүч чадал юутай аймшигтай агаад түүний дор буй ард түмэн хичнээн их төвөгтэй байдалтай зовж байгаа талаар өөрөөсөө асуугаад үз. Зүүн Германд жаахан хүүхдийг бульдо-зероор өргөж аваад төмөр утсаар тусгаарласан хашаа давуулан

хаяхад хүргэж, гэр бүл, амь насаа гаргуунд гарган ийм хэрэг үйлдэхэд хүргэсэн хүч чухам юу вэ?

Барууныхан гүн нойронд дарагдан унтаж байна. Харин сэрэх цаг нэгэнт болжээ!

булл * * *

Зовж буй хүн гэмийг нь цагаатгахад хэрэглэгдэх ямаа адил өөрийн гэм бурууг үүрүүлэх хэн нэг хүнийг хайна. Тийм хүний хайж олоход үүрч явваа зовлон нь асар их хөнгөрнө. Гэвч миний хувьд тийм бишээ.

Коммунизмыг дэмжин гар нийлэн явваа барууны зарим ахлагч нарт бурууг тохоод зүгээр суугаад байж би чадахгүй. Адгийн бузар юм тэднээс гараагүй шүү дээ. Адгийн муу ёрын сүнс тэднээс илүү урт настай. Эртний нөгөөх залыт адгийн муу ёрын сүнсэнд тэд чинь өөрсдөө мэхлүүлчихээд явж байна. Христэд итгэгчдийн өмнө тулгараад байгаа замбараагүй, арчаагүй байдлыг тэд бий болгоогүй. Харин тэд ийм болчихсон байгааг л олж харсан юм.

Нэгэнт баруунд гараад ирчихсэн хойно би нилээд хэдэн Библийн сургалт явуулдаг сургуулиудтай танилцлаа. Лекцүүдийг нь сонсоод үзэхэд голдуу эртний хонхны түүх, яруу сайхан эгшигэлэнт дуу хэрхэн бий болсон түүх, аль эрт хэрэглэгдэхээ больсон хууль дүрэм, хэдийн амьдралд хэрэгжихээ больсон арга хэмжээ авч хүмүүжүүлэх арга хэлбэрийн тухай байлаа. Библийн сургуульд сурч байгаа хир нь Библид өгүүлсэн бүтээлийн тухай түүх нь үнэн биш, тэр бүү хэл Адаам, Нуахын үеийн үер, Мүшэхийн үйлдсэн гайхамшигт үйлс, зарлагуудын зөгиөн хэлсэн бүхэн хожим нь хэрхэн биелсэн тухай түүх гээд бүгд худал агаад хөндөгдөөгүй бүсгүй хүү төрүүлсэн түүх нь зөвхөн дөмог гэдгийг л мэдэхийн тулд суралцдаг аж. Тэд бас Есүс үхлээс дахин амилсанд итгэдэггүй тул түүний яс нь хaa нэгтээ булшинд хэвтэж байгаа гэж бодно. Пууль болон бусад төлөөлөгчдийн захидалтууд жинхэнэ биш ба «Үзэгдэл» ном бол галзуу хүний өдрийн тэмдэглэл гэж үзнэ. Эдгээрийг оруулахгүй бол аль ч талаас нь аваад үзсэн Библи бол ариун ном ажээ. (Энэ янзаар дүгнэн үзвэл коммунист суртал ухуулга бүхий сонингуудад гарах худал хуурмаг бүхэнтэй холбоотой юм болгон ариун ном болж болох нь гэсэн үг юм.)

Өнөөгийн ахлагч, удирдагч нар Библийн сургуульд ороод ийм л юм сураад гарч байна. Энэ бол тэдний амьдардаг орчин, уур амьсгал нь. Ийм хачин этгээд тодотголтой Их Эзэнд тэд яагаад үнэнч байх хэрэгтэй гэж? Ертөнцийн Эзэн үхмэл гэж эрх чөлөөтэй нь аргагүй тунхаглан зааж буй ахлагч, удирдагч нар яагаад Христийн хүмүүст үнэнч байх ёстой гэж?

Тэд чинь Христийн сүйт бүсгүй биш, харин албан ёсны ажилтай байгууллагын ахлагч нар шүү дээ. Тэдний ахалж буй хүмүүсийн ихэнх нь хайртай Их Эзэнээсээ аль хэдийн урван нүүр буруулсан урвагч нар байдаг. Тиймээс нууцаар үйл ажиллагаа явуулдаг, итгэлийнхээ төлөө амь бие үл хайлрадаг, зовж тамлуулж буй Христийн хүмүүсийг хараад хачин жигтэй юм-үзсэн мэт болох нь аргагүй.

Асуудалд хэрхэн хандаж байгааг ганц нэг удаа харчихаад хүмүүсийг шүүх нь зөв хэрэг явч биш. Хэрвээ бид ийнхүү шүүвэл Есүсийг муучлан үздэг Паараш бүлгийнхнээс нэг их ялгарахгүй. Тэд бямба гаригийн амралтын хуулийг зөрчлөө гэж Есүсийг муучилж байсан. Үүнээс болж тэдний нүдэн дээр ил харагдаж байсан Есүсийн хайр татам сайхан чанаруудыг олж харах чадвар нь алга болон таг сохор мэт болсон.

Коммунизмд хандах хандлага нь буруу байгаа боловч өөр бусад талаар бусдыг давуулахгүй сайн ахлагч нар тэдний дунд олон л байгаа байх. Магадгүй хувь хүнийхээ хувьд тэд зөв юм хийж байна гэж бодоод байгаа боловч аливаад чин сэтгэлээс ханддаг байж болохыг үгүйсгэхгүй.

Хэдийгээр тэд буруу зөрүү зүйл хийж байгаа ч засагдаж өөрчлөгдөх найдваргүй болчигоогүй байна. Өөрчлөгдөж болно гэж найдах л хэрэгтэй.

Румынд би нэг үнэн алдартны шашны байгууллагын тэргүүн хамбатай уулзсан юм. Тэр коммунистуудын талд орж, өөрийн хүмүүсээс нүүр буруулсан урvasан ажээ. Үдэш орой би түүний эзэмшлийн цэцэрлэгт суугаад хоёр гарыг нь чанга атгаж тэнэмэл хүүгийн тухай сургаалт үлгэрийг түүнд ярьж өгөв. “Эргээд өөр рүү нь хандан тэмүүлэн ирсэн гэмт хүнийг хичнээн их хайлран угтдагийг та одоо хараач. Ертөнцийн Эзэн хэнийг ч гэсэн гэмээ ухаарч хаях юм бол хүлээн авах болно, бүр папыг хүртэл хайлран үзнэ шүү” гэж түүнд хэлэв. Би түүнд Христэд итгэгч-

дийн дуулдаг дуунуудаас дуулж өглөө. Эцэст нь тэр Христийн хүн болсон юм.

Суллагдах гэж горьdon Ертөнцийн Эзэнийг үгүйсгэсэн утгатай сургаал бичдэг байсан үнэн алдартны шашны сүмийн нэг сургаал номлогчтой би нэг өрөөнд хоригдож байлаа. Би түүнтэй уулзан ярилцсаны дараа нөгөө цаасуудаа тэр шууд хэдэн хэсэг тасчин хаяж суллагдах боломжоо үгүй хийв.

Би хэн нэгэнд бурууг тохчиоод сэтгэл зүрхэн дэх тэсэхийн аргагүй шаналалаа мартана гэж дэмийг горьdon сууж ясан ч чадахгүй.

булл * * *

Миний хамгийн, бүр бүхнээс илүү дотно найзууд маань хүртэл намайг буруу ойлгох нь сэтгэл зовоосон бас нэг асуудал болж хувирав. Тийм биш гэсээр байхад тэдний зарим нь намайг коммунистуудад хорсож, занаж байна гэж буруутгана.

Есүс Паараш бүлгийнхэн болон сургаал номлогчдыг олны өмнө буруушаан, яллах аястай ханддаг байсан нь дайснаа хүртэл энэрэн хайрлах хэрэгтэй гэсэн сургаалыг нь зөрчиж байгаа хэрэг хэмээн Клауд Монтефьоре гэгч Мүшэхийн хуулийг баримтлагч зохиолч хэлсэн байдаг. Лондон хотын гэгээн Павеллийн сүмийн туслах байгаад саяхан тэтгэвэртээ гарсан доктор В.Р. Матфейс үүнийг дүгнэхдээ: «Есүс уялдаа холбоогүй, хоорондоо авцалдахгүй сургаал заадаг ... » гэсэн. Есүсийг сэтгэн бодох чадвар муутай гэдгээр үүнийг тайлбарлах гэж оролджээ!

Есүсийн талаар гаргасан Монтефьорегийн дүнгэлт буруу байв. Есүс хэдийгээр Паараш бүлгийнхнийг олны өмнө буруутган зэмлэдэг байсан ч тэднийг маш их хайрладаг байв. Би хэдийгээр коммунизмыг үзэн ядаж зэмлэвч коммунистуудыг, тэдний гар хөл болсон хүмүүсийг ялгахгүй хайрладаг.

Надад “Коммунистуудыг март! Оюун санааны асуудалд, ер бусын дээд юмст л санаа тавь!” гэж хэлэх нь олон.

Нацистуудын дарангуйлалд зовж байсан Христэд итгэгч нэг хүнтэй уулзахад тэр намайг Христийн тухай тунхаглан байгаа цагт үргэлж миний талд дэмжин бат зогсоно гэхдээ коммунизмын эсрэг юу ч хэлээд хэрэггүй гэж байв. Би түүнээс, “Хэрвээ германд Гитлерийн дэглэмийн эсрэг тэмцэж байсан Христэд итгэгчид тэмцэхийн оронд зөвхөн Библиэс иш татан яриад,

дарангуйлан зовоогчийнхоо тухай нэг ч үг хэлэхгүй байсан бол юу болох байсан бэ?“ гэж асуув. Тэр хариулахдаа,“Гэвч Гитлер зургаан сая Иудей хүний амийг хөнөөсөн шүү дээ! Түүний тухай эсэргүүцэж ярихаас өөр арга байхгүй!” гэлээ. “Коммунизм тэгвэл гучин сая орос, мөн олон сая хятад болон бусад орны иргэдийг хөнөөж байна. Иудейчуудыг ч гэсэн тэд алж устгаж байна. Иудейчууд алагдах үед л бид эсэргүүцэх ёстой юм гэж үү? Оросууд алагдаж байгаа нь хамаагүй хэрэг болж байна уу?” гэж хариу өчив. Тэрээр,“Энэ ч харин өөр хэрэг ээ!” гэхээс өөр тайлбар хэлсэнгүй өнгөрөв.

Би Гитлерийн үед ч, коммунистуудын гарч зодуулж тамлуулж үзсэн хүн. Тиймээс энэ хоёрт ямар ч ялгаа байхгүй гэдгийг сайн мэднэ. Аль аль нь дэндүү их зовлон шаналалыг бий болгодог.

Христэд итгэгчид зөвхөн коммунизмын эсрэг тэмцээд байх биш харин гэмийн аливаа бүх талуудыг үндсээр нь устгахаар тэмцэж байх ёстой. Бид ганц энэ асуудалд эзэмдүүлчихээд байгаа хэрэг биш шүү дээ.

Гэвч одоохондоо коммунизм бол Христэд итгэгчдийн хамгийн том заналт дайсан, хамгийн их аюул, хор хөнөөл дагуулсан этгээд болоод байгаа нь үнэн. Тиймээс дахин хэлэхэд, бид нэгдэх хэрэгтэй, нэгдмэл байж тэмцэх хэрэгтэй.

Би та нарт дахин хэлье! Хүний амьдралын эрхэм чухал зорилго нь Христийн адил зан чанартай болох явдал юм. Үүнд саад болох нь коммунизмын үндсэн зорилго. Тэд бол үндсэндээ аливаа шашныг эсэргүүцэгчид мөн. Тэд үхсэний дараа хүн давс, эрдэс болон хувирахаас өөр юу ч болдоггүй гэж итгэдэг. Тэдний хүслээр бол амьдрал тэр чигээрээ материас гаралтай ба ийм л чанартай байх ёстой аж.

Тэд зөвхөн бөөн юмыг л мэднэ. Тэдний үг нь «Шинэ Гэрээнд» гардаг муу ёрын сүнснээс нэр чинь хэн бэ хэмээн асуухад “түмэн” гэсний адил болой. Хүний хувь чанар бол Ертөнцийн Эзэний хүн төрөлхтөнд өгсөн онцгой гайхамшигтай бэлэг атал тэд үүнийг устган нэг хэвэнд цутгахыг зорино. Альфред Адлерийн бичсэн “Хувь хүний сэтгэл зүй” номыг уншиж явааг харвал барьж аваад шоронд хийнэ. Нууц цагдаагийн офицерүүд ”Хувь

хүн, хувь хүн. Дандаа хувь! Яахаараа нэгдэл, нийгэм гэж болдоггүй улс вэ!“ хэмээн хашгичина.

Хувь хүн бүрт бэлэг болгон өгсөн чанарыг нь илтгэн харуулж байгаасай гэж Есүс үргэлж хүснэ. Тийм учраас коммунизм болон бидний хооронд эвлэлдэн зохицох гэсэн асуудал огтхон ч байж таарахгүй юм. Коммунистууд ч үүнийг сайн мэднэ. ”Наука и религия“ (Шинжлэх ухаан ба шашин) сэтгүүлд, «Шашин бол коммунизмд үл нийцнэ. Энэ бол хар тамхи мэт хортой ... Коммунист намын хөтөлбөрүүдийн утга агуулга нь үүнийг үндсээр нь устгахад чиглэсэн ... Шашны хүлээсээс хүн ардыг үүрд чөлөөлөх зорилт бүхий шашиングүй үзлийг хөхүүлэн дэмжих зорилгоор энэ хөтөлбөрүүдийг бий болгосон билээ» гэж бичсэн байв.

Тэгвэл Христэд итгэх итгэл нь коммунизмыг зөвшөөрөн зэргэцэн оршиж болно гэж үү? Энэ асуултад коммунистууд өөрсдөө хариу өгөөд байна. «Коммунизм бол аливаа шашныг устгагч үхлийн элч мөн.»

ТАВДУГААР БҮЛЭГ

Одоо би та бүхэнд нууц бүлгийн тухай цааш нь яръя.

Маш хүнд хэцүү нөхцлийн дор тэд үйл ажлаа явуулдаг. Өөрсдийн бий болгосон шашингүй үзлээ коммунистууд шашнаа болгосон юм. Ахмад настнуудад юунд итгэх итгэхгүй нь зааж хязгаарлаад байхгүй боловч залуу үе, хүүхдүүдийг эрс хориглоно. Радио, телевиз, кино театр, драммын театр, хэвлэлийн газар, хэвлэх үйлдвэрүүд гээд улс оронд буй бүх юм Ертөнцийн Эзэнд итгэх итгэлийг бүрэн үгүй хийх ганц зорилгод захирагдан үйлчилнэ.

Бүх нийтийг хамарсан асар том хүчиний дэргэд нууц бүлгийн хийж буй ажил үнэхээр өчүүхэн. Оросын нууц бүлгийн ахлагч нар сургалт эсвэл сургуульд явж Библи судлаагүй, тэр бүү хэл Библийг бүтнээр нь уншиж үзээгүй байх боловч тэдний дотор зөвлөгөө өгөх үүрэгтэй хүмүүс олон.

Тэдний хэд нь ёслол хийн томилуулсан талаар ярьж өгье. Бид нэг залуухан орос туслахтай уулзвав. Хэн түүнийг ийнхүү туслахаар томилсныг асуухад,

— Бидний томилоод байх хамба энэ тэр бидэнд ямар байх биш дээ. Коммунист намаас зөвшөөрөл батлах аваагүй цагт хэн ч хэнийг ч томилдоггүй. Тиймээс бидний арваад залуус итгэлийнхээ төлөө амиа алдсан нэг эрийн булшин дээр очиж, түүний гэрэлт хөшөөн дээр хоёр маань гарсаа тавьж, бид өөрсдөө тойрон зогсоод Ертөнцийн Эзэний Ариун Сүнснээс биднийг томилж өгөхийг гүйсан. Есүсийн хадаасанд хатгуулсан тэр гар биднийг томилсон гэдэгт бид итгэдэг гэж хариулав.

Миний хувьд энэ залуугийн өөрийгөө томилсон нь Ертөнцийн Эзэний өмнө бүрнээ хүчин төгөлдөрт тооцогдоно гэдэгт итгэж байна!

Ийм байдлаар томилогдсон, Библийг хэзээ ч дэс дараалалтай цэгцтэй судалж заалгаж байгаагүй, Библийг барагтай сайн мэдэхгүй боловч Христийн ажлыг хийж байна.

Энэ байдал нь анхны Христэд итгэгчдийн байдалтай адилхан юм. Христийн төлөө орчлон хорвоог орвонгоор нь эргүүлсэн тэдгээр хүмүүс хаанаас тийм их цэгцтэй мэдлэгийг олж авсан бэ? Тэд бүгдээрээ уншиж бичиж чаддаг байсан хэрэг үү? Тэгээд тэд хаанаас Библи олоод авчихсан хэрэг вэ? Зөвхөн Ертөнцийн Эзэн тэдэнтэй ярьдаг байсан биш үү?

Нууц бүлгийн бидэнд хурал хийх байр энэ тэр байхгүй. Тэнгэрээр дээвэр, газраар шал хийн бид ой модонд нууцаар хуралдана. Гэтэл энэ сайхан үзэсгэлэнг ямар нэг сүмийн барилгын үзэсгэлэнт сайхан байдал үнэндээ гүйцэж чадна гэж үү? Эн зэрэгцэх юм уу? Шувуудын жиргэн шулганах нь магтан дуулах дуунд маань хөг аялгуу нэмнэ. Алаг цэцэгсийн анхилам үнэр бидний хувьд тансаг үнэрт тос болно. Саяхан шоронгоос суллагдсан эрийн томдсон хэлхгэр хувцас нь ахлагчийн цэмцгэр дээлээс хавьгүй илүү анхаарал татам баходлтай харагдана. Алтан наран, мөнгөн саран хүртэл биднийг гэрэлтүүлэх дэнлүү болно. Харин ер бусын элч нар бол дэнлүү асаагч ажилчид мэт.

Христийнх болсон энэ хүмүүс юутай баходам сайхан! Үгээр дүрслэн илэрхийлэхийн аргагүй үнэхээр сайхан!

Нууцаар хуралдсаны дараа ихэвчлэн зарим маань баригдан шоронд ордог байв. Хайртай залуугаасаа үнэт эрдэнийн титэм хүлээн авсан мэт баяр хөөр болон тэд шоронгийн дөнгө гинжийг зүүнэ. Шоронд ч гэсэн Христийн зүгээс урсах урсгал ус тогтуун сайхан. Учир нь тэр таныг үнсч, тэврэн авч угтана. Тиймээс энэ сайхан байдлыг ямар ч хаадын ордоор солих хүсэл хэнд ч, хэзээ ч төрдөггүй. Гялалзсан гал цог, урам зориг бадарсан чин үнэнч итгэгчдийг би Библиэс, нууц бүлгээс, мөн шоронгоос олж харсан.

Нууц бүлгийг байнга эсэргүүцэн дарамтлах нь элбэг боловч олон анд найзтай болоод авсан байв. Тэдний зарим нь нууц цагдаагийнхны дунд, зарим нь бүр засгийн газарт томхон алба хашина. Заримдаа энэхүү нууцхан итгэлтэй нөхөд маань бусдыгаа хамгаална.

Саяхан оросын нэг сонинд "гаднаа гяланцаг, дотроо паланцаг" нар олширч байгаа тухай гомдол гарсан байв. Энд тайлбарлахдаа, засгийн газрын чухал албан тушаалуудад идэвхи зүтгэлтэй ажиллаж, суртал ухуулга энэ тэр гээд аль ч салбарт дажгүй,

гялалзсан сайн коммунистууд олон байх боловч үнэн чанартаа тэд нууц бүлгийг дэмжиж байна гэжээ.

Коммунист хэвлэл мэдээллийнхэн суртал ухуулгын хэлтэст ажилладаг нэгэн залуухан эмэгтэйн түүхийг бичсэн байв. Ажил тарсны дараа тэр гэртээ хариад нөхрөө ажлаасаа бууж ирэхийг нь хүлээх ба оройн хоолоо идэцгээж амарч аваад бүлэг залуусыг гэртээ цуглуулж нууцаар Библи заан, Ертөнцийн Эзэнтэй ярьдаг гэжээ. Ийм явдал коммунист орнуудад элбэг тохиолдоно. Коммунист улс орон болгонд гаднаа гял, дотроо пал оргисон хүн мянга мянгаараа бий. Тэд цаг үргэлж ажиглалтад өртөж, гүйвуулж мушгисан сургаал сонсон суухын оронд гэртээ суухаар шийдсэн улс. Тийш очиж үзүүлэн болсонд орвол чимээгүйхэн засаг захиргааны албаа хашиж тэруүхэндээ хүрээгээ тэлээд нууцхан шиг байх нь дээр гэж үздэг. Ингэж нам гүм байдлаар Христийн төлөө зутгэдэг.

Ийм байдалтай мянга мянган хүн манай нууц бүлэгт бий. Тэд бол Христийн ер бусын үзэсгэлэн төгөлдөр байдлыг бүрдүүлэгч салшгүй хэсгүүд юм. Тэд дээврийн хөндийд, байшингийн доод хонгилд, гэр орондоо, орон сууц гээд олдсон газар болгондоо чадах ядахаараа хамт хуралддаг билээ.

Орост одоо хэн ч хүүхдийг усаар угаан баталж болох эсэх, мөн зөвхөн насанд хүрэгчид батлуулах ёстой эсэх, эсвэл Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч гэмгүй байх ёстой зэрэг асуудлыг хэн дэмжиж, хэн эсэргүүцэж байгаа талаар маргахаа, мянган жил өнгөрсөн, өнгөрөөгүй талаар хэлэлцэн суухаа бүр больсон. Хэн ч Ертөнцийн Эзэний зарлагуудын зөгнөлийн учрыг тайлах гэж оролдохгүй, сөхөн гаргаж ирдэг ч үгүй болжээ. Гэвч тэд тун хялбархнаар шашингүй үзэлтнүүдэд Ертөнцийн Эзэн үнэхээр бодитой байдгийг батлаад үзүүлж чаддаг юм.

Шашингүй үзэлтнүүдэд өгдөг тэдний хариу тун энгийн.

— Хэрвээ чамайг олон янзын амьтны амт шимтэй махаар хоол хийх их найранд уривал чи энэ олон махыг чанаж болгож хоол хийсэн хүн байхгүй гэж итгэх хэрэг үү? Гэтэл байгаль дэлхий гэдэг чинь бидэнд зориулан бэлтгэсэн найрын ширээ! Та нарт улаан лооль, чангаанз, алим, сүү, зөгийн бал гээд бүх юм байна. Хэн тэгвэл үүнийг чинь хүн төрөлхтөнд зориулан бэлдэж өгсөн юм? Байгаль дэлхий бол амьгүй сохор. Хэрэв та нар

Ертөнцийн Эзэнд огт итгэдэггүй юм бол амьгүй сохор байгаль дэлхий яж ийм олон төрөл байдлаар хэрэгтэй бүгдийг маань элбэг хангаж өгдөг гэж тайлбарлах вэ?

Тэд бас мөнхийн амьдрал байdag гэдгийг хялбархан баталж дөнгөнө. Шашингүй үзэлтэй хүнд,

— Эхийнхээ хэвллийд байгаа үр хөврөлтэй бид ярьж чадна гэж бодьё. Та түүнд үр хөврөлийн энэ ахархан амьдралын дараа жинхэнэ амьдрал, урт удаан үргэлжлэх тэр амьдрал эхлэх болно гээд хэл. Тэгэхэд тэр үр хөврөл танд юу гэж хариулах бол? Тэр танд шашингүй үзэлтэн та нар мөнхийн улс болон мөнхийн зовлонгийн талаар юу гэж хэлдэг билээ түүгээр чинь л хариу барина. Тэр танд эхийн хэвллийд буй энэ амьдрал маань л цорын ганц тохиох амьдрал агаад таны хэлж байгаа бүхэн чинь утгагүй тэнэг, хоосон шашны санаа байна гэх болно.

Харин тэр үр хөврөл бодож сэтгэх чадвартай байсан бол өөрөө өөртөө "Энд байхад гар минь ургаж байна. Надад тэд хэрэггүй. Би нэгэнт тэднийг чинь сунган сунайж ч чадахгүй шүү дээ. Тэд яагаад ургадаг юм бэ? Магадгүй дараа нь би тэднийг ашиглан ажиллах хэрэгтэй болох байх. Хөл ургаж байна, яахав би цээжиндээ наагаад хөдөлгөхгүй л байя. Яагаад ер нь хөл ургадаг юм бэ? Магадгүй дараа нь том ертөнцөд очвол алхах хэрэг гарах байх. Нүд бас бий болж байна. Гэтэл тас харанхуйд байгаа надад ямар хэрэг байна. Ер нь яагаад нүдтэй байх ёстай вэ? Магадгүй дараа нь өнгө, гэрэл алагласан хорвоогийн амьдрал дагалдах юм байх даа" гэж хэлэх байсан биз. Тиймээс хэрэв үр хөврөл хүртэл өөрийн өсөлт хөгжлийн тухай тунгаан эрэг-цүүлэх чадвартай бол хараагүй боловч эхийнхээ хэвллийгээс гаднах ертөнцийг мэдэж авч болох нь. Бидний хувьд ч гэсэн адилхан шүү дээ. Бид залуу халуун байхдаа эрч хүчтэй, дэгэж дэрвээд байх боловч оюун ухаанаа хэрхэн ашиглаж, зөв тийш залахaa мэддэггүй. Тэгээд нас тогтох ухаан суугаад аливааг мэддэг болсны дараа биднийг үхэл хүлээгээд отож байгааг ухаарна. Нэгэнт цаашид хэрэглэж чадахгүй мэргэн ухаан, амьдралын туршлагыг олж авах гэж хичээх хэрэг юу байв? Үр хөврөлд яагаад гар, хөл, нүд гээд эрхтнүүд хэрэгтэй байдаг юм бэ? Хожмын их хэргийн төлөө энэ бүхэн бий болж хөгжиж байдаг. Бидний хувьд ч гэсэн энэ дэлхий дээрх амьдрал маань

ийм л байдалтай. Хожмын үр дүнгээ бодож бид энд мэргэн ухаан, амьдралын туршлага, мэдлэг олж авна. Үхлийн дараа бий болох эрхэм дээд зорилгод үйлчлэхийн тулд бид ийнхүү бэлтгэгдэж байдаг гээд л түүнийг хялбархан итгуулж дөнгөнө.

Коммунистууд албан ёсны аливаа баримтдаа Есүсийг хэзээ ч энэ дэлхийд амьдарч байгаагүй гэж бичицгээдэг. Нууц бүлгийн хүмүүс үүнд тун амархан хариу өгч чадна.

— Халаасанд чинь ямар сонин байна вэ? «Үнэн» сонин уу? Гэхдээ өчигдрийнх үү эсвэл өнөөдрийнх үү? Алив, нэг хараадахъя. За, тэр! 1964 оны 1-р сарын 14. 1964 оныг хэдийнээс эхлэн тоолсон хэрэг вэ? Хэзээ ч амьдарч байгаагүй, түүхэнд ямар ч үүрэг гүйцэтгээгүй тэр нэг хүний мэндэлсэн цагаас хойш биш гэж үү? Та нар түүнийг хэзээ ч бодитой амьдарч байгаагүй гэдэг боловч түүний төрсөн цагаас эхлээд он тооллоо хөтөлдөг шүү дээ. Түүнийг төрөхөөс өмнө цаг хугацаа байсан. Гэвч түүнийг хорвоод ирэхэд хүн төрөлхтний туулж өнгөрүүлсэн бүхэн нь утга учиргүй, дэмий хоосон санагдаж он тооллоо шинээр тоолж эхлэх болжээ. Жинхэнэ цаг хугацаа тэгэхэд л эхэлсэн. Коммунистууд та нарын сонин хэвлэл чинь хүртэл түүнийг бодит хүн, үлгэр домог төдий бус гэдгийг нь батлаад байна шүү гэнэ.

Барууны ихэнх ахлагч нар хүмүүсээ Христэд итгэх үндсэн сургаалуудыг амьдралдаа бат ойлгон итгэсэн хүмүүс гэж үнэлэн бодох боловч байдал үнэндээ тийм биш ажээ. Бидний итгэлийн үндэс үнэн бодитой болохыг батжуулж өгөх сургаал олж сонсоно гэвэл бараг бүтэхгүйтэй адил. Гэтэл Төмөр Хөшигний цаана хэзээ ч сургууль соёлоор сургаагүй боловч үүнийг хэнээс ч дутахгүй чадварлаг заан, үгийг нь сонсон итгэсэн хэнд ч гэсэн энэ үндсэн мэдлэгийг сайтар олгож өгч чадаж байдаг.

Нууц бүлгийн ажил хаанаас эхэлж байна, гол хүч нь хаана байгаа ба албан ёсны зөвшөөрөлтэй хүмүүсийн ажил хаана дуусч байгааг ялган салгах хэмжүүр гэж байхгүй. Тэд хоорондоо нягт холбоотой. Үзүүлэн төдий байгууллагын ахлагч нарын олонх нь нууцаар давхар ажил гүйцэтгэж байдаг ба коммунистуудын тавьсан хориг саад үүнийг яаж ч чадахгүй байв.

Коммунистуудтай хамтран ажилладаг албан ёсны гэсэн тодотгол хүмүүсийн тухай сайн, муу барагдахгүй урт түүх бий.

Оросын социалист хувьсгал ялсны дараа ахлагч Сергейн толгойлсон "Христийн хүмүүс" гэж өөрсдийгөө нэрлэсэн бүлэг хүмүүсээс эхэлсэн юм.

Тэд Москва хотын талбайд олны өмнө зогсоод,

— Бидний ганц зорилго бол Христэд итгэх итгэлийг сэргээх биш, харин бүрэн нураах явдал болно. Ингэснээр аливаа шашныг ул мөргүй арилгана хэмээн зарлан мэдэгдэж байв. Юутай гайхамшигтай төлөвлөгөө!

Сергей мэтийн хүмүүс хaa сайгүй байдаг нь мэдээж.

Унгарт, католикуудын эцэг нь болох Балогх нилээд хэдэн протестант байгууллагын ахлагч нартай нийлж коммунистуудын гарти засгийн эрхийг бүрэн атгуулах ажилд голлох үүргийг гүйцэтгэсэн.

Румынд Бурдусия хэмээх үнэн алдартны шашны байгууллагын тэргүүний тусlamжтайгаар коммунистууд засгийн эрхийг гартаа оруулсан билээ. Тэрээр урьд нь фашист байгаад одоо улааныханд тал олохын тулд өөрийн дарга захирагч нараас илүү улаантан болох гэж ийм хэрэг хийжээ. Шинэ засгийн газрыг тунхаглах тэр өдөр зөвлөлтийн төрийн нарийн бичгийн дарга Вишинскийн дэргэд зогсоод инээмсэглэн,

— Энэ засгийн газар нь эх дэлхий дээр аз жаргалыг цоглоон босгох тул та нарт цаашид ер бусын аз жаргалтай улс хэрэггүй боллоо хэмээн хэлж байв.

Орост тэргүүн хамба Никодим засгийн газар мэдээлэл дамжуулагч гэсэн тодотголтой байсан ба энэ үг үнэн байв. Оросын тусгай цагдаагийн албаны хошууч, мөрдөн байцаагч Деръябын Никодимыг тусгай албаны тагнуулын ажилтан байсан гэдгийг нь баталсан байдал.

Христийн гэгдэх бүх байгууллагад байдал иймэрхүү байв. Румыны баптист байгууллагын ахлагч нар хүчинд автан бас л ийм байдалтай болцгоосон. Энэ бол жинхэнэ итгэлтэй, чин хүсэл зорилготой Христэд итгэгчдээс нүүр буруулсан явдал юм. Оросын баптист байгууллагын удирдлагууд ч гэсэн ялгаагүй. Румыны адвентист байгууллагын удирдагч Тачики коммунистуудыг засгийн эрхэнд гарсан эхний өдрөөс эхлээд л нууц цагдаагийн ажилтан болж мэдээлэл дамжуулдаг байснаа хожим хүлээн зөвшөөрсөн.

Мянга мянган байгууллагын үйл ажиллагааг зогсоон хаагаад заримыг нь тэд үлдээжээ. Толгой дараалуулан нэгийг ч үлдэхгүй хаахын оронд тэд зальжин арга зохион хэдийг нь сонгон үлдээж, түүнийгээ ашиглан Христэд итгэгчдийг хянаж цагдах, мөрдөх, улмаар өөрөөр өөрийг нь устгах бодлого барин ажиллаж байв. Тэд итгэгчдийн байгууллагыг үндсэн хэлбэрээр нь хэвээр үлдээж хяналтын зэвсгээ болгон ашиглаад зогсохгүй эх оронд нь зочлон ирсэн гадаадынхны нүдийг хуурах хэрэгсэл болгохоор шийджээ. Миний мэтийн ахлагч нар гишүүдийнхээ талаар дэлгэрэнгүй мэдээллийг нарийвчлан гаргаж өгнө гэсэн ам өчиг өгсний үндсэн дээр албан ёсны бүртгэл авч үйл ажиллагаа явуулах эрхтэй болох байв. Хар ч бай, цагаан ч бай ялгаагүй барууныхан үүнийг огт ойлгохгүй, ухаан санаанд нь багтаж ч өгөхгүй байх шиг санагдана. Гэвч нууц бүлгийнхэн хэзээ ч тийм ам өчгийг өгч чадахгүй ба хянаж цагдуулсан байгууллагууд утга төгөлдөр сургаал зааж, хөгшин залуу гэхгүй хүн бүрт Христийн үнэнийг тунхаглаж үр нөлөөтэй ажиллаж чадахгүй болдог. Гэвч тэд үүнийг нууцаар хийсээр байна.

Албан ёсны байгууллагуудын ахлагч нар иймэрхүү хорон санаатай хүмүүс боловч оюун санааны хувьд үхмэл байдалтай болсон хэрэг бишээ. (Баруунд байдал үүнээс нэг их ялгарахгүй байгаа юм шиг надад санагдсан. Ахлагч удирдагч нараасаа шалтгаалахгүйгээр гишүүд нь гайхалтай эрчтэй, итгэлтэй байх нь элбэг.)

Үнэн алдартнуудын номыг огт өөрчлөөгүй өнгөрсөн ба сургаал нь коммунистуудад бялдуучлах өнгө аястай байсан ч гишүүдэдээ тус нэмэр болж чаддаг байв. Лютеран, протестантууд нөгөө л аль эрт галавын үеийн магтаалын дуу, дуулалаа дуулцгаана. Хэдийгээр мэдээ дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг ч ялгаагүй зааж буй сургаалдаа заавал Библиэс ямар нэг хэсгийг оруулна. Аль хэдийн урвагч гэдгийг нь, мөн тэд амьдралдаа Христийг оруулбал энэ тухай нууц цагдаагийнханд мэдээлнэ гэдгийг нь мэдэж байсан ч түүний энэхүү эvdэгдсэн сургаалын нөлөөгөөр Христийг таньж ойлгон итгэл олж авсан хүмүүс энэ тухайгаа тэднээс нууж эргэлт буцалтгүй Христийн араас дагадаг. Энэ бол Ертөнцийн Эзэний хийдэг аугаа гайхамшигтай ажил юм. «Хууль» номноо энэ тухай гайхалтай зөгнөн хэлсэн байдаг.

«Хэрэв хүний ясны өчүүхэн хэсэг бузар болсон бол тарьж буй үр тариан дээр унавал цэвэр болсонд тооцно.»

Тиймээс бодит байдлаас үүдэн бид албан ёсны байгууллагын ахлагч удирдагч бүр, тэр бүү хэл төрийн өмнө хариуцлагатай ахлагч нар хүртэл бүгд коммунистуудын гар хөл бологч гэж хэлж болохгүй.

Мэдээж нууцлахаас өөр аргагүй боловч нууц бүлгийнхний ихэнх нь албан ёсны байгууллагад ч бас нилээд нэртэй, байр суурьтай байв. Ингэснээр тэд Христэд итгэнэ гэдэг нь дураа хүрвэл итгээд дургүйгээ хүрвэл хаяад явдаг тоглоом төдий биш харин амьдрал өөд тэмүүлэх тэмцэл гэдгийг харуулдаг юм. Румыны Владимишты дахь итгэгчдийн байгууллагын үйл ажиллагааг зогсоохоор нууц цагдаагийнхан ирэхэд тэндхийнхэнд хүнд хэцүү байжээ. Ийм байдал оросын олон хот, тосгодод бас тохиолдсон. Зарим коммунистууд шашин шүтэх явдлыг хоргилгүй гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө амиараа төлөөсийг нь төлсөн тохиолдол ч элбэг байдаг.

Гэсэн хэдий ч албан ёсны байгууллагын тоо цөөрсөөр. ЗХУ-д нийтдээ ердөө л тав зургаан мянгаас хэтрэхгүй байгууллага байсан нь одоо хэвээрээ байгаа болов уу гэж гайхах үе надад олон гардаг. (Гэтэл хүн амын тоогоор тэнцүүхэн АНУ-д гурван зуун мянган байгууллага байдаг байна.) Эдгээр "нууц бүлгүүд" та нарынхтай адил том танхимд хуралддаггүй, харин хэдхэн хүнтэй жижигхэн өрөөнд хуралдана. Гадаадын зочид төлөөлөгчид ирээд Москва хотноо байх байнга хүнээр тасардаггүй, цорын ганц протестант сүмд очиж үзээд л шашин шүтэх эрх чөлөө орост байна гэж онцлон тэмдэглэнэ. «Христэд итгэгчдийн тоо нэмэгдэж багтахаа байж байна!» хэмээн хөөр баяр болон цааш нь мэдээлнэ. Гэтэл цаана нь буй хөөрхий долоон сая хүний амин сүнс ямар аюулд өртөөд байгааг олж харахгүй, эмгэнэлт дүр төрхийг нь анзаарах ч үгүй өнгөрнө. Алхаад хүрчих хэмжээний зйтгэлийг газар бүр ганц өрөөнд тогтмол хуралддаг итгэгчдийг олно гэхэд хэцүү. Зөвлөлтийн хүн амын ная шахуу хувь нь ийм байдалтай байна. Энэ олон хүнийг зориуд мартаж хаях уу, эсвэл тэдэнд Ертөнцийн Эзэний авралын мэдээг нууцаар ч гэсэн сонсгох уу гэдгийг бид шийдэх хэрэгтэй. Нууцаар ажиллахаас өөр сонголт гэж байхгүй.

Улс оронд коммунизм улам бүр цэцэглэн хөгжихөд улам илүү олон итгэгч хүмүүс нууцаар ажиллахаас өөр аргагүй болдог.

Албан ёсны байгууллагууд хаагдан байр нь төрийн байгууллагуудад шилжинэ. Тэнд тэд шашныг хэрхэн устгахаа зөвлөлдөн хуралдана.

ШАШИНГҮЙ ҮЗЛИЙН УХУУЛГА ЮУ ХЭЛНЭ ВЭ?

Ийм ном зохицуудыг хэрхэн ашиглахaa нууц бүлгийнхэн гаргууд мэднэ. Юуны өмнө, Элигаах хон хэрээгээр хоол хийдэг байсны адил тэд үүгээр оюун санаагаа тэтгэж авна. Шашигүй үзэлтнүүд аль болох доог хийж, үгүйсгэх гэж оролдохдоо Библиэс иш татаад түүнийгээ өөрсдийнхөөрөө тайлбарлах гэж хичээдэг байв.

Тэд "Инээдмийн Библи" буюу "Итгэдэг болон итгэдэггүй бүх хүнд зориулагдсан Библи" нэртэй номуудыг хэвлэн гаргажээ. Тэд Библийн үгс нь хичнээн мунхаг тэнэг болохыг батлах гэж оролдохдоо Библийн олон сургаалыг багтаан бичсэн байв! Үүнийг уншаад бид хичнээн их баярласан гэж санана! Шүүмжлэл нь үнэхээр тэнэг байсан нь мэдээж, хэн ч түүнийг сүрхий юм болгон тоож үзсэнгүй. Гэхдээ уг номуудыг сая сая хувиар хэвлэсэн байв. Библиэс зогсоо зайгүй иш татан өгүүлэх эдгээр номууд хaa сайгүй тарна. Энэ бол үнэхээр гайхамшигтай, үгээр хэлэхийн аргагүй сайн хэрэг байлаа. Балай юм хийж байх юм хэмээн коммунистууд хүртэл өөрсдийгээ шоолон инээлдэж байв. Урьд өмнө нь "буруу сургаал" газар авч үүний үр дүнд зүсэн бүрийн хачин этгээд хувцас хунар өмсөж зүүсэн байдалтайгаар адгийн муу ёрын сүнс болон мөнхийн зовлонгийн галыг дүрслэн үзүүлсэн зүйлс гарч байсан билээ. Ийм хөгийн зүс царайтай юмнуудыг хэн ариун гэгээнтэн гэх билээ! Гэсэн хэдий ч энэ нь мөнхийн зовлон гэж юутай аймшигтай болохыг, адгийн муу ёрын сүнс хичнээн муухай бузар болохыг харуулж чадсан. Үүний адил адгийн муу ёрын сүнс хорлохыг оролдсон боловч Ертөнцийн Эзэн түүнийг нь өөрийн зорилгодоо нийцүүлэхээр шийдвэрээ. Хэдийгээр тэд доог хийн худал гэж батлахыг оролдовч Библийн сургаалаас иш татан оруулснаараа үнэн боло-

хыг нь баталж орхив. Учир нь Библийн үг хэзээд үнэн хэвээр үлдэнэ.

Элэглэн дооглохын тулд Библийс иш татсан шашингүй үзлийг дэмжсэн номуудыг дахин хэвлэж өгөхийг хүссэн захидал олноор хүлээн авч байгаадаа хэвлэлийн газрууд тун баяртай байв. Гэтэл Библийг яагаад ч олж уншиж чадахгүй болсон нууц бүлгийнхэн энэ захидалтуудыг бичдэг байсныг тэд мэдсэнгүй.

Тэдний зохион явуулдаг сургалт семинарыг ч яаж ашиглахаа бид сайн мэддэг байв.

Нэгэн коммунист профессор Есүс бол илбэчинээс өөр хэн ч байгаагүй гэдгийг батлах гэж олныг хамарсан лекц үншив. Профессор өмнөө савтай ус тавьж дотор нь нунтаг юм хийгээд улаан өнгөтэй болгов. Тэгснээ,

— Энэ бол түүний үйлдсэн гайхамшигт үйлс гэж тэр тайлбарлаад,

— Есүс ханцуйдаа үүнтэй адилхан нунтаг нууж байсан ба дараа нь гайхамшигтай ер бусын аргаар усыг дарс болгосон дүр эсгэсэн юм. Тэгвэл би Есүсээс илүүг хийж чадна. Есүс усыг дарс болгосон бол би усыг дарс, дарсыг ус болгож чадна гээд өөр нэг нунтаг нөгөө сав руу хийлээ. Тэгтэл өнгө нь цагаан болчихов. Дахиад эхний нунтагаа хийхэд улаан болов.

Тэгтэл Христэд итгэдэг нэг хүн босоод,

— Нөхөр профессор oo, таны хийсэн юмыг хараад бид үнэхээр гайхан биширч байна. Харин танаас нэг юм асууя. Та наад өөрийнхөө бий болгосон дарснаас нэг балгыг уугаад үзэхгүй юу? гэж хэлэв. Тэгтэл профессор,

— Үүнийг чинь би хийж чадахгүй. Тэр нунтаг чинь хор гэж хариулав. Тэгтэл өнөөх эр,

— Есүс, та хоёрын хооронд асар том ялгаа байна. Тэр хоёр мяанган жилийн өмнө энэ дарстайгаа ирж бидэнд баяр жаргал өгсөн байхад таны дарс зөвхөн хордуулж байна гэж хариу өчив. Ингэснийхээ төлөө өнөө итгэгч шоронд орсон боловч энэ түүх хaa сайгүй тархаж, бусдынхаа итгэлийг батжуулсан юм.

Бид бол сүл дорой бяцхан Давидууд л гэсэн үг. Гэвч Ертөнцийн Эзэн бидний хамт байгаа тул бид шашингүй үзэлт Голиатаас хавьгүй илүү хүчтэй. Хүний амьдралын цорын ганц үнэн бидэнд хамаатай, энэ бол биднийх.

Нэг удаа коммунист багш шашингүй үзлийн онолын талаар лекц үншиж байв. Үйлдвэрийн бүх ажилчид уг лекцэнд зайлшгүй хамрагдах ёстой байсан тул Христэд итгэгч ажилчид нилээд олон сууж байлаа. Тэд чимээгүй суугаад Ертөнцийн Эзэний эсрэг болон Христэд итгэх нь юутай тэнэг мунхаг хэрэг болохыг тайлбарлахыг анхааралтай сонсов. Багш бүр цаашлаад ер бусын ертөнц, сүнс, Ертөнцийн Эзэн, Христ, мөнхийн амьдрал гэж огт байдаггүй, хүн бол зөвхөн материас гаралтай ба эргээд матери болж хувирна хэмээн батлахыг хичээн зөвхөн матери л байдаг гэдэг үгээ төть шиг давтсаар байв.

Нэг Христэд итгэгч залуу үг хэлэх зөвшөөрөл авч босоод эвхэгддэг сандлаа аваад газар руу чулуудаж орхив. Бүгд зогтуулсан түүн рүү харав. Дараа нь нөгөө багш руу ойртож очоод улаан нүүрэн дундуур нь тасхийтэл алгадаж орхилоо. Багш ч маш их хилэгнэн уурлав. Түүний уур буцалж байгаа нь илэрхий, нүүр нь час улайжээ. Зүсэн бүрийн хараал урсган хашгичиж коммунист нөхдөө дуудан түүнийг баривчлуулав. Тэр түүнээс,

— Чи яаж намайг алгадаж зүрхлэв? Ямар учраас ингэж байгаа юм? хэмээн тайлбар шаардаж гарлаа.

Өнөөх эр хариуд нь,

— Та худалч гэдгээ баталлаа даа. Та бүх юм матери, өөр юу ч биш гэж хэлээ биз дээ? Би сандлаа аваад газар руу шидсэн. Энэ үнэхээр матери мөн байсан. Сандал надад уурлаагүй. Зөвхөн матери юм чинь юу гэж тэгэхэв. Харин таныг алгадаад та сандалтай адил байсангүй. Та тун өөрөөр хандсан. Матери уурладаггүй, гэтэл та уурлалаа. Тиймээс нөхөр профессор oo, та буруу ярьжээ. Хүн бол зөвхөн матери биш. Хүмүүс бид чинь ер бусын чанартай, амин сүнктэй байдаг юм! гэв.

Хурал, лекц ийнхүү тасалдуулан үнэнийг илчлисэн нууц бүлгийн эгэл жирийн гишүүдийн тухай түүх тоймгүй олон бий.

Намайг шоронд байхад улс төрийн захирагч нэг удаа тун ууртайхан,

— Чи энэ тэнэг шашнаа хэзээ хүртэл хадгалах гэсэн хүн бэ? гэж асууж билээ. Би түүнд,

— Ертөнцийн Эзэнийг үл тоон байсныхаяа төлөө үхэхийнхээ өмнө орондоо харуусан хэвтээ олон коммунистуудыг би өөрийн нүдээр үзсэн. Тэд Христийг хүсэмжлэн дуудаж байлаа. Тэгвэл

та Христэд итгэгч хүн үхэхийнхээ өмнө энэ замаар бат дагаж амьдарсныхаа төлөө харуусан Маркс, Ленин нарыг дуудан итгэлээс нь салган өгч аврахыг гүйж байна гээд төсөөлж чадах уу? гэж хэлэв.

— Тун ухаалаг, цэцэн хариу байна гээд тэр учиргүй их инээж эхлэв. Би цааш үргэлжлүүлэн,

— Нэг инженер гүүр барьсан гээд бодоод үзье л дээ. Мэдээж гүүрэн дээгүүр муур аюулгүй гараад өнгөрөх нь гүүр сайн болсны шалгуур байж чадахгүй. Тиймээс галт тэргээр гүүрэн дээгүүр гараад үзвэл гүүрний хүчин чадал, даацыг тодорхойлж болно. Та бүх юм сайхан байхад шашингүй үзлийг дэмжин дагаж л байна, гэхдээ энэ чинь шашингүй үзлийн үнэн чанарыг батлах баталгаа болохгүй шүү дээ. Их хямралт амьдралд чинь тулгарахад энэ танд тус болж тайтгаруулах юм гэж үү? Тийм юм байхгүй шүү дээ гэж хэллээ. Тэгээд би түүнд Лениний номоос иш татан аливаа хэрэг буруугаар эргэхэд хэдийгээр тэр Зөвлөлт Холбоот Улсын ерөнхий сайд байсан боловч Ертөнцийн Эзэнтэй ярьdag байсныг үзүүллээ.

Бид үйл явдал хэрхэн өрнөхийг чимээгүй хараад хүлээгээд сууж байна. Гэтэл коммунистууд дуугүй суухгүй, шинээр байнга ямар нэг хөдөлгөөн өрнүүлэн аль болох устгахыг хичээсээр. Үүгээрээ тэд гэгээн Августины «Тан руу ирж нэгдэхээс нааш хэн ч амар тайван сууж чадахгүй, сэтгэл зүрх нь үргэлж шаналан зовно» гэж хэлснийг улам бүр батлан харуулах ажээ.

ХРИСТИЙН АРААС КОММУНИСТУУДЫГ

Эрх чөлөөт итгэгчид та нар хэрэв туслах юм бол нууц бүлгийнхэн та нарын тусламжтайгаар коммунистуудын зүрх сэтгэлд хүрч тэднийг Христийн араас дагуулснаар дэлхий ертөнцийн өнөөгийн байдлыг бодитой өөрчилж чадна. Коммунист байх нь тэдний төрөлхийн чанар биш учир тэднийг эрэн хайж буй Христтэй нь учруулж, түүний араас дагуулах нь боломжгүй хэрэг бишээ. Нохой хүртэл өөрийн гэсэн ястай байхыг хүсдэг шүү дээ. Коммунистуудын сэтгэл зүрх хүртэл өөрсдийн гүйцэтгэж байгаа үүрэг хариуцлага болон итгэж буй зүйлийнхээ ичгүүртэй утгагүй байдлыг үзэн ядаж байдаг.

Коммунистуудтай хувьчлан уулзаад материйн тухай яриа өрнүүлж бид бол зөвхөн матери, өвөрмөц байдлаар нийлүүлэн тавьсан атга дүүрэн химийн элементүүд ба үхлийн дараа эргээд давс, эрдэс болж хувирах болно гэж итгэдгийг нь мэдэж авна. «Коммунизмын үзэл суртлын төлөө ийм олон хүн яагаад амь насаа зольж байгаа юм бэ? Атга дүүрэн химийн элементэд сэтгэн бодох оюун ухаан, бодол санаа, үзэл суртал гэж байж болно гэж үү? Бусдын сайн сайхны төлөө эрдэс бодис өөрийгөө зольж чадах юм уу?» гээд асуувал тэд үүнд чинь хариу өгч чадахгүй байх болно.

Түүнээс гадна харгис хэрцгийгээр тамлана! Хүмүүс цуст алуурчид биш ба хэзээ ч тийм байхаар бүтээгдээгүй учир уг байдлыг удаан тэсэхгүй. Нацист удирдагч нарын зарим нь амиа хорлож, зарим нь хөргээ хүлээнээс үзээд бид үүнийг ойлгосон.

Коммунист улс орнуудад архидалт хамгийн түгээмэл болсон үзэгдэл. Коммунизмын өгч чадахгүй байгаа илүү хангалиун, өргөн хүрээг хамарсан амьдралыг хүмүүс хүсэн эрэлхийлж байгааг харуулдаг ганц эерэг тал үүнд бий. Энгийн орос иргэд аливаад чин сэтгэлээсээ ханддаг, өгөөмөр зантай, сайхан сэтгэлтэй хүмүүс байдаг. Харин коммунизм нь өнгөн хэлбэрийн, дүр төдий л эд. Тиймээс тэд гүн гүнзгий утга учиртай амьдралыг хайгаад хаанаас ч олж авч чадахгүй болохоороо архинаас олж авах гэж хичээнэ. Ингэж өөрийн амьдарч буй бузар хуурмаг амьдралын аймшигтай балмад байдлыг тэр илэрхийлдэг. Түр зуур архи түүнийг эрх чөлөөтэй болгох боловч цорын ганц үнэний адил үүрд эрх чөлөөтэй болгож чадахгүй аж. Харин тэр хүний амьдралын цорын ганц үнэнийг олж мэддэг л юм бол өөрийн болгох нь гарцаагүй.

Бухарестыг оросууд чөлөөлөн байрлаж байх үед дотроос минь маш хүчтэй хатган дэн буудлын газар руу түлхэх мэт хүчтэй сэтгэл төрөхийг би мэдрэв. Дотогш явж оронгуут гар буу атган толгойдоо зоон бүх хүнийг айлган сүрдүүлж дахиад архи өгөхийг нэхэж буй орос цэргийн ахмадыг олж харав. Тэр аль хэдийн мал болтлоо согтсон тул тэд дахин өгөхөөс татгалзжээ. Хүмүүс бүр сандарч тэвдэцгээсэн байлаа. Эзэн нь миний танил байсан тул түүн рүү дөхөж очоод ганц шил ликёр өгөхийг гүйгаад өөрөө дэргэд нь сууж түүнийг дуугүй байлгахаа амлав.

Нэг лонхыг цааш нь харуулаад дахиад нэгийг гэх мэтээр авчирч өгсөөр байлаа. Ширээн дээр гурван хундага байсан ба ахмад гурвууланд нь дүүртэл хийгээд өөрөө бүгдийг нь ууж байлаа. Эхнэр бид хоёр огт амссангүй. Тэр хэдийгээр дэндуү согтуу байсан ч толгой тархи нь ажилласаар. Тэр архинд хэтэрхий дассан байв. Би түүнд Христийн тухай ярьж өгөхөд тэр миний төсөөлөөгүй байдлаар хачин анхааралтай сонсож суулаа.

Эцэст нь тэр,

— Та надад өөрийн хэн болохыг хэлж өглөө. Харин би одоо хэн болохоо хэлээд өгье. Би бол Сталины удирдлагаар хавчлага гарч эхлэхэд итгэлээсээ няцсан үнэн алдартны шашны сургаал номлогчдын нэг. Би тосгоноос тосгон хэсэж Ертөнцийн Эзэн байдаггүй гэж тунхаглаж явсан. Сургаал заадаг хүний хувьд би бол адгийн худалч. «Би бол адгийн худалч. Та нар ч бас ийм хууран мэхлэгчид» гэж би бусад сургаал заагч наарт хэлж байсан. Өөрийн олж авсан зорилгодоо би сэтгэл хангалуун байсан учир үүнийгээ улам бүр гүйцэлдүүлэхийн тулд нууц цагдаагийн ажилтан болсон. Үүний хариуд Ертөнцийн Эзэнээс надад оноосон шийтгэл нь өөрийн гараар Христэд итгэгчдийг яргалж тамласныхаа дараа амийг нь хороох явдал байв. Харин одоо хийсэн бүхнээ мартахын тулд уудаг болсон. Гэсэн ч энэ хүртэл огт тус болохгүй байна гэж хэллээ.

Коммунистуудын олонх нь амия хорлож дуусдаг. Тэдний агуу их яруу найрагч Есенин, Майковский нар ч гэсэн амия хорлосон. Их зохиолч Фадеев ч мөн адил. Тэрээр «Аз жаргал» нэргэй зохиолоо бичиж дуусгаад дараа нь амия хорлосон. Энэ зохиолдоо тэрээр аз жаргал гэдэг бол коммунизмын төлөө нойр хоолгүй, цаг наргүй зүтгэхийг хэлнэ хэмээн тайлбарласан байдаг. Тэр үнэхээр аз жаргалтай байсан болоод баярласандаа толгойдоо буу тулган өөрийгөө хороосон хэрэг үү? Үнэндээ ийм их худал хуурмагийг тээж тэсвэрлэнэ гэдэг бол туйлын хэцүү хэрэг. Эзэн хааны засаглалын үед коммунизмын төлөө тэмцэж байсан агуу их хувьсгалч, удирдагч Жоффе Томкин коммунизм үнэн чанартаа юу болохыг хараад тэсээд сууж чадсангүй. Тэгээд тэд бүгд амия хорло замаар асуудлаа шийдэцгээсэн.

Коммунистууд бол хамгийн аз жаргалгүй хүмүүс. Тэдний аугаа их удирдагчид нь хүртэл ямар ч аз жаргалгүй улс. Сталин

юутай дүнсгэр, гунигт царайтай хүн байв! Эрт цагийн сайн нөхдөө нэгийг ч үлдээлгүй шахам устгасныхаа дараа тэр үргэлж хэн намайг алах бол, хэзээ намайг хор өгч дуусгах бол хэмээн үргэлж айдаг байлаа. Тэр найман унтлагын өрөөтэй байсан ба өрөө болгон нь банкны мөнгөний хадгаламж шиг олон давхар цоожтой. Энэ олон унтлагын өрөөнүүдийнхээ чухам алинд нь хэзээ унтахыг хэн ч хэлж мэддэггүй. Түүний дэргэд тогооч өөрөө хоолоо амсаагүй тохиолдолд тэр хэзээ ч юм идэхгүй. Коммунизм хэнийг ч, тэр бүү хэл дарангуйлагчийг ч хүртэл аз жаргалтай болгодоггүй. Тэдэнд зөвхөн Христ л хэрэгтэй.

Коммунизмыг түлхэн унагаснаар бид зөвхөн хохирогчдыг нь чөлөөлөөд зогсохгүй коммунистуудыг өөрсдийг нь бас чөлөөлөх болно.

Та бүхэнд нууц бүлгийнхний өмнө тулгараад байгаа амин чухал асуудлуудын тухай танилцууллаа. Бидэнд туслаач!
булл * * *

Нууц бүлгийн бусдаас ялгараах онцгой гойд шинж нь итгэлдээ чин сэтгэлийн угаас хандан үнэнч байдаг явдал юм.

“Жорж“ хэмээх нууц нэрээр хэвлүүлсэн номдоо нэг хүн Ертөнцийн Эзэний ажлыг нууцаар хийгчдийн тухай нэгэн бодит түүхийг өгүүлэхдээ:

«Унгарыг чөлөөлсний дараа оросын армийн ахмад Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч дээр ирж ганцаарчлан уулзахыг хүсчээ. Тэр эр залуу ч, зоригтой ч байж. Байлдан дагуулагчийн үүрэг хариуцлагаа ухамсарласан тэрээр их болгоомжтой аливаад хандаж байв. Уулзалтын бяцхан өрөөнд түүнийг дагуулан ороод хаалга хаасны дараа тэрээр хананд өлгөсөн модон загалмай өөд толгойгоороо заав.

— Энэ юм худал гэдгийг та мэднэ биз гэж тэр ахлагчид хандан хэлээд цааш нь,

— Энэ бол ядуусыг хуурч баячуудад таатай байх боломж олгох гэж итгэгчдийн байгууллагын ахлагч та нарын хэрэглэдэг зальжин хэрэгсэл. Бид энд хоёулхнаа байна! Есүс Христ Ертөнцийн Эзэний хүү мөн гэдэгт та хэзээ ч чин сэтгэлээсээ итгэж байгаагүй гэдгээ хүлээн зөвшөөрөөч! гэж тэр хэлэв.

Тэгтэл тэр инээмсэглэн,

— Ээ хөөрхий, залуу минь, сонс! Мэдээж би итгэлгүй яахав дээ. Энэ чинь үнэн юм чинь! гэж хариулав.

— Ийм зальт аргаар намайг мэхлэх гэж оролдсоны хэрэггүй шүү. Тантай тоглож нялуураад байгаа юм алга! Энэ чинь тун ноцтой асуудал. Битгий хүн шоолж инээгээд бай! гэж тэр ахмад чанга хашгираад, гар буугаа сугалан гаргаж ахлагчийн биед тулган барив.

— Хэрвээ чи худлаа гэдгийг нь хүлээн зөвшөөрөхгүй бол би чамайг нам буудаж орхино шүү!

— Би үүнийг чинь хүлээн зөвшөөрч чадахгүй. Бидний Их Эзэн бол үнэхээр, үнэн хэрэгтээ Ертөнцийн Эзэний хүү мөн хэмээн ахлагч хариу өчив.

Тэр ”Энэ бол үнэн!“ гэж чанга хэлээд уйлж гарав. ”Энэ бол үнэхээр үнэн. Би ч бас үүнд итгэдэг, гэвч өөрөө үүнийг биеэр олж мэдэхээсээ өмнө үүний төлөө хүн амь бие зориулж чадна гэдэгт итгэж өгөхгүй байсан юм. Танд маш их баярлалаа. Та миний итгэлийг батжуулж өглөө. Одоо би Христийн төлөө амиа зориулж чадах боллоо. Хэрхэн ингэхийг та надад зааж өглөө гэж баярлан хэлэв“ гэжээ.

Би иймэрхүү тохиолдлууд олныг үзсэн. Оросууд Румындын ирсэн өдөр хоёр орос цэрэг гартаа буугаа бэлэн барьчихсан хурлын танхимд орж ирэв. Тэд,

— Бид та нарын итгэдэг зүйлд итгэдэггүй. Үүнийгээ одоохон хөсөр хаян татгалзаагүй хэнийг ч болов газар дээр нь нам буудна! Итгэлээсээ урван татгалзаж байгаа хүмүүс одоохон баруун тийшээ болж зогс! гэж хэлэв. Зарим нэг улс баруун тийш очив. Танхимаас гарч гэртээ харихыг тэдэнд тушаалаа. Тэд хар амиа бодон гэр гэрийн зүг зугтав. Орос цэргүүд үлдсэн хүмүүсийн хамт хэдүүлхнээ болж авсан хойно тэднийг тэврэн авч,

— Бид ч бас Христэд итгэдэг. Гэхдээ бид итгэлийнхээ төлөө амиа өгөхөөс буцахгүй тэр хүмүүстэй л уулзаж нөхөрлөө гэж бодсон юм гэв.

Ийм л хүмүүс эх оронд минь Христийн төлөө амь бие үл хайрлан зүтгэж байна. Тэд зөвхөн Христийн авралын үнэн мэдээг хамгаалаад зогсохгүй мөн эрх чөлөөний төлөө тэмцэгчид юм.

Христэд итгэгч барууныхан ихэвчлэн элдэв төрлийн хөгжим сонсох зэрэгт хамаг цагаа дэмий зориулж байх шиг санагддаг. Бидний гэр оронд хөгжим чанга тавих тохиолдол элбэг байдаг боловч энэ нь Христийн тухай ярьж байгаагаа айл саахалтынхандаа мэдэгдэхгүй байх арга байв. Хэрэв тэд Христийн тухай, нууц ажлын тухай ярьж байгааг мэдвэл цагдаагийнханд тэр дор нь л дамжуулж орхих аюултай учир хөгжим чанга тавих нь зөвхөн халхавч болж байв.

Барууны орнуудаас ирсэн, чин сэтгэлийн угаас итгэсэн хүмүүстэй ховорхон уулзах боловч уулзах бүртээ тэд хачин их баярладаг. Тэдний энэ баяр хөөр юутай сайхан!

Энэ бүхнийг бичигч би бээр өчүүхэн мэдээ дамжуулагч төдийхөн боловч дуу хоолойгоо сонсгож чадахгүй байгаа тэдний дуу хоолой нь юм. Би бол барууныханд хэзээ ч өөрсдийгөө таниулж, хэрхэн ямар байдалтай байгаагаа илэрхийлж чадахгүй, хавчигдсан тэр хүмүүсийн дуу хоолой. Тэдний нэрийн өмнөөс итгэлийнхээ төлөө, Христэд итгэгчдэд тулгараад байгаа асуудлуудын төлөө үнэн сэтгэлийн угаас та бүхнээс гүйж байна. Тэдний нэрийн өмнөөс би тэдний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярьж, коммунист улс орнуудад хавчигдан буй итгэлтэй ахан дүүстээ бодитоор туслахыг та бүхнээс гүйж байна.

булл * * *

Бид коммунистуудыг Христийн араас дагуулах ёстой. Юуны түрүүнд, Ертөнцийн Эзэн өөрөө бидний хамт байгаа учир бид үүнийг хийх ёстой.

Хоёрт, бидний тунхаглан буй мэдээ нь хүний сэтгэл зүрхний гүнд буй амин чухал асуудлуудад хариу өгдөг учир үүнийг хийх ёстой юм.

Нацистуудын гарг шоронд тамлагдан зовж байхдаа Ертөнцийн Эзэнтэй ярьж тусламж гүйдаг байснаа олон коммунистууд наадаа хэлж хүлээн зөвшөөрч байсан. Коммунист офицерүүд хүртэл үхэхдээ амандаа "Есүс, Есүс" гэж хэлсээр амьсгал хураахыг би харсан.

Манай ард түмний соёл иргэншил, зан заншил хүртэл бидний талд байхад бид зүгээр сууж болохгүй. Оросууд орчин үеийн өнгө аясаар Христэд итгэгчдийн тухай тунхаглах, сургаалыг тайлбарлан бичих зэргийг хориглож болно. Гэвч Толстой, Дос-

тоевский нарын ном зохиолуудад Христийн сургаалын үзэл санаа илэрхий туссан байх тул хүмүүс ямар ч байсан тэдний зохиолуудаас олж мэдээд сураад байхыг хориглож дийлэхгүй. Зүүн германы Гётё, польшийн Сзыенкиевыч гээд олон хүнийг нэрлэж болно. Румыны их зохиолч нь Садовеану байв. Коммунистууд түүний "Гэгээнтнүүдийн амьдрал" номыг нь "Гэгээнтнүүдийн тухай домог" нэртэйгээр хэвлэн гаргасан. Хэдий ийм нэртэй ч төлөөлөгчдийн амьдралын түүх олон хүнд урам зориг, урагшаа тэмүүлэх хүсэл эрмэлзэл өгсөн.

Тэд Рафаэль, Мигель Анжело, Леонардо да Винчи нарын түүхэн сонгодог уран зургуудыг хуулбарлан зурахгүй байж чадахгүй. Энэ zuрагнууд хүртэл Христийн талаар ямар нэг үнэнийг илтгэн харуулдаг.

Коммунистуудтай ярилцахад оюун санааны хоосрол болон үнэнийг эрэлхийлэн байгаа сэтгэл зүрхнийх нь гүнд буй хүсэл нь миний гол туслах хүчин зүйл болдог. Түүний хамгийн хэцүү асуудал нь намайг ярихад миний талд орон дотроос нь хашгичих дотоод сэтгэлийнхээ дуу хоолойг цагдан хорьж чадахгүй байгаа явдал юм.

Маркизмын онолыг заадаг нэг профессорыг би сайн танина. Лекцээ унших болгондоо тэр эхлээд Ертөнцийн Эзэнтэй ярьж тусlamж гүйдаг байв! Mash хол зайдуу газар болж буй нууц хуралд оролцооир ирдэг коммунистуудыг олон бий. Баригдахдаа тэд ямар ч нууц хуралд оролцоогүй гэж худал хэлнэ. Гэвч сүүлд нь тэднийг тийш очиж оролцоход хүргэсэн тэр их хүч чадал бүхий итгэлийнхээ төлөө үнэнч зоригтой байж чадаагүйдээ харамсан уйлна. Тэд ч гэсэн хүн шүү дээ, тиймээс хүнд байдаг аливаа сул дорой чанар тэдэнд бас байж л таарна.

Хувь хүн итгэлтэй золгоод авсан л бол энэ нь хүчтэй бат бэх эсэх нь хамаагүй, цаг хугацаа өнгөрөхийн хирээр ямар ч байсан батжин нэмэгдэх нь гарцаагүй. Энэ эхлэл төдий итгэл, өчүүхэн жаахан оч төдий ойлголт мэдлэг нь улмаар тэр хүнийг аврал руу хөтлөн авчирна гэдэгт нууц бүлгийнхэн ямагт бат итгэсээр ирсэн. Учир нь бид ийм явдал тохиолдохыг өөрсдийн нүдээр олонтаа үзсэн.

Коммунистуудыг Христ үнэхээр хайлладаг. Тэднийг Христийн араас дагуулах боломж бий, бас тэгэх ч шалтгаан бий.

Тэднийг төмөр хөшигний цаана буй нууц бүлгийнхэн л ийм байдалтай болгож чадна. Бүх хүн төрөлхтнийг авран гэмээс чөлөөлөх гэсэн Есүсийн чин хүслийг биелүүлэх хүсэл зорилготой хэн ч гэсэн нууц бүлгийнхнийг дэмжин тусалж байвал зохино. Есүс, "Бүх улс үндэстэнд миний тухай тунхагла" гэж хэлсэн. Тэр хэзээ ч төмөр хөшигний дэргэд хүрээд зогс гэж хэлээгүй. Ертөнцийн Эзэн болон төлөөлөгчдийн зааж байсан сургаалд үнэнч итгэлтэй зүтгэх хүсэл нь биднийг төмөр хөшигний цаана хүн төрөлхтнөөс тусгаарлагдан коммунизм хэмээх шоронд хоригдож буй хүмүүст Христийн үнэн мэдээг хүргэх урам зориг, хүсэл зорилгыг бадраан өгдөг.

Аль хэдийн тэнд үйл ажлаа явуулсаар байгаа нууц бүлгүүдтэй хамтран тэдэнд үнэний сайhan мэдээг бид дуулгаж чадна.

НУУЦ БҮЛГИЙГ БҮРДҮҮЛЭГЧ ГУРВАН ХҮЧИН ЗҮЙЛ НЭГД, КОММУНИСТУУДАД ХӨӨГДСӨН АХЛАГЧ НАР

Коммунист улс орнуудад оршин буй нууц бүлгийг бүрдүүлэгч гурван хүчин зүйл байна. Эхний бүлэг нь Христийн сургаалыг гүйвуулан мушихаас татгалзсаныхаа төлөө өөрийн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн мянга мянган ахлагч, удирдагч нар. Тэдний олонх нь шоронд олон жил хоригдон итгэлийнхээ төлөө тамлуулж байсан улс. Тэднийг сулласны дараа нэн даруй ажилдаа шамдан орж нууц бүлгийн хүмүүст туслан дэмжиж үр бүтээлтэй ажиллаж байна. Хэдийгээр коммунистууд байгууллагыг нь хааж, эсвэл оронд нь "найдвартай" хүнийг томилон тавьсан ч тэд задгай тал, ойн шугуй, байшингийн хонгил, дээврийн хөндий гээд боломжтой бүх л газар Христийн хүмүүсийг цуглуулан Ертөнцийн Эзэнийг хүндэтгэн хурлаа хийсээр тусалсаар урьд урьдынхаас хавьгүй илүү үр дүнтэй үйл ажиллаж байна. Тэд шөнө дунд хамаг хүн ид нойрондоо дугжирч байх зуур энэ бүхнээ амжуулна. Тэд бол итгэлийнхээ төлөө амь бие гаргуунд нь гаргасан бодит хүмүүс. Хэдийгээр дахин баривчлагдаж, илүү ихээр тамлуулан зовно гэдгээ тэд мэдэж байсан ч бууж өгөхийг үл мэдэн бат шийдвэртэй тэмцэгчид юм.

ХОЁРТ — ЭГЭЛ ЖИРИЙН ИТГЭГЧИД

Нууц бүлгийн хамгийн том бөгөөд хамгийн өргөн хүрээг хамрах хүчирхэг хэсэг нь улс орны хaa сайгүй тархсан жирийн ажилчид, албан хаагчдаас бүрддэг. Тэд бол асар олон хүнтэй аварга том арми гэсэн үг. Орос, хятадад хоёрдмол сэтгэлтэй, өөх ч биш булчирхай ч биш байдалтай, төвийг сахисан итгэгч гэж байхгүйг та бүхэн ойлгох хэрэгтэй. Христэд итгэгчдийн төлдөг үнэ маш их. Сэтгэлдээ санаж байвал зохих бас нэг зүйл бол аливаа хавчлага зовлон итгэгчдийг улам бат итгэлтэй, урам зоригтой тунхаглан бусдыг Христийн араас дагуулдаг хүмүүс болгож байдаг. Энэ бол гарцаагүй үнэн. Коммунистуудын хавчлага нь өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр гэгчээр улам бат итгэлтэй, чин зоригтой итгэгчдийг бий болгосон ба ийм их итгэлтэй, үнэнч хүмүүсийг чөлөөт ертөнцөөс олно гэдэг бол бэрх даваа. Тэд бол бусдыг Христийн араас дагуулах явдлыг эрхэм зорилгоо болгоогүй байж өөрсдийгөө яаж Христэд итгэгч гэж хэлж чаддагийг ойлгодоггүй тийм л шулуухан итгэлтэй хүмүүс.

«Улаан Од» хэмээх оросын армийн сонинд Христэд итгэгчдийн талаар "Христийг дагалдагч эдгээр хүмүүс хүн бүрийг алдахгүй байхыг хичээн савраа нээсэн бар мэт байх юм" хэмээсэн байв. Гэвч тэдний үлгэр жишээ амьдрал, хайр дүүрэн байдал нь хөршүүдийнхээ хайр хүндэтгэлийг ямагт татна. Ямар ч хот, тосгонд очсон ялгаагүй хамгийн үлгэр жишээ, хүндэтгэл хайр хүлээсэн иргэд нь Христэд итгэгчид байдаг. Үр хүүхдүүдээ асрах тэнхээгүй болтлоо өвдэж зовсон эхэд туслахаар гар сунган гэрт нь ирж асран сувилаад зогсохгүй хүүхдүүдийг нь харж өгдөг хүмүүс ихэвчлэн Христэд итгэгч эмэгтэйчүүд байдаг. Эрчүүл нь өвдөн түлээ модоо хагалан базааж чадахгүй боллоо гэхэд өнөө Христийн эрчүүлээс гэрт нь ирж ажлыг нь амжуулж өгнө. Нэгэнт тэд амьдралаараа Христийг бодитоор харуулдаг тул Христийн тухай тэднийг ярьж эхлэхэд хүн бүр хүндэтгэн сонсч итгэнэ. Тэдний амьдралыг нүдээр үзсэн тул итгэхээс өөр яах билээ. Зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хүн л итгэгчдийн байгууллагад сургаал заан ярих эрхтэй тул чадвартай, авьяастай, амь амьдралаа үүний төлөө эргэлт буцалтгүй зориулах болсон

Христэд итгэгчид эх орныхоо газар болгонд Христийн тухай тунхаглан зах зээлийн газар, дэлгүүр хоршоо, тосгоны худаг гээд газар бүрд боломжийг алдахгүй ашигладаг. Махны мухлагийн Христэд итгэгч худалдагчид хүртэл мах худалдахдаа боодлын цаасан завсраа Христийн сургаал бүхий товхимолыг тарааж байна гэж коммунист сонин хэвлэлээр их л шуугидаг байв. Коммунист хэвлэх үйлдвэрүүдийн удирдлагад ажилладаг эрх мэдэл бүхий дарга нар хүртэл ажил тарж хамаг амьтан амарсан хойно нууцаар үйлдвэртээ ирж Христийн номнуудыг хэдхэн зуун хувиар хэвлэн гаргаад үүр цайж хүн амьтан сэргээс өмнөхөн үйлдвэрээ дахин хаан цоожлоод яваад өгдөг тухай ч хэлсэн байдаг. Моксва хотын сургуулийн хүүхдүүд хaa нэг газраас Христийн номнуудыг гараар хуулан бичиж олшуулж байсан тухай хэвлэлийнхэн бичсэн. Хуулж бичсэн хэсгээ багш нарын өрөөний шүүгээнд өлгөөтэй байгаа багш нарынхаа гадуур хувцасны халаасанд хийн тарааж байв. Энгийн албан хаагч, ажилчдаас бүрдэх энэ аварга армийн хүч чадал асар их, ажил нь үр дүнтэй агаад коммунист улс оронд Христийн ажлыг хийх тулгуур хүч нь болдог.

Коммунист Куба улсад Ертөнцийн Эзэний ажлыг урьд нь хийж байсан хүмүүс "ажилчдын энэ бүлгийг" улам илүү тодрон гарч ирж байгаа тухай хэлсэн байдаг. Нэгэнт сургаал заадаг ахлагч нарын ихэнх нь баривчлагдан широнд орсноор итгэгчдийн байгууллагын удирдах хэсэгт засгийн газрын томилсон хүмүүс товойн гарах боломж гарч байна.

Христийн төлөө амьдралаа бат шийдвэртэй зориулан амьдарч буй, үнэнч итгэлтэй сая сая хүмүүс ажилчин ангийг бүрдүүлэх ба тэд коммунистуудын устгахаар зэхсэн хавчлагад улам бүрхурцлагдан чангалацдаж байна.

ГУРАВТ — АМАА ҮДҮҮЛЖ, ДУУГАА ХОРИУЛСАН Ч ДУУГҮЙ БАЙЖ ЧАДАХГҮЙ АХЛАГЧ НАР

Нууц бүлгийг бүрдүүлэгч гуравдагч хэсэг нь амаа хамхиулан хязгаарлагдмал байдалтай болсон ахлагч, удирдагч нар юм.

Тэд бол нууц бүлгийн маш чухал хэсэг. Нууц бүлэг гэдэг бол албан ёсны байгууллагаас зуун хувь тусдаа салангид юм огт бишээ. Югослав, Польш, Унгар зэрэг олон коммунист оронд албан ёсны байгууллагын ахлагч нар нууц бүлэгтэй нягт хамтран ажиллаж Христийн төлөө зүтгэж байдаг. Зарим улс орнуудад энэ хоёр нь хоорондоо нягт уялдан тайлахын аргагүй холбоотой ажилладаг. Тэд жижигхэн ганц өрөөтэй сүмээсээ гадуур Христийн тухай ярих эрхгүй. Хүүхдүүд болон залууст зориулан тэд ямар нэг үйл ажиллагаа явуулах эрхгүй. Христэд итгэдэггүй хүмүүс тийш зүглэхээс үргэлж айн болгоомжилно. Тэд өвчтэй гишүүдийнхээ гэрээр явж тэдний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярих эрхгүй. Тэд коммунистуудын бий болгосон дүрэм журам гэгч том хащаагаар хүрээлүүлж тэдний байгууллага нь бүхэлдээ утга учраа алджээ. "Шашны эрх чөлөө" хэмээн элэг доог хийхдээ ашигладаг дарга тушаалтуудтай нүүр тулахдаа тэд ихэвчлэн амь нас алив бүхнээ золиослон коммунистуудын тогтоосон хил хязгаарыг зөрчин нууцаар үйл ажиллагаа явуулж байгаагаа нууна. Ийм ахлагч нар хүүхэд, залуучуудын дунд идэвхтэй ажилладаг. Тэд Христэд итгэгчдийн гэр орон, байшингийнх нь хонгилыг ашиглан Христийн авралын тухай ярина. Зүрх сэтгэл нь ангаж цангасан хүмүүсийн цангааг тайлах гэж тэд хaa газраас хамаагүй Христийн номнууд, Библийн хэсгүүдийг олж нууцаар тараана. Тэд эрх чөлөөгөө үл хайхран коммунистуудын бий болгосон хязгаарлалтуудыг үл тоон өөрсдийн эргэн тойронд буй сэтгэл зүрх нь ангаж үнэнийг хайж яваа хүмүүст тусалдаг. Өнгөн талдаа хачин дуулгавартай, номхон санагдах боловч тэд Ертөнцийн Эзэний үгийг бүгдэд хүргэхийн тулд амь нас, эрх чөлөөг үл хайрлан зүтгэнэ. Орост саяхан ийм хүмүүсийг олноор нь илрүүлэн баривчлан хэдэн жил шоронд хорих ял оноосон билээ.

Тэд бол нууц бүлгийн салгаж болшгүй гуравдагч чухал хэсэг нь билээ.

Коммунистуудад гологдон хаягдаж, зад хавчигдсан хуучин ахлагч, удирдагч нар; албан ёсны зөвшөөрөлтэй боловч зөвшөөрсөн хэмжээнээс нь хавьгүй илүү хол давсан ажлыг нууцаар амжуулж байдаг одоогийн ахлагч нар гээд олон хүн хүчээ нэгтгэн хамтран зүтгэж байна. Энэ нууц бүлэг коммунизм нуран

унах хүртэл энэ хэвээр байсаар байх болно. Зарим газар нэг хэсэг нь нөгөөдүүлээ бодвол илүү идэвхтэй эрчтэй ажиллаж байх боловч бүгд л Христийн төлөө амь биеэ үл хайхран зүтгэж явна.

Коммунист улс орнуудаар нилээд их хэсч, шашин шүтлэгийн талаар сонирхдог нэг хүн нутагтаа эргэж ирээд нууц бүлгийнхэнтэй огт уулзсангүй, байдаггүй юм байна гэх мэтийн юм бичсэн байв.

Энэ байдал нь төв Африкийн бичиг үсэгт тайллагаагүй овог аймгийнхантай уулзсаныхаа дараа, "Би нарийн нягтлан асууж сураглаа. Тэднээс би хүүрнэх хэлбэрээр ярьдаг эсэхийг нь асуув. Гэтэл тэд бүгд надад үгүй гэж хариулсан билээ" гэж бичихтэй адил хэрэг ажээ. Гэтэл үнэн чанартаа тэдний ярьж байгаа хэлбэр нь хүүрнэх хэлбэр гэдгийг тэд мэдэхгүй л болохоос биш хүүрнэн ярьж л байгаа шүү дээ.

Хүмүүс өөрсдийг нь Христийнхэн гэж нэрлэдгийг анхны итгэгчид мэдээгүй л байсан. Хэрэв та тэднээс юунд итгэдэг улс болохыг нь асуувал тэд өөрсдийнх нь талаар Иудей, Израйль хүмүүс бөгөөд Аврагч Есүст итгэдэг, Ертөнцийн Эзэний хүүхдүүд, ахан дүүс болсон хүмүүс гэж хэлэх байсан. "Христийнхэн" гэдэг энэ нэрийг хожим нь өөр хүмүүс тэдэнд анх Антиох хотод байхад нь өгснөөс хойшийнхүү нэрлэгдэх болсон аж.

Лютерийг тэр үед дагалдаж байсан улсын хэн нь ч өөрийгөө лютеран гэж мэдээгүй байсан. Лютер өөрөө хүртэл ийнхүү нэрлүүлэхгүй байх гэж бүх хүчээрээ үзэлцэх байв.

"Нууц бүлэг" гэдэг нэрийг коммунистууд өгсөн ба коммунист системийн улс орнуудад элбэг тохиолддог үзэгдэл учраас шашин шүтлэгийн асуудлыг судлаачид зүүний байдлыг судлахдаа тогтоож өгсөн билээ. Гэтэл нууц бүлгийн гишүүд өөрсдийгөө хэзээ ч ийм нэрээр нэрлэдэггүй. Тэд өөрсдийгөө Христэд итгэгчид, Ертөнцийн Эзэний хүүхдүүд гэдэг. Гэхдээ тэд нууцаар ажлаа явуулж, хүний нүднээс далд уулзаж нөхөрлөн, лааны гэрэлд хуралдан авралын мэдээг тунхаглан, гадаадынхны нүдээрээ үзсэн хирнээ байдаггүй гээд байгаа хуралд биеэрээ сууж оролцож явдаг. Дайснуудын маань өгсөн энэ нэр тун оносон нэр юм. Мөн гайхалтай сайхан энэ хүмүүсийг гаднаас нь ажиглан харж хайрлан суугаа улсын ч онож хэлсэн нэр мөн.

Та нар барууны орнуудаар хөлөө хүрэх газраа хүртэл тэнэж яваад зөвлөлтийн тагнуулын сүлжээнд гар хөл болсон нэг ч хүнтэй уулзаагүй учир ийм юм байхгүй гээд хэл л дээ. Замын аянчинд хамаг байдаг нууцаа дэлгээд байх нь ухаалаг хэрэг үнэндээ мөн юм гэж үү? Тийм гэнэн тэнэг хaa ч үгүй бизээ.

Урам зориг, итгэл найдвар төгс, улам бүр хүчирхэгжин буй нууц бүлгийн оршин байдгийг баталсан зөвлөлтийн сонин хэвлэлийнхний хэлсэн үгсээс би та бүхэнд дараагийн бүлэгтээ танилцуулах болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Христийн авралын тухай зөвлөлтийн армийнхан, румыны коммунистуудад хэрхэн тунхагладаг байсан туршлагаасаа эхлээд та бүхэнд толилуулсан.

Бас коммунистуудын дарангуйлал дор зовж буй хүмүүст Христийн сайхан мэдээг тунхаглахад та бүхний тус дэмжлэг хэрэгтэй байгааг ойлгуулахыг оролдлоо.

Миний хэлж, уриалж буй ажил "зүүд зэрэглээ" эсвэл "хэзээ ч биелэхгүй" мэт санагдаж байна уу?

Бодит байдлаас хол хөндий гэж үү?

Орос болон бусад холбоот улсуудад нууц бүлэг одоо байхгүй байгаа юм уу? Одоо ч гэсэн тэдний дунд нууцаар ажиллах боломж хир байна вэ?

Эдгээр олон асуултуудад бид тун ч баяртай мэдээ барин хариу өгөх болно.

Коммунистууд тавин жил ноёрхлоо тогтоосныхоо баярыг тэмдэглэж байна. Гэвч тэдний ялалт бол ялагдал юм. Христэд итгэх итгэл л ялна уу гэхээс коммунизм хэзээ ч ялж чадахгүй. Оросын хэвлэлийг бид нарийвчлан судлан үзэхэд нууц бүлэг үнэхээр байдгийг батлах хангалттай баталгаа байв. Анх удаа нууц бүлэг үнэхээр хүчирхэгжин зарим талаар олон нийтийн өмнө ил тод гарч коммунистуудыг айлгаж байна. Коммунист хэвлэл мэдээллэд бичигдсэн нь үнэхээр үнэн гэдгийг батлах баримт бид олныг хялбархан гаргаад ирж дөнгөх болжээ.

Нууц бүлэг гэдэг бол мөсөн уултай адил гэдгийг сана! Үүний ихэнх хэсэг нь газрын гадарга дор байх боловч голдуу олны нүдний өмнө ил байdag.

Дараагийн хэдэн хуудсанд би та бүхэнд хэлэх гэсэн хамгийн чухал мэдээгээ толилуулах болно.

МӨСӨН УУЛЫН ОРОЙ

Задгай их тэнгэрийн дор Сухумид (Кавказад) нууц бүлгийнхний нэгэн том хурал 1966 оны арван нэгдүгээр сарын 7-ны өдөр болов. Христэд итгэдэг олон хүн энэ хуралд оролцохоор янз бүрийн хотуудаас ирсэн байлаа. Нээлттэй урилга өгөхөд дөчин долоон залуу Христийг амьдралдаа оруулахаар шийдэн хүлээн авч тэр даруй тэдний итгэснийг батлан ойролцоо орших Хар тэнгист усаар угаав. Библи анх бичигдэж байсан үед яваад очсон мэт санагдаж байлаа.

Заавар зөвлөгөө өгөх урьдчилсан үе гэж байсангүй. Коммунизмын диктатур тогтоод тавин жил болсны хойно нууц бүлгийнхэнд Библийн сургууль, сургалт энэ тэр байтугай Библи, Библийн холбогдолтой номууд ч байсангүй. Тиймээс тэднийг тусгайлан бэлтгэгдсэн хүмүүс мэт ойлгох нь буруу. Гэвч Филийп туслах ч бас сурч боловсроогүй хүн байсан шүү дээ. Гэтэл түүнтэй бараг цаг шахуу ярилцсан тайган сайд хүртэл дараахи үгийг түүнд хэлж байсан биш үү? "Харагтуун, энд ус байна. Намайг усаар угаан батлахад болохгүй юм юу байна?" гэж асуув. Филийп түүнд, "Хэрэв та чин сэтгэлээсээ итгэж байгаа бол бололгүй яахав" гэж хариулав. Тэгээд тэд тэр даруй ус руу очиж тайган сайдыг итгэснийг усаар угаан батлав. (Үйл явдал 8.36—38)

Хар тэнгисийн ус хангалттай их агаад нууц бүлгийнхэн ч энд Библийн цаг үед хүмүүс юу хийдэг байсныг шууд хийж эхэлсэн билээ.

«Учительская газета» ("Багш нарын сонин")-ийн 1966 оны наймдугаар сарын 23-ны дугаарт Ростов он Донд байгууллагаа хуулийн дагуу бүртгүүлж, коммунистуудын томилсон "удирдагч" гэгдэх этгээдүүдээр удирдуулахаас татгалзсан баптистууд гудамжинд эсэргүүцэл илэрхийлэн жагсаал хийсэн тухай мэдээлэл байв.

Энэ бол тавдугаар сарын нэгэн байлаа. Паараш бүлгийн эсэргүүцэгч нараа үл тоон анхны гайхамшигт үйлсээ зориуд бямба гаригийн амралтын өдөр хийсэнтэй адил нууц бүлгийнхэн коммунистуудын тогтоосон хууль дүрмийг эсэргүүцэж байгаа-

гаа илэрхийлэхийн тулд тэдний тэмдэглэлт баярын өдрийг зориуд сонгожээ.

Жил бүрийн тавдугаар сарын нэгэн бол коммунистуудын хувьд асар том жагсаал хийн тэмдэглэдэг чухал баяр нь бөгөөд хүн бүр их багагүй үүнд зайлшгүй оролцох ёстой. Гэвч энэ удаа оросын хоёр дахь хүчирхэг бүлэг болох нууц бүлгийнхэн ч бас тэдний адил гудамжнаа гарч жагсан эсэргүүцэл илэрхийлэв.

Шоронгийн тамлал, өлсгөлөн гээд тоочихын аргагүй их зовлон хүлээж байгааг мэдэж байсан ч мянга таван зуун итгэгч оролцооор ирсэн ба тэднийг ийнхүү уриалан дуудсан их хүч бол зөвхөн Ертөнцийн Эзэний хайр байлаа.

Оросын итгэгч нар Барнаул дахь Христэд итгэгчдийн хэвлэн гаргасан "Нууц тунхаг"-аас Кулунда тосгоны эмэгтэй Хмарагийн нөхөр шоронд нас барсан тухай мэдээг олж уншсан байв. Одоо тэрээр дөрвөн жаахан хүүхэдтэйгээ хоцорсон бэлбэсэн эмэгтэй болжээ. Тэр нөхрийнхөө хөрсөн биеийг очиж авахдаа гарть нь зүүсэн гав нь хэвээр байгааг, гар, гарын хуруунууд болон хөлийн ул нь аймшигтай шархдан гэмтэн, гэдэснийх нь доод хэсгээр хутганы эсгэсэн шарх сорви олон байгааг олж харжээ. Баруун хөл нь хөөн хавдаж, хоёр хөл нь зодуулж тамлуулж байсны ор болох шарх сорви ихтэй байв. Бүх бие нь аймшигтай яргалуулсан шинжтэй хaa сайгүй шарх сорви болсон байлаа.

Ростов он Донд болсон эсэргүүцлийн жагсаалд оролцох гэж ирсэн итгэгч хүн бүр өөрийг нь ийм хувь тавилан хүлээн байгааг мэдэж байсан ч огт хайрхахгүй тэмцэхээр ирсэн байв.

Гэвч тэд бас Христэд итгээд гуравхан сар болоогүй байж баатарлагаар амия алдсан залуу эрийн оршуулга хичнээн хүндэтгэлтэй болж оролцооор ирсэн олон итгэгч нарын гэрэлт хөшөөн дээр нь тавих гэж суржавхлантай сайхан үгс хавтанд сийлэн авчирч байсныг ч бас сайн мэдэж байв. Хавтангууд дээр тун гаргацтайгаар:

«Миний хувьд Христтэй нэгдэх нь амь амьдрал бол түүний төлөө амия өгөх нь асар их шагнал авч буй хэрэг.»

«Бие маходыг устгаж чадахаас биш сэтгэл зүрхийг, амин сүнсийг устгаж чадахгүй хүмүүсээс бүү айгтун!»

«Ертөнцийн Эзэний үнэн сургаалын төлөө амь биээ үл хайхран зориулсан тэднийг би түүний өргөлийн ширээний өмнө байхыг олж харсан» хэмээн сийлсэн байлаа.

Түүний зоригтой, үнэнч байдал нь олон итгэгчдэд Ростов он Донд болсон жагсаалд оролцох урам зориг, хүчийг хайлласан хэрэг болов. Тэд жижигхэн байшингийн ойролцоо цуглажээ. Хаа сайгүй хүмүүс. Зарим нь байшингийн дээвэр, шатаар сууж, зогсох нь зогсож, зарим нь эртний Захчайн адил ойролцоо ургаж буй модон дээр гарч суусан байлаа. Наян хүн Христийг амьдралдаа оруулан тэдний эгнээнд орсон ба тэдний ихэнх нь залуу улс байв. Тэдний дунд комсомолын идэвхтэн гишүүд (Коммунист залуучуудын эвлэлийн хороо) хорин гурав байжээ.

Дон мөрнийг чиглэн итгэгчид хотын гудамжаар жагсан алхаж тэдний итгэснийг батлан усаар угаах газраа хүрч ирэв.

Голын эрэгт хүрээд удаагүй байхад машин дүүрэн коммунист цагдаагийнхан хүрч ирж бүслэн авав. Тэд энэ ажиллагааг зохион байгуулж удирдаж байсан ах нарыг баривчлахыг хүссэн байв. (Мэдээж тэд мянга таван зуун хүнийг бүгдийг нь баривчилж чадахгүй шүү дээ.) Итгэгчид тэр даруй өвдөг сөгдөн Ертөнцийн Эзэнтэй чин сэтгэлээсээ ярин тэр өдрийн хурлаа хийж дуусгах зөвшөөрөл гүйж байлаа. Дараа нь итгэгчид мөр мөрөөрөө нийлэн удирдаж буй ах нараа тойрон зогсож цагдаа нарт нэвтрэх боломж өгөхгүйг хичээж байв. Гэвч байдал улам бүр хурицдаж эхэллээ.

“Учительская газета“-д ”хууль бус“ үйл ажиллагаа явуулагч баптистууд хэвлэлийн газар, хэвлэх үйлдвэр нууцаар ажиллуулдаг гэж мэдээлжээ. (Баптист гэдэг үгэнд оросууд Христийн эвангелийн болон протестант урсгалыг бүгдийг багтаан оруулдаг.) Хэвлэсэн ном товхимол бүхэндээ залуусыг итгэлийнхээ төлөө зоригтой босч тэмцэхийг уриалдаг байна. Нууцаар хэвлэсэн ийм материалуудын нэгэнд нь Христэд итгэгч эцэг эхчүүдэд нэг сайн зөвлөгөө өгсөн байв. Үүнд, хэн нэг хүн итгэлийнхээ төлөө амиа алдсан бол түүний оршуулах ёслолд оролцохоор ирэхдээ хүүхдүүдээ дагуулан ирэх хэрэгтэй, ингэснээр тохиолдож болох аливаа хэрэгт санаа зовохгүйгээр хэрхэн хандах ёстойг бодитоор зааж сургах болно гэж зөвлөжээ. Миний хувьд энэ бол тун сайн хэрэг. Коммунист сургуулиудад тэдний онол,

үзэл суртлыг ягштал заалгаж байгаа хүүхдүүдэдээ Христийн сургаалыг зааж өгч шашингүй үзлийн хор уршгаас сэргийлэх хэрэгтэйг эцэг эхчүүдэд мөн зөвлөсөн байв.

“Учительская газета“-д өгүүллэгээ дуусгахдаа, “Багш нар яагаад гэр орондоо шашнаар хордож байгаа хүүхдүүдийн гэрийхэнтэй ойр зууралдан ажиллахгүй хол байгаад байна? Ингэж болохгүй биз дээ?“ гэсэн асуултыг тавьсан байв.

Багш нарын энэ сэтгүүлд нууцаар усаар угаалган батлуулсан хүмүүсийг шүүх ажиллагааны үеэр болсон нэгэн үйл явдлын тухай нилээд дэлгэрэнгүй бичжээ. Үүнд:

«Гэрчээр ирсэн залуу итгэгч нар шүүх хурлын үеэр тоомсоргүй, эрс өдсөн маягтай байлаа. Биеэ авч яаж байгаа нь ууртай, хэнээтэй хүмүүс болохыг нь илтгэх мэт. Залуу эмэгтэй байцаагч нар тэдний өдөөн хатгасан байдлыг дэмжин сайшааж, харин шашингүй үзэлт өргөн түмнийг буруушаах аястай харцааж байв» гэжээ.

Оросын коммунист намын удирдлагын өмнө зоригтой зогсон эрх чөлөө олгохыг шаардан тэмцэхдээ шоронгийн ял, тамлал зэргийг нууц бүлгийн гишүүд огт тоохгүй байсан юм.

Зөвлөлт Холбоот Улсын баптист байгууллагуудын зөвлөл хэмээх “хууль бус“ байгууллагын бидэнд дамжуулсан нэгэн чухал нууц баримт бидэнд бий. Энэ бол коммунист эрх баригчдын нэрлэдгээр Баптист нэгдлийн тэргүүн урвагч этгээд гэгдэх Каврегийн олон мянган Христэд итгэгчдийг алж устгасан алуурчдыг хүн төрөлхтний сайн сайхны төлөө үйлчлэгч хэмээн сайшаан магтан, Зөвлөлт орос улсад шашиш шүтэх, эс шүтэх “эрх чөлөө“ байгааг тодотгон «Зөвлөлтийн өнөөгийн амьдрал» сэтгүүлд (1963 оны 6-р дугаар) бичсэн тэднийг эсэргүүцэж байх ёстой баримт байлаа. Нууц сувгаар дамжин энэ баримтыг хил давуулан баруунд оруулж ирсэн билээ.

Энэ баримтаас бид саяхан Москва хотноо болсон бас олон нийтийн бас нэг баатарлаг жагсаалын тухай мэдээлэл олж авлаа.

Энэ тунхаг бичгээс би та бүхэнд орчуулан толилуулья.

«Чухал асуудал.

— Хайрт ах, эгч, дүү нараа. Та бүхэнд Ертөнцийн Эзэн эцэг, аврагч Их Эзэн Есүс Христийнхээ өмнөөс амар тайван, сайн сайхныг хүсэн мэндчилж байна.

— Бид та бүхэнд нэгэн чухал зүйлийн талаар дамжуулья. Таван зуун хүний бүрэлдэхүүнтэй баптист байгууллагын итгэгчийн бүлгүүдийг төлөөлсөн баг 1966 оны тавдугаар сарын 16-ны өдөр Москваг зорин гарлаа. Тэд төр засгийн эрх баригчидтай уулзах хүсэлт тавьсан ба өөрсдийн дуу хоолойг сонсгохын тулд Зөвлөлт Холбоот Улсын Коммунист намын төв хорооны байранд нэвтрэн орж тэдэнтэй биечлэн уулзах хүсэлтэй байна.

— Ерөнхий нарийн бичгийн дарга Брежневт бид аль хэдийн бичгээр өргөдөл илгээсэн байгаа.» гээд цааш нь Энэ таван зуун хүн засгийн газрын ордны өмнө бүтэн өдөр хүлээн зогссон тухай өгүүлжээ.

Энэ бол Москва хотноо болсон коммунистуудыг эсэргүүцсэн анхны жагсаал байв. Энэ жагсаалыг нууц бүлгийн гишүүдийн төлөөлөлгчид анх хийсэн. Оройн бүрийн орох үест тэд Брежневт гэж хаягласан хоёр дахь өргөдлөө гардуулав. Энэ өргөдөл нь Строганов гэгч нөхөр Брежневт хаягласан өргөдлийг дамжуулахаас татгалзаад зогсохгүй тэднийг сүрдүүлсэн тухай гомдол мэдүүлсэн утгатай байлаа.

Таван зуун төлөөлөгч шөнөжингөө гудамжинд суун хүлээлээ. Хажуугаар нь машинууд зориуд хурдтай өнгөрөн шавар шавхай цацан доог тохуу хийн доромжилж байв. Хэдийгээр бороо орж байсан ч тэдэнд ийнхүү хүний үнэргүй хандсан юм. Тэд коммунист намын байрны өмнө өглөө болтол зогсчээ!

Дараагийн өдөр нь тэдэнд ордонд орж жижиг албан тушаалын хүнтэй уулзах зөвшөөрөл олгосон боловч тэд бүгдээрээ дотогш орвол шууд баривчлан широн руу илгээж, үүнийг нь гэрчлэх хүнгүй болно гэдгийг мэдэж байсан тул энэ саналыг хүлээн авсангүй, Брежневтэй биечлэн уулзах шаардлагаа дахин тавиад хүлээхээр шийджээ.

Гэтэл давтагдашгүй аймшигтай хэрэг тохиолоо.

Өдрийн 1 цаг 45 минутад хорин найман автобус дүүрэн цагдаа нар ирж итгэгчдээс өшөө авах цуст ажиллагаа эхлэв.

— Бид тойрог үүсгэн гар гараасаа барилцан зогсоод ”Бидний амьдралын хамгийн аз жаргалтай сайхан үе нь загалмайн их зовлонгоос өчүүхэн жаахныг мэдрэн тэмцэж явах үе байdag“ гэсэн утгатай хүндэтгэлийн дуулал дуулан байв. Нууц цагдаагийнхан хөгшин залуу гэхгүй зодож гарав. Хүмүүсийг эгнээ-

нээс нь чирч гаргаад нүүр, нүд, толгой руу нь цохиж зодон асфальтан газар руу шиднэ. Заримынх нь үснээс зулгаан чирч автобус руу аваачихыг оролдоно. Тэдний зарим нь автобусны орчмоос холдохыг хичээхэд ухаан алдаж унатал нь зодож нүдэж байлаа. Ийнхүү ирсэн автобуснуудаа итгэгчдээр дүүргэж аваад хэний ч үл мэдэх нэг газар аваачив. Тэдний дуулах магтаалын дуу нууц цагдаагийнхны автобусны цонхоор сонсогдсоор далд оров. Энэ явдал олон түмний нүдэн дээр болсон билээ.

Үүнийг дагалдан нэг гайхамшигтай сайхан хэрэг гарлаа. Таван зуун хүнийг баривчлаад, мэдээж тамлаад эхэлчихсэн байсан үед Христэд итгэгчдийг удирдан толгойлогч идэвхтэй гишүүд болох Винс, Хорев (Христийн хүмүүсийг сайн харж хамгаалж байдаг хоньчин мэт хүмүүс) нар тэднийг баривчлан авч явсан газар болох коммунист намын төв хорооны байрны өмнө очиж зоригтой тэмцэл зарлав. Тэдний энэ хэрэг нь усаар угаан батлагч Жоган «Ертөнцийн Эзэний ер бусын мөнхийн улс дэргэд ирсэн байгаа тул гэмт амьдралаа хаягтун!» гэж хэлснийхээ төлөө баривчлагдан зовж байсан тэр газар Есүс ирээд түүний хэлж байсан үгийг улам илүү хүчтэй тунхаглан зааж байсантай адил хэрэг боллоо.

Винс, Хорев нар төлөөлөгчдийг хаана аваачсаныг хэлэхийг, мөн тэднийг суллахыг тэднээс шаардав. Эрэлхэг зоригтой энэ эрс мэдээж сураг чимээгүй алга болсон. Дараагаар нь тэднийг Лефортовскаягийн шоронд хорьсон тухай сураг сонсогдлоо.

Нууц бүлгийн гишүүд аймхай хулчгарууд байсан хэрэг үү? Үгүй! Энэ явдлын дараахан өөр олон хүн амь наасаа золиослон байж өдгөө бидний өмнө байгаа болсон явдлын талаар өгүүлсэн энэ тунхаг бичгийг хэвлэн тараасан юм. Тэдэнд хандан, «Тиймээс ч Есүс Христэд итгэх боломжийг Ертөнцийн Эзэн та нарт өгсөн байна. Бас та нар миний нэгэн адилаар тэр гайхамшигт үнэний төлөө тэмцэхдээ түүнийхээ төлөө хавчлага зовлон эдлэх ариун үүргийг Есүсээс авсан.» (Филиппий 1.29) гэж хэлсэн байна. Тэднийхээ алдрыг хүндэтгэн дурсахдаа, «Тимот бол Есүс Христийн тухай гайхамшигт үнэнийг тунхаглан Ертөнцийн Эзэний төлөө бидний хамт зүтгэгч мөн. Та бид одоо адилхан хавчигдаж байна. Үүнээс болж хэнийг чинь ч Есүсээс урвахад хүргэхгүйн тулд бид Тимотыг илгээн, урам зориг оруулж, итгэлийг чинь

батжуулах гэсэн юм. Ер нь хавчлага эдлэх үүргийг Ертөнцийн Эзэн өөрөө Есүст итгэгчдэд хүлээлгэснийг та нар сайн мэднэ.» (1Тесалоник 3.2—3) хэмээн өгүүлжээ. «Еврэйчүүдэд» номын 12.2-оос иш татан бас «Хамгийн чухал нь, тамирчин хүн бария руу нүд салгалгүй харж байдгийн адилаар бид Есүс рүү ямагт харж найдах хэрэгтэй. Есүс бол Ертөнцийн Эзэнд бүрэн итгэхийн үндэс бөгөөд өөрийн амьдралаар Ертөнцийн Эзэний зорилгыг гүйцээсэн хүний эрхэм дээд үлгэр дууриалал юм. Үүнд, хожим туйлын их жаргал авахаа тэр мэдэж байсан учраас модон загалмайд цовдлуулан харгис этгээдэд алуулах хамгийн жигшүүртэй үхэл болон тэр их тамлалыг зоригтойгоор тэсвэрлэн эдэлсэн байна. Одоо тэр Ертөнцийн Эзэний ер бусын ертөнцөд очоод баруун гарын эрхэм хүндэт суудлыг эзэлжээ» хэмээн биднийг уриалан дуудаж байна.

Нууц бүлгийнхэн Ростов, Москва гээд орос орны хaa сайгүй тархан өсвөр үеийнхний оюун санааг сүйрэл рүү түлхэн буй шашингүй үзлийн савраас тэднийг аврахыг хичээн ил тод эсэргүүцэж байна. Тэд коммунизмын хор уршиг, албан ёсны байгууллага нэрийн дор коммунистуудын тоглоомын хүн болсон ахлагч нарын эсрэг тэмцэж байгаа юм. Энэ тухайгаа тунхаг бичигтээ өгүүлэхдээ, «Бидний өнөө үед адгийн муу ёрын сүнс эзэн хаан мэт болж "Христэд итгэгчдийн зарим бүлэг" түүний бүх шийдвэрийг хэдийгээр Ертөнцийн Эзэний тогтоосон бүх хуулийнх нь эсрэг байсан ч хамаагүй хүлээн зөвшөөрдөг болсон байна. ("Правда Украины" 1966 оны аравдугаар сарын 4-ны өдрийн дугаарт гарсан нийтлэлээс иш татав) гэж бичжээ.

Алексей Неверов, Борис Гармашов, Аксен Зубов нарыг ами-рекаас нэвтрүүлж байсан радио нэвтрүүлгийг сонсгохын тулд хүмүүс цуглуулсан хэргээр шүүж байгаа тухай "Правда Востоки"-д нийтэлсэн байна. Тэд энэ нэвтрүүлгүүдийг хуурцагт буулгаж аваад дараа нь хүмүүст тараан өгдөг байжээ.

«Тойрон аялал», "уран бүтээлчдийн уулзалт ярилцлага" нэрийн дор хүмүүс цуглуулсан Христийн сургаалыг тунхаглан заах ажил хийж байсан хэргээр тэднийг бас яллах гэж байв. Ромын эзэн хааны дарангуйлал, дарамтын дор Христэд итгэсэн эртний хүмүүс хэрхэн ажилладаг байсны адил нууц бүлэг маань ажлаа хийсээр байна.

”Советская Молдавия“-ийн 1966 оны есдүгээр сарын 15-ны дугаарт нууц бүлэг товхимол, бичиг сачиг олшруулан үйлдэж хэвлэж байна гэсэн гомдлын чанартай нийтлэл хэвлэгдсэн байв. Хэдийгээр хуулиар үүнийг хориглосон боловч тэд олон нийтийн газруудаар цуглан хаа сайгүй хэрэн хэсэж Христийн сургаалыг заан тунхаглаж байна.

Энэ сонинд мөн Ренигээс Чизинау хүрэх галт тэргэн дотор гурван хүү, дөрвөн охин хамтдаа ”Залуу балчир үеэ Христийг дагахад зориульяа, бат шийдвэртэй зөвхөн түүнийг дагая“ гэсэн утгатай дуу дуулж байсан тухай бичжээ.

Уг нийтлэлийг бичсэн сэтгүүлч өөрөө үүнд тун их жигшин зэвүүцсэнээ өгүүлсэн байв. Учир нь ”гудамж, буудал зогсоол, автобус, тэр бүү хэл улс орны томоохон сургуулиудад“ хүртэл Христэд итгэгчид аль хэдийн очоод Христийн сургаалыг ил тод зааж байна. Дахин хэлэхэд, Христэд итгэгч оросуудын нууц бүлэг ийм маягаар ажлаа хийсээр байна.

Олон нийтийн газар Христийн дуу дуулж байсныхаа төлөө тэдэнд оноосон шийтгэлийг зарлан мэдэгдэхэд тэд өвдөг сөгдөн суугаад хэлэхдээ:

— Ертөнцийн Эзэн таныхаа гарч бид өөрсдийгөө тушааж байна. Бид танд чин сэтгэлээс талархаж байна. Итгэлийнхээ төлөө зовлон туулах боломж олгосон Их Эзэн тандаа талархана гэжээ. Тэгтэл шүүх хурлын танхимд ажиглагчаар сууж байсан тэдний хэлдгээр ”хэнээтэн“ гэгдэх ах дүүс нь тэдний дуулсныхаа төлөө ял эдлэхэд хүргэсэн өнөөх дууг хурлын танхимд хоолой мэдэн дуулан дэмжиж байв.

Тавдугаар сарын эхний өдөр Христэд итгэгчид Захаровка болон Копшак тосгонд уулзан нууцаар хуралдан Ертөнцийн Эзэнээ хүндэтгэв. Эдгээр тосгонд уулзах барилга нэг ч үгүй тул тэд ойд цугласан байлаа!

Тэд бас төрсөн өдрийн баяр тэмдэглэж байгаа дүр эсгэн нууцхан шиг хуралдаад амждаг байв. (Дөрвөөс таван хүний бүрэлдэхүүнтэй нэг итгэдэг гэр бүл халхавч болгон жилд гучин таван удаа ”төрсөн өдөр“ тэмдэглэдэг.)

Нууц бүлгийн гишүүнийг ямар ч широн, тамлал зовлон айлган сүрдүүлж чадахгүй. Анхны итгэгчдийн үед хавчлага

зовлон итгэлийг улам илүү батжуулж өгдөг байсны адил тэдний итгэлийг батжуулж байв.

“Правда Украины“ сонины 1966 оны аравдугаар сарын 4-ны өдрийн дугаарт оросын нууц бүлгийн ахлагчдын нэг болох Прокофьевын тухай бичсэн байв. Тэр аль хэдийн гурван удаа баривчлагдан шоронд орж байсан боловч гурав дахь удаагаа дөнгөж суллагдаад дахиад л хүүхдүүдэд зориулан ням гариг болгон Библийн хичээл нууцаар заан зохион байгуулсан учир дахин баривчлагджээ.

Тэрээр өөрийн бичсэн нууц бичигтээ: «Хүний гараар бүтээгдсэн тогтоол дүрмийг (тэр коммунист хууль дүрмийг ийнхүү нэрлэжээ) даган мөрдөхдөө албан ёсны байгууллагууд Ертөнцийн Эзэний ерөөлийг өөрсдөөсөө тулхэн холдуулсан юм» гэжээ.

Орос оронд итгэгч ахан дүүсийн чинь нэг шоронд хоригдох ял авлаа гэхийг сонсвол түүний нөхцөл байдлыг барууны шоронгийн байдалтай харьцуулж бүү сэтгэ. Шорон гэдэг нь тэдний хувьд өлслгөлөн, тамлал, тархи угаах үйл ажиллагаа юм.

“Наука и религия“ (Шинжлэх ухаан ба шашин) сэтгүүлийн 1966 оны 9-р дугаарт Христийнхэн ном товхимлоо одоогийн та нарын уншдаг “Цаг үе“ зэрэг сэтгүүлтэй адил “Огонёк“ сэтгүүлийн хавтасны дор нуун тарааж байгаа тухай бичжээ. Та нарын харахад “Анна Каренина“, эсвэл Лев Толстой гэсэн гарчиг бүхий ном байх боловч дотор нь Библи болон Библийн холбогдолтой номнууд байдаг байв! Тэд зөвхөн хавтсыг нь ашигладаг байлаа!

Тэд бас байнга дуу дуулна. Тэдний дууны ая нь “Коммунист Интернациональ“ гэх мэт дууны ая байх боловч үг нь Христийг магтан алдаршуулсан утга бүхий үгсээр солигдсон байдаг байна! (“ Казакстанская правда“, 1966 оны 6-р сарын 30-ны дугаар)

Кулундад (Сибирьт) хэвлэгдсэн нэгэн нууц захидалд албан ёсны баптист байгууллагуудын удирдлагууд Ертөнцийн Эзэний үнэнч итгэлт зарц нарыг устгасан нь паараш бүлгийнхэн, сургаал номлогчид болон сүмийн зэрэгтнүүд хэрхэн Есүс Христээс урван Пилатад барьж өгсөнтэй адил байна гэжээ. Гэвч үнэн чанартаа үнэнч итгэлтэй Христийн хүмүүс нууцаар ч гэсэн оршин тогтнож, Их Эзэндээ зүтгэсээр байна.

Христийн бэр мэт хүмүүс түүний төлөө идэвхитэй ажилласаар! Коммунистуудыг нууц бүлгийнхэн ямар ч байсан Христийн өмнө авчран ялалт байгуулна гэж миний хэлсэн үг үнэн болохыг коммунистууд өөрсдөө ч хүлээн зөвшөөрдөг. Тэд үнэхээр гэмт амьдралаа хаян Христийн хүн болж чадна!

”Бакинские рабочий“ (Бакугийн ажилчид) сэтгүүлийн 1966 оны дөрөвдүгээр сарын 27-ны өдрийн дугаарт Христэд итгэгч болсон Таня Зыгуновагийн захидалыг хэвлэсэн байв. (Тэрээр коммунист залуучуудын хорооны гишүүн байжээ.) Энэ захидалын эзнийг коммунистууд олохыг хичээж байлаа.

”Эрхэм хүндэт авга эгч Надя минь. Хайртай Их Эзэнийхээ нэрээр танд сайн сайхныг хүсэн ерөөе. Эгч минь, тэр надад ямар их хайртай юм бэ! Түүний өмнө бид юу ч биш. Надя эгч минь, та миний энэ үгийг ойлгож байгаа гэдэгт би итгэж байна. «Дайснаа та нар өөрийн адил хайрла, та нарыг хараасан хүнийг ерөө, та нарыг үзэн ядаж буй хүмүүст сайн сайхан юм хийж өгч тэдний төлөө Их Эзэнээс гүй. Та нарыг хичнээн гутаан үзэж байсан ч тэднийг хайрла“» гэжээ.

Энэ захидалыг олж авсаныхаа дараа тэд түүнийг болон өөр олон залуу коммунистуудыг Христийн өмнө авчирсан Петр Серебренниковыг баривчлан шоронд хийв. Коммунистуудын нэгэн сонинд түүний нэг удаа заасан сургаалаас иш татан, ”Бид Аврагч Их Эзэндээ анхны итгэгчид хэрхэн бат итгэдэг байсны адил итгэх хэрэгтэй. Бидний хувьд хамгийн чухал дагах хууль бол Библи байх ёстой юм. Түүнээс өөр ямар ч юмыг бид хүлээн зөвшөөрөхгүй. Хүмүүсийг гэмээс нь чөлөөлөхийн тулд бид яарах хэрэгтэй байна, ялангуяа залууст гэмт амьдралаас салах арга замыг үзүүлэх хэрэгтэй“ гэж өгүүлснийг бичсэн байв. Зөвлөлтийн хуулийн дагуу залууст Христийн тухай зааж сургахыг хориглосон байдаг шүү дээ гэхэд тэрээр,

— Бидний хувьд дагаж мөрдвөл зохих цорын ганц хууль маань Библи гэж хариулсан нь ямар ч коммунист дарангуйлал бүхий улс оронд харгис хэрцгий шашингүй үзэл нэвт шингэсэн удирдлагуудын сонсвол зохих ердийн хариу юм.

Дараагаар нь тэрхүү коммунист сонинд тун аймшигтай дүр зургийг илтгэх зүйлийг нийтэлсэн байв. Залуу охид, хөвгүүд магтаалын дуу дуулж, шашны заншлын дагуу усаар угаалгах

боловч бузар мую болгоноо өөртөө үлдээж, дээрээс нь дайснаа хайлрах сургаалыг элэглэн тохуурхаж байгааг зураглан дүрсэлжээ.

«Казакстанская правда» сонини 1966 оны 6-р сарын 30-ны дугаарт сургуулийн сурагчдын дотроос хамгийн шилдэг дүнгийн үзүүлэлттэй, сайн сахилга баттай сурагчид нь Христэд итгэдэг хүү байхыг олж мэдээд айн цочирдсон тухай бичсэн байлаа!

«Киргизская правда» сонини 1966 оны нэгдүгээр сарын 17-ны дугаарт нууц бүлгийн гишүүний эхдээ бичсэн захильтыг нийтэлсэн байв. "Үр хүүхдээ өлгийтэй байхаас нь эхлээд өөрсдийн амьдрал, бие сэтгэлийг тэднийхээ төлөө Ертөнцийн Эзэнтэй ярьж, түүний хүн болгон өсгөхийн төлөө зориулахдаа хэзээ ч шантрахгүй, хамтдаа зүтгэе! ... Үр хүүхдүүдээ хүний нийгмийн бузар булаг нөлөөнд авталаас хамгаалцаа" гэж бичсэн байлаа.

Тэдний хүчин чармайлт талаар өнгөрсөнгүй! Коммунистуудын сонин хэвлэлүүд өөрсдөө үүнийг гэрчлэх баримт болно! Христэд итгэх явдал залуусын дунд улам бүр газар авсан.

Оросын Селябынскийн нэгэн сонинд коммунист залуучуудын эвлэлийн гишүүн залуу бүсгүй Нина хэрхэн Христэд итгэсэн тухай бичсэн байв. Тэрээр Христэд итгэгчдийн нууц хуралд очиж авралын замыг олж авчээ.

«Советская Юстиция» сэтгүүлийн 1966 оны 9-р дугаарт тиймэргүү нууц хурлын тухай өгүүлсэн байна. "Тэд ихэвчлэн шөнө дунд болоход хуралдана. Хүн амьтнаас бүү хэл өөрсдийнхөө сүүдрээс нуугдах шахам явсаар тэд зүг зүгээс ирж цугларна. Намхан таазтай байшингийн өрөө тэр дороо дүүрнэ. Тэд дэндүү олуулаа учир өвдөглөөд суух ч боломжгүй. Агаарт хүчилтөрөгч дутагдсанаас эртний дэнлүү нэг их удалгүй унтрал гэрэлгүй болно. Ирсэн хүмүүс халууцан хацрыг нь даган хөлс урсаж байгаа үзэгдэнэ. Гадаа гудамжинд нэг нь зогсоод цагдаа нарын эргүүлд гарна" гэжээ. Ийм хүмүүс Нинаг халуун дотно тэврэн угтаж авчээ.

— Одоогийн надад байгаатай адил аугаа их итгэлийг тэд Ертөнцийн Эзэнээс хүлээн авсан хүмүүс байсан. Тэр биднийг өөрөө хамгаалах болно. Намайг таньдаг мэддэг комсомолын гишүүд надтай үг дуугаран мэндлэхгүй өнгөрвөл өнгөрөг! Тэд над руу хорсон харж, зэвүүцэн "Баптист!" гэж нэрлэн хацрыг

минь алгадан авах мэт аашилбал аашлаг! Тэгж л байг! Хийнэ гэснээ л хийг! Надад тэд хэрэггүй гэжээ.

Түүнтэй адил олон залуу коммунистууд үхэн үхтлээ Христийн төлөө амьдрах бат шийдвэр гаргасан.

«Казакстанская правда» сонины 1967 оны наймдугаар сарын 18-ны дугаарт Классен, Бондар, Телегин нарыг шүүх хурлын ажиллагааны тухай бичсэн байв. Тэдэнд ямар ял оноосныг тодорхой хэлээгүй боловч тэдний үйлдсэн хэргийг дэлгэрэнгүй бичжээ. Тэд хүүхдүүдэд Христийн тухай зааж өгдөг байв.

«Советская Киргизия» сонины 1967 оны зургадугаар сарын дугаарт Христэд итгэгчдийн талаар, "өөрсдийн эсрэг бүхий л захиргааны арга хэмжээг авахаас өөр аргагүй байдалд ортол эсэргүүцэл илэрхийлэгчид" гэжээ. Тиймээс гэм зэмгүй коммунист засаг захиргааны хариуцлагатай ажилтнууд эрх чөлөөгөө здлээд зүгээр байж чаддаггүй, чадаж буй нэгэндээ гай чирэн цаг үргэлж хэрэг төвөг дэгдээж байдаг хүмүүсээс болж нэг булгийг баривчлаад, дахин нөгөөг нь баривчлах хэрэгтэй болдог тухай өгүүлсэн байна. Тэдний үйлдсэн гэмт хэрэг нь ном үдэх зургаан машин, гектографийн арван таван машинаа ашиглан Христийн ном зохиолыг хэвлэж байсан явдал юм.

1968 оны хоёрдугаар сарын 21-ны «Правда» сонинд Библийн угс болон Ертөнцийн Эзэнтэй ярьсан яриаг тэмдэглэн бичиж хэвлэсэн тууз, хавчуурга зэргийг хэрэглэдэг нь илэрсэн мянга мянган охид эмэгтэйчүүд байдаг тухай бичжээ. Гэтэл коммунистууд судлан мөшгисөөр энэ шинэ шийдэл загварыг гаргаж олонд түгээсэн хүнийг олж илрүүлэхэд тэр нь нууц цагдаагийн газарт ажилладаг Христэд итгэгч, Любертийн Штасюк гэгч хүн байв. Түүнд санаа тавихыг би та нараас хичээнгүйлэн гүйя. Сонинд энэ тухай тодорхой бичжээ.

Коммунистуудын шүүх хурлын танхимд дуудагдан хэргээ шүүлгэж буй итгэгчдийн амнаас гарах үг бүрийг Ертөнцийн Эзэн өөрөө хэлээд байх шиг санагддаг. Нэг шүүгч тэднээс,

— Хориотой шашны бүлэглэлдээ та нар яагаад ингэж олон хүнийг татан оруулах гээд байгаа юм? хэмээн тайлбар шаардан асуухад Христэд итгэгч нэг охин,

— Бидний зорилго бол бүх дэлхийн ард түмэнд Христийг таниулан, түүний араас дагуулах явдал болно гэж хариу өчив.

Бас нэгэн шүүх хурал дээр өнөө шүүгч хэрэгтэн болох оюутан охиноос,

— Чиний шашин шинжлэх ухааныг үгүйсгэдэг гэж хэлэхэд тэрээр,

— Та Эйнштейн, Ньютон нараас илүү шинжлэх ухааныг судлаад мэдчихсэн хэрэг үү? Тэд чинь ч бас Христэд итгэдэг байсан юм. Бидний энэ дэлхий ертөнц Эйнштейний нэрийг одоо хүртэл дурсаар байна. Би бүр дунд сургуульд байхдаа л энэ дэлхий бол Эйнштейнийх гэж сонсож түүний гаргасан онолуудыг судалсаар ирсэн. Эйнштейн бичихдээ, "Хэрэв бид зарлагуудын үгийг Иудейн шашнаас, Христэд итгэх явдлыг Есүсийн хэлсэн ёсоор цэвэрлэн ялгах юм бол, ялангуяа сүмийн зэрэгтнүүдийн хожим хойно бий болгосон элдэв ёс жаягаас салгаж дөнгөвөл бүх орчлон хорвоог бузар муугаас бүрмөсөн салган аварч чадах гайхамшигтай баходам итгэлийг авч үлдэх байсан. Энэ итгэлийг ялалтад хүргэх нь энэ дэлхий дээр амьд мэнд алхаж гишгэж буй хүн бүрийн туйлын ариун үүрэг зорилго байх ёстай" гэсэн байдаг. Түүнээс гадна манай агуу их сэтгэл судлаач Павловыг сана! Түүнийг бас Христэд итгэдэг байсан гэдгийг манай ном зохицуудад тэмдэглэн үлдээгээгүй гэж үү? Тэр байтугай, Маркс хүртэл өөрөө "Капитал" номынхоо өмнөх үгэнд, "Христийн шашин нь ялангуяа протестант маягийн сургаал нь гэмийн улмаас болж устан сүйрсэн хүний сайн сайхан мөн чанарыг сэргээхэд чухал үүрэгтэй" гэсэн байдаг. Би ч гэсэн гэмд бузартан сайн сайхан гэх юмгүй шахам болсон хүн байсан. Үүнийг засан сайжруулж өөрчлөхийн тулд би Христэд итгэгч болох хэрэгтэй гэдгийг Маркс надад зааж өгсөн. Тиймээс та нар марксист сургаалыг баримталдаг байж намайг үүний төлөө хэрхэн шүүж болох вэ? гэж хэлж байв.

Ингээд л шүүгч хэлэх үггүй таг дуугүй болдог юм. Яагаад гэдгийг ойлгож цөхөөд байх юмгүй ээ.

Шинжлэх ухааныг үгүйсгэсэн шашинд итгэлээ гэж буруудсан хүнийг шүүх бас нэг хурал дээр тэр эр,

— Эрхэм шүүгч ээ! Симпсоны адил хлорын олон төрлийг, мөн янз бүрийн эм тариа нээж илрүүлсэн их эрдэмтэн та биш гэдэгт би итгэлтэй байна. Гэвч түүнээс хийсэн нээлтүүдийнх нь чухам аль нь хамгийн агуу их нээлт байсан тухай асуухад, «Энэ

бол хлорын төрөл байгаагүй. Миний амьдралдаа хийсэн хамгийн том нээлт бол би гэмтэй хүн бөгөөд зөвхөн Ертөнцийн Эзэний хайр энэрлээр л аврагдаж болно гэдгийг олж нээсэн явдал» гэж тэр хариулсан хэмээжээ.

Итгэлийнхээ төлөө цусаа урсгахад бэлэн тэдний амь биеэ үл хайрлан тэмцэх сэтгэл, шийдвэр нь нууц бүлгийн гишүүдийн тунхаглан байдаг авралын сайхан мэдээний хамгийн агуу баримт нь болдог. Энэ бол африкт Ертөнцийн Эзэний ажлыг хийгч Алберт Швайцерийн хэлсэн ”зовлон туулсан тэдний ариун нөхөрлөл“ буюу асар их зовлон туулан хүн төрөлхтний гэмийг үүрсэн Есүстэй нөхөрлөх нэгдмэл бат холбоо юм. Нууц бүлгийнхэн Аврагч Их Эзэнтэйгээ хайрын бат холбоогоор салшгүй бат нэгдсэн хүмүүс. Тэднийг энэ дэлхий дээр хэн ч дийлэн устгаж чадахгүй.

Нууцаар хил давуулан авчирсан нэг захидалд нууц бүлгийнхэн хэлэхдээ,

— Бид илүү сайн итгэлтэй хүн больё гэж гүйдаггүй, харин Ертөнцийн Эзэний хүсч буй тэр л хүмүүс байхыг хүсдэг. Өөр хэн ч биш зөвхөн түүний хүсч буй хүн байхыг хүсдэг. Христийн адил зан чанартай, Христийн яруу алдрын төлөө амь биеэ үл хайрлан зориулдаг тийм бат итгэлтэй хүмүүс байхыг хүсдэг гэж бичсэн байв.

Есүсийн хэлсэн шиг могой мэт хурц ухаантай байж шүүхийн өмнө хэн тэдний тэргүүн болохыг харуулан коммунистуудын элдэв асуулт байцаалтыг ийнхүү няцааж чаддаг.

”Правда Востока“ (Зүүний үнэн) сонины 1966 оны нэгдүгээр сарын 15-ны дугаарт яллагдагч Мария Севчукаас хэн түүнийг Христэд дагуулан авчирсаныг асуухад,

— Ертөнцийн Эзэн өөрийн хүмүүсээр дамжуулан миний сэтгэлийг өөр рүүгээ татсан гэж хариулжээ. Хэн чиний ахлагч чинь вэ? гэж өөр нэг хүн түүнээс асуухад,

— Ямар ч хүн биднийг удирддаггүй юм гэв.

Христэд итгэгч хүүхдүүдээс,

— Пионерын гишүүнээс татгалzan улаан бүчээ зүүж болохгүй гэж хэн та нарт сургасан бэ? гэж асуухад тэд,

— Бид өөрсдөө хүссэн учраас ингэсэн юм. Хэн ч бидэнд зааж өгөөгүй гэж хариулна.

Зарим газар Христэд итгэгчдийн үйл ажиллагаа мөсөн уулын орой мэт багахан үзэгдэх боловч зарим газар хүмүүс ахлагч нараа барьж өгөхгүйн тулд өөрөө өөрийгөө батлан усаар угаана. Зарим газар голд усаар угаан батлах боловч угааж байгаа, угаалгаж байгаа хоёр хоёул хэнд ч зургаа даруулахгүйн тулд нүүрэндээ битүү баг зүүнэ.

1964 оны нэгдүгээр сарын 30-ны "Учительская газета" сонины Волнечин— Корский дүүргийн Воронин тосгоны шашингүй үзэлт багшийн тухай бичсэн байв. Түүнийг лекцээ дуусгав уу үгүй юү шашингүй үзлийг үгүйсгэсэн агуулга бүхий зөндөө олон асуултууд түүнээс асуун дайралт хийхэд тэр алинд нь ч хариу өгч чадсангүй. Тэд түүнээс,

— Коммунистууд та нар хаанаас ёс суртахууны тухай онол зарчмаа гаргаж авсан юм бэ? Та нар өөрсдөө "хулгай бүү хий", "хүн бүү ал" гэдэг хирнээ үүнийгээ огт дагадаггүй шүү дээ. Христэд итгэгчид түүнд тэдний сургаад байгаа энэ сургаал нь хүртэл эсэргүүцээд байгаа Библид нь байдгийг батлан харуулав. Сүүлдээ нөгөө лекц уншсан багш толгой нь бүр өргөж эцсийн дүнд итгэгчид ялалт байгуулаад дуусав!

ХАВЧЛАГА УЛАМ БҮР ИХЭССЭЭР

Нууц бүлгийн итгэгчид урьд урьдынхаас илүү их хавчигдан зовж байна. Орост ямар ч шашныг хавчин гадуурхдаг. Христэд итгэгчдийн хувьд Иудейчуудыг коммунистууд хэрхэн хавчиж гадуурхаж байгааг мэдэх нь сэтгэл шимширмээр өрөвдөлтэй санагдана. Гэвч хавчиж буй хамгийн гол бай нь нууц бүлгийнхэн юм. Зөвлөлтийн хэвлэлүүдэд олноор баривчлах ажиллагаа явуулан олон хүнийг илрүүлсэн тухай их гарна. Нэг удаа тэд наян хоёр Христэд итгэгчийг баривчлан хүчээр сэтгэл мэдрэлийн эмнэлэгт галзуу өвчтэй болгон хэвтүүлсэн байв. "Удаан хугацаагаар Ертөнцийн Эзэнтэй ярьсны" үр дүнд тэдний хорин дөрөв нь хэдхэн хоногийн дараа нас барсан юм! Хэзээ байтлаа удаан хугацаагаар ярилаа гээд хүн амь насaa алдаж байсан юм бэ? Тэд чухам юу туулсныг та төсөөлж чадах уу?

Тэдэнд оноодог хамгийн аймшигтай шийтгэл нь хэрэв тэд хүүхдүүдэд Библи заадаг байсан нь илэрвэл төрүүлсэн үр

хүүхдээсээ үүрд салан хагацаж, хэзээ ч уулзаж, ядаж холоос ч гэсэн барааг нь харж чадахгүй болдог явдал байв. Эх үрсийг ийнхүү салгахдаа тэд гаршсан улс.

Зөвлөлт Холбоот Улс Нэгдсэн Үндэстний байгууллагад гишүүнээр элсэхдээ олон улсын хүний эрхийн тухай тунхагийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурахдаа "боловсролын хүрээнд хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх" тухай тусгасан байдгийг зөвшөөрч л байсан. "Эцэг, эх үр хүүхдийнхээ сайн сайхны төлөө шаардлагатай гэж үзвэл ёс суртахууны болон шашны аливаа мэдлэгийг олгох үүднээс зааж өгч сургах эрхтэй" гэсэн заалт энэ тунхагт бий. Зөвлөлт Холбоот Улсын албан ёсны бүртгэлтэй баптистуудын нэгдлийн тэргүүн урвагч Карев дээр дурдсан зүйлийн талаар өгүүлэхдээ орос оронд энэ эрх бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа гэдгийг батлан илэрхийлж чадсан ба тэнд байсан хүмүүс түүнд гэнэн тэнэгхнээр итгэсэн! Тэгвэл одоо зөвлөлтийн сонин сэтгүүлүүд юу гэж бичдэгийг мэдэж авагтун.

1963 оны зургадугаар сарын 4-ны "Советская Россия" сонинд баптист байгууллагын гишүүн Макринковагийн зургаан хүүхдийг хүүхдүүдэдээ Христийн тухай зааж өгч, улмаар улаан бүч зүүхийг нь хориглосон шалтгаанаар салган авч шийтгэсэн тухай байна.

Түүнд энэ ялыг уншин тайилцуулахад тэр, "Би итгэлийнхээ төлөө зовж байна" гэснээс өөр юм хэлсэнгүй. Хүчээр салган аваад асрах газар хүүхдүүдийг нь аваачсан ба тэнд амьдрах зардал мөнгийг тэр өөрөө төлөх ёстой болов. Одоо тэд коммунизмын үзэл сурталд нэвт автан хордож байна. Христэд итгэгч эх хүний сэтгэл хэрхэн шаналж байгааг бодоод үз!

Игнатий Мюллинд үүнтэй адил хэрэг тохиолдсон тухай "Учительская газета" сонинд мэдээлсэн. Тэднийг итгэлээсээ няц хэмээн шүүгч шаардан,

— Ертөнцийн Эзэн, төрүүлсэн охин хоёрынхoo аль нэгийг сонгох болж дээ. Чи Ертөнцийн Эзэнээ сонгож байна уу? гэхэд тэр,

— Би итгэлээсээ яагаад ч ухарч няцахгүй гэж хариулжээ.

Пууль хэлэхдээ, "Бүх юмыг эцэст нь сайн сайхан үр дүнд хүргэдэг" гэж хэлсэн байdag. Би өөрийн нүдээр Христэд итгэдэг эцэг эхтэй хүүхдүүдийг салган аваад асрах газар аваачин хү-

мүүжүүлж байхыг үзсэн. Тэд шашингүй үзэлд хордохын оронд гэр орондоо олж авсан итгэлийн сайхан мэдээгээ бусад хүүхдүүдтэй хуваалцан ярилцаж улам батжуулж авдаг байв!

Библид үр хүүхдээ Есүсээс илүү хайлласан хэн боловч Христийн хүн байх эрхгүй гэж хэлсэн байдаг. Энэ үгс төмөр хөшигний цаанаа буй итгэгчдийн хувьд бодит утга агуулгатай.

Үр хүүхдээ олж харалгүй долоо хоног амьдрах гээд оролдоод үз! Тэгвэл та орос орноо шаналан буй ахан дүүсийнхээ зовлонгоос жаахан ч гэсэн ойлгох болно.

Өдгөө хүртэл Христэд итгэгчдийн эцэг, эх байх эрхийг хасах явдал байсаар байна. Зөвлөлтийн сонин хэвлэлээс баримт татан бидний хэлж чадах хамгийн саяхны нэг жишээ гэхэд л "Знания Юности" сонины 1967 оны гуравдугаар сарын 29-ны дугаарт гарсан хатагтай Сичийн хэрэг юм. Түүнийг хүүгээ Их Эзэнээс эмээн хүндэлдэг хүн болгон өсгөж байгааг мэдээд хүү Вечеславыг нь салган авчээ. Мөн Хабаровскийн хатагтай Забавинаг хүүхдэдээ "ердийн бус боловсрол" олгохыг завдсан гэдэг шалтгаанаар өнчин ганц ач охин Таняг нь салган асрах газар аваачсан байна. («Советская Россия», 1968 оны нэгдүгээр сарын 13-ны дугаар.)

Протестант маягийн нууц бүлгийн тухай л яриад байх нь шудрага хэрэг болохгүй байхаа.

Оросын үнэн алдартны шашны сүсэгтийн үд хүртэл маш их өөрчлөгдсөн. Тэд сая саяараа шире орж байв. Тэдэнд эрхи, загалмай, ариун гэгээн зургууд, үнэртэн, лаа гээд юу ч байсангүй. Томилогдсон хамбагүй болсон ажилчин ард шире орсон байлаа. Хамбууладад тусгай өмсгөл дээл нь, өргөлд өргөх улаан буудайн гурилан талх, дарс нь, ариун тос нь уншлага, сургаалаа бэлддэг ном нь ч байсангүй. Тэд энэ бухэнгүйгээр Ертөнцийн Эзэн рүү шууд очиж харилцаж чадна гэдгээ ойлгож авав. Тэд Ертөнцийн Эзэнтэй зүгээр л ярьж эхэлсэн бөгөөд Ертөнцийн Эзэн ч тэдэнд энэрэл хайрын бэлгээ харамгүй өгч байлаа. Оросын үнэн алдартны шашны байгууллагын хүмүүсийн дунд асар их өөрчлөлт гарч, тэд бусдынхаа адил оюун санааны хувьд сэргэн босч байна.

Зөвхөн орос шире байдал ийм байгаа хэрэг бишээ. Үнэн алдартны шашны байгууллагын үндэс суурь бүхий зөвлөлтийн

дагуул улс орнуудад ч гэсэн ёс заншил зэргээ даган жинхэнэ хүч чадлыг умартсан байдлаа халж хаян сэргэн дээшилж зөвхөн Христийг хүсэн тэмүүлж Ертөнцийн Эзэнтэй улам илүү ойр дотно болж буй улс олон. Энэхүү үнэн алдартны нууц бүлгийнхэн дотроос ч гэсэн маш олон хүн итгэлээ хамгаалан амь наасаа алдсан. Калугагийн ахмад тэргүүн хамба Ермогений одоо хаана байгааг хэн хэлж чадах вэ? Ертөнцийн Эзэнийг үл тоогч коммунистуудтай гар хөл болон хамтран ажиллахаас татгалзан эрс шийддэмгий тэмцэхээс тэр шантраагүй агаад үүнийхээ шанг ч бас хүртсэн.

Коммунизм тавин жил ноёрхлоо! Гэтэл зөвлөлтийн хэвлэлүүдэд Христэд итгэгчдийн нууц үйл ажиллагаа хэрхэн амжилттай ялалт байгуулж байгааг үргэлж зарлан мэдээлж байна. Ярихын аргагүй хэцүү бэрхшээл зовлонг тэд туулдаг боловч үлдэн хоцорсоор, өргөжин тэлсээр байна!

Румынчууд бид оросын армийн цэргүүдийн сэтгэлд жаахан ч гэсэн үнэний үрийг суулгасан. Оросууд өөрсдөө ч үүнийг хийсэн ба оросуудад эзлэгдсэн бусад улс орнуудын хувьд байдал иймэрхүү байв. Тарьсан үр болгон маань үр дүнгээ өгөх нь гарцаагүй.

Коммунистуудыг Христийн өмнө авчирч болно. Коммунистыуд Христэд итгэж чадна. Хэрэв бид тэдэнд туслах л юм бол тэдний дарангуйлалд зовж буй хүмүүс ч гэсэн Христийнх болох болно.

Миний зөв гэдгийг батлах баталгаа нь Зөвлөлт Холбоот Улс, хятад гээд коммунист дэглэмтэй олон улс оронд нууц бүлгүүдийн хүмүүсийн тоо өдөр ирэх бүр нэмэгдэж байгаа явдал юм.

Аймшигтай хэцүү нөхцөл байдалтай байгаа Христэд итгэгч ахан дүүсийн тань сайхан сэтгэл, бат итгэлийн илэрхийлэл болгон оросоос хүлээн авсан захидалтуудаа та бүхэнд толи-луулья. Сүүлчийн захидалтуудыг оросын широнгуудаас ирүүлсэн билээ.

ВАРИЯ ОХИНЫ ТҮҮХ

Эхний гурван захидал нь Варияг Христийн өмнө дагуулан авчирсан жаахан охин Мариягийн захидалтууд болно.

Эхний захидал

” ... Би эндээ амьдарсаар л байна. Хүмүүс намайг маш их хайрладаг. Түүнээс гадна комсомолын (Коммунист Залуучуудын Эвлэл) бүлгийн гишүүн ч надад хайртай байдаг. Тэр надад, «Чи чухам ямар учиртай хүн болохыг би мэдэхгүй. Энд олон хүн чамайг тамлан зовоож, доромжилж байхад чи тэдний хэнийг нь ч ялгахгүй хайрлах юм» гэж байв. Би түүнд Ертөнцийн Эзэн надад зөвхөн найз нөхдөө биш, харин дайснаа хүртэл ялгаварлахгүй хайрлахыг зааж сургасан гэдгийг хэлсэн. Энэ эмэгтэй намайг урьд нь маш хэрцгийгээр зовоож байсан ч би түүний төлөө онцгойлон анхаарч Ертөнцийн Эзэнтэй ярьж байсан юм. Тэр надаас өөрийг нь хайрлаж чадах эсэхийг асуухад би түүнийг гарaa сунган тэврэн авсан ба бид тэврэлдэн уйлцааж байв. Одоо харин бид хамтдаа Ертөнцийн Эзэнтэй ярьдаг болсон.

Түүний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярьж байгаарай. Түүний нэрийг Вария гэдэг.

Ертөнцийн Эзэнийг аман дээрээ чанга дуугаар үгүйсгэгч хүмүүсийг сонсоход надад эхлээд тэд үнэн сэтгэлээсээ хэлээд байх шиг санагддаг байв. Гэвч амьдрал бидэнд тэдний олонх нь аман дээрээ Ертөнцийн Эзэнийг хараан зүхэж байдаг боловч зүрх сэтгэлдээ түүнийг асар ихээр хүсэн тэмүүлж байдгийг харуулсан. Тэгээд л бид тэдний сэтгэлийн хүсэн тэмүүлэх дууг олж сонсдог ... Энэ хүмүүс ямар нэг юм эрэн хайх ба зүрх сэтгэлийнхээ хоосон орон зайл нөхөн дүүргэхийн тулд Ертөнцийн Эзэнийг үгүйсгэн хүслээрээ амьдрах гэж хичээх юм.

Христийн нэрээр нэгдсэн таны дүү, Мария“

Хоёр дахь захидал

”Өмнөх захидалдаа би танд Вария гэдэг шашингүй үзэлт нэг охины тухай бичсэн. Харин одоо би хайртай ахан дүүс та нартаа аугаа их баярын мэдээ дуулгая. Вария Христийг өөрийн Аврагч Их Эзэнээ болгон хүлээн авлаа. Тэр үүнийгээ хүн бүрийн өмнө ил тод мэдэгдэн бусдад Христийн тухай тунхаглаж байна.

Тэр Христэд итгэн аврал олж авсандаа хязгааргүй их баяртай байсан боловч энэ бүхэнтэй зэрэгцэн нилээд гунигтай байх болсон. Урьд нь Ертөнцийн Эзэн байдаггүй гэж суртал ухуулга

хийж байснаасаа болж гунигласан аж. Тиймээс тэр одоо энэ гэмийнхээ төлөө хариуцлага үүрэхээр шийджээ.

Бид Вариягийн хамт Ертөнцийн Эзэнийг үл ойшоогч хүмүүсийн хуралд очлоо. Хэдийгээр болгоомжлох хэрэгтэй гэж хэлсэн боловч ямар ч нэмэр болсонгүй. Вария ч, би ч бас чухам юу болохыг үзэхийг хүсч байв. Коммунистууд төрийн дууллаа дуулж дуусахад (Вария өөрөө тэдэнтэй хамтран дуулсангүй) тэр үг хэлэх зөвшөөрөл авлаа. Түүний ээлж болоход тэр цугласан олны өмнө гарч зогсоод сэтгэлийнхээ гүнээс Христийн тухай тэдэнд зоригтой ярьж эхлэв. Тэр түүнийг өөрийн Аврагч Их Эзэнээ болгон хүлээн авсан бөгөөд өөрөө ч мэдэлгүй бусдыг мөнхийн зовлонгийн аймшигт шийтгэл рүү дагуулан явж байснаа хүлээн зөвшөөрч тэдний оюуны нүдийг таглан таг сохор байдалтай болгохын төлөө хийсэн бүхэндээ туйлын их харамсан урьд хамтран зүтгэдэг байсан нөхдөөсөө учлал гуйв. Тэр гэмт амьдралаа бүрмөсөн хаяж, Христ рүү ирэн түүнтэй хамт байхын тулд бүхнийг хөсөр хаях болсноо мэдэгдээд үгээ дуусгав.

Хүмүүс бүгд чив чимээгүй, хэн ч түүнд саад болсонгүй, тэр ч яриагаа дуусгаад гайхамшигтай чадварлаг сайхан хоолойгоор Христийг магтан дуулав. "Миний өмнөөс амиа өгсөн Христийн тухай тунхаглахаас би ичихгүй. Түүний хэлсэн үг бүрийг, түүний загалмайн их хүчийг хамгаалан тэмцэхээс би айхгүй" гэсэн утгатай дуу байлаа.

Гэтэл дараа нь, дараа нь тэд бидний хайрт Варияг баривчлан аваад явлаа.

Өнөөдөр тавдугаар сарын есний өдөр. Бид түүний талаар ямар ч сураг сонсоогүй сууж байна. Гэвч Ертөнцийн Эзэнд түүнийг авран хамгаалах хүч чадал бий. Түүний төлөө Ертөнцийн Эзэнтэй яриарай!

Таны хайрт Мария"

Гурав дахь захидал

"Өчигдөр, наймдугаар сарын хоёрond би шоронд хайрт Вариятайгаа ярилцлаа. Түүний тухай бодох бүр зүрх сэтгэл минь хайллан урсашиг болж байна. Үнэндээ тэр жаахан хүүхэд шүү дээ. Тэр дөнгөж л арван естэй. Их Эзэнд итгэсэн итгэлийнхээ

хувьд ч гэсэн нярай хүүхдээс ялгарахгүй шахуу. Гэсэн ч тэр Ертөнцийн Эзэнд чин зүрхнээсээ хайртай ба энэ хэцүү замыг аль хэдийн сонгон эргэн буцах аргагүй болжээ. Хөөрхий охин маш их өлсөж байна. Түүнийг шоронд байгааг олж мэдээд бид даруй түүнд зориулан илгээмж явуулсан боловч тэр өчүүхэн жаахан хэсгийг нь хүлээн авсан байна.

Түүнтэй өчигдөр уулзахад маш их турж, цонхийж, үргэлж зодуулдаг шинжтэй харагдлаа. Гэвч түүний нүдэнд энэ дэлхийгээс хэзээ ч олж авч чадахгүй асар их баяр баясалан гэрэлтэн, Ертөнцийн Эзэний амар тайван нүүрэнд нь тодрон байв.

Тийм дээ, хайрт ахан дүүс минь. Та нар Христийн өгдөг амар тайвныг өөрийн биеэр хэзээ ч олж аваагүй бол ойлгож чадахгүй нь мэдээж ... Гэвч энэ амар тайвныг олж авсан тэр хүмүүс юутай их аз жаргалтай вэ!.. Христтэй бат нэгдсэн бидний хувьд ямар ч зовлон тамлал, хэцүү бэрх бүхэн биднийг зогсоож чадахгүй ...

Төмөр торны цаанаас би,

— Вария. Хийсэн зүйлдээ чи харамсахгүй байна уу? гэж асуув.

— Үгүй ээ! Огтхон ч үгүй! Хэрэв тэд намайг сулладаг л юм бол би дахиад л тэдэн рүү очиж Христийн аугаа их хайрын тухай ярих болно. Би өөрийгөө зовж байна гэж боддоггүй, харин Их Эзэн надад маш их хайртай болохоороо ариун дархан түүний төлөө бага ч атугай хэцүү бэрхийг туулах боломж өгсөнд нь их баяртай байна гэж хариулсан.

Та бүхэн чин сэтгэлээсээ түүний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярихыг би гүйя. Түүнийг Сибирь рүү цөлж магадгүй. Тэд түүний хувцас хунаар, ер нь байгаа бүгдийг нь хураан авсан. Түүнд өмсөж байгаа хувцаснаас нь өөр юм үлдээгүй. Хамаатан садан, ах дүү гэж бас байхгүй. Тиймээс бид түүнд шаардлагатай юмыг нь олж өгөх хэрэгтэй. Таны надад явуулсан мөнгийг би түүнд зориулахаар хадгалж байна. Хэрэв Варияг цөлөх юм бол би түүнд хэрэгтэй юмыг нь өгнө. Ертөнцийн Эзэн түүнийг ирээдүйд ч гэсэн үргэлж тэвчээртэй байлгаж, түүний итгэлийг батжуулна гэдэгт би итгэлтэй байна. Ертөнцийн Эзэн түүний хамт байж харж хамгаалах болтугай!

Таны хайртай Мария“

Дөрөв дэх захидал

”Хайрт Мария минь. Арайхийж л би танд захидал бичих боломжтой болж байна. Бид энд дажгүй явсаар хүрлээ. Бидний лагерь хотоос арваад миллийн зйттай. Би өөрсдийн амьдралыг танд дурслэн илэрхийлж чадахгүй нь. Та тэртээ тэргүй мэдэж байгаа биз. Зөвхөн өөрийнхөө тухай л жаахан юм бичихийг хүслээ. Ертөнцийн Эзэн надад эрүүл саруул бие махбод өгсөнд, биеийн хүчний ажил хийх чадвар өгсөнд би баярлаж байна. Би нэг эгчтэй хамт цехэд ажиллах болсон. Бид том машинууд дээр ажилладаг. Ажил их хүнд, түүнээс гадна нөгөө эгчийн эрүүл мэнд тааруу. Тийм болохоор би өөрийнхөө ажлын хажуугаар түүний нормыг бас хийх хэрэгтэй болдог. Би эхлээд өөрийнхөө ажлыг дуусгачаад эгчид тусалдаг. Бид өдөрт арван хоёроос арван дөрвөн цаг ажилладаг. Бидний хоол унд гэвэл та нарынхтай л адил тарчиг хомс. Гэвч миний бичих гэж хүссэн юм энэ биш л дээ.

Ертөнцийн Эзэн танаар дамжуулан надад авралын замыг зааж өгсөнд би чин сэтгэлээсээ Ертөнцийн Эзэнд талархан түүнийг хүндэлж байдаг. Одоо миний сонгон авсан энэ амьдрал утга учир, зорилготой болсон. Би хаашаа явж байгаа, хэний төлөө зовлон туулж байгаагаа ч сайн мэднэ. Сэтгэл зүрхэнд минь буй авралын сайхан мэдээг хүн бүрт хэлэх хүсэл надад бий. Христтэй нэгдэн олж авсан Ертөнцийн Эзэний хайраас хэн биднийг салгаж чадах вэ? Хэн ч, юу ч хэзээ ч чадахгүй. Шорон, тамлал зовлон ч чадахгүй. Бидний туулж буй зовлон гэдэг бол бидний өөрт нь итгэсэн итгэлийг улам илүү батжуулахын тулд өгсөн Ертөнцийн Эзэний бэлэг юм. Ертөнцийн Эзэнээс тасралтгүй урсан ирэх энэ их энэрэл хайраар сэтгэл зүрх минь дүүрэн бялхаж байна. Их Эзэн надад юу хийж өгснийг хүн бүрт хэлэхгүй дуугүй байж чадахгүй учир тэд намайг ажил дээр хараан зүхэж, шийтгэн илүү их ажил өгдөг. Мөнхийн зовлонгийн шийтгэл авах байсан намайг тэр өөртөө авч цоо шинэ хүн болгон өөрчилсөн байтал би яаж дуугүй байж чадах билээ? Угүй ээ, хэзээ ч чадахгүй! Ам минь хөдөлж үг хэлж чадаж байгаа цагт би хүн болгонд түүний аугаа их хайрын тухай ярих болно.

Лагерь руу явж байхдаа бид Христэд итгэдэг олон хүмүүстэй уулзсан. Ах дүүсээ хараад анхны харцаар шууд л тэд Ертөнцийн Эзэний хүмүүс гэдгийг түүний Ариун Сүнсний хүчээр мэднэ гэдэг юутай гайхамшигтай сайхан гэж санана. Үг хэлэхийн ч хэрэггүй. Анх хараад л тэд хэн болохыг та хэлүүлтгүй сэтгэлдээ шууд мэднэ.

Биднийг лагерь руу явж байхад галт тэргэн дотор нэг эмэгтэй бидэн рүү ойртож ирээд хоол унд өгөхдөө,

— Ертөнцийн Эзэн одоо ч амьд гэж хэлээд явсан.

Энд ирсэн анхны өдөр (их орой болсон байсан) биднийг газар доорхи нуувч шиг юманд оруулав. Тэнд байсан хүмүүстэй бид "Амар тайван байх болтугай!" гэж мэндэлтэл бараг булан бүрээс "Амар тайвныг хүсэн хүлээн авья!" гэж хэлэхийг сонсоод бид маш их баярласан. Ирсэн анхны өдрөөсөө л бид нэгэн гэр бүл гэдгээ мэдэрсэн.

Тийм ээ. Үнэхээр байдал ийм байна. Христийг өөрийн Аврагч Их Эзэнээ болгон авсан хүмүүс энд олон. Хоригдлуудын тэн хагас илүү хувь нь Христийн хүмүүс. Бидний дунд гайхалтай сайн дуулдаг, хүч чадалтай сургаал заадаг хүмүүс ч бас бий. Хүнд ажлаас тарж ирснийхээ дараа бид оройдоо хамтдаа цуглан Аврагч Эзэнийхээ хөлд сөгдөн сууж хамтдаа хэсэгхэн ч гэсэн хугацааг түүнтэй ярьж, үгийг нь сонсон өнгөрөөдөг. Христтэй хамт байхад хaa сайгүй эрх чөлөө байдаг гэдгийг би олж мэдсэн. Би олон сайхан магтаал хүндлэлийн дуунууд сурсан ба өдөр бүр Ертөнцийн Эзэн надад өөрийнхөө үгийг хэлж олон юм заан сургаж байна. Арван есөн нас хүрсэн хойноо анх удаа би Христийн хамт төрсөн өдрөө хийлээ. Энэ гайхамшигтай өдрийг би хэзээ ч мартахгүй! Бид бүтэн өдрийн турш ажилласан. Голын эргийн ойролцоо ажиллаж байсан ах нарын зарим нь боломж гарган голын мөсийг цоолон цооног гаргаж тэр орой миний хамт долоон ахыг усаар угаан баталсан. Ертөнцийн Эзэний үгийг дагаж бид үүнийг хийсэн. Би ямар их аз жаргалтай байна гээч! Мария, таныг надтай хамт энд байгаасай гэж ясан их хүснэ вэ! Тэгвэл би урьд өмнө нь чамд учруулсан тэр олон гэмээ хайрынхаа улмаас жаахан ч гэсэн цайруулахсан. Гэвч Ертөнцийн Эзэн бидэнд байвал зохих газрыг маань зааж өгч тэр газар нь байлгаж

байдаг тул бид тус тусын байх газраа амьдрах нь зүйтэй болов уу.

Ертөнцийн Эзэний бүх хүүхдүүдэд мэнд хүргээрэй. Намайг хэрхэн ерөөснийхөө адил Ертөнцийн Эзэн та нарын ажил үйлсийг бүтээмжтэй болгох болтугай! «Еврэйчүүдэд» 12.1—3-ыг уншаарай.

«Өнө эртнээс эхлэн маш олон хүн Ертөнцийн Эзэнд итгэж үгийг нь дагаж байсан юм. Одоо тэд бидний үлгэр дууриалал болж байна. Бид энэ тухай сайн мэднэ. Энэ байдал нь үлгэрлэвээс, гүйлтийн уралдаан мэт ажээ. Иймээс бид бүхэн тэдний адил уралдаанд оролцож амжилт гаргах хэрэгтэй. Уралдаанд оролцох тамирчин тээртэй хувцсаа тайлж хаян, тэсвэр хатуужилтай гүйх ёстойн адил бид ариун амьдралд саад болсон гэмт зангаа хаяж, Ертөнцийн Эзэний замаар тэвчээртэй уралдах хэрэгтэй. Хамгийн чухал нь, тамирчин хүн бариа руу нүд салгалгүй харж байдгийн адилаар бид Есүс рүү ямагт харж найдах хэрэгтэй. Есүс бол Ертөнцийн Эзэнд бүрэн итгэхийн үндэс бөгөөд өврийн амьдралаар Ертөнцийн Эзэний зорилгыг гүйцээсэн хүний эрхэм дээд үлгэр дууриалал юм. Үүнд, хожим туйлын их жаргал авахаа тэр мэдэж байсан учраас модон загалмайд цөвдлуулан харгис этгээдэд алуулах хамгийн жигшигүртэй үхэл болон тэр их тамлалыг зоригтойгоор тэсвэрлэн эдэлсэн байна. Одоо тэр Ертөнцийн Эзэний ер бусын ертөнцөд очоод баруун гарын эрхэм хүндэт суудлыг эзэлжээ. Итгэлээсээ ухарч шантрахгүйн тулд Есүс гэмт хүмүүст хавчигдахдаа хэрхэн тэсвэртэй байсныг сана.» («Еврэйчүүдэд» 12.1—3)

Энд байгаа ах дүү нар маань ч бас танд мэнд хүргэж байна. Бэрхшээл зовлонг үл хайхран түүнд үнэнч итгэлтэй байж түүнийг хүндлэн алдаршуулж байгааг чинь мэдээд бид баяртай байна. Хэрэв та бусад хүмүүст захидал бичвэл бидний мэндийг бас дамжуулаарай.

Таны хайртай, Вария“

Тав дахь захидал

”Хайрт Мария минь, танд хэдэн мөр ч гэсэн бичих боломж сая нэг юм гарлаа. Ертөнцийн Эзэний хайр ивээлээр нөгөө эгчийн бие сайжирч эрүүл саруул, сэргэлэн цовоо болсныг танд хэлэх гэсэн юм. Бид одоо ... эндээ байна, тэд биднийг ииш нь авчирсан. Бид энд нилээд удах бололтой.

Надад эхийн хайраар хандан халамжилж байдагт тань би баярладаг шүү. Таны бидэнд зориулан бэлтгэж явуулсан юмыг бид бүгдийг нь авсан. Хамгийн үнэтэй эрдэнэ болох Библи өгсөнд чинь би юу юунаас илүү баярлаж байна. Бүгдэд чинь баярлалаа. Хэрэв та захиа бичвэл тэдэнд бас миний төлөө хийсэн бүхэнд нь талархаж байгааг минь, мэндийн хамт дамжуулаарай. Нэгэнт Ертөнцийн Эзэн надад өөрийн аугаа их хайрын нууцуудаас нээн харуулсан тул би өөрийгөө энэ дэлхий дээрх хамгийн аз жаргалтай хүнд тооцдог. Намайг анх итгэсэн цагаас эхлээд өөрийнх нь төлөө амь биеэ үл хайрлах гэж юу болохыг заан өгч хэцүү бэрхшээлтэй учруулсан Их Эзэндээ маш их талархаж байна. Эцсийн мөч хүртлээ үнэнч итгэлтэй байхын минь төлөө та бүхэн Ертөнцийн Эзэнээс гүйгаарай.

Ариун тэмцэлд шантрахгүй зүтгэж байгаа та бүхэнд Их Эзэн маань хүч чадал өгч, харж хамгаалах болтугай!

Нөгөө эгч бид хоёр та нарыг үнсье. Биднийг дахин өөр нэг тийш нь явуулбал магадгүй надад дахиад жаахан юм бичих боломж гарах байх гэж найдаж байна. Бидний төлөө санаа зовох хэрэггүй. Ер бусын мөнхийн улсад Ертөнцийн Эзэнээс хүлээн авах шагнал маань зүйрлэшгүй агуу учир бид баяр хөөр, аз жаргал дүүрэн байна.

«Надад итгэсний чинь төлөө хүмүүс та нарт хорсож, хараан, зүхэж, хавчиж, хилс хэргээр гүтгэнэ. Тийм хэцүү үед ч та нар жаргалтай байж чадна. Урьд нь Ертөнцийн Эзэний зарлагууд ийнхүү хавчигдсан. Та нар түүний ер бусын улсад орохдоо өндөр шагнал авах болно.» (Матай» 5.11—12)

Таны хайрт, Вария“

Энэ бол коммунист байсан боловч Христийг таньж мэдсэн залуухан охин Вариягийн сүүлчийн захидал. Тэр Христийн тухай тунхагласныхаа төлөө шийтгүүлэн хүнд хүчир хөдөлмөр хийх болсон. Түүнээс дахиад ямар ч сураг чимээ гараагүй боловч түүний гайхамшигтай их хайр, Христийг тунхаглан бусдад мэдүүлэх хүсэл, зүтгэл нь зовлон зүдгүүр хүнд ямар их ашиг тус өгдгийг харуулсан юм. Үнэнч итгэлтэй хүний хувьд энэ бол баходам сайхан бэлэг ажээ. Дэлхийн гуравны нэгийг эзэлсэн коммунист орнуудад ийм итгэлтэй хүмүүс олон бий.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТА БҮХЭНД ХҮРГЭХ СҮҮЛЧИЙН МЭДЭЭ

Намайг ”нууц бүлгийн дуу хоолой“ гэцгээдэг. Би өөрийгөө Христийн биеийн тийм чухал хүндэтгэл хүлээсэн хэсгийг төлөөлөх дуу хоолой нь гэж дуудагдахаар гавьяатай хүн гэж бодоггүй байна.

Гэсэн хэдий ч би коммунист улс оронд олон жилийн турши nuuц бүлгийн зарим хэсгийг удирдан ахалж байсан. Гайхамшигийн хүчээр арван дөрвөн жилийн шоронгийн амьдрал, тамлагыг тэсч гарсан. Их Эзэний хүчээр би хоёр жил ”үхлийн өрөөнд“ хоригдсон ч эсэн мэнд гарч ирсэн. Гэтэл үүнээс илүү гайхамшигийг бүтээн Ертөнцийн Эзэн намайг шоронгоос гаргаж баруунд авчран түүний хүмүүс тэнд хэрхэн зовж буйг та бүхэнд мэдээлэх ажлыг өгөхөөр нэгэнт шийдсэн ажээ.

Нэр нь үл мэдэгдэн нас барцгаасан баатарлаг, үнэнч итгэлтэй ахан дүүсийнхээ нэрийн өмнөөс би ярьж байна. Одоо хир нь ой мод, байшингийн хонгил, дээврийн хөндий зэрэг газар нууцаар хуралдсаар байгаа ахан дүүсийнхээ нэрийн өмнөөс би ярьж байна.

Румыны нууц бүлгийн шийдвэрээр би эх орноо орхин гарч чөлөөт нийгмийн иргэд та нарт тэдний тухай мэдээ дамжуулах үүргийг авсан. Гайхамшигаар би тэндээс гарч чадсан ба миний ард коммунист эх орондоо үлдэж хоцроод шаргуу хөдөлмөрлөн, амь өрсөн тэмцэж, зовж, амь наасаа алдаж буй тэднийхээ өгсөн даалгаврыг биелүүлэх боломж нэгэнт бий болжээ.

Нууц бүлгийнхнээс авчирсан миний та нарт дамжуулах сүүлчийн мэдээ энэ байна:

”Биднийг бүү орхи!“

”Биднийг бүү март!“

”Биднийг амьдралаасаа, хүн төрөлхтнөөс бүү арчин хая!“

”Бидэнд хэрэгтэй байгаа зэвсгийг өгөгтүн! Христийг тунхаглаад төлөөсийг нь бид төльв!“

Энэ бол миний та нарт дамжуулах ёстой мэдээ. Энэ бол надад найдаж өгсөн даалгавар.

Дуу хоолойгоо хориулж ”хэлгүй“ болсон хүмүүсийг, ”нууц бүлгийн гишүүдийг“ төлөөлөн би ярьж байна.

Коммунист улс орнуудад байгаа итгэгч ахан дүүсийнхээ сэтгэл зүрхний шаналан буй дууг сонсооч! Тэд та нараас амар тайван, хялбар амьдрал өгөхийг, тэндээс гарган авахыг хүсч гүйгаагүй. Тэдний ирээдүй хойч үе болсон хүүхдүүдийг шашингүй үзлээр хордуулах хэрэгт саад болж үнэн зөв мэдлэг олгожын тулд хэрэглэх зэвсгийг өгөхийг л та нараас гүйж байна. Ертөнцийн Эзэний үгийг уlam олон хүнд хүргэхийн тулд Библиэр хангаж өгөхийг гүйж байна. Өөрсдөд нь байхгүй байхад тэд яаж Ертөнцийн Эзэний үгийг бусдад хүргэх вэ?

Нууц бүлэг гэдэг нь галт тэргээр зорчин яваа мэс засалчтай адил юм. Сууж явсан галт тэрэг нь өөр галт тэргэгтэй мөргөлдөн хaa сайгүй хүмүүс бэртэж гэмтэн, шархалж, үхэж байна. Мэс засалч үхэж буй хүмүүсийн дундуур гүйн «Эмчийн багаж минь надад одоо байсан ч болоосой! Багажнуудаа авах минь яв!» гэж хашгирна. Мэс заслын тэр багажнуудаа ашиглан олон хүний амийг аварч болох байв. Туслах хүсэл сэтгэл байсан ч багаж нь түүнд байсангүй. Нууц бүлэг ийм л байдалтай байна. Өөртөө байгаа бүхнээ өгөхөд үнэхээр бэлэн, амь насаа хүртэл үл хайрлан өгөхөд тэр бэлэн! Гэвч ажилдаа аваад хэрэглэх багаж хэрэгсэл нь байхгүй бол түүний их хүсэл ямар ч ашиггүй талаар өнгөрнө. Үнэнч итгэлтэй, зоригт нууц бүлгийнхэн эрх чөлөөтэй та бүхнээс,

— Бидэнд багаж хэрэгсэл өгөөч! Библи, Библийн номууд, бусад холбогдох номуудыг өгөөч! Бидэнд туслаач! Тэгвэл бид үлдсэнийг нь өөрсдөө хийе! хэмээн гүйж байна.

ТУСЛАХЫН ТУЛД ...

Эрх чөлөөтэй байгаа итгэдэг хүн бүр дараахи байдлаар туслаж чадна. Үүнд:

Шашингүй үзэлтнүүд бол амьдралын нүдэнд үл харагдах эх үүсвэрийг ялган харах чадваргүй болсон хүмүүс. Тэд орчлон ертөнц болон хүний амьдралын нууц гэж юу болохыг мэдэрч чаддаггүй. Христэд итгэгчид өөрсдөө харагдах зүйлээр бус итгэлээр амьдралаа удирдуулан, нүдэнд үл үзэгдэх Ертөнцийн Эзэнтэй бат холбоотой нөхөрлөн амьдарснаар тэдэнд нөлөөлж чадна.

Хэзээ ч гувахгүй бат итгэлтэй, амь биеэ үл хайрлан зориулдаг байдлаараа нөлөөлж чадна. Христэд итгэгчдийг хавчин гадуурхах тохиолдол бүрийг алгасалгүй ашиглаж олон нийтийн өмнө ил тод эсэргүүцдэг болсноор тэд тусалж болно.

Коммунистуудыг аврахыг хүсэн Ертөнцийн Эзэнтэй тогтмол ярьж санаа тавьснаар та бүхэн бидэнд тусалж чадна. Ингэж гүйх нь тэнэг, гэнэн хэрэг шиг санагдаж магад. Бид Ертөнцийн Эзэнтэй тэдний төлөө ярихад маргааш нь тэд биднийг урьд өдрийнхөөсөө илүү их тамлан зовоодог байсан. Гэвч Их Эзэн Есүсийн гүйлт хүсэлт ч бас биднийхтэй адил байсныг бүү март. Түүнийг Ертөнцийн Эзэнтэй ярьсных нь дараа тэд цовдлон алсан. Гэвч зөвхөн хэдхэн өдрийн дараа тэд цээжээ дэлдэн харамсаж таван мянган хүн нэг өдөр түүнд итгэн амьдралаа өгсөн. Бусад олон хүний хувьд ч гэсэн Ертөнцийн Эзэнтэй ярилаа гээд улам дордох мэт санагдавч хэзээ ч тийм байгаагүй. Хэн нэг хүний төлөө та нар Ертөнцийн Эзэнтэй зуучлан ярихад түүнийг хүлээн аваагүй бол энэ яриа чинь эргээд танд ирэхдээ өрөөл, харин нөгөө зуучлуулж буй хүний хувьд хараал болно. Христийн үгийг биелүүлэн бидний хэдэн итгэгч нар Гитлер болон түүний хүмүүсийн төлөө үргэлж Ертөнцийн Эзэнтэй ярьдаг байв. Түүнийг ялахад холбоотны цэргүүдийн зэр зэвсэг сумас гадна бидний энэ гүйлт яриа тус болсон гэдэгт би итгэдэг.

Бид нөхдөө өөрийн бие шигээ хайрлах ёстой. Коммунистууд ч гэсэн бусдын адил хүн бөгөөд бидний нөхөд мөн.

Коммунистууд бол Христийн үгийг бүрэн дагаж биелүүлээгүйн улмаас гарч ирсэн хүмүүс. Христ хэлэхдээ, "Би та нарт хангалуун амьдрал өгөхөөр ирсэн" гэсэн. Хүн бүрийн амьдралыг Христэд итгэгчид хангалуун жаргалтай болгож амжаагүй байна. Амьдралд үнэтэй санагдах юм бүрийн хойноос хөөцөлдөхдөө тэд заримыг нь хөсөр хаясан. Энэ нь коммунист намын

бодлогод нийцсэн учир тэднийг дэмжин бидний эсрэг боссон. Тэд голдуу нийгмийн шудрага бус байдлын улмаас хохирогчид байдаг. Тэд одоо харгис бүдүүлэг, хорсол занал дүүрэн улс болжээ. Бид тэдний эсрэг тэмцэх хэрэгтэй. Гэвч Христэд итгэгчийнхээ хувьд хэдийгээр дайсныхаа эсрэг тэмцэж байгаа боловч хайр энэрэл гэдгийг мэдэхийн хувьд тэднийг ойлгон хайлрах ёстай.

Бидний зарим нь коммунист болсны төлөө бид ч бас хариуцлага хүлээх учиртай. Бид ямар ч байсан өөрсдийн үүрэг хариуцлагыг үл тоон орхигдуулсан буруутай хүмүүс.

Ийм учраас бид тэднийг хайлаж тэдний төлөө Ертөнцийн Эзэнтэй ярьснаар гэмээ цайруулах ёстай. (Хайлрана гэдэг бол тэдэнд дуртай байж, таашаахаас тэс өөр.)

Зөвхөн хайлраад л коммунистуудын асуудлыг шийдчихнэ гэж итгэдэг гэнэн хүн би биш. Засгийн эрх баригчдад зөвхөн хайлра, тэгвэл танхайчуудын асуудлыг шийдэж болно гэж би зөвлөхгүй. Тэднийг шийдэхийн тулд цагдаа ажиллуулж, шийтгэдэг хууль, шорон орон гэж байх ёстай. Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч байлгүй л яахав, гэхдээ бусад нь ч бас байх ёстай. Хэрэв танхайчууд гэмт амьдралаа хаяхгүй бол тэднийг шоронд суулган хүмүүжүүлэхээс өөр аргагүй. Христэд итгэгчдийн хэрэглэдэг “хайр“ гэдэг үгийг би олон улсын хэмжээнд тэд танхайчууд гэхээс өөрөөр тодорхойлох боломжгүй коммунистуудын эсрэг улс төр, эдийн засаг, соёлын салбарт тэмцэлдэхдээ хэзээ ч ашиглахгүй. Танхайчууд хүний цүнх сав хулгайлдаг, дээрэмддэг. Тэд удалгүй улс орныг ч гэсэн дээрэмдэн тонох аюултай.

Гэвч Христэд итгэгчдийн бүлгийн ахлагч, итгэгч хүн бүр коммунистуудыг Христийн өмнө авчрахын тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй. Тэр аймшигтай гэмт хэрэгтэн ч бай, жирийн нэгэн хохирсон этгээд ч бай хамаагүй бүхнээ зориулан хөдлөх ёстай. Тэднийг ийнхүү авчрахын тулд өөрийн зорилгоо мэдэн аливааг гаргуунд нь гаргах шаардлагатай билээ.

БИБЛИ БОЛОН БУСАД НОМУУД

Хоёрдугаарт, чөлөөт нийгмийн итгэгч та нар тэдэнд Библи болон холбогдох номнуудыг илгээн тусалж болно. Хил давуулан тэднийг коммунист улс орнуудад оруулах янз бүрийн арга байж л байна. Би энд ирснээсээ хойш нилээд олныг тэдэн рүү аль хэдийн явуулж амжсан, тэд ч бас бүгдийг нь аюулгүй хүлээн авсан. Нууц бүлгийн ахан дүүстээ та нар бэлдээд өгөх юм бол ямар ч байсан тэдний гарг хүргэх арга зам байж л таарна. Тодорхой арга замаар оруулж ирсэн Библи болон холбогдолтой номуудыг би Румынд байхдаа олон удаа авч байсан. Тэднийг явуулах арга замын хувьд асуудал байхгүй. Хэрвээ хангаад өгдөг л юм бол гарг нь өгөх арга гарцаагүй байна.

Үнэхээр шаардлагатай байгаа зүйл бол энэ. Орос болон түүний дагуул улс орнуудад хориос тавин жилийн турш Библи болон түүнтэй холбогдох номуудыг олж хараагүй, уншаагүй хүн хэдэн мянгаараа байна.

Нэг өдөр манайхыг зорин халтартсан хоёр хүн тосгоноос ирэв. Тэд тосгоноосоо гарч бүтэн өвлүүн турш газар хүрздэн мөнгө олоод олсон хэдээрээ элэгдэж хуучирсан ч хамаагүй ганц Библи олж аваад тосгон руугаа буцах бодолтой байжээ. Америкаас би Библи хүлээн авсан байсан тул тэдэнд элэгдэж хуучирсныг биш харин шинэ ном өгөх боломжтой байв. Тэд нүдэндээ ч итгэж чадахгүй байлаа! Хөлдсөн газар ухаж олсон мөнгөө надад өгөх гэж байдгаараа хичээж байв. Би тэдний мөнгийг авахаас эрс татгалзаж, тэд ч Библиэ аваад тосгон руугаа яaran буцлаа. Хэдэн өдрийн дараа надад баяр хөөрөө дарж ядан байгаа аястай талархсан агуулга бүхий захидал ирэв. Доор нь тосгоны гучин хүн гарын үсгээ зуржээ! Тэд уг Библийг тун болгоомжтой гучин хэсэг болгон салгаад хүн тус бүр нэг хэсгийг авч гар дамжуулан ээлжлэн уншдаг болжээ!

Оросууд бие биенээсээ Библийн ганц хуудсыг гүйж авч уншдаг гэдгийг сонсоход зүрх өвдөм санагдана. Библи олж авахын тулд үнээ, ямаа гээд юугаа ч худалдахад бэлэн аж. Тэр оюун санаа, амин сүнсээ энэ ганц хуудсан дахь үгсээр тэжээн тэтгэж байдаг. Хуучирч элэгдсэн «Шинэ Гэрээ» олж авахын тулд хуримын бөгжөө хүртэл худалдаж байсан нэг эрийг би мэднэ. Бидний

ҮР ХҮҮХДҮҮД Христийн мэндэлсний баярын тухай утга агуулгатай зураг бүхий ил захидал хэзээ ч олж хараагүй. Хэрэв хэн нэг хүүхдэд ганц тийм захидал байвал тосгоны хүүхдүүд бүгд тойрон цуглаж, настайчуулын нэг нь тэдэнд хөндөгдөөгүй бусгүйгээс бяцхан хүү Есүс төрснөөс эхлээд Христийн авралын тухай ярьж өгч болох байна. Ийм утга бүхий ганц ил захидаас болж энэ их түүхийг ярьж болно! Бид тэдэнд зориулан Библи, Библийн номнууд гэх мэтийг илгээж болно. Ийм маягаар та нар ямар нэг юм хийж болно шүү дээ.

Гуравдугаарт, цэцэрлэгт орохосоо өгсүүлээд их, дээд сургууль төгсөн төгстлөө шашингүй үзлийн онол заалган хордож буй залуу үеийнхэнд зориулан тусгай ном товхимол хэвлэх хэрэгтэй. "Шашингүй үзлийн гарын авлага" болохоор номуудыг коммунистууд аль хэдийн хэвлэн гаргасан. Энэ бол тэдний хувьд "Библи" болсон ном. Цэцэрлэгийн насны хүүхдийн сэтгэхүйд тааруулан тун дажгүй найруулан бичиж, хүүхдийн оюун ухаан хөгжин тэлэхийн хирээр улам нарийн болгон дэлгэрүүлэн тайлбарладаг бүх төрлийн номыг тэд хэвлэн гаргасан. Энэ адгийн бузар "Библи" нь хүүхдийг бага балчир байхаас нь эхлээд насанд хүрсэн хойно нь ч дэргэдээс нь холдохгүй дагаж шашингүй үзлээрээ хордуулж байдаг. Гэтэл Христэд итгэгчид энэ номын агуулгыг тайлбарлан үнэнийг харуулах харьцуулан үзэх ном одоо болтол нэгийг ч хэвлээгүй байна. Хор уршигтай, шашингүй үзэл суртлын санааг үнэн зөв тайлбарлан Библийн дагуу хариу өгсөн ном бид хэвлэн гаргаж өгөх хэрэгтэй, ингэж бас чадна. Энэ номд хордсон залууст өгөх ном нууц бүлэгт байхгүй гээд зүгээр сууж болохгүй. Коммунист улс орнуудын хэлээр уг номыг орчуулан бүгдийг зэрэг гаргахаас нааш нууц бүлгийнхэн гарaa ардаа хүлүүлсэн хүний адил юу ч хийж чадахгүй байдалтай хэвээр байх болно.

Оюун санаа нь хордон сүйрч буй хойч үеийхэндээ Ертөнцийн Эзэний хүмүүс бид түүний үгээр үнэн зөв хариу өгөх хэрэгтэй! Ийм аргаар та бүхэн хүүхэд ахуй цагаасаа эхлээд шашингүй үзэл суртал агуулсан ном зохиол уншиж өссөн хүмүүст үнэн зөв хариу өгөхөд тусалж чадна. Хүүхдүүдэд зориулсан Библийн түүхүүд, сургаалт үлгэрүүд гэх мэтийг хэвлэн тэдэнд өгснөөр тэдэнд үнэн зөв ойлголт өгөхөд тусалж чадна.

Бидний хийж чадах дөрөв дэх чухал зүйл нь нууц бүлгийн гишүүдтэй гар гараасаа барилцан авралын сайхан мэдээг тээн хaa сайгүй явж, хүн бүрт хүргэхэд нь туслахын тулд зам, унаа тээврийн зардлыг нь ханган өгөх явдал юм. Автобус, унаа, галт тэрэгний билет болон хоол унд, хоноглох газрын үнэ өртөгний асуудлаас болоод одоохондоо тэдний ихэнх нь гэртээ гинжлүүлсэн мэт байдалтай байна. Гэр орноос нь хорь гучин миллийн цаанаа орших бөглүү тосгоны хүмүүс тэднийг урин дуудаж нууцаар хуралдах санаа хичнээн байвч боломж нь байхгүй тул очиж чадахгүй дэмий өнгөрнө. Сард хэдхэн фунт стерлинг (5—10) өгөхөд л та тэдний гинжийг мултлан тосгоноос тосгон, хотоос хот хэсэн явж Христийн авралын мэдээг тунхаглах болон урин дуудаж буй бүхэнтэй уулзан Ертөнцийн Эзэний үгээр тэднийг урамшуулан зоригжуулах боломжийг олгох болно.

Итгэлийнхээ төлөө шоронд сууж байгаад гарч ирсэн Христэд итгэгчдийн ахлагч, сургаал заагч наарт хүний зүрх сэтгэлд гал мэт нэвтрэн орох чадалтай сургаал, төөрсөн хүн бурийг авралд хүргэх асар их хайр, тэмүүлэл бий боловч тосгоноос тосгон, хотоос хот руу түүнийгээ тээгээд явах хэрэгсэл, боломж алга. Сард өгөх хэдхэн фунт стерлинг чинь тэдэнд энэ боломжийг олгох болно.

Христэд итгэгч энгийн ажилчид мэдээж тусалж л байна. Гэтэл Христэд итгэдгийнхээ төлөө шийтгэл амсах мэт тэд ч гэсэн их ажиллах боловч амьдралдаа чүү ай хүрэлцэх жаахан мөнгө олно. Тийм учраас тэгж тосгон, хот хэсэн явж Христийн тухай тунхаглахад хэрэглэх юмгүй шахам болдог. Гэтэл та нарын өгөх хэдэн юм тэдний хувьд үүнийг боломжтой болгох гайхамшигт үйлс мэт билээ.

Албан ёсны байгууллагын ахлагч боловч амь насаа эрсдэлд оруулан байж нууцаар үйл ажиллагаа явуулдаг хүмүүс үүнд зориулсан тусгай мөнгийг ямар ч байсан хүлээн авах боломжтой байдаг. Тэдэнд улсаас тогтоож өгсөн цалин нь маш бага. Тэд коммунист хууль дүрмийг үл тоон хүүхдүүдэд Библи зааж, залуус болон насанд хүрэгчидтэй нууцаар уулзан хуралдахын тулд амь насаа аюулд учруулах нь хангалтгүй хэрэг шиг санана. Дан ганц хүсэл байгаад бүх асуудал шийдэгдэхгүй. Үйл ажил-

лагаагаа үр нөлөөтэй явуулахад тэдэнд олон тодорхой юм хэрэгтэй.

Христийн сургаалыг үр нөлөөтэй дэлгэрүүлэхэд та нарын өгөх сарын тав арван фунт стерлинг чинь маш их тус болох болно. Нууц бүлэгт та бас ийм аргаар тусалж болно. Энэ нь коммунист улс орнуудад радиогийн суваг ашиглан Христийн сургаал заадаг нэвтрүүлэг явуулах явдал юм. Амьдрал бэлэглэгч талх мэт хэрэгтэй байгаа тул эрх чөлөөт нийгмийн студиг ашиглан тэдэнд заах нь нууц бүлгийн гишүүдийн оюун санаа, амин сүнсийг тэтгэхэд асар их ач тустай. Коммунист засгийн газар өөрсдийн суртал ухуулгаа явуулахын тулд богино долгион ашиглан нэвтрүүлэг явуулдаг. Нэгэнт бараг айл болгон радиотой учир ийм нэвтрүүлгүүдийг үргэлж сонсох боломжтой. Коммунист улс орнуудын хилийн заагийг нэвтрэн агаарын долгиноор нэвтрүүлэг явуулах боломж одоо нээгдээд байна. Энэ ажлыг илүү өргөн хүрээг хамруулан хийх хэрэгтэй. Коммунист орнуудын нууц бүлгүүдэд та бүхэн энэ аргыг ашиглан бас тусалж болно.

ХАВЧИГДАГСДЫН ГЭР БҮЛД УЧИРДАГ ЭМГЭНЭЛТ ХЭРГҮҮД

Итгэлийнхээ төлөө амиа алдсан хүмүүсийн ар гэрийнхэнд бид туслах үүрэгтэй. Олон арван мянган гэр бүл өгүүлэхийн аргагүй эмгэнэлт байдалтай зовж байна. Нууц бүлгийн хэн нэг гишүүн баригдлаа гэхэд түүний ар гэрийнхнийг өгүүлэхийн аргагүй аймшиг нөмрөн авна. Тэдэнд туслах нь асар том гэмт хэрэгт тооцогдоно. Энэ бол ард нь үлдэж хоцорсон үр хүүхэд, эхнэрийг нь зовоох гэж шийдсэн коммунистуудын ухаалаг төлөвлөгөөний нэг хэсэг. Христэд итгэгч хүн широнд орлоо гэхэд түүнийг тамлал, зодуур, цаашлаад үхэл хүлээн байх боловч энэ бол түүнд учраад байгаа зовлонгийн зөвхөн эхлэл. Харин түүний гэр бүлийн зовлонд эцэс төгсгөл гэж үгүй. Би өөрийн амьдралын бодит түүхээс үндэслэн та нарт хэрэв чөлөөт нийгмийн итгэгчид бидэнд гар сунган туслаагүй байсан бол манай гэр бүлийнхэн хэзээ ч амьд гарахгүй байсан агаад өнөөдөр би энд

зогсоод та нартай ярьж, энэ үгсийг дамжуулан бичээд суухгүй байх байсныг баталгаатай баримттай хэлж чадна!

Дөнгөж саяхан орос болон бусад коммунист орнуудад Христэд итгэгчдийг баривчлах их ажиллагаа өрнөлөө. Итгэлийнхээ төлөө амиа алдаж буй хүмүүсийн тоо өдөр ирэх бүр улам л нэмэгдсээр. Хэдийгээр тэд булшинд орон, амар тайван нойрсох боловч ард нь хоцорсон гэр булийн хүмүүс нь төсөөлөхийн аргагүй аймшигтай нөхцөлд амьдарна. Мэдээж бид өлсгөлөнд нэрвэгдээд байгаа энэтхэг, африкийн хүмүүс туслах хэрэгтэй байлгүй яахав. Гэвч Христэд итгэснийхээ төлөө тамлуулан до-ромжлол амсан амиа алдсан, шоронд зовж буй Христэд итгэгчдээс, тэдний ар гэрийнхнээс өөр хэнд бид туслах ёстой юм бэ? Юуны түрүүнд бид тэдэнд сайн юм хийж өгч тусалж байх ёстой биш үү?

Намайг суллагдсанаас хойш Христэд итгэгчдийн Европын нийгэмлэгээс амь үрэгдэгсдийн гэр булийнхэнд зориуулан тусламж явуулж эхэлсэн байв. Та нарын тус дэмжлэгээр бидний хийж чадах их хэрэгтэй харьцуулахад тэдний хийж буй ажил өчүүхэн жаахан зөвхөн эхлэл гэлтэй.

Зовлон туулан гарч, амьд үлдэн чөлөөлөгдсөн нууц бүлгийн гишүүнийхээ хувьд би та бүхэнд тэдний хэлэх гэсэн үгийг дамжуулж ард минь үлдэж хоцорсон ахан дүүсийнхээ гүйлт хүсэлтийг толилууллаа.

Энэ үгийг дамжуул гэж тэд намайг та нар руу илгээсэн. Харин би үүнийг та бүхэнд дамжуулахын тулд өдий хүртэл гайхамшигийн хүчээр амьд явж байна.

Коммунистуудын ертөнцөд Христийг оруулах нь хичнээн чухал болохыг би та нарт ойлгуулахыг хичээллээ. Итгэлийнхээ төлөө амиа алдсан тэдний гэр булийнхэнд туслах нь яагаад чухал болохыг хэллээ. Христийн авралын мэдээг тунхаглахад нь тус болох бодит арга замуудаас зааж өглөө.

Хөлийн минь улнаас эхлэн намайг тамлан яргалахад миний уруул ам хөдлөн би орилдог. Хөлийг минь оролдоогүй байхад би яагаад орь дуу тавина вэ? Хөлийн ул, хэл хоёр нэг биед хамаатай эрхтнүүд учир би ийнхүү өвдөхдөө хашгирдаг. Үүний адил чөлөөт нийгмийн итгэгч та нар ч бас Христийн биесийг бүрдүүлэгч ба та нарын салшгүй нэг хэсэг коммунист улс

орнуудад оршин байна. Тэд тэнд зовж, тамлуулж Христийн төлөө амь насаа алдаж байна.

Бидний хэрхэн зовж байгааг, хэрхэн шаналж байгааг та мэдээрч байна уу?

Анхны итгэгчид хайртай Их Эзэнийхээ төлөө амь нас, байгаа бүхнээ зориулсан тэмцдэг туйлын үзэсгэлэн төгөлдөр, гайхамшигтай чанаруудтай байсан. Коммунист улс орнуудад байгаа итгэгчид ч гэсэн энэ чанар одоо ч байсаар, тэд бас ийнхүү тэмцсээр байна.

Гэтсэмэн цэцэрлэгт бидний хайрт Их Эзэн Есүс Христ шаналлан Ертөнцийн Эзэн эцгэгтэйгээ ярж байхад Пётр, Иоган, Яахооб нар хүн төрөлхтний түүхийн хамгийн чухал тэр үед чулуу дэрлээд унтаж байсан. Амь биеэ үл хайхран итгэлээ хамгаалан буй хүмүүсийн төлөө та нар хир их санаа тавин шанална вэ? Төмөр Хөшигний цаана буй ахан дүүстээ туслахын тулд ямар ажил хийж буй талаар ахлагч нараасаа лавлан асуугаад үз.

Төмөр хөшигний цаана хэдэн хананы дунд Христэд итгэгчид анхны итгэгчдийн адил баатарлаг, зоригтой тэмцэн байхад чөлөөт нийгэм дэх хүмүүс унтсаар.

Тэнд бидний ах, эгч, дүүс хорьдугаар зууны хамгийн агуу их, хамгийн их зориг, тэвчээр шаардах тэмцэлд талд ганцаар хаягдсан хүүхэд мэт гав ганцаар, тусламж дэмжлэггүй итгэлийнхээ төлөө зоригтой, тууштай тэмцэн байна. Аврагч Их Эзэн нь шаналан байх тэр цагт юу ч бодоогүй янзтай өөрт тулгарсан хэцүү байдлыг бодоод унтаж байсан Пётр, Иоган, Яахооб нарын адил чөлөөт нийгмийн итгэгч нар маань тулган доторхоо л анхаараад унтаа байдалтай байсаар байна.

Христийн сургаалын төлөө нууц бүлгийн ахан дүүс чинь ганцаар тэмцэн зовж шаналж байхад ч гэсэн та нар тоохгүй унтаад л байх юм гэж үү?

Бидний хэлж буй энэ үгийг сонсохгүй юм гэж үү? «Биднийг дурсан санаач! Бидэнд туслаач!»

«Биднийг ганцааранг нь бүү орхиоч!»

Коммунист улс орнуудад суугаа, итгэлийнхээ төлөө амь насаа гаргуунд гарган тэмцэж, Христийн авралын мэдээг бүх хүнд хүргэхийн төлөө ямар ч бэрхшээл зовлонг үл хайхран, бүхнээ

ДОЛДУГААР БҮЛЭГ

зориулан тэмцэж буй нууц бүлэг болон Христийн нэрээр нэгдмэл ахан дүүсийн чинь үгийг би та бүхэнд дамжууллаа.

ИТГЭЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

ISBN 1 84475 007 8

© ШХИ, 2005

Монголын Библийн Нийгэмлэг
Улаанбаатар—13, ш/х 2390



Ричард Вурмбранд шоронд
хоригдож байхдаа.

МОЛДОВА
БІБЛІОГРАФІЯ

ISBN 184475007-8

9 7 8 1 8 4 4 7 5 0 0 7 8